



ШҮҮХИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА
МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН



ХАННС-ЗАЙДЕЛИЙН САН



МОНГОЛЫН ТӨР, ЭРХ ЗҮЙ

ШҮҮХИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА
МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН



МОНГОЛЫН ТӨР, ЭРХ ЗҮЙ

ДОТООДЫН МЭРГЭЖЛИЙН, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ
УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

2022 № 3 (101) тусгай дугаар

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

ЭРХЛЭГЧ:

Д.ЭРДЭНЭЧИМЭГ

Хууль зүйн ухааны доктор /Ph.D/
Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал

ГИШҮҮД:

Ж.АМАРСАНАА

Академич, Хууль зүйн шинжлэх ухааны доктор /Sc.D/

С.НАРАНГЭРЭЛ

Академич, Хууль зүйн шинжлэх ухааны доктор /Sc.D/

Ж.БЯМБАА

Хууль зүйн ухааны доктор /Ph.D/

Ч.ХОСБАЯР

Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн

Г.БАНЗРАГЧ

Улсын Дээд шүүхийн шүүгч, Хууль зүйн ухааны доктор /Ph.D/,

Д.ЦОЛМОН

Улсын дээд шүүхийн шүүгч

Б.ӨЛЗИЙСАЙХАН

Хууль зүйн ухааны доктор /Ph.D/

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

Д.ЯНЖИНХОРЛОО

Хууль зүйн ухааны доктор /Ph.D/
Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн
Судалгааны төвийн дарга



ӨМНӨХ ҮГ

ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сан Монгол Улстай анх 1993 оноос холбоо тогтоож, 1995 онд Засгийн газартай эрх зүй, захиргааны салбарт хамтран ажиллах хэлэлцээр байгуулж үйл ажиллагаагаа албан ёсоор эхлүүлсэн үеэс Улсын дээд шүүхтэй идэвхтэй хамтран ажиллаж олон үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлж байгаа билээ.

Тухайлбал шүүгчид, шүүхийн захиргааны ажилтнуудын сургалт, эдгээр сургалтад зориулж хэвлүүлсэн цуврал гарын авлага, хуулийн тайлбарууд; “Монгол Улсын захиргааны хэргийн шүүхийн төлөвшил, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилт” зэрэг судалгааны ажлаас гадна 2004 онд Монгол Улсад захиргааны хэргийн дагнасан шүүх байгуулах үйл явцад бид хамтран зүтгэж хувь нэмрээ оруулсан. Түүнчлэн улсын хэмжээнд захиргаа, эрүүгийн шүүхийн шүүгчдийн сургалтыг удирдан явуулах сургагч багшийн хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлсэн, шүүгчдийн удаа дараагийн сургалт семинар, ажлын айлчлалыг ХБНГУ-д зохион байгуулсныг энд мөн дурдаж болох юм.

Бидний хамтын ажиллагааны бас нэг чухал хэлбэр нь шүүгчдийг оролцуулсан хэлэлцүүлэг, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж тулгамдаж

буй асуудлаа хэлэлцэн санал бодлоо солилцох явдал байдаг. Үүнд “Шүүх эрх мэдэл- шинэ зуун” сэдэвт олон улсын онол- практикийн бага хурал /2001 он/, “Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэглэхэд анхаарах асуудлууд” хэлэлцүүлэг /2019 он/, “Үндсэн хуулийн болон захиргааны эрх зүйн үндсэн асуудлууд: хямралын үеийн тулгамдсан асуудал” олон улсын эрдэм шинжилгээний III хурал /2021 он/ зэргийг нэрлэж болно.

Үр бүтээлтэй, тогтвортой хамтын ажиллагааныхаа үргэлжлэл болгож “Байгаль орчныг хамгаалахтай холбоотой хэрэг маргааныг шүүхэд хянан шийдвэрлэж буй байдал, дүн шинжилгээ, анхаарах асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнтэй хамтран зохион байгуулсан нь бидний хувьд нэр төрийн хэрэг байлаа. Энэхүү хурал Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн /2021 оны шинэчилсэн найруулга/ дагуу шинээр байгуулагдсан хүрээлэнгийн нэг жилийн ойн өдөр тохиосноороо онцлог байв. 1995 оноос эхлэн монголын нийт шүүгчид, хуульчдын хүртээл болсон “Монголын төр, эрх зүй” сэтгүүлийг тус хүрээлэн эрхлэн гаргах болж, энэ удаагийн дугаараар бидний

хамтран зохион байгуулсан анхны эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүд олон нийтэд хүрч байгааг тэмдэглэхэд таатай байна.

Тус сангийн Монголд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны нэн тэргүүний зорилго нь эрх зүйт төр, ардчилсан тогтолцоог хөгжүүлэх, орчин үеийн ардчилсан, эрх зүйт төрт улс болон хөгжихөд дэмжлэг үзүүлэх явдал байсаар ирсэн. Энэхүү зорилгыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, Монгол Улсын тогтвортой хөгжлийг дэмжихэд та бүхэнтэй хамтран ажиллах болно.

Миний бие Ханнс-Зайделийн сангийн төлөөлөгчийн газрыг 30 орчим

жил үр бүтээлтэй удирдаж, үүрэгт ажлаа нэр хүндтэйгээр хүлээлгэн өгсөн хатагтай профессор, др. Ц.Сарантуяагийн үйл хэргийг үргэлжлүүлэн, цаашид хөгжүүлэхээр тус сангийн Монгол дахь суурин төлөөлөгчөөр томилогдон ирснээс хойш танай хуулийн салбарын төлөөлөлтэй удаа дараа уулзаж, Монгол Улсын хууль зүйн салбарт богино хугацаанд асар их өөрчлөлт бий болсонд бахархаж байлаа.

Тиймээс та бүхэнтэй хамтран хэрэгжүүлэх амжилттай туршлага бүхнийг цаашид үргэлжлүүлэн дэмжихэд таатай байна.

ХАННС-ЗАЙДЕЛИЙН САНГИЙН МОНГОЛ ДАХЬ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН ТЭРГҮҮН ФЕЛИКС ГЛЕНК

АГУУЛГА

Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Д.Ганзориг

"Байгаль орчныг хамгаалахтай холбоотой хэрэг, маргааныг шүүхэд хянан шийдвэрлэж буй байдал, дүн шинжилгээ, анхаарах асуудал" сэдэвт эрдэм шинжилгээний хурлын нээлтийг үг.

I ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА

Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Б.Батзориг, Ц.Оч

Хууль бус уул уурхайтай холбоотой эрүүгийн хэрэг хянан шийдвэрдэх ажиллагааны төлөв байдал

УДШ-ийн ШССМХ-гийн Шүүхийн судалгааны төвийн судлаач Б.Батбаяр

Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн шүүхийн практик, хуульчлагдсан байдалд хийсэн дүн шинжилгээ

УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн, шүүгч Ч.Хосбаяр

Эрүүгийн эрх зүйн салбар илтгэлүүдийн дүгнэлт

Санхүү, эдийн засгийн их сургуулийн багш С.Энхбаяр

Байгаль орчинд учруулсан хохирлыг иргэний журмаар шаардах эрхийн асуудал

УДШ-ийн ШССМХ-гийн Шүүхийн судалгааны төвийн судлаач Д.Бямба-Од

Уул уурхайн салбарт байгаль орчинд нөхөн сэргээлт хийх үүргээ гүйцэтгээгүйгээс учирсан хохирол, нөхөн сэргээлтийн төлбөр гаргуулах тухай маргааныг шийдвэрлэж буй шүүхийн практикийг "бохирдуулагчаар нөхөн төлүүлэх" зарчимтай уялдуулан авч үзэх нь

УДШ-ийн Иргэний хэргийн танхимын тэргүүн, шүүгч Г.Алтанчимэг

Иргэний эрх зүйн салбар илтгэлүүдийн дүгнэлт

Нагоягийн их сургуулийн Хууль зүйн сургуулийн докторант С.Сүхчулуун

Байгаль орчин болон соёлыг өвийг хамгаалах асуудлаар төрийн бус байгууллагад нэхэмжлэл гаргах эрхийг олгохтой холбоотой Япон Улсын өнөөгийн чиг хандлага

УДШ-ийн ШССМХ-гийн Шүүхийн судалгааны төвийн судлаач С.Жансая

Захиргааны хэргийн шүүхэд байгаль орчныг хамгаалахтай холбоотой хэрэг маргааныг хянан шийдвэрлэж буй байдал

Нийгмийн Антропологийн Макс Планк Институтийн Хууль ба Антропологийн тэнхимийн докторант Д.Баяр

Үндсэн хууль, байгаль орчны хамгаалал, байгалийн баялаг, эрүүл орчинд амьдрах эрх ба Цэц



УДШ-ийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн, шүүгч Ч.Тунгалаг

Захиргааны эрх зүйн салбар илтгэлүүдийн дүгнэлт

II ҮЗЭЛ БОДОЛ /СЭДЭМЖ, ЯРИЛЦЛАГА, ШҮҮМЖ/

Шүүхийн сахилгын хорооны дарга, хууль зүйн ухааны доктор, дэд профессор Д.Мягмарцэрэн

Сахилгын хороо байгуулагдсанаар шүүгчийн сахилга ёс зүйн

зөрчил хянан шалгах үйл ажиллагаа хөндлөнгийн хараат бус бие даасан хэлбэрт

орсон



“БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХТАЙ ХОЛБООТОЙ ХЭРЭГ, МАРГААНЫГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭЖ БУЙ БАЙДАЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ, АНХААРАХ АСУУДАЛ” СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН НЭЭЛТИЙН ҮГ

Шүүхийн тухай хууль шинэчлэгдэн батлагдаж, цаашид шүүхийн системийн шинжлэх ухааны ой санамж болох Шүүхийн Сургалт Судалгаа Мэдээллийн Хүрээлэнг одоогоос яг нэг жилийн өмнө Улсын дээд шүүхийн дэргэд байгуулсан. Энэ хугацаанд хүрээлэн залуу судлаачид, эрх зүйчдээр эгнээгээ тэлж, 2022-2024 оны Шүүхийн сургалтын нэгдсэн бодлогоо баталж, шүүгч нарын мэргэшил дээшлүүлэх багц цагийн сургалтын хөтөлбөр боловсруулан төлөвлөгөөт сургалтуудаа амжилттай хийж ирлээ.

Шүүх, шүүгчийн захиалгат судалгаануудыг хийж, шүүхийн шийдвэрийн хураангуй бэлтгэж олон нийтэд хүргэж эхлээд байна.

Мөн Монгол Улсын дээд шүүх эрхлэн гаргаж ирсэн Монголын төр, эрх зүй сэтгүүлийг тус Хүрээлэнд шилжүүлж, 100 дахь дугаараас нь эрхлэн гаргаж, улмаар эрдэм шинжилгээний чиглэлд мэргэшсэн сэтгүүлийн ангилалд багтаж, ээлжит дугааруудаа бэлтгэн шүүгчид, хуульчдын хүртээл болгоод байна. Энэ бол нэгхэн жилийн дотор хийж хэрэгжүүлсэн гэхэд чамлахааргүй амжилт, түүхэн чухал ажлын гараа гэж дүгнэж болно.

Энэ бүх ажлыг амжуулж, хийж хэрэгжүүл буй Шүүхийн Сургалт Судалгаа Мэдээллийн Хүрээлэнгийн хамт олондоо ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Бидэнтэй олон жил хамтран ажиллаж ирсэн Ханнс-Зайделын сан энэ удаад ч мөн Хүрээлэнгийн анхны дотоодын эрдэм шинжилгээний хурлыг хамтран зохион байгуулж байгаад чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Хүрээлэн байгуулагдсан жилийнхээ ой дээр дотоодын эрдэм шинжилгээний бага хурлаа анхлан зохион байгуулж, тэр тусмаа Монгол Улсын төдийгүй дэлхий нийтийн өмнө тулгамдсан асуудлыг хөндөж, “Байгаль орчныг хамгаалахтай холбоотой хэрэг, маргааныг шүүхэд хянан шийдвэрлэж буй байдал, дүн шинжилгээ, анхаарах асуудал” гэсэн энэ сэдвийг сонгосон нь тохиолдлын гэж хэлэх боломжгүй.

Байгаль бол бидний амьдралын эх үндэс, ирээдүй юм.

Хүн төрөлхтний амьдралын эх үндэс болсон байгаль орчныг хувийн ашиг хонжоо олох зорилгоор учрах хор уршгийг мэдсээр байж санаатай сүйтгэх нь шинж, бүрэлдэхүүнээрээ эцсийн үр дүндээ хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт ч тооцогдох боломжтой талаар олон улсын эрх зүйчид саналаа илэрхийлж, олон улсын эрүүгийн эрх зүйн салбарт экоцид хэмээх шинэ гэмт хэргийн талаар түгээмэл ярьж бичих боллоо.

Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийн улмаас тодорхой үндэстэн,



ястан, бүлэг хүмүүсийн амь нас, эрүүл мэнд, ахуй амьжиргаанд нөхөгдөшгүй хохирол учирч хойч ирээдүйг нь ч мөхөл рүү хөтөлж байхад нөгөө талд ийм үнэ өртгөөр бүлэг хүмүүс баяжиж, хөлжиж байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн оршихуйн нөлөө, хор аюулыг харуулж, энд шударга ёс, үнэт зүйлсийн харьцаа хэрхэн алдагдаж байгааг тов тодорхой харуулсаар байгаа юм.

Иймд Та бүхэнд дараах хэдэн санааг нэмэрлэе гэж бодлоо.

Ноцтой гэмт хэрэгтэй нухацтай аргаар тэмцэж байж үр дүн гарах нь эрх зүйг тэнцвэрт харьцаагаар хэрэглэх зарчмын суурь санаа юм. Байгаль, хүрээлэн буй орчинд ноцтой хохирол учруулж буй шинэ үйлдэл, эс үйлдэхгүйг авч үзэх, энэ төрлийн гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг чангатгах зэргээр эрх зүйн дэг журмыг шинэчлэн тогтоох хэрэгцээ, шаардлага байна.

Одоо байгаа эрүүгийн хууль тогтоомжийн хүрээнд хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх боломж, бололцооны талаар бид няхуур бодож үзэх хэрэгтэй. Олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, мөрдөн шалгах ажиллагааг хил хязгааргүй явуулах, үүнтэй зэрэгцүүлэн үндэсний хэмжээнд хууль сахиулах, прокурор, шүүх байгууллагуудыг хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийн шинж, бүрэлдэхүүн, нотлох ажиллагааны онцлогийн талаар нэгдмэл ойлголттой болох, харилцан ойлголцол, хамтран ажиллах уур амьсгалыг бий болгох шаардлагатай.

Монгол Улсын нутаг дэвсгэрт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах харилцаа болон бичил уурхайгаар ашигт малтмал олборлох харилцааны эрх зүйн зохицуулалтаар халхавчлан хууль бус уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй

явдалтай тэмцэх, эдгээр харилцаан дахь "тусгай зөвшөөрөл"-ийн эрх зүйн үр дагаврын ялгааг тодотгон гаргаж өгөх, бичил уурхайн орчинд үйлдэгдэж буй хэрэг, зөрчлийн шинж, бүрэлдэхүүнийг тодорхойлоход Эрүүгийн болон Зөрчлийн хуулийг оновчтой хэрэглэхэд анхаарал хандуулах нь зүйтэй.

Хууль бусаар ашигт малтмал хайх, олборлох гэмт хэрэг, зөрчлийн ялгааг тайлбарлах, энэ төрлийн гэмт хэрэгт ашиглахаар төвлөрүүлсэн өмчлөгч, эзэмшигч тодорхойгүй, эсхүл хуурамчаар бүртүүлсэн техник, хэрэгслийг Эрүүгийн хуулийн зорилго, зорилтод нийцүүлэн шийдвэрлэж тогтоох зэрэг тодорхой асуудлуудыг шүүхийн практик, онолын үндэслэл, судалгаа шинжилгээнд үндэслэн дэвшүүлэн тавьж, гарц гаргалгааг хайх хэрэгтэй байна.

Байгаль хамгаалах хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй, зөрчсөн тохиолдолд хариуцлагын асуудал бүрхэг байна. Шүүхийн практикт эрх зүйн тодорхойгүй байдал, хууль хоорондын зөрчил, хийдэл томоохон асуудал болж буй бөгөөд үүнийг хууль хэрэглээний нэгдмэл байдлыг бий болгох замаар засаж залруулахыг зорихоос гадна хууль тогтоогчдод хуулийг боловсронгуй болгох сэдэл санааг өгч байх нь чухал байна. Энэ чиглэлд бидэнд дорвитой судалгаа, шинжилгээ, чиг баримжаа болгох бүтээл хомс байна. Цаашид Шүүхийн мэдээлэл судалгааны сан бүрдүүлэх шаардлагатай байна.

Хүрээлэн буй орчныг хамгаалах тухай бие даасан цогц хуультай улсууд улам хүрээгээ тэлсээр байна. Хүрээлэн буй орчны эрүүгийн эрх зүй, зүй бус нөлөөллөөс хамгаалах эрх зүйг тус тус бие даасан хууль баталж хөгжүүлэх чиг



хандлагатай байна. Тухайлбал гадаадын зарим оронд газар, байгалийн баялгийг эзэмших, ашиглах тухай ярихаас илүүтэй хамгаалах бодлогыг баримталж Газар, түүний хэвлийг хамгаалах эрх зүй, Байгаль орчныг хамгаалах эрх зүй, Ус хамгаалах эрх зүй гэх мэт бие даасан эрх зүйг амжилттай хөгжүүлж байна.

Ингээд өнөөдрийн хурлын илтгэлүүд дээрх сэдвүүдийг хөндөж, энэ асуудалд шүүхийн систем ямар үүрэг гүйцэтгэх боломжтой талаар дэлгэрэнгүй ярилцаж, үнэтэй санал, онолыг хуваалцана гэдэгт итгэж байна.

Та бүхэнд амжилт хүсье.

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ Д.ГАНЗОРИГ



**ХУУЛЬ БУС УУЛ УУРХАЙТАЙ ХОЛБООТОЙ ЭРҮҮГИЙН
ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ
ТӨЛӨВ БАЙДАЛ**

**CRIMINAL COURT PROCEEDINGS ON HANDLING
OF ILLEGAL MINING DISPUTES**

Б.БАТЗОРИГ, Ц.ОЧ¹

- I. Удиртгал
- II. Түүхэн уламжлал
- III. Практик судалгаа
- IV. Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд тулгамдсан асуудал
 - 1. Хохирлын үнэлгээ хийх асуудал
 - 2. Гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан эд зүйлийн шийдвэрлэлт
 - 3. Ашигт малтмал бол нөхөн сэргээгддэг баялаг биш.

¹ Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчид



ХУУЛЬ БУС УУЛ УУРХАЙТАЙ ХОЛБООТОЙ ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

Б.БАТЗОРИГ, Ц.ОЧ

Уул уурхай нь ашигт малтмал ашиглах, олборлох боломжийг олгодог эдийн засгийн үйл ажиллагаа бөгөөд түүнийг хөгжүүлэх нь тухайн улс, бүс нутгийн эдийн засагт ач холбогдолтой.

Том, жижиг, бичил уул уурхай нь газрын хөрсийг ухаж байж доорх эрдэс баялгийг олборлодог бөгөөд энэ нь ойн сан, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн талбай, амьтан ургамлын аймгийн төрөл зүйлийн орчин, популяцыг хорогдуулдаг, малын бэлчээрийг сүйтгэх зэргээр мал, амьтны ундны ус хомстох, хөрс, ус бохирдох төдийгүй хүний амьдрал, удмын санд сөргөөр нөлөөлдөг зэргээр ихээхэн хохирол, хор уршигтай тул хууль бус уул уурхайн үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох, түүнтэй тэмцэх нь манай улсын хувьд нэн тулгамдсан асуудал юм.

Иймд эдийн засгийн тулгуур болсон уул уурхайн салбарын эрх зүйн орчин, түүний тулгамдсан асуудал, ялангуяа хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй байдал зэргийг судлах нь нэн чухал бөгөөд сүүлийн жилүүдэд энэ төрлийн гэмт хэргийн гаралт нэмэгдсээр байгаа нь төрөөс энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх бодлогыг эргэн харах зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

Түүхэн уламжлал

Монгол Улсын Үндсэн хуулийн зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна” гэж заасан бөгөөд өнөөдрийн байдлаар манай улсад байгаль орчны чиглэлийн 30 гаруй багц хууль үйлчилж байна.

Манай улс байгаль орчныг хайрлан хамгаалах, газар, ус, бэлчээрийг зүй зохистой ашиглах зэргийг төрийн бодлогын түвшинд гаргаж, үе үеийн эрүүгийн болон бусад хууль тогтоомждоо тусган, дагаж мөрдсөөр ирсэн бөгөөд энэхүү хууль тогтоомжийн эх сурвалжууд нь “Их засаг” хуулиас эхлэлтэй “Алтан хааны цааз бичиг”, Их Юан гүрний “Нэвтэрхий хууль”, “Дөчин дөрвөн хоёрын их цааз”, “Халх журам”, “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг”, “Жинхэнэ дагаж явах хууль дүрэм” зэргийг дурдаж болно.

Энэхүү судалгаагаар 20 дугаар зуун гарснаас хойш Монголчуудын дагаж мөрдөж байсан шүүх цаазын бичиг, эрүүгийн хууль тогтоомж дахь хүрээлэн буй орчны эсрэг тодорхой гэмт хэргийг хуульчилсан байдлыг судлан үзлээ.

¹ Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчид



1926 оны БНМАУ-ын шүүх цаазын бичиг.

Цаазын бичигт (103) Дэлхийн баялгийг ашиглах тухай дүрэм, хэмжээг зөрчих, (104) алт мөнгөний зэрэг эрдэнийн зүйл ба элдэв зүйлийн эрдэнийн чулууг жич: чулууны тос, чулууны нүүрс зэргийг зоргоороо тэмтрэн үзэх буюу малтах, (110) ой модын хамгаалах тухай дүрмийг зөрчих, (113) хүн малын уух, хэрэглэх ус ба тариалангийн сувгийг зоргоороо хааж боогдуулах буюу сэтэлж гэмтээх зэрэг үйлдлүүдэд ял шийтгэхээр заажээ.

Мөн аливаа малтсан газрыг эс таглаж тэгшилсэн буюу байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй эс үйлдэлд 1 сар хүртэлх гянданд хорих буюу 50 хүртэлх төгрөгөөр торгохоор цаазын бичгийн 117 дугаар зүйлд заасан.

Ард олны ашиг, хөрөнгийг хамгаалах тухай хууль дүрмийг зөрчсөн гэмт хэргүүдэд гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан эд зүйлсийг албадан хураах, 1200 хүртэлх төгрөгөөр торгох, 3 жил хүртэлх хугацаагаар гянданд хорих ял оногдуулж байжээ.

1942 оны Эрүүгийн хууль.

БНМАУ-ын 25 дугаар бага хурлаас 1942 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн тогтоолоор баталсан Эрүүгийн хуулийн "Ардын эрүүл мэнд ба олон нийтийн амгалан байдал хийгээд хэв журам сахиж хамгаалах тухай хууль, дүрмийг зөрчсөн гэмт хэргүүд" хэмээх есдүгээр бүлэгт худаг, булгийг санамсаргүйгээр эвдэн гэмтээх, ой, хээрийн түймэр тавих хэргүүдийг хамааруулсан бол "Засаг захиргааны журмыг эсэргүүцсэн бусад гэмт хэргүүд" хэмээх гуравдугаар бүлэгт ой модын хөнөөн сүйтгэх явдлаас хамгаалахын тулд гаргасан тогтоолуудыг зөрчих, цаазалсан газар нутагт буюу

цаазтай цаг үед эсвэл цаазлагдсан амьтан агнасан хэргийг хамааруулжээ.

1986 оны Эрүүгийн хууль

Хуулийн 7 дугаар бүлэгт байгаль орчин, түүний баялгийг хамгаалах журмын эсрэг гэмт хэргүүдийг хуульчилсан бөгөөд недрийг ашиглах, алт бусад үнэт металл, үнэт чулууг улсад тушаах журам зөрчих, газар эдэлбэрийн хууль тогтоомж зөрчих, байгалийн объектыг санаатай устгах, эвдэх, гэмтээх зэрэг үйлдлийг гэмт хэрэгт тооцож байжээ.

Дурдсан гэмт хэргүүдэд хоёр мянга хүртэл төгрөгөөр торгох, нэг жил зургаан сар хүртэлх хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, 5 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулж байв.

2002 оны Эрүүгийн хууль

Хуулийн 23 дугаар бүлэгт байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийг хуульчилсан бөгөөд 214 дүгээр зүйлд хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэргийг заасан.

Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох үйл ажиллагаа явуулж үлэмж хэмжээний хохирол учруулсан, их буюу онц их хэмжээний хохирол учирсан, эсхүл уг үйл ажиллагааг тусгай хамгаалалттай газар нутагт явуулсан, тусгай зөвшөөрлийн дагуу ашигт малтмалын хайгуул, ашиглалт, олборлолтын үйл ажиллагаа явуулсан талбайд нөхөн сэргээлтийн ажил хийгээгүй, эсхүл химийн хорт болон аюултай бодис хэрэглэх журам зөрчсөний улмаас хүний эрүүл мэнд, мал, амьтан, байгаль орчинд их хэмжээний хохирол бусад хүнд хор уршиг учруулсан бол энэ зүйлд зааснаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хорин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэгээс зургаан сар



хүртэл хугацаагаар баривчлах, 10 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулж байжээ.

2015 оны Эрүүгийн хууль

Дагаж мөрдөж буй Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлэгт хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргүүдийг заасан бөгөөд 24.2 дугаар зүйлд хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэргийг хуульчилсан.

Тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолт, боловсруулалт, ашиглалт явуулсан, эсхүл ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар хууль бусаар газрын хэвлийд халдсан, тусгай зөвшөөрөлтэйгөөр ашигт малтмалын хайгуул, ашиглалт, олборлолт, боловсруулалт явуулсан талбайд нөхөн сэргээлтийн ажлыг зохих журмын дагуу хийгээгүйн улмаас байгаль орчинд их хэмжээний хохирол учирсан, уг гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэгээс найман жилийн хугацаагаар хорих ял шийтгэх, хуулийн этгээдэд үйл ажиллагаа явуулах эрх хасаж, хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор заасан байна.

1990 оноос манай улсын нийгэм эдийн засгийн тогтолцоо өөрчлөгдөж, зах зээлийн нийгэмд шилжсэнээс хойш уул уурхайн салбарт хувийн хэвшил, хувь иргэд ажиллах болж 1994 онд Ашигт малтмалын тухай хууль, улмаар Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Байгалийн ургамлын тухай, Газрын тухай, Ойн тухай, Агаарын тухай, Амьтны тухай зэрэг байгаль орчныг хамгаалах багц

хуулиуд батлагдаж уул уурхай, эрдэс баялгийн салбар манай улсын эдийн засагт томоохон нөлөө үзүүлэх болж, уул уурхайн салбар манай улсын экспортын 81 хувийг эзэлж, Монгол Улсад орсон шууд хөрөнгө оруулалтын 89 хувь нь энэ салбарт хамаарч, эдийн засгийн өсөлт энэ салбараас шууд хамаарах болсон. Үүнийг дагаад энэ төрлийн гэмт хэрэг ихээр үйлдэгдэх болж байгаль, нийгэмд тодорхой хэмжээнд хор хөнөөл учруулах болсон тул бид анхаарлаа хандуулж, энэ салбарын эрх зүйн зохицуулалтыг эргэн харах шаардлагатай болоод байна.

1995 онд батлагдсан "Байгаль орчныг хамгаалах тухай" хуульд тусгагдсан "байгаль орчинд учруулсан хохирол", "байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөр", "байгаль орчинд "учирсан хохирлыг нөхөн төлөгч" гэх зэрэг ойлголтууд бий болж эдгээрийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зөв хэрэглэх нь чухал төдийгүй хэргийн шийдвэрлэлтэд нөлөөлсөөр байна.

Жишээлбэл:

"Байгаль орчны хохирол" гэж хүрээлэн буй орчин бохирдох, байгалийн нөөц баялаг хомсдох, экологийн тогтолцоо алдагдах зэргээс хүний эрүүл мэнд болсон хүрээлэн буй орчинд аюул занал үүсэх, байгаль орчинд сөрөг нөлөөлөхийг хэлнэ. Байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийн хувьд ашигт малтмалыг ил уурхайгаар ашиглах арга хамгийн халтайд тооцогддог.

"Байгаль орчны хохирлын үнэлгээ" гэж хүрээлэн буй орчны хохирол, түүний үр дагавар нь хүний эрүүл мэндийн доройтол, бэлчээрийн талхагдал, хөдөө аж ахуйн ургацын бууралт, байгалийн нөөц хомсдох, түүнчлэн хүрээлэн буй орчинд буюу байгалийн нөөцөд учирсан



хохирлыг нөхөн сэргээхэд шаардагдах хөрөнгийн тооцооллыг хэлнэ. Байгаль орчны хохирол нь зэрлэг ан амьтан тэдгээрийн төрөл зүйлийн амьдрах орчинд учирсан хохирол, түүнчлэн тэдгээрийн нийгэмд үзүүлдэг үйлчилгээнд учирсан хохирол, өөрчлөлтийн бодит хэмжээг тодорхойлсны үндсэн дээр тэдгээрт эдийн засгийн үнэлгээ өгдөг.

Үнэлгээг тогтооход эвдрэл, бохирдолд өртсөн объект тус бүрээр ялгавартайгаар авч үзэх, эсвэл орчных нь хэмжээнд /агаар, ус, хөрс, ургамал, газар г.м / хэсэг тус бүрийн нийлбэр хохирлоор илэрхийлэгдэнэ.

Байгаль орчны нөхөн төлбөр нь байгаль орчныг /агаар, хөрс, ус г.м/ бохирдуулсны болон газар ургамал амьтныг устгаж сүйтгэсний нөхөн төлбөрийн хураамжийн хэлбэр юм. Нөхөн төлбөрийн хэмжээ нь дээр дурдсан эдийн засгийн үнэлгээнд үндэслэхээс гадна түүнийг нөхөн сэргээх, үржүүлж бий болгох, засаж сайжруулах арга хэмжээнд хүрэлцэхүйц байх ёстой. Ялангуяа уул уурхайн олборлолтын үйл ажиллагааны нөхөн төлбөрийн хэмжээ нь түүнийг нөхөн сэргээж ажлын зардал, байгалийн нөөц баялгийг бохирдуулж хомсдуулсны төлбөр, хохирлыг тогтоох

үйл ажиллагааны зардал зэргээс бүрддэг.

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт ойлголт нь хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, байгаль хамгаалах, түүний зүй зохистой ашиглах, элдэв түүний баялаг, ус, ургамал, амьтан агаарт халдаж хор уршиг учруулдаг, учруулах боломжтой, нийгэмд гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйн цогц бүрдлийг хэлдэг. Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт явдлын хор уршигийг:

1. Хүнд учрах хор уршиг
2. Байгаль орчинд учрах хор уршиг
3. Төрд учрах хор уршиг
4. Нийгэмд учрах хор уршиг гэж ерөнхийд нь тодорхойлж болно.

Практик судалгаа

Тус гэмт хэргийн практик судалгааг хийхдээ цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо мэдээ, шүүхийн шийдвэрийн цахим сан болон Сэлэнгэ аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрүүдийг ашиглав.

- Цагдаагийн Ерөнхий газрын Экологийн Цагдаагийн албанаас ирүүлсэн хүрээлэн байгаа орчны

эсрэг гэмт хэргийн тоон мэдээ:

д/д	Зүйл, анги	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020	2021
1	Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлэг Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	197	395	368	484	622	721
2	24.1 Байгаль орчныг бохирдуулах			4	2	4	2
3	24.2 Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох	35	104	135	142	223	285
4	24.3 Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах	7	18	15	18	19	28
5	24.4 Цөмийн бодис, цацраг идэвхт хаягдал, цөмийн материал, цацрагийн үүсгүүрийг хууль бус эргэлтэд оруулах			0	0		



6	24.5 Хууль бусаар ан агнах	30	42	33	49	84	89
7	24.6 Хууль бусаар мод бэлтгэх	72	128	155	244	262	325
8	24.7 Ой хээрийн түймэр тавих			0	0	1	1
9	24.8 Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх			12	15	28	11
10	24.9 Байгалийн тэнцэл алдагдуулах			1	2	1	1

- Шүүхийн шийдвэрийн цахим сан / shuukh.mn/-д байршуулсан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.2 дугаар зүйлд заасан гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн 2017-2021 оны 203 шийдвэр байгаагаас 246 хүнд холбогдох 184 хэрэгт дүн шинжилгээ хийхэд¹:

Он	Нийт хэрэг	2017	2018	2019	2020	2021
Шийдвэрлэсэн хэрэг	184	15	49	41	28	51
Ял оногдуулсан хэрэг	179	14	48	40	28	49
Ял шийтгүүлсэн хүн	224	21	52	43	52	56
Холбогдогчийн мэдээлэл байхгүй				5	2	3

179 хэрэгт холбогдох 224 хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн бол 6 хэргийн 11 хүнийг цагаатгасан байна.





Хэргийн холбогдогч	Хүний тоо	Хувь
Иргэн	171	93%
Уул уурхайн компани	6	3%
Нөхөрлөл	6	3%
Төрийн албан хаагч	1	1%

Хэргийн холбогдогчдын 93 хувь нь иргэд бол уул уурхайн компани, нөхөрлөл холбогдсон бүр 6 хэргийг шийдвэрлэжээ.

Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэсэн байдлыг аймгуудаар авч үзвэл:

№	Аймаг	Шалгасан хэргийн тоо	Шүүхээр шийдсэн хэргийн тоо	Шийдвэрлэлт
1	Сэлэнгэ	186	58	31%
2	Баянхонгор	111	32	29%
3	Төв	76	6	8%
4	Ховд	64	10	16%
5	Өвөрхангай	52	18	35%
6	Булган	47	15	32%
7	Дархан-Уул	44	21	48%
8	Дорноговь	29	3	10%
9	Өмнөговь	23	7	30%
10	Дундговь	23	0	0%
11	Говь-Алтай	21	9	43%
12	Архангай	19	1	5%
13	Хэнтий	18	1	6%
14	Сүхбаатар	12	1	8%
15	Дорнод	9	1	11%
16	Завхан	6	0	-
17	Баян-Өлгий	3	0	-
18	Орхон	2	0	-
19	Говьсүмбэр	2	0	-
20	Увс	1	1	100%

Эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн байдал:

90 орчим хувьд нь торгох ял оногдуулсан, хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн байна. нийт хэргийн 35 хувьд нь торгох ял оногдуулсан, үүнээс 87 хувь

нь 5.400 – 6.000 нэгжээр торгожээ. Холбогдогчдын 53 хувьд хорих ял оногдуулахгүйгээр тэнссэнээс 59 хувьд 1 жил, 22 хувьд нь 2 жилийн хугацаагаар тэнссэн байна. 4 хувь буюу 8 хүнд хорих ял оногдуулжээ.



Хорих ял оногдуулахгүйгээр тэнсэн хугацаа	Хүний тоо	Хувь
6 сар	4	3%
1 жил	68	59%
1 жил 1 сар	1	1%
1 жил 3 сар	1	1%
1 жил 6 сар	9	8%
2 жил	26	22%
2 жил 6 сар	1	1%
3 жил	5	4%
4 жил	1	1%



Гэмт хэргийн улмаас учирсан хохирол

Нийт 166 хэрэгт байгаль орчинд учруулсан шууд хохирол тогтоогдсон байгаа бол 17 хэрэгт ямар нэгэн хохирол тогтоогоогүй байна.

Байгаль орчинд шууд хохирол тооцсон байдал	Хэргийн тоо	Хувь	Дундаж	Нийт
500,000-аас доош	57	34.3%	194,458	11,084,126
501,000-1,000,000	16	9.6%	801,539	12,824,627
1,000,001-2,000,000	27	16.2%	1,599,999	43,199,960
2,000,001-3,000,000	10	6.0%	2,683,859	24,154,731
3,000,001-5,000,000	16	9.6%	3,867,185	61,874,965
5,000,001-10,000,000	20	12.0%	7,093,519	141,870,376
10,000,001-15,000,000	6	3.6%	12,134,939	72,809,635
15,000,001-20,000,000	7	4.2%	18,293,269	128,052,886
20,000,001-30,000,000	2	1.2%	25,384,387	76,153,162
30,000,001-40,000,000	2	1.2%	33,341,208	66,682,416
60,000,001-70,000,000	1	0.6%	61,750,799	61,750,799
100,000,001-аас дээш	2	1.2%	123,901,415	247,802,829

Тус гэмт хэргийн улмаас хамгийн их хохирол учирсан таван аймгийг авч үзвэл:

	Хэргийн тоо	Байгаль орчинд учруулсан нийт хохирол	Экологи, эдийн засгийн дундаж үнэлгээ
Сэлэнгэ	58	410,234,430.00	5,654,123.65
Баянхонгор	32	45,132,142.00	1,455,875.55
Дархан-Уул	21	275,884,205.00	2,841,544.18
Өвөрхангай	18	73,651,567.00	4,601,410.44
Булган	15	70,568,889.00	1,054,079.90



Гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан машин, тоног төхөөрөмж:

Гэмт хэрэг үйлдсэн хэлбэр	2017	2018	2019	2020	2021	Нийт
Гар аргаар	0	1	4	7	10	22
Өөрийн багажаар	0	1	2	3	7	13
Түрээсийн багажаар	0	0	2	4	3	9
Машин, тоног төхөөрөмж ашигласан	14	48	37	19	41	159
Өөрийн МТТ	1	11	6	8	9	35
Түрээсийн МТТ	13	37	29	11	32	122

Гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан машин, тоног төхөөрөмж, түүний эдийн засгийн дундаж үнэлгээ:



- Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг хамгийн их үйлдэгдэж буй Сэлэнгэ аймгийн шүүхээр 2019-2021 онд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.2 дугаар зүйлд заасан гэмт хэргийн шийдвэрлэсэн байдалд дүн шинжилгээ хийхэд:

2019 онд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан 19 эрүүгийн хэрэг шийдвэрлэгдсэн

бөгөөд үүнээс 11 шүүгдэгчийг 1-2 жилийн хугацаагаар тэнссэн, 8 шүүгдэгчид 5.400-6.000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял оногдуулжээ. 19 хэрэгт гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан тээврийн хэрэгсэл болон алт угаах тоног төхөөрөмжийн үнийг шүүгдэгч нараас гаргуулж, улсын орлогод оруулахаар шийдвэрлэсэн бол 1 хэрэгт нэмж байгаль орчинд учирсан хохирол болон нөхөн сэргээлтийн төлбөрийг гаргуулахаар шийдвэрлэжээ.



2020 онд анхан шатны шүүх нийт 14 хэрэг шийдвэрлэсэн бөгөөд үүнээс 7 шүүгдэгчийг 1-2 жилийн хугацаагаар тэнсэж, 6 шүүгдэгчид 5.400-6.000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял, 1 шүүгдэгчийг 1 жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэжээ. 13 хэрэгт гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан тээврийн хэрэгсэл болон техник хэрэгслийн үнийг шүүгдэгчээс гаргуулж, улсын орлогод оруулахаар шийдвэрлэсэн бол үүнээс 1 хэрэгт байгаль орчинд учирсан хохирлын нэмж гаргуулахаар шийдвэрлэсэн байна. Аймгийн давж заалдах шатны шүүх 1 жилийн хугацаагаар хорих ял оногдуулсныг 1 жилийн хугацаагаар тэнссэн өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн.

2021 онд анхан шатны шүүх 7 хэрэг шийдвэрлэсэнээс 2 шүүгдэгчийг 1 жилийн хугацаагаар тэнсэж, 5 шүүгдэгчид 5.400-6.000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял оногдуулжээ. 5 хэрэгт гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан тээврийн хэрэгсэл болон техник хэрэгслийн үнийг гаргуулж, улсын орлогод оруулахаар шийдвэрлэсэн бол 4 хэрэгт байгаль орчинд учирсан хохирлын дүнг, 4 хэрэгт нөхөн сэргээлтийн төлбөрийг гаргуулахаар шийдвэрлэсэн байна. Мөрдөн шалгах ажиллагааны явцад 4 хэрэгт байгаль орчинд учирсан хохирол болон нөхөн сэргээлтийн төлбөр төлөгдсөн байна. Давж заалдах шатны шүүхээс 1 хэрэгт байгаль орчинд учирсан хохирлын дүнг багасгасан, 1 хэрэгт гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан тээврийн хэрэгслийн үнийг нэмж гаргуулахаар тус тус өөрчлөлт оруулж шийдвэрлэсэн байна.

Тус аймаг дахь Сум дундын анхан шатны шүүх 2019 онд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт засан 19 эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэсэнээс 16 нь Ерөө сум, 3 нь

Хүдэр суманд үйлдэгдсэн байна.

Дээрх 19 хэрэгт Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.5 дугаар зүйлд зааснаар гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан тээврийн хэрэгсэл, эксковатрын үнэ нийт 505.805.300 төгрөгийг гаргуулж улсын орлого оруулахаар шийдвэрлэсэн бол 2 хэрэгт нийт 12 грамм алт, 1 хэрэгт гар аргаар хийсэн 600.000 төгрөгийн үнэ бүхий алт угаах төхөөрөмжийн үнэ, 1 хэрэгт гитаран буу 1 ширхэг, 1 хэрэгт экологийн хохирол 3.761.827 төгрөг, нөхөн сэргээлтийн 5.461.330 төгрөгийг тус тус гаргуулан улсын орлогод оруулахаар, 1 хэрэгт 110.000.000 төгрөгийн үнэ бүхий ашигт малтмал олборлоход ашигладаг “мини драг” төхөөрөмжийг улсын орлогод оруулахаар тус тус шийдвэрлэжээ.

ХУУЛЬ БУСААР АШИГТ МАЛТМАЛ ХАЙХ, АШИГЛАХ, ОЛБОРЛОХ ГЭМТ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХЭД ТУЛГАМДСАН АСУУДАЛ

1. Хохирлын үнэлгээ хийх асуудал

Дээр дурдсан “Байгаль орчинд учруулсан хохирол”, “экологи эдийн засгийн үнэлээ”, “байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөр” гэх мэт ойлголтуудыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зөв ойлгож, хэрэглэх шаардлагатай байна.

Судалгаанаас үзэхэд байгаль орчинд учруулсан хохирлын үнэлгээ хийж байгаа боловч дүгнэлтэд “ЯАГААД?” гэдэг үндэслэлээ дүгнэхгүй байна. Ямар үндэслэлээр ийм үнэлгээ гарсан, ямар учраас үнэлгээг бууруулсан эсхүл ихэсгэсэн байгааг тодорхойлохгүй байна.

Мөн үнэлгээг хуульд заасан журмын дагуу хийхгүй комиссын гишүүд өөрсдийн үзэмжээр, илт доогуур үнэлж “ХЭВШСЭН”, ийнхүү “бууруулан үнэлсэн” талаар тайлбар өгөхгүй байгаа нь хохирлын хэмжээг бодит бусаар тогтоох,



байгаль орчин “улам хохирох” эрсдэл үүсэж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн үзэл баримтлалаас дүгнэхэд:

- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ач холбогдолтой гэж үзсэн объектын шинж байдал, хохирлын хэмжээнд хамаарах баримт сэлтийг мөрдөгч бэхжүүлж, нотлох баримт болгох,
- Боломжтой гэж үзвэл мөрдөгч / мэргэшсэн/ магадлагаа хийх, харин хэргийн оролцогч хүсэлт гаргасан буюу шаардлагатай гэж үзвэл шинжээчийн дүгнэлтээр хохирлын хэмжээг тогтоох, ийнхүү тогтоохдоо хохирлыг “бүрэн тогтоох” талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан шаардлагыг биелүүлэх,
- Эдгээрийг үндэслэн шүүх хохирлыг эцэслэн тогтоох, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирлыг барагдуулах ажлыг хэвшүүлэх ёстой. Өөрөөр хэлбэл байгаль орчинд учруулсан хохирлыг тэргүүн ээлжид барагдуулах, хор уршиг арилсны дараа ял хариуцлагыг хөнгөрүүлэх, гэм бурууд тохирсон хариуцлагыг хүлээлгэх үзэл хандлага, тогтолцоог бий болгох нь зүйтэй.

2. Гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан эд зүйлийн шийдвэрлэлт

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.5 дугаар зүйлд эд хөрөнгийн шинжтэй хууль зүйн хариуцлага буюу хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг хуульчилсан бөгөөд гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналга нь гэм буруутай этгээдийн өмчлөлд байсан нь тогтоогдсон тохиолдолд түүнийг хураан авах, гэмт хэргийн хохирол

нөхөн төлөхөд зарцуулах, хэрэв хууль ёсны дагуу хийгдсэн хэлцлийн үндсэн дээр бусдын өмчлөлд шилжсэн бол шүүх тухайн эд зүйлийг үнэлж гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох, хураан авахыг хуулиар хориглоогүй хөрөнгө, орлогоос албадан гаргуулахаар заасан.

Гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан бусдын өмчлөлийн техник, хэрэгслийн үнэлгээ нь гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлын хэмжээнээс их байсан ч гэм буруутай этгээдээс ашигласан эд зүйлийн үнэлгээтэй тэнцэх хэмжээний мөнгөн дүнг гаргуулдаг.²

Гэмт хэрэг үйлдэж байгаа этгээд нь машин, техник төхөөрөмжийг урьдчилан бусдын нэр дээр шилжүүлж, эсхүл бусдаас түрээсэлсэн мэтээр зохиомол байдлыг бий болгон техник, хэрэгслийг хураалгахгүйгээр авч үлдэж, дахин гэмт хэрэг үйлдэхдээ ашиглаж байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн гаралт өсөн нэмэгдэх гол шалтгаан нөхцөл болж байна.

Тухайлбал, шүүх хууль бусаар ашигт малтмал ашиглах, олборлох гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан бусдын эзэмшлийн техник хэрэгслийн үнэлгээтэй тэнцэх хэмжээний мөнгөн дүнг шүүгдэгчээс гаргуулахаар шийдвэрлэсний дагуу мөнгийг улсын орлогод тушаасны дараа машин, тоног төхөөрөмжөө буцаан авч дахин гэмт хэрэг үйлдэх тохиолдол гарсаар байгаа юм. Битүүмжилсэн машин, техник төхөөрөмжийг эрх бүхий байгууллагаас хянах боломжгүй, зориулалтын хашаа, агуулах сав дутмагаас өмчлөгч, эзэмшигч нарт нь буцаан өгдөг, том оврын машин, техникийг зөөвөрлөх эдийн засгийн нөөц бололцоо муу, ашигт малтмалын олборлолтод ашиглагдаж байгаа техник

² Улсын Дээд шүүхийн 2021 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 207 дугаартай тогтоол.



хэрэгслийн дугаар, бүртгэлд тавих хяналт сул зэрэг нь үүнд нөлөөлдөг.

Түүнчлэн, орон нутагт техник төхөөрөмжийн үнэлгээг үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл бүхий нэг компаниар дагнан хийлгэх нь түгээмэл байдаг бөгөөд техник хэрэгслийн үнэлгээний хувьд үнэлгээний дүн зөрүүтэй, ашиг сонирхлын зөрчилтэй буюу маш бага хэмжээгээр үнэлгээ хийснийг гэм буруутай этгээдээс гаргуулдаг практик тогтсон байна.

Иймд, хууль бусаар уул уурхайн үйл ажиллагаа явуулсан гэмт хэргийг хянан шийдвэрлэхдээ гэмт үйл ажиллагаандаа техник хэрэгсэл, машин тоног төхөөрөмж ашигласан нь тогтоогдсон тохиолдолд тэр нь хэний өмчлөлд байгаагаас үл хамаарч хураан авч, улсын орлого болгох зохицуулалтыг бий болгох шаардлагатай.

Ингэснээр, тоног төхөөрөмжийг “илт бага хэмжээгээр үнэлдэг” явдал багасч, өмчлөгч, эзэмшигч нь гэм буруутай этгээдээс хохирлоо нэхэмжлэх хууль зүйн боломжтой тул зах зээлийн үнэлгээгээр үнэлүүлэх буюу аль болох өндрөөр үнэлүүлэх, техник төхөөрөмжийн үнэлгээнд ашиг сонирхлын зөрчил бий болохоос урьдчилан сэргийлэх, техник, тоног төхөөрөмж түрээслүүлэгч иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа илүү хариуцлагатай болох, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил дахин үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэхэд өндөр үр нөлөөтэй юм.

3.Ашигт малтмал бол нөхөн сэргээгддэг баялаг биш.

Монгол Улсын эдийн засгийн тулгуур болсон уул уурхайн салбарын эрх зүйн орчин, түүний тулгамдсан асуудал, ялангуяа хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн шийдвэрлэлт, хянан шийдвэрлэж буй байдал, сүүлийн

жилүүдэд энэ төрлийн гэмт хэргийн гаралт нэмэгдсээр байгаа нь төрөөс энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх бодлогыг эргэн харах зайлшгүй шаардлагыг бий болгож байна. Энэ төрлийн гэмт хэрэгт оногдуулж буй ял шийтгэл, эрүүгийн хариуцлагын тогтолцоог сайжруулах зүй ёсны шаардлага бий болж байна.

4.Зөвхөн ашигт малтмал хууль бусаар хайх олборлох гэмт хэргээс гадна авлига, мөнгө угаах, хөдөлмөрийн мөлжлөг, хөдөлмөр хамгааллын аюулгүй байдлыг зөрчигдсөний улмаас хүний амь нас, эрүүл мэнд хохирох гэх мэт гэмт хэргүүд давхар зүйлчлэгдэх явдал цөөнгүй байх тул хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлж байгаа мөрдөгч, прокурор, шүүгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх шаардлага тавигдаж байна.

5. Энэ төрлийн гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдлаас дүгнэлт хийхэд шүүхээр тухайн шүүгдэгчид Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэж Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.5 дугаар зүйлд заасан “хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ”-г мөн хэрэглэсэн байх боловч 7.3 дугаар зүйлд заасан “үүрэг хүлээлгэх арга хэмжээ”-г хэрэглээгүй байна. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.3 дугаар зүйлд заасан албадлагын арга хэмжээг хэрэглэн шүүгдэгч нарт “гэмт хэргийн хор уршгийг арилгах талаар арга хэмжээ авах”, “тодорхой ажил, үүрэг гүйцэтгэх” албадлагын арга хэмжээний хүрээнд тодорхой хугацаа тогтоон байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлөх, байгаль орчны нөхөн сэргээлтийг тодорхой хугацаанд хийж гүйцэтгэхийг даалгах зэрэг албадлагын арга хэмжээг хэрэглэх нь эрүүгийн хариуцлагын зорилгыг хангахад чухал ач холбогдолтой болно.



б. Байгаль экологид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой харилцаа нь иргэний эрх зүй дэх гэм хор учруулснаас үүсэх хариуцлагатай холбогдоно. Гэвч, гэм хорын зохицуулалтын урьдчилсан нөхцөл нь хуульд зааснаар бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд санаатай

болон болгоомжгүй хэлбэрээр халдсаныг шаардах бөгөөд байгаль орчинд хохирол учирсан нь энэхүү урьдач нөхцөлийг хангах эсэх, байгаль орчинд учруулсан гэм хорын хохирлыг Иргэний хууль дахь гэм хорын зохицуулалттай шууд хэрэглэх эсэх нь маргаантай байна.

**ХУУЛЬ БУСААР МОД БЭЛТГЭХ ГЭМТ ХЭРГИЙН
ШҮҮХИЙН ПРАКТИК, ХУУЛЬЧЛАГДСАН БАЙДАЛД ХИЙСЭН
ДҮН ШИНЖИЛГЭЭ**

**ANALYSES IN JUDICIAL PRACTICE AND CURRENT CRIMINAL
CODE OF MONGOLIA REGARDING ILLEGAL
LOGGING CRIME**

Баасандоржийн БАТБАЯР¹

- I. Оршил
- II. Хуулийн дагуу мод бэлтгэх процесс /ЭХ-д заасан агуулгаар/
- III. Мод бэлтгэх зөвшөөрлийн талаар ойлголт, түүний төрөл /ОтХ болон ЭХ-д заасан агуулгаар/
- IV. Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргээс сэргийлэх, илрүүлэх тогтолцоо
- V. Шүүхийн практик ба УДШ-ийн 64-р тогтоолоор хийсэн “Казуаль тайлбар” түүний практик нөлөөлөл
- VI. Санал, дүгнэлт
- VII. Ном зүй

¹ УДШ-ийн дэргэдэх ШССМХ-ийн Эрүүгийн эрх зүйн секторын судлаач



ХУУЛЬ БУСААР МОД БЭЛТГЭХ ГЭМТ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ПРАКТИК, ХУУЛЬЧЛАГДСАН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Б.БАТБАЯР. ШССМХ-ийн Эрүүгийн эрх зүйн секторын судлаач

Товчлол

Энэхүү өгүүллээр Эрүүгийн хуулийн /2015 онд батлагдсан шинэчилсэн найруулга/ 24.6 дугаар зүйлд УДШ-ээс 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 64 дугаартай тогтоолоор “Казуаль тайлбар” хийсний дараа шүүхийн практик болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд нөлөөлж буй нөлөөлөл, тус гэмт хэргийн хуульчлагдсан байдал болон дээрх тайлбарын үндэслэлт байдалд дүн шинжилгээ хийж, санал дүгнэлтээ танилцуулсан.

Түлхүүр үг

Мод бэлтгэх зөвшөөрөл, эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ, казуаль тайлбар, шүүхийн практик, хууль дээдлэх зарчим, эрх зүйн нигилизм.

I. Оршил

Манай улсын нийт нутаг дэвсгэрийн 8 орчим хувийг ой мод эзэлдэг бөгөөд газар нутгийн дийлэнх хэсэг нь цөл, хээрийн бүсээс бүрддэг, хуурай уур амьсгалтай тул ой модны нөхөн сэргэх чадвар сул, шатамхай чанар нь чийглэг дулаан уур амьсгалтай бусад газраас өндөр байдаг.

Ойн экологийн ач холбогдол нь ургамал, амьтны аймгийн амьдрах

тааламжтай орчин, газрын хөрсийг эвдрэлээс хамгаалах, уур амьсгалыг зөөлрүүлэх, усны ундарга, нөөцийг нэмэгдүүлэх, агаарыг хүчилтөрөгчөөр сэлбэж цэвэршүүлэх шим мандлын гол хүчин болдогт оршино.

Аливаа байгалийн баялаг нь эдийн засгийн эргэлтэд орж, үйлдвэрлэлийн процесст ашиглагдах үед түүний тоо хэмжээ эрс буурдаг зүй тогтолтой. Иймд түүний нөхөн төлжих, сэргэх боломжийг бүрдүүлсэн хамгаалах тогтолцоог бий болгож, түүнд хяналт тавих ёстой.

Энэ зорилгод үйлчилж, дэлхийн ихэнх улс орнууд ой, модыг Эрүүгийн хуулиар хамгаалалтдаа авсан байдаг. Манай улсын хувьд энэ жишгийг баримталсан бөгөөд ой, модыг сүйтгэхийг болон түүнийг үйлдвэрлэлийн процесст ашиглах зорилгоор хуульд заасан зөвшөөрөлгүйгээр бэлтгэхийг гэмт хэрэгт тооцож эрүүжүүлсэн.

Гэвч дээрх гэмт хэргийн диспозиц хэсэгт заасан нэр томъёоны ойлгомжгүй байдал нь шүүхийн практикт нөлөөлж, энэ байдлыг залруулах оролдлогын хүрээнд УДШ-ээс хийсэн “казуаль тайлбар”-ын үндэслэлт байдал, үр нөлөөнд дүн шинжилгээ хийж, үүсээд буй бэрхшээлтэй нөхцөл байдлыг гэтлэх арга замын талаар өөрийн саналыг дэвшүүллээ.



II. Хуулийн дагуу мод бэлтгэх процесс /ЭХ-д заасан агуулгаар/

Мод бэлтгэх процессын тодорхой үе шатууд зохих зөвшөөрөлгүй явагдсан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан байдаг. Тэгвэл гэмт хэрэг үйлдхээс зайлсхийхийн тулд хуулиар зөвшөөрөгдсөн процессын талаар мэдлэгтэй байх шаардлагатай. Хуулийн дагуу мод бэлтгэх процесс нь дараах үе шатуудыг дамждаг. Үүнд:

- Зөвшөөрөл авах; (Ойн ангитай гэрээ байгуулах, мод бэлтгэх эрхийн бичиг авах)
- Мод бэлтгэх эрхийн бичигт заасны дагуу мод бэлтгэх¹ (тоо хэмжээ, арга, газар)
- Эрхийн бичигт заасны дагуу бэлтгэсэн модыг өөр аймаг, сум, хот, суурингийн хооронд тээвэрлэх, худалдахаар бол гарал үүслийн гэрчилгээг ойн ангиас заавал авна²
- Гарал үүслийн гэрчилгээнд тээвэрлэлт хийх явцад хяналтын цэг дээрх эрх бүхий албан тушаалтнаар тэмдэглэгээ хийлгэх
- Ийм тэмдэглэгээ хийсэн гарал үүслийн гэрчилгээтэй модыг худалдах, худалдан авах зэрэг болно.

Дээр дурдсан дараалал, журмыг зөрчсөнөөр эрүүгийн хариуцлага хүлээх үр дагавартай.

III. Мод бэлтгэх зөвшөөрлийн талаар ойлголт, түүний төрөл /ОтХ болон ЭХ-д заасан агуулгаар/

Ойн тухай хуулийн холбогдох заалтуудыг нарийвчлан шалгавал ЭХ-д заасан “зөвшөөрөл” гэх нэр томъёоноос агуулгын хувьд зөрүүтэй байдал ажиглагдаж байгаа юм.

¹ Ойн тухай хуулийн 33, 34 дүгээр зүйл.

² Ойн тухай хуулийн 34.4 дүгээр зүйл.

Тухайлбал Ойн тухай хуулийн 34-р зүйлд зааснаар “мод бэлтгэх эрхийн бичиг”, “гарал үүслийн гэрчилгээ”-г хамтад нь ойлгохоор хуульчилсан болох нь тодорхой харагддаг. Гэтэл ЭХ-д “зөвшөөрөлгүйгээр” мод бэлтгэсэн, гарал үүслийн гэрчилгээгүйгээр мод, модон материалыг бэлтгэсэн, тээвэрлэсэн, худалдсан, худалдан авсан гэх байдлаар хуульчилснаар нэр томъёоны хувьд ойлгомжгүй, зөрчилдөөнтэй нөхцөл байдлыг бий болгосон байдаг. Үүнээс улбаалан шүүхээс төсөөтэй тохиолдлуудыг өөр өөр байдлаар шийдвэрлэх явдал гарсан бөгөөд энэ нь энэхүү өгүүлэлд дурдаж буй УДШ-ийн 64 дүгээр тогтоолын “Казуаль тайлбар” гарах үндэслэл болсон.

Дээр дурдсанчлан мод бэлтгэх зөвшөөрөл нь “мод бэлтгэх эрхийн бичиг”, “гарал үүслийн гэрчилгээ”-нээс бүрдэх тул ЭХ-ийн 24.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “зөвшөөрөлгүйгээр” гэх объектив талын шинжийг “мод бэлтгэх эрхийн бичиггүйгээр” гэж ойлгох нь зохистой юм. Ингэснээр эрхийн бичиггүйгээр мод бэлтгэх нь гарал үүслийн гэрчилгээгүйгээр мод, модон материалыг бэлтгэх, тээвэрлэхтэй ижил эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэх хууль бус үйлдэл гэсэн агуулгыг тодотгоно.

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А-153 дугаартай тушаалаар батлагдсан “Гарал үүслийн гэрчилгээ олгох, хяналт тавих журам” (цаашид журам гэх)-д зааснаар мод бэлтгэх эрхийн бичиг /цаашид “эрхийн бичиг” гэх/ гэж иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад Ойн тухай хуулийн 34.1-д заасны дагуу олгосон ойн нөөц ашигласны төлбөр төлснийг баталгаажуулсан баримт бичгийг; мод, модон материалын



гарал үүслийн гэрчилгээ /цаашид “гарал үүслийн гэрчилгээ” гэх/ гэж мод, модон материалыг нийслэл, өөр аймаг, сум тэдгээрийн хооронд тээвэрлэх, худалдахад ойгоос зохих журмын дагуу бэлтгэсэн мод болохыг гэрчилж Ойн тухай хуулийн 34.1, 34.4-д заасны дагуу олгосон баримт бичгийг тус тус ойлгохоор заажээ.

Үүнээс үзвэл мод бэлтгэх эрхийн бичиг нь гэрээний үүргээ биелүүлж, төлбөр төлсөн болохыг баталгаажуулахын сацуу гэрээнд заасан мод бэлтгэх хэмжээ, аргыг тодорхойлон заах ач холбогдол бүхий баримт бичиг бол, гарал үүслийн гэрчилгээ нь тухайн мод, модон материалын хууль ёсоор бэлтгэгдсэн болохыг тээвэрлэх, худалдах, худалдан авах тохиолдлуудад гэрчлэх ач холбогдолтой юм.

Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн хуульчлагдсан байдлын талаар манай улстай эрх зүйн ижил бүлд хамаарах 10 улсын³ ЭХ-ийг судалж үзэхэд Бүгд найрамдах Болгар улсын Эрүүгийн хуулийн 235 дугаар зүйлд заасан гэмт хэргийн диспозиц нь манай Эрүүгийн хуулийн 24.6 дугаар зүйлд заасантай ихээхэн төсөөтэй хуульчлагдсан байв. Сонирхолтой нь хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийг Болгар улсын ЭХ-д “Эдийн засгийн гэмт хэрэг” бүлэгт хуульчилсан бол бусад улсуудын хувьд нийтлэг байдлаар байгаль орчны буюу хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэгт хамааруулж, хууль бусаар мод бэлтгэх бус ой, мод сүйтгэх гэсэн агуулгаар хуульчилжээ.

IV. Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргээс сэргийлэх, илрүүлэх тогтолцоо

Тус гэмт хэргээс сэргийлэх тогтолцооны байнгын ажиллагааг хангаж, төрийн захиргааны болон тусгай байгууллагын хяналт тавих боломжийг бодитоор олгодог гол хэрэгсэл нь “гарал үүслийн гэрчилгээ”⁴ юм. Тухайлбал эрхийн бичгийн дагуу мод бэлтгэсэн иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж нь тухайн бэлтгэсэн модыг тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэрээс өөр байршилд шилжүүлэн тээвэрлэх шаардлага гарсан бол заавал гарал үүслийн гэрчилгээ авна. Уг гэрчилгээг “ойн анги” гэх төрийн захиргааны чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллага олгох бөгөөд ийнхүү олгохдоо тээвэрлэж хүрэх газрыг лавлаж, уг газарт хүрэхдээ аль замаар явахыг нарийвчлан заана.

Учир нь ойн ангийн мэргэжилтэн нь гагцхүү хяналтын цэгээр дамжин өнгөрөх төв замыг зааж өгдөг. Ингэснээр гарал үүслийн гэрчилгээнд хяналтын цэг дээр ажиллаж буй байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын байцаагч, цагдаагийн албан хаагчид хяналт тавьж, зохих тэмдэглэгээг хийж, өөрт үлдэх хэсгээ гэрчилгээний хэсгээс таслан авч хадгалдаг. Үүнээс өмнө гарал үүслийн гэрчилгээг ойн ангиас анх олгохдоо цахим бүртгэлд олгосон гарал үүслийн гэрчилгээний сери дугаар болон бусад мэдээллийг оруулдаг. Уг цахим бүртгэлд оруулсан мэдээллийг үндэслэн хяналтын цэг дээр шалгагдаж буй гарал үүслийн гэрчилгээг хуурамчаар үйлдсэн эсэхэд хяналт тавих боломжтой болох юм.

Ойн тухай хуульд зааснаар жил бүр ойн менежментийн төлөвлөгөө, тухайн орон нутгийн засаг даргын саналыг үндэслэн тухайн жилд бэлтгэх нийт модны хэмжээг төрийн захиргааны



төв байгууллагаас баталдаг бөгөөд уг хэмжээнд үндэслэн мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээг мөн хэвлэж, тухайн орон нутгийн ойн ангиудад тараадаг. Ийнхүү мод бэлтгэх хүсэлтэй иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгжүүд ойн ангитай гэрээ байгуулж, төлбөрөө төлснөөр эрхийн бичиг болон гарал үүслийн гэрчилгээг ойн ангиас хүлээн авах бөгөөд эдгээр бүртгэгдсэн мэдээллийг ойн анги нь харьяалах Байгаль орчны газарт улирал бүрийн эхний сарын 10-ны дотор тайлан болгож явуулдаг. Байгаль орчны газар нь ойн ангиудаас хүлээн авсан тайланг төрийн захиргааны төв байгууллагад тухайн сарын 15-ны өдрийн дотор явуулдаг.

Тус тайланд үндэслэн төрийн захиргааны төв байгууллага нь улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд ямар хэмжээний мод бэлтгэх зөвшөөрөл олгогдсонтой танилцах бөгөөд шаардлагатай бол бодитоор үзлэг хийх замаар зөвшөөрөлд дурдсан хэмжээний модноос илүү мод хууль бусаар мод бэлтгэгдсэн эсэхэд бодит хяналт тавих боломжтой.

V. Шүүхийн практик ба УДШ-ийн 64-р тогтоолоор хийсэн "Казуаль тайлбар" түүний практик нөлөөлөл

Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэгт хамгийн сүүлд 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдөр өөрчлөлт орсон бөгөөд энэ үеэс 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийг хүртэл хяналтын шатны шүүхээр эцэслэгдэн шийдэгдсэн нийт 20 хэрэг www.shuukh.mn сайтад байршсан байна. Ойролцоогоор 5 жилийн хугацаанд төлөвшөн тогтсон шүүхийн практикт хамгийн олон янзаар шийдэгдэж ирсэн тохиолдол нь "гарал үүслийн гэрчилгээгүйгээр мод, модон материалыг ... тээвэрлэсэн" үйлдэл байв. Уг үйлдлийг

хэлзүйн тайлбарын хувьд авч үзвэл гарцаагүй эрүүжүүлсэн үйлдэл болох нь тодорхой харагдана.

Гэвч ЭХТА-ийн 24.6 дугаар зүйлд заасан "зөвшөөрөлгүйгээр" гэх гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын шинж нь уг гэмт хэргийн диспозицийг бүхэлд нь хэрэглэхэд төвөгтэй болгосон хэмээн үзэж байна. Зүй нь бол "зөвшөөрөлгүйгээр" биш "эрхийн бичиггүйгээр" гэж томьёолвол уг гэмт хэргийг зүйлчлэхэд ямар нэгэн маргаан үүсэхгүй юм.

Дээрх байдлаас үүдэн Улсын дээд шүүхээс анх удаа 2019 оны 05 дугаар сарын 10-ны өдөр 206 дугаартай тогтоолоор "хууль ёсоор бэлтгэгдсэн модыг гэрчилгээгүй худалдсан, худалдан авсан, тээвэрлэсэн тохиолдолд гэмт хэрэг болохыг тодорхойлох шаардлагатай" гэсэн агуулга бүхий *obiter dicta*⁵ хийсэн байдаг.

Энэ дагуу 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 64 дүгээр тогтоолд "ЭХ-ийн 24.6 дугаар зүйлд заасан хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн диспозицид заагдсан гарал үүслийн гэрчилгээгүйгээр, мод модон материалыг тээвэрлэсэн үйлдлийг гэмт хэрэгт тооцох эсэх асуудлыг шийдвэрлэхдээ тухайн мод, модон материал нь ойд зөвшөөрөлгүйгээр бэлтгэгдсэн эсэхийг зайлшгүй давхар шалгаж, зохих зөвшөөрлийн дагуу ойд бэлтгэгдсэн эсэхийг зайлшгүй давхар шалгаж, зохих зөвшөөрлийн дагуу ойд бэлтгэгдсэн, эсхүл зохих зөвшөөрөлгүйгээр, хууль бусаар ойд мод бэлтгэсэн үйлдэлтэй шалтгаант холбоогүй болох нь тогтоогдвол тухайн мод, модон материал тээвэрлэсэн үйлдлийг гэмт хэргийн шинжгүй гэж

⁵ Хэргийн шийдвэрлэх үндэслэл болоогүй боловч дурдах шаардлагатай гэж үзэж шийдвэрт тусгасан шүүх бүрэлдэхүүний сэтгэгдэл.



үзнэ” гэсэн “казуаль тайлбар”-ыг хийсэн юм. Уг тайлбар нь мөн тухайн хэргийн хувьд *ratio decidendi*⁶ болж, шүүгдэгчийг цагаатгасан.

Улмаар УДШ-ийн 64-р тогтоол гарсны дараа шүүхийн практикт тээвэрлэсэн модны гарал үүслийн гэрчилгээтэй байсан эсэхийг төдийлэн авч үзэхгүй, гагцхүү эрхийн бичигтэйгээр мод бэлтгэсэн эсэхэд төвлөрч нотлох баримтыг үнэлэн хэргийг шийдвэрлэх хандлага бүх шатны шүүхүүдэд түгээмэл ажиглагдах болсон.

Санал, дүгнэлт

Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн диспозицид заасан нэр томъёоны оновчгүй байдлаас үүдэлтэйгээр төсөөтэй тохиолдлуудыг олон янзаар шийдвэрлэж буй шүүхийн практикыг УДШ-ээс хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор залруулах шаардлагатай болсон. Ингэхдээ ЭХ-д заасан эрүүгийн хариуцлага хүлээх үр дагавар бүхий гэмт үйлдлийг УДШ хэрэг маргааныг шийдвэрлэх замаар “казуаль тайлбар” хийж эрүүгүйжүүлсэн. Үүний үр дүнд хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн объектив талд хамаарах гэрчилгээгүйгээр мод, модон материал тээвэрлэх үйлдэлд эрүүгийн болон бусад хуулиар хариуцлага хүлээлгэх боломжгүй болж байна.

Учир нь Зөрчлийн тухай хууль нь 100 хувь бланкет диспозиц бүхий бүтэцтэй хууль тул холбогдох салбарын хуульд тухайн үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчилд тооцсон эсэхийг шалгаж үзэх учиртай. Гарал, үүслийн гэрчилгээгүйгээр мод, модон материалыг тээвэрлэх талаар хориглосон заалт ойн тухай хуульд байхгүй. Харин энэ үйл ажиллагааг процедурын хувьд Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А-153 дугаар

тушаалаар баталсан “Гарал үүслийн гэрчилгээ олгох, хяналт тавих журам”-аар зохицуулдаг.

Тус журмын дагуу хууль бусаар мод бэлтгэсэн гэж үзэх тохиолдлыг тодорхойлон заасан байдаг. Гэвч Зөрчлийн тухай хуулиар хэм хэмжээний актын дагуу бус зөвхөн хуульд заасан тохиолдолд хариуцлага хүлээлгэхээр тодорхой заасан тул тус журмыг зөрчсөн үндэслэлээр Зөрчлийн тухай хуулиар хариуцлага оногдуулах боломжгүй юм. Нөгөөтэйгүүр Ойн тухай хуульд тус үйлдлийг хориглон зохицуулаагүй явдал нь хууль зүйн техникийн хувьд гарцаагүй зөв шийдэл болсон. Учир нь ЭХ-иар эрүүжүүлсэн үйлдлийг давхар зөрчилд тооцох нөхцөл байдлыг үүсгэж болохгүй билээ.

Мөн ЭХ-ийн 1.2 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Энэ хуулийн нэр томъёо, ухагдахууныг тайлбарлахад захиргааны хэм хэмжээний актыг ашиглаж болно” гэж зааснаас үзвэл тус журмын заалтыг баримтлан хариуцлага оногдуулахаас илүүтэй ЭХ-д заасан объектив талын шинжийг тайлбарлахад ашиглах боломжтой байна.

Ийнхүү дээрх тайлбараар ЭХ-д заасан гэмт үйлдлийг эрүүгүйжүүлсний улмаас хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэгтэй тэмцэх төрийн тусгай болон захиргааны байгууллагын хөгжүүлэн, бэхжүүлсэн тогтолцооны байнгын ажиллагааг хангах гол хэрэгсэл болсон гарал үүслийн гэрчилгээ ач холбогдлоо алдаж, үүнтэй холбоотой холбогдох хэм хэмжээний хэрэгжилтийн хүрээнд эрх зүйн нигилизм тогтож, хууль дээдлэх ёс алдагдах бодит эрсдэл бий болоод байна.

УДШ-ийн “казуаль тайлбар”-ын дагаж мөрдөх шинж нь *de facto* буюу заавал дагаж мөрдөх шинжийг

⁶ Хэргийн шийдвэрлэх үндэслэл.



агуулдаггүй тул үүнийг хүчингүй болгох агуулга бүхий ямар нэгэн шинэ хууль зүйн баримт бичиг шаардлагагүй. Иймд Эрүүгийн шүүхүүд ЭХТА-ийн 24.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн диспозицид заасан объектив шинж бүхий үйлдлийг үгийн шууд утгын дагуу тайлбарлан хэрэглэснээр үүсээд буй энэ нөхцөл байдал арилна гэсэн саналыг дэвшүүлж байна.

Ном зүй

I. Эрх зүйн эх сурвалж

Монгол Улсын Үндсэн хууль 1992

Эрүүгийн хууль 2015

Ойн тухай хууль 2012

Зөрчлийн тухай хууль 2017

Бүгд Найрамдах Болгар Улсын Эрүүгийн хууль 1968

Гарал үүслийн гэрчилгээ олгох, хяналт тавих журам 2013

II. Гадаад эх сурвалж

Luca Tacconi, Frances Seymour. Illegal logging: Law Enforcement, Livelihoods, and the Timber Trade., 2007.

III. УДШ-ийн тогтоол

2018.02.09 дугаар 57

2019.02.20 дугаар 82

2019.02.27 дугаар 92

2019.03.22 дугаар 135

2019.05.10 дугаар 206

2019.06.07 дугаар 278

2019.10.16 дугаар 510

2019.12.25 дугаар 06

2019.12.26 дугаар 16

2020.01.08 дугаар 22

2020.01.15 дугаар 37

2020.01.29 дугаар 64

2020.02.12 дугаар 88

2020.05.04 дугаар 215

2020.06.08 дугаар 287

2020.06.12 дугаар 296

2020.07.03 дугаар 370

2021.07.29 дугаар 73

2021.03.03 дугаар 103

2021.03.06 дугаар 177

**Abstract****ANALYSES IN JUDICIAL PRACTICE AND CURRENT
CRIMINAL CODE OF MONGOLIA REGARDING
ILLEGAL LOGGING CRIME****B.BATBAYAR**

*Researcher of the Criminal law Sector,
Judicial Training, Research and Information Institute under
Supreme Court of Mongolia*

This article introduces my analysis of the judicial casual interpretation of the Supreme Court of Mongolia by resolution No.64 on January 29, 2020 regarding the 24.6th provision of the Criminal Code of Mongolia. Furthermore, also reviews the effects of the above judicial casual interpretation on combatting activities

against illegal logging crime by executive organizations and ongoing judicial practice.

Keywords

License for logging, harvesting license, forest certification, judicial casual interpretation, judicial practice, rule of law, legal nihilism.



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАНХИМЫН ТЭРГҮҮН Ч.ХОСБАЯР

Та бүхний энэ өдрийн мэндийг хүргэе. Өнөөдрийн “Байгаль орчныг хамгаалах талаарх хэрэг маргааныг шүүхэд хянан шийдвэрлэж буй байдал, дүн шинжилгээ анхаарах асуудал” сэдвээр эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж байгаа Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнд талархал илэрхийлье. Энэ хурлын сэдэв байгаль орчинтой холбоотойгоор, өнөө цаг үед хурцаар тавигдаж байгаа асуудлыг хэрхэн хуулиар хамгаалах гэж байгаа тухай, нийт ард иргэдийн аюулгүй байдал, амь настай холбоотой асуудал яригдаж байна. Энэ талаар Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч агуулга, сэдвийг бидэнд мэндчилгээгээр хүргүүлсэн байна.

Ингээд би хоёр илтгэлтэй холбоотой товчхон дүгнэлтийг хэлье. Батзориг болон Оч шүүгч бол Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн эрүүгийн хэргийн шүүгчид байгаа. Энэ хоёр шүүгчийн маань тавьсан илтгэл бол ач холбогдол бүхий олон зүйлийг хөнджээ. Тэгэхээр хохирлын асуудлыг хөндөж байна. Хохирлыг үнэлж байгаа үнэлгээ, аргачлал хоцрогдсон байгаа нь үнэн, 1990-ээд онд бий болсон хууль, тогтоомжийн эрх зүйн орчин үйлчилж байгаа юм аа. Ялангуяа нөхөн сэргээлтэй холбоотой, бичил уурхайн орчинд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн хувьд үнэлэмж буурсан, нөхөн

сэргээхээр шаардаж буй хөрс гэдэг утгаар тэнд энгийн нүдээр харахад том хэмжээний газарт хохирол, хор уршиг учруулсан хэргүүд дээр саяны үнэлгээний жишиг гарч байна.

Сая төгрөг хүртэлх үнэлгээтэй хэрэг ховор байдаг. Энэ асуудал хоцрогдож байна гэдгийг харуулсан байна. Дараагийн сэдэв: Гэмт хэрэг үйлдэхэд ашигласан зэвсэг хэрэгсэл, эд зүйл гэдэг утгаараа энэ гэмт хэрэг үйлдэгдэхэд ашиглагдаж буй техник, тоног төхөөрөмжийг хураах асуудлыг хөндлөө. Энэ зүйл эрх зүйн зохицуулалттай холбоотойгоор өнөөдөр нэг мөр шүүхийн практикт хэрэгжиж чадахгүй байгаа асуудлууд мөнөөс мөн. Гэмт хэрэг үйлдэхэд ашиглаж байгаа экскаватор, самосвал, төхөөрөмжүүд, машинууд санаатайгаар хэн нэгний өмчлөлд байдаггүй. Өмчлөлд бүртгүүлсэн этгээд нь хуурамч өөр хүний нэр дээр байлгадаг, хуулийн зохицуулалтаар хураалгахгүйн төлөө ийм бүртгэлийн тогтолцоотой явдаг. Уг тоног төхөөрөмжийн үнийг гаргуулах асуудлаар өмчлөгч тодорхойгүй үед энэ асуудлыг шийдэж байгаа, энэ тохиолдолд тухайн гэмт хэрэг үйлдэгдэхэд ашиглагдаж, улмаар дараачийн уул уурхайн гэмт хэрэгт тэр чигтээ шилжээд гэмт хэрэг үйлдэгдэхэд ашиглагддаг.



Тиймээс энэ тал дээр эрх зүйн орчныг сайжруулах, хураах энэ арга хэмжээг гуравдагч этгээд, шударга өмчлөгчийн эрхийг хөндөхгүйгээр хэрхэн шийдвэрлэх боломжтой вэ гэдэг асуудал дээр нарийн хэлэлцүүлгийг хийж ярилцах шаардлагатай байна. Батзориг болон Оч шүүгчийн илтгэлд уул уурхайн орчинд үйлдэгдсэн гэмт хэрэгт үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээг хэрэглэх шаардлага байгаа мөртлөө шүүх хангалттай хэмжээнд энэ эрх зүйн хариуцлагын арга хэмжээг хэрэглэхгүй байгаа нь дурдагдаж байна. Тэгэхээр үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээнд экологийн гэмт хэргийн үр дүнд бий болсон хор уршгийг арилгах талаар хангалттай хэрэгжүүлэх боломж бага байгаа юм аа.

Судлаач Батбаяраас илтгэл тавилаа. Мод бэлтгэх үйл ажиллагаатай холбоотой илтгэл. Энд зөвшөөрлийн асуудлыг хөндөж байгаа нь үнэхээр чухал сэдэв мөн юм. Тусгай зөвшөөрөл, энэ эрхийн бичиг, гарал үүслийн энэ олон эрх олгосон бичгүүдийг ямар үйл ажиллагааг зөвшөөрч байгаа юм, тэр үйл ажиллагааны далайц, энэ эрхийн бичгийг аваагүй тохиолдолд эсхүл үүнийг зөрчсөн тохиолдолд бий болох хор уршгаар нь ангилж зөвшөөрөл олгож, тэр зөвшөөрлийн босго дор ангилах хэрэгтэй байгаа юм. Зөвхөн энэ мод бэлтгэх гэмт хэрэг дээр ч биш, хууль бусаар уул уурхай, ашигт малтмалыг эрэх, хайх, олборлох гэмт хэрэг дээр ч энэ байдал ажиглагддаг. Өөрөөр хэлбэл ЭХ-ийн Тусгай ангийн 24.2-т заасан энэ гэмт хэрэг маань ашигт малтмалын тухай хуулиар хамгаалагдсан харилцааг эрүүгийн горимоор хамгаалах талаар гарсан байдаг. Гэтэл яг ашигт малтмалын хуулиар зохицуулагддаггүй уул уурхай болон бичил уурхай өөр

актаар буюу Засгийн газрын тогтоолоор зохицуулагдаад явдаг. Энэ хуулийн текст нь юу гэдэг вэ гэхээр, тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал эрсэн, хайсан, борлуулсан, олборлосон бол гээд явдаг.

Гэтэл тусгай зөвшөөрлийн асуудал бол бичил уурхайд өөр зөвшөөрөл буюу нутгийн өөрөө удирдах байгууллагаас олгосон зөвшөөрлийн тогтолцоогоор энэ үйл ажиллагаа хэрэгжээд явчихдаг. Эрх зүйн ийм хийдэл оршин тогтнож байгаа учраас өнөөдөр яг уул уурхайн гэмт хэрэг хаана илүү үйлдэгдэж байна вэ гэхээр энэ бичил уурхайн орчинд шүү дээ. Бичил уурхай тусгай үйлдвэрийн технологиор олборлох боломжгүй, жижиг нөөц орд, газрууд дээр гар аргаар л олборлох харилцааг зохицуулдаг. Гэтэл том том аж ахуйн нэгжүүд бүхэл бүтэн экскаватор, тээвэрлэгч, бульдозер зэрэг томоохон аж ахуйн нэгжүүд энд орчихсон. Тэгээд сумын засаг дарга, иргэдийн хурлын төлөөллөөс олгосон зөвшөөрлийн дагуу тэнд алт болон бусад ашигт малтмалыг олборлох бүрэн хэмжээний үйл ажиллагаа явуулж байдаг, нөхөн сэргээлт хийх нэрийн дор гэж хэлж болно.

Тэхээр тэнд ЭХ-ийн зүйл, хэсэг хэрхэн ажиллах асуудал хүнд байгаа юм. Нөхөн сэргээлт хийж байгаа орчин-талбайд зөвхөн дээр дурдсан нутгийн өөрөө удирдах байгууллагаас хил хязгаарыг тогтоогоод улаан шугамыг татчихсан. Тэгэхээр магадгүй өөр аж ахуйн нэгж нөхөн сэргээлт хийх талбай дээр бусад аж ахуйн нэгж нөхөн сэргээлт хийсэн тохиолдолд эрүүгийн эрх зүйгээр хамгаалагдах уу, зөрчлийн хууль тогтоомжоор хамгаалагдах уу гэдэг нь ойлгомжгүй орчин үүссэн байгаа нь үнэн.

Энд зөвшөөрлийн систем, тогтолцоо, ямар зөвшөөрлөөр ямар үйл ажиллагааг



өгч байгаа далайцын асуудал ялгаатай байх ёстой. Зөрчлийн хуулийн хүрээлэн буй орчны эсрэг зөрчлүүдтэй холбоотой хэсгийг идэвхтэй эрх зүйн хэрэглээнд оруулах шаардлагатай байгаа. Дээд шүүхийн эрүүгийн хэргийн тогтоолын талаар яригдлаа, энд яг энэ асуудал хөндөгдөж байгаа үнэн.

Гэхдээ судалгааны үр дүн бол шүүх бүрэлдэхүүний шийтгэх тогтоолд заасан, гаргасан санаанаас бага зэрэг зөрүүтэй тусгагдсан байна. Эрүүгийн эрх зүйн, эрүүгийн хуулийн тухайн зүйл хэсгийн агуулгыг тодорхойлсон байгаа, тэгэхээр хэл зүйн тайлбараар хэрэглэх асуудал яригдаж байна, Тэнд зорилго, зорилтын тайлбар явагдаж байгаа юм. Энд ан, агнууртай холбоотой гэмт хэрэг гарч ирдэг, агнах зөвшөөрлийн дагуу агнасан амьтныг агнах дээр зөвшөөрлийн дагуу агнагдсан амьтан, зөвшөөрөгдөөгүй цаг хугацаанд агнагдах юм бол гэмт хэрэгт тооцогдоод явна. Түүнийг тээвэрлэж байгаатай холбоотой, саяны мод тээвэрлэлттэй холбоотой асуудал үүсдэг.

Зөвшөөрөлгүй ан агнасан, тээвэрлэсэн тохиолдолд гэмт хэрэг мөн, гэхдээ тодорхой хуулийн заасан хугацаанд агнаагүй ч угтаа бол зөвшөөрсөн, жишээ нь тарваганы асуудал. 3 жилээр хориглосон байлаа гэхэд, агнахыг хориглоогүй хугацаанд агначихсан тарваганы арьс нөөцлөгдчихсэн байж байгаад тээвэрлэгдсэн энэ тохиолдолд гэмт хэргийн шинж агуулахгүй ээ гэсэн тайлбарыг Дээд Шүүх хийсэн, модны хувьд ч тийм байгаа.

Зөвшөөрлийн дагуу мод бэлтгээд, тухайн байгууллага зөвшөөрлийн үндсэн дээр гарал үүслийн гэрчилгээ олгох эрхийг өөртөө шилжүүлж авах, хуулбарлан олгох, тээвэрлэх болон тэр модон материалыг хийх үүргийг хүлээдэг.

Тэр зөвшөөрлийг аваагүйгээр модыг тээвэрлэчихсэн, тусгай ойд бэлтгэхдээ зөвшөөрлийн дагуу бэлтгэчихсэн харин түгээхдээ гарал үүслийн гэрчилгээ өгдөг бол тэр тохиолдолд зөрчлөөр арга хэмжээ авах ёстой.

Зөрчлийн хуульд ЭХ-д заасан энэ бичвэрээр зөрчлийг тодорхойлдоггүй, зөрчлийн үндсэн агуулга Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэдэг шаардлагаараа дандаа ерөнхий заалттай байгаа. Өөрөөр хэлбэл мод бэлтгэх журмыг зөрчсөн бол зөрчлийн хуулийг амилуулж хэрэглэх ёстой. Ан амьтны тухайд нэн ховор амьтны эд зүйлийг тээвэрлэсэн бол эрүүгийн хариуцлага хүлээдэг ялгаатай. Хоёр илтгэл маань дээрх чухал сэдвүүдийг хөндсөн нь өнөөдөр шүүхийн практикт бэрхшээл, эргэлзээ үүсгээд байгаа энэ асуудлыг хөндсөнөөрөө ач холбогдол бүхий боллоо.

Уул уурхайн том салбарууд дээр, бичил уурхайгаас бусад салбарууд дээр алт олборлох, нөөцийг ашиглах, олборлох ийм харилцаанд бол гэмт хэргийн орчин өөр утгаар явагдах хандлагатай байна. Олон улсын экологийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн эх сурвалжуудад бол зөвхөн саяны бидний ярьсан хууль бусаар олборлох гэмт хэргээс гадна дээр нь нэмээд энэ авлигын конвенцууд, гадаадын нийтийн эрх зүйн албан тушаалтныг авлигадах гэмт хэргийг оруулан тооцдог.

Мөн үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх Палермогийн конвенц, авлигын эсрэг Нэгдсэн Үндэсний байгууллагын конвенц зэрэг нь гарцаагүй эрх зүйн олон улсын эх сурвалж болдог. Бичил уурхайн орчинд нөхөн сэргээлт хийх эрхийн төлөө өрсөлдөж байгаа дотоодын компаниуд байгаа учраас хууль зөрчигдсөн талаарх

**БАЙГАЛЬ ОРЧИНД УЧРУУЛСАН ХОХИРЛЫГ ИРГЭНИЙ
ЖУРМААР ШААРДАХ ЭРХИЙН АСУУДАЛ**

**PROCEDURAL ISSUES REGARDING CIVIL RIGHT FOR CLAIMING
DAMAGES CAUSED TO ENVIRONMENT**

С.ЭНХБАЯР¹

¹ Санхүү, эдийн засгийн их сургуулийн багш, доктор, дэд профессор.



БАЙГАЛЬ ОРЧИНД УЧРУУЛСАН ХОХИРЛЫГ ИРГЭНИЙ ЖУРМААР ШААРДАХ ЭРХИЙН АСУУДАЛ

С.ЭНХБАЯР. Санхүү, эдийн засгийн их сургуулийн багш,
доктор, дэд профессор.

Хураангуй: Дэлхий ертөнц дээр болж буй байгалийн жам ёсны үйл явдлаас гадна хүнээс байгаль орчныг хандсан аливаа үйл ажиллагаа нь эерэг болон сөрөг үр дагаварт хүргэж байна. Хүний хүчин зүйл, шинжлэх ухаан технологийн үсрэнгүй хөгжилтэй холбоотой байгаль, түүний нөөц баялагт халдах, устгах, гэмтээх зэрэг зөрчил сүүлийн жилүүдэд ихсэх хандлагатай байгаа нь эрх зүйн зохицуулалтын боловсронгуй бус байдалтай шууд холботой бөгөөд байгаль орчин учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, иргэний журмаар шаардах эрхийн эрх зүйн зохицуулалтыг өнөөгийн байдлыг судлах зайлшгүй шаардлага бий болжээ. Иргэн, төрийн бус байгууллага нь байгаль орчинд учруулсан хохирлыг шаардаж, нөхөн төлбөрийг Засгийн газрын тусгай санд байршуулах шаардлага гаргахад улсын тэмдэгтийн хураамжийг хуульд заасан хэмжээгээр төлдөг нь шаардах эрхийг хэрэгжүүлэхэд саад болох нэг нөхцөл болж байна. Мөн, байгаль орчинд учруулсан нөхөн төлбөр шаардаж байгаа иргэн, төрийн бус байгууллага нь нэхэмжлэлээ татан авах, нэхэмжлэлээсээ татгалзах явдал цөөнгүй байгаа нь анхаарал татсан асуудлын нэг байсаар байна.

Түлхүүр үг: Шаардах эрх, хохирол, улсын тэмдэгтийн хураамж, хохирлын

үнэлгээ, шаардах эрхээс татгалзах, байгаль орчинд учирсан хохирлын нөхөн төлбөр.

Дэлхийн хөгжингүй орнууд нийгмээ орон зайд зохион байгуулахдаа экологийн (хүмүүнлэгийн) шалгуурыг гол болгон хөгжил дэвшлийн ирээдүйтэй загварыг сонгох шинэ гарц хайж байна. Энэ нь байгаль, нийгмийн орон зайн харилцан үйлчлэлийн хүрээгээр улс бүрийн бодлогыг уялдуулан хөгжлийн хурдцыг сааруулахгүйгээр байгальтайгаа хэрхэн зохицон аж ахуй эрхлэх вэ гэдэг адармаатай асуудлыг зохицуулсан улс төр, нийгэм, эдийн засгийн нэгдмэл үзэл баримтлал буй болгох асуудал юм. Чухам үүнтэй холбогдон 1970-аад оны үеэс хүний ба нийгмийн экологи бүрэлдэн бий болж байгаль орчныг хамгаалах асуудал 1990-ээд оны үед дэлхий дахиныг хамарсан амин чухал асуудал болсон нь бүр НҮБ-ын хэмжээнд нийгмийн ба экологийн хөгжлийн чиглэлийг дэвшүүлэн тавихад хүргэжээ. Үүний бодит тусгал болох улс төрийн бие даасан бүрэлдэхүүн хэсэг болон улс төрийн экологийн бодлого дэвшин гарч ирсэн байна.

Монгол улсын үндэсний экологийн бодлого нь зөвхөн Монголдоо төдийгүй бүс нутаг, цаашилбал дэлхий дахинд экологийн аюулгүй байдлын тогтолцоог бүрэлдүүлэхэд чухал нөлөөтэй гэдэг



талаас нь хандах нь зүйтэй юм. Дэлхий ертөнц дээр болж буй байгалийн жам ёсны үйл ажиллагаанаас гадна хүнээс байгаль орчныг хандсан аливаа үйл ажиллагаа нь эерэг болон сөрөг үр дагаварт хүргэж байна. Монголчууд байгаль хамгаалахтай холбоотой олон зуун жилийн заншил, ёс горимтой бөгөөд байгаль хамгаалах эрх зүйн хамгаалалтаас гадна ёс заншил, өв уламжлалаар зохицуулж ирсэн. Их засаг хуулиас эхлэн өнөөдрийг хүртэл хуулиудад байгаль хамгаалах талаар эрх зүйн хамгаалалтын тогтолцоог бий болгож боловсронгуй болгож байгаа нь сайшаалтай.

Прокурорын байгууллага 2021 онд нийт 1086 хэрэгт хяналт тавьсан нь өмнөх оноос 15 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Үүнээс 725 хүнд холбогдох 531 хэргийг яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлж, гэмт хэрэг үйлдэгдсэн гэх нөхцөл байдал тогтоогдоогүй 226 хэргийн хэрэг бүртгэлтийн хааж, гэмт хэргийн шинжгүй болон хөөн хэлэлцэх хугацаа дууссан болох нь тогтоогдсон 2 хэргийг хэрэгсэхгүй болгож, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг орон нутагт 958, Нийслэлд 128 бүртгэгдсэн байна. Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн зүйлчлэлээр нь авч үзвэл Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг 425, Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг 422, Хууль бусаар ан агнах гэмт хэрэг 118 үйлдэгдсэн нь хамгийн их байна.

Хүний хүчин зүйл, шинжлэх ухаан технологийн үсрэнгүй хөгжилтэй холбоотой байгаль, түүний нөөц баялагт халдах, устгах, гэмтээх зэрэг зөрчил сүүлийн жилүүдэд ихсэх хандлагатай байгаа нь эрх зүйн зохицуулалтын боловсронгуй бус байдалтай шууд

холбон тайлбарлаж болно. Экологийн эрх зүйн сурах бичигт дүн шинжилгээ хийж үзэхэд байгаль орчинд учирсан хохирлыг иргэний журмаар шаардах үндэслэл, хуулийн зохицуулалтын талаар товчхон авч үзсэн байгаа нь учир дутагдалтай байна.

Жишээлбэл, Улсын хэмжээнд 2016 онд 14 аймгийн 61 суманд 138 удаагийн ой, хээрийн түймэр гарч, түймрийн улмаас 31,3 мянган ой, 3.2 сая га бэлчээр, нийт 3.2 сая га ой, хээрийн талбай өртөж, иргэд аж ахуйн нэгжийн өмч хөрөнгөд 1.3 тэрбум төгрөг, байгаль, экологид 10,7 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна. Уг ой, хээрийн түймрийн улмаас дөрвөн хүн нас барж, дөрвөн хүн түлэгдэж, 41 айлын гэр, байшин, 64 өвөлжөө, хашаа, 6,143 толгой мал, 6 автомашин 27,766 боодол өвс шатжээ. Эдгээр тоонуудаас харахад манай оронд зөвхөн нэг жилд гарсан ой, хээрийн түймэрт олон мянган га ой мод, бэлчээрийн чухал ач холбогдол бүхий газар нутгууд өртөн байгаль, экологид асар их хохирол учирч, иргэдийн аж амьдралд түймрийн үзүүлж буй сөрөг нөлөөлөл улам ихэссээр байгаа юм. Ой хээрийн түймэр гарах шалтгааны 96 хувь нь хүний буруутай үйл ажиллагаанаас болдогийг мэргэжилтнүүд тогтоожээ.¹ Гэтэл, 2016 онд гарсан ой хээрийн түймрийн 138 тохиолдлоос 10 тохиолдолд Цагдаагийн газраас эрүүгийн хэрэг үүсгэсэн талаар “Улсын Онцгой Комисс”-ын албан даалгаварт дурдагджээ. Зөвхөн эрүүгийн хариуцлага хүлээгээд өнгөрдөг харин хохирол нөхөн төлөх, түүнийг шаардах ажил эзэнгүй орхигдож байгаа нь байгалийн баялаг үнэ цэнэгүй устгах, мөн цаашид нөхөн сэргээлт хийхгүй байхтай холбоотой.

¹ Ой хээрийн түймрийн 96 хувь нь хүний буруутай үйл ажиллагаанаас болж гардаг (ikon.mn)



Нэг: Байгаль орчинд учруулсан хохирлын онолын үндэс

Байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөртэй холбоотой асуудал нь зөрчлийн улмаас үүсэх үүргийн зохицуулалтад хамаарах бөгөөд зөрчлийн улмаас байгаль орчинд болон хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учирсан байх объектив шинж болон гэм буруугийн субъектив шинжийг харгалзан үзэх нь чухал ач холбогдолтой.

Иргэний эрх зүйн шинжлэх ухаанд хохирол, гэм хор гэсэн нэр томъёогоор илэрхийлдэг ба хууль зүйн ном зохиол, шүүхийн практикт хохирол гэсэн нэр томъёог өргөнөөр хэрэглэдэг төдийгүй дийлэнхдээ адил утгаар ойлгодог, аль ч тохиолдолд хохирол нөхөн төлөх үүргийг агуулж байдаг гэж үзжээ.²

Хохирол /убыток, damages/ нь эрх зүйн утгаараа иргэний хэргийн хариуцагч нэхэмжлэгчид учруулсан хохирлыг барагдуулахаар олгох мөнгөн төлбөр юм. Гэм буруутай үйлдэл /эс үйлдэл/ нь гэрээний үүрэг зөрчсөн байвал хохирлыг барагдуулах зорилго нь тухайн гэрээ зохих ёсоор хэрэгжсэн тохиолдолд хүртэх байсан ашиг тусыг хохирсон талд өгөхөд оршино. Учирсан нэг гэм хорын нөхөн төлбөрт нэгээс олон төрлийн хохирол / шууд, тохиолдлын, шийтгэлийн шинж чанартай/-ын нөхөн төлбөр тогтоож болно³ хэмээн тайлбарлажээ.

Харин эрх зүйн толь бичигт "Гэмт хэргийн хор уршиг бол гэмт халдлагын улмаас нийгэм, төр, байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн Эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхолд учирсан гэм хор бөгөөд гэмт хэргийн

² Варпаховская Е.М. "Вопросы компенсаций морального вреда потерпевшему в российском уголовном судопроизводстве", Иркутск, 2004, стр 75

³ Britannika ширээний нэвтэрхий толь-6, 3642 дахь тал

онцгой үр дагавар юм"⁴ хэмээн тайлбарласан байна.

Нөхөн сэргээлтийн зорилго нь аливаа зүйлийг эрх зүйн зөрчил үйлдэгдэхээс өмнөх байдалд нөхөн сэргээх явдал юм. Нөхөн сэргээлтэд, жишээ нь хууль бусаад байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зэрэг багтана.

Нөхөн төлбөр нь эрх зүйн зөрчлийн улмаас учирсан хохирлын санхүүгийн илэрхийллээр тооцогдож байгаа мөнгөн төлбөрийг хэлэх бөгөөд олон улсын эрх зүйн нэг чухал шаардлага болох *status quo ante* сэргээн тогтоох явдал мөн.

Дэд профессор Д.Наранчимэг "Гэм хор /хохирол/ нь иргэний эрх зүйн хариуцлага үүсэх нэг нөхцөл, субъектын амин хувийн эрх болон эд хөрөнгийн эрхийг зөрчсөн явдлаар илэрдэг гээд гэм хорыг материаллаг ба материаллаг бус гэж ангилсан байна. Материаллаг гэм хор гэдэгт бодит хохирол алдагдал, олох байсан орлого, зардал ордог бол материаллаг бус /ёс суртахууны/ гэм хор нь амь нас хохирсон, эрүүл мэндийг сарниулсан, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаах зэрэг орно гээд хохирол гэдэгт үүрэг гүйцэтгүүлэгчээс гарсан зардал, эд хөрөнгийн алдагдал, үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгэсэн бол үүрэг гүйцэтгүүлэгчид зайлшгүй орох байсан орлого багтана"⁵ хэмээжээ.

Буруутай этгээд нь байгалы орчны эсрэг үйлдэл /эс үйлдэхүй/ нь гэм буруутай байх. Гэм буруу гэдэг нь тухайн этгээдээс эрх зүй зөрчсөн зан үйл / үйлдэл, эс үйлдэхүй/ ба хор уршигт харьцсан сэтгэцийн хандлага бөгөөд тухайн этгээд өөрийн зан үйл түүнтэй холбогдсон үр дүнгийн хориглогдсон / эрх зүйн эсрэг/ байдлыг ухамсарласан

⁴ С.Нарангэрэл "Эрх зүйн эх толь бичиг"

⁵ Наранчимэг Д. "Иргэний эрх зүйн үндсэн асуудал", I дэвтэр, УБ, 1999, 88-89 дэх тал



/ойлгосон/ байдаг.⁶ Доктор, профессор Т.Мөнхжаргал “Эрх зүйн шинжлэх ухаанд гэм бурууг хууль бус үйлдэл, түүний эцэст бий болох хохиролд хандах байдлаар нь санаатай ба болгоомжгүй гэж хоёр хэлбэрт хуваадаг.

Гэм хор учруулагч өөрийн үйлдлээ /эс үйлдэхүй/ хууль бус болохыг, мөн үйлдэл /эс үйлдэхүй/-ийн эцэст сөрөг үр дагавар гарахыг мэдсэн, мэдэх боломжтой байсан атлаа түүнийг зориуд хүсэж үйлдсэн сэтгэл зүйн хандлагыг гэм буруугийн санаатай хэлбэр гэнэ. Гэм хор учруулагч үйлдэл /эс үйлдэхүй/-ийнхээ хууль бус болохыг мэдсэн боловч гарах үр дагаварыг гаргуулахгүй гэж хөнгөмсгөөр найдсан, эсхүл үйлдлийнхээ хууль бус болохыг, мөн гарах үр дагаварыг урьдчилан мэдээгүй бол гэм буруугийн болгоомжгүй хэлбэр байна”⁷ гэж үзсэн.

Бусад этгээдийн эрхийг зөрчсөн эрх зүйн эсрэг үйлдэл /эс үйлдэхүй/ гэм хор буюу хохирлын хооронд шалтгаант холбоотой байх.⁸ Доктор Т.Мөнхжаргал “Гэм хор учруулагчийн хууль бус идэвхитэй ба идэвхигүй үйлдлийн эцэст хохирол учирсан байхыг шаардана. Иймд хууль бус үйлдэл /эс үйлдэл/ хохирол хоёрын хооронд шалтгаант холбоотой байх ёстой”⁹ гэж үзжээ. Шалтгаан ба үр дагавар нь хоорондоо салшгүй холбоотой ойлголтууд ба шалтгаангүй үүсэх юмс үзэгдэл гэж байгаль нийгэмд үгүй бөгөөд тэдгээр нь харилцан нөхцөлдөж байдаг объектив шинжтэй ухагдахуунууд юм.¹⁰

⁶ Нарангэрэл С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн Ерөнхий анги, УБ 2000 он., 123 дах тал

⁷ Мөнхжаргал Т. Иргэний эрх зүй /Үүргийн тусгай төрөл/, УБ, 1998,149 дэх тал

⁸ Наранчимэг Д. Иргэний эрх зүйн үндсэн асуудал”, УБ, 1999, 90 дэх тал

⁹ Мөнхжаргал Т. Иргэний эрх зүй /Үүргийн тусгай төрөл/, УБ, 1998,148 дахь тал

¹⁰ Гантөмөр Г. “Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол, УБ, 2003, 66 дахь тал

Буруутай этгээд нь гэм буруугийн үйлдлээ ухамсарласан болон ухамсарлаагүй үйлдсэн төлөвт байх ба аль ч тохиолдолд хэлцлийн нөгөө талд хохирол учруулсан бол нөхөн төлөх үүрэгтэй байна.

Хоёр: Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжид байгаль орчинд учирсан хохирлыг шаардах эрхийг зохицуулсан байдал

Шаардах эрх нь нэг этгээд нөгөө этгээдээс тодорхой үйлдэл эсхүл эс үйлдэхүй хийхийг шаардах субъектив эрх¹¹ гэж үзэх бөгөөд шаардах эрх нь зөрчилтэй холбоотой хууль болон гэрээнд зааснаар үүсэх онцлогтой.

Байгаль орчинд учруулсан гэм хорыг арилгах шаардах эрх нь зөвхөн хуульд заасны дагуу үүсэх бөгөөд байгаль орчинд учруулсан хохирлын тухайд гэм буруутай этгээдээс учирсан хохиролыг шаардах эрх нь хуулиар олгогдсон этгээд болон эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байгаа этгээд шаардах эрхтэй. Гэхдээ нийгмийн хариуцлагын хүрээнд байгаль орчинд учирсан хохирлыг шаардах эрхийг хуулиар олгосон субъект хохирол шаардаж болно.

Байгаль орчныг хамгаалах багц хууль нь хүний амьдрал, үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар нөлөөлдөг Монгол Улсын нутаг дэвсгэрийн чулуун мандал, усан мандал, шим мандал, агаар мандлын харилцан шүтэлцээт хангаж, байгалийн газар, түүний хөрс, газрын хэвлий, түүний баялаг, ус, ургамал, амьтан, агаар зэрэг объектыг байгаль орчинд хортой нөлөөлж болзошгүй үйл ажиллагаанаас хамгаалж, байгаль орчны тэнцэл алдагдахаас сэргийлэх зорилготой.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 4.1.2-д “байгаль орчныг

¹¹ Б.Тэмүүлэн, Д.Энхзул, Б.Бунхишиг, 2013. УБ.,



хамгаалах тухай хууль тогтоомжийн зөрчилтэй тэмцэх болон байгаль орчинд хортой нөлөөлсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг шаардах, байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах” эрхийг иргэнд, 17.2.9-д “үүргээ нутгийн иргэдийн байгалийн нөөцийг зохистой ашиглах ухамсрыг төлөвшүүлэх, байгалийн нөөцийн хууль бус ашиглалттай тэмцэх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, шүүхэд нэхэмжлэл гаргах зэрэг хэлбэрээр хэрэгжүүлэх” сум, дүүргийн засаг даргад, 32 дугаар зүйлийн 32.1.1-д “ Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах” төрийн бус байгууллагад тус тус олгосон.¹² Нөхөн төлбөрийг Байгаль орчин, уур амьсгалын санд төвлөрүүлнэ.

Дээрхи зохицуулалт нь байгаль орчныг хамгаалах нөхөн төлбөртэй холбоотой суурь зохицуулалт бөгөөд байгаль орчныг хамгаалах иргэний журмаар шаардах эрхийн үндэслэл юм.

Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.9-д “ус ашиглах, хаягдал ус зайлуулах шаардлагыг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ус ашиглах, хаягдал ус зайлуулах эрхийг цуцлах дүгнэлт гаргах, байгальд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах”¹³ эрхийг Сав газрын захиргаанд олгосон байх бөгөөд уг хуулиар байгальд учруулсан хохирлыг

хаана төвлөрүүлэх талаар зохицуулаагүй байна.

Ойн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-д “ойн тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс ойн санд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах”¹⁴ эрхийг Төрийн бус байгууллагад олгосон ба хориглосон үйл ажиллагаа явуулсан, хууль бусаар мод бэлтгэсэн, зөвшөөрөлгүйгээр ойн дагалт баялаг түүсэн, бэлтгэсэн, ойн санд хортой нөлөөлөл үзүүлсэн, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, ашигт малтмал олборлох зэрэг үйл ажиллагаа явуулахдаа ойг устгасан, хууль бус бусад үйл ажиллагаа явуулсны улмаас шууд хохирол болон ойг нөхөн сэргээхэд шаардагдах зардлын нөхөн төлбөрийг байгаль орчны хяналтын улсын байцаагч ногдуулж, төлөлтөд хяналт тавина.

Дээрхи хуулийн зохицуулалтаас үзэхэд байгаль орчныг хамгаалах, учирсан хохирлыг шаардах эрхийг иргэд, төрийн бус байгууллага болон засаг дарга нарт олгосон боловч урамшууллын механизм байхгүй, мөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25, 26 дугаар зүйлд заасан процессын эрхийг эдлэн нэхэмжлэлээсээ татгалзах, мөн татан авах зэргээр процесс дуусгавар болгох сөрөг төл бий.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд байгаль орчинд учирсан хохирлыг шаардахад улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх хуулийн зохицуулалт байхгүй байгаа нь шаардах эрхийг эдлэх боломжийг хязгаардаж байгаа үйл баримт гэж үзэхээр

¹² Байгаль орчныг хамгаалах тухай хууль. 1995.03.30//Төрийн мэдээлэл. УБ, №5-6

¹³ Усны тухай хууль. 2012.05.17.//Төрийн мэдээлэл. УБ., №22

¹⁴ Ойн тухай хууль. 2012.05.17.//Төрийн мэдээлэл. УБ., №22



байна. Хэрэв, байгаль орчинд учирсан хохирлыг арилгуулахаар шаардаж байгаа тохиолдолд улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл, Засгийн газрын Байгаль орчин, уур амьсгалын санд орох нөхөн төлбөр шаардаж байгаа тохиолдолд иргэн, төрийн бус байгууллагаас улсын тэмдэгтийн хураамж шаардах нь хууль зүйн логикгүй тогтолцоо юм.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1-д “Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд үзүүлэх хортой аюултай нөлөөллийг багасгах дэвшилт арга, хоргүй, аюулгүй, бохирдолгүй, хаягдалгүй технологи нэврүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг төрөөс урамшуулна” гэж заасан боловч байгаль орчны нөхөн төлбөрийг Байгаль орчин, уур амьсгалын санд төвлөрүүлэх бөгөөд уг нөхөн төлбөрөөс олгох урамшууллын хэмжээг тодорхой болгох нь онолын төдийгүй практик ач холбогдолтой.

Түүнчлэн, Засгийн газрын Байгаль орчин, уур амьсгалын санд оруулсан нөхөн төлбөр нь шүүхийн шийдвэрт заасан нөхөн сэргээх газар, байгалийн объектод зарцуулагдаж байгаад иргэний нийгмийн хяналт нэн шаардлагатай.

Гурав: Байгаль орчинд учирсан хохиролтой холбоотой иргэний хэргийн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ

Шүүхийн шийдвэрийн цахим санд байршсан байгаль орчинд учирсан хохирлыг шаардсан шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж үзэхэд байгаль орчинд учирсан хохирлыг шаардах буюу нөхөн төлбөр шаардах процесс нь нарийн төвөгтэй, баримтаар тогтооход хүндрэлтэй процесс болох нь ажиглагдав.

Судлаач С.Энхмэнд Газарт учруулсан экологийн бүрэн хэмжээгээр арилгаж тэр бүр чаддаггүй учраас иргэний эрх зүйн хариуцлагын үр нөлөөг дээшлүүлэх, шүүхийн практикийн боловсронгуй болгох шаардлагатай гэж үзсэн нь тохиолдлын хэрэг биш юм.¹⁵

Г сумын засаг даргын нэхэмжлэлтэй хариуцагч Ж-ХХК-д холбогдох иргэний хэрэг:

Хариуцагч нь 2006 оноос 2012 оныг хүртэл хугацаанд Баянхонгор аймгийн Гурван булаг сумын ихэрийн аманд алт олборлох үйл ажиллагаа явуулахдаа байгаль орчинд хохирол учруулсан гэж байгаль орчинд учруулсан хохиролд 3,966,800,000 төгрөгийг Засгийн газрын Байгаль орчин, уур амьсгалын санд оруулах тухай нэхэмжлэлийн шаардлага гаргасан.

Дээрхи шаардлага нь хариуцагч Ж ХХК нь 2006 оноос 2012 оныг хүртэл хугацаанд Баянхонгор аймгийн Гурван булаг сумын ихэрийн аманд алт олборлох үйл ажиллагаа явуулахдаа байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөрийг гаргуулахаар шаардлага гаргасан ба техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн зардал шаардаагүй байна.

Уг хэрэгт шинжээчийн дүгнэлт зөрүүтэй гарсан бөгөөд шинжээч К-ийн дүгнэлт нь 3,966,800,000 төгрөг, Э ХХК-ийн дүгнэлтээр 178,830,000 төгрөг гэж зөрүүтэй дүгнэлт гарсан бөгөөд 2006-2012 оны үйл баримтад 2018 онд шинжээч томилох боломжгүй ба амьд байгаль өөрийнхөө жамаар нөхөн төлжиж байдаг жамтай тул нөхөн төлжих процесс явагдсан байх тул өнгөрсөн хугацааны буюу 2006 оны үйл баримтыг

¹⁵ С.Энхмэнд, Газрын эрх зүйн үндсэн асуудлууд, 2010. УБ., 131 дэх тал



тогтоох боломжгүй нөхцөл байдал үүссэн байна.

Байгаль орчинд учирсан хохирлыг нөхөн төлбөр гаргуулах процесс нь хэт удаашрахад байгаль өөрийнхөө жамаар нөхөн сэргээгдэж байдаг тул бодит хохирлыг тогтооход хүндрэлтэй байдаг.

Мөн, байгаль орчинд учирсан хохиролыг нөхөн төлүүлэхээр шаардаж байгаа маргаанд байгаль орчны мэргэжилтэн, эрдэмтдийн шинжлэх ухааны үндэслэлтэй тайлбар чухал ач холбогдолтой болох нь уг шийдвэрээс харагдаж байна. Жишээлбэл, Ихрийн ам нь усгүй, цэвдэгтэй хэсэг нь ил гарсан байсан. Энэ цэвдэг нь хөрсний ус боловч уг ил гарч, нуур болон тогтсон уснаас болон мал ундаалж байгаа тул нэг талаар ашиг тустай гэж үзсэн боловч хөрсний ус ил гарч, нуур болон тогтож, өдөр бүр ууршиж байгаа нь хөрсний усанд учирсан хохирол болохыг зөвхөн эрдэмтэн судлаачид тогтоох, тайлбарлах боломжтой үйл баримт юм.

Жишээлбэл, нэхэмжлэгч МГННХ, ОГХ нар нь хариуцагч Засгийн газарт холбогдуулан 235 алтны шороон орд ашиглах явцад байгаль орчинд учирсан хохирол 1 161 451 800 000 төгрөгийн хохиролыг барагдуулах, улсын хэмжээнд эвдэрсэн 8147.58 га талбайг 2 жилийн хугацаанд нөхөн сэргээж, нутгийн иргэдэд хүлээлгэн өгөхийг Засгийн газарт даалгуулахаар нэхэмжлэлийн шаардлага гаргаж, шүүх Засгийн газар гэм буруугүй гэж дүгнэж хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.¹⁶

Төрийн бус байгууллагаас нэхэмжлэл гаргах эрхтэй боловч Засгийн газраас шаардаж байгаа нь үндэслэл муутай бөгөөд байгаль орчинд сөрөг үйл

ажиллагаа явуулсан иргэн, хуулийн этгээдээс шаардах нь зүйтэй.

Сэлэнгэ аймгийн Прокурорын газрын нэхэмжлэлтэй хариуцагч Г -д холбогдох иргэний хэрэгт холбогдуулан байгаль орчинд учруулсан гэм хорын хохиролд 36,705.772 төгрөг гаргуулах тухай шаардлага гаргасан бөгөөд Г нь хууль бусаар олборлолт явуулсан гэм буруутайд тоцогдсон байна. Шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д “Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэж заасны дагуу нэхэмжлэгч Сэлэнгэ аймгийн Прокурорын газар нэхэмжлэл гаргасан боловч хүчин төгөлдөр шийтгэх тогтоолд дурдсан асуудлаас гадна төрийн ашиг сонирхол хэрхэн, ямар байдлаар зөрчигдсэн, энэ талаар прокурорын байгууллагад төрийн ямар байгууллага хүсэлт гаргасан нь баримтаар тогтоогдохгүй байна гэж нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэв.¹⁷ Харин Нэхэмжлэгч Дорнод аймгийн П.Г нь тус аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Байгаль орчин, Аялал жуулчлалын газрын хүсэлтээр Прокурорын байгууллагын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу хариуцагч Б.Б-д холбогдуулан байгаль орчинд гэм хор учруулсны хохиролд 30 000 000 төгрөгийг улсын төсөвт оруулах тухай нэхэмжлэлийн шаардлагыг шүүх хангаж шийдвэрлэсэн.¹⁸

¹⁶ Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан (shuukh.mn)



Прокурорын байгууллага нь байгаль орчинд учирсан хохирлыг шаардар эрхтэй эсэх талаар шүүх хууль хэрэглээний нэгдмэл ойлголтод хүрээгүй байгаа нь дээрхи жишээнээс харгдаж байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд хохирол гаргуулахаар

шаардах эрхтэй этгээдийн хуульчилсан байхад шаардах эрхийг шилжүүлэн авахгүйгээр прокурор шаардаж байгаа нь үндэслэлгүй төдийгүй шүүх нэгдмэл ойлголтод зайлшгүй хүрэх шаардлагатайг илэрхийлж байна.

**Abstract****PROCEDURAL ISSUES REGARDING CIVIL RIGHT FOR CLAIMING DAMAGES CAUSED TO ENVIRONMENT****S.ENKHBAYAR***Lecturer of the University of Finance and Economics,
Doctor Ph.D, Associate Professor*

Apart of the natural phenomens occurring in the world, also any human activity towards the environment has both positive and negative consequences. Violations such as encroachment to natural resources, destruction and damage to environment, due to the human factors as well as to a rapid development of science and technology, have been on the rise during the recent years, which is directly related to imperfect legal and regulatory framework. There is an urgent need to study the current state of such regulations. One of the conditions hindering the exercise of a civil procedure right by either citizens or

non-governmental organizations (NGOs) to claim damages for the environment is a payment of the state stamp duty, in the amount specified by law, and thereafter to place such compensation claimed in a special government fund. In addition, one of the current issues that attracts attention that a number of cases, where either citizens or NGOs withdraw complaints or court claims for such environmental damages.

Keywords: Right to claim, damages, state stamp duty, damage assessment, waiver of claims, compensation for environmental damage.

**УУЛ УУРХАЙН САЛБАРТ БАЙГАЛЬ ОРЧИНД НӨХӨН
СЭРГЭЭЛТ ХИЙХ ҮҮРГЭЭ ГҮЙЦЭТГЭЭГҮЙГЭЭС УЧИРСАН ХОХИРОЛ,
НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛБӨР ГАРГУУЛАХ ТУХАЙ МАРГААНЫГ
ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ШҮҮХИЙН ПРАКТИКИЙГ “БОХИРДУУЛАГЧААР
ТӨЛҮҮЛЭХ” ЗАРЧИМ (PPP)¹-ТАЙ УЯЛДУУЛАН АВЧ ҮЗЭХ НЬ**

**JUDICIAL PRACTICE OF HANDLING DISPUTES
ON NEGLIGENCE OF MINE REHABILITATION AND THE POLLUTER
PAYS PRINCIPLE (PPP)**

Доржтовоогийн БЯМБА-ОД²

- I. Удиртгал
- II. Үндсэн хэсэг
 - A. Монгол Улсын байгаль орчныг хамгаалах эрх зүйн уламжлал
 - Б. Байгаль орчин, уул уурхайн салбарын нөхөн сэргээлтийн бодлого
 - В. Нөхөн сэргээлтийн менежмент, зорилго, ач холбогдол
 - Г. “Бохирдуулагчаар төлүүлэх” (PPP) зарчмын агуулга, түүнийг гадаад улсын шүүхийн практикт хэрэглэсэн тохиолдол
 - Д. Монгол Улсын шүүхийн практик
- III. Дүгнэлт
- IV. Эх сурвалж, ном зүй

¹ Polluter Pays Principle (англ.)

² Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн Иргэний эрх зүйн секторын судлаач.



холбоотойгоор Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2010 оны А-132/112 дугаар тушаалаар “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээх ажлын зардлын үнэлгээ тооцох аргачлал”-ыг, 2015 оны А-138 дугаар тушаалаар “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”-ыг баталсан.

Уг аргачлалын дагуу уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийхийг олборлолтын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага болон газрын хэвлийн нөхөн сэргээлтийн эрх бүхий мэргэжлийн байгууллагуудад даалгаж, аргачлалыг мөрдүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг холбогдох байгууллага, эрх бүхий албан тушаалтанд даалгаж шийдвэрлэсэн.

Судалгааны ажлын хүрээнд Монгол Улсын шүүхийн практикт байгаль орчинд учирсан хохирлын нөхөн төлбөр, нөхөн сэргээлтийн зардлыг нэхэмжилсэн маргааныг хэрхэн шийдвэрлэж байгаа талаар судлахын зэрэгцээ “бохирдуулагчаар төлүүлэх” зарчмын талаар судалж, түүний агуулга, тус зарчмыг хэрэглэн шийдвэрлэсэн гадаад улсын шүүхийн шийдвэрийг судласны үндсэнд Монгол Улсын хууль тогтоомжид уг зарчим тусгагдсан эсэх, цаашид энэхүү зарчимд үндэслэн хэрэг маргаан хянан шийдвэрлэх боломжтой эсэх талаар дүгнэж шүүхийн практик болон зарчмын уялдааг тодорхойлоход чиглэсэн болно.

Үндсэн хэсэг

А. Монгол Улсын байгаль орчныг хамгаалах эрх зүйн уламжлал

Уул уурхайн үйл ажиллагаа нь газар, ой, ус, агаар, биологийн төрөл зүйлийг эвдэн гэмтээж, хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэнд, удам зүй, улс орны хөгжилд нөлөөлж болзошгүй учир уул уурхайн салбар дахь нөхөн сэргээлтийн эрх зүйн орчны талаарх асуудал нэн чухалд тооцогддог. Монгол улсын хувьд уул уурхайн салбар нь улс орны хөгжлийг тодорхойлж, ард түмэн нь нийтээрээ ашиг хүртэж байгаа боловч байгаль орчноо хэрхэн зүй ёсоор хамгаалж, сэргээсэн байдлаар үлдээх асуудал нь уг харилцааг зохицуулж буй хууль, эрх зүйн орчноос ихээхэн шалтгаалдаг ба хууль тогтоомж дахь заалтууд, эрх зүйн зохицуулалт боловсронгуй биш, хийдэл-зөрчилтэй, салбарын харилцааг зохицуулж буй хуулиудын хоорондын уялдаа хангалтгүй байгаа⁵.

Хууль зүйн шинжлэх ухаан нь байгаль орчныг хамгаалах асуудлыг төр, эрх зүйн онол болон салбар эрх зүйн талаас нь судалдаг⁶ тул төр, эрхийн онолын үзэл баримтлалаар түүхэн эх сурвалжуудад тулгуурлан судалгааг хийж, хууль цаазаа эргэн харж судлах нь өнгөрсөн үеэсээ сургамж авч үр ашигтайг нь уламжлан сэргээх нь ач холбогдолтой юм.⁷

Эрдэмтэн, судлаачид байгаль орны хууль тогтоомжийн хөгжлийг дараах байдлаар ангилжээ⁸:

1. Монголын нэгдсэн төрийн болон түүний дараах үеийн байгаль орчны хууль тогтоомж /XIII-XVIII зуун/;
2. Богд хаант Монгол Улсын болон

⁵ Эрдэс баялгийн эрх зүйн тойм, УБ 2012 он, 152 дахь тал.

⁶ Амархүү О. Байгаль орчныг хамгаалах Монгол зан заншил, хууль цааз, УБ 2000 он, 27 дахь тал

⁷ *Supra* note 6.

⁸ Сэнгэдорж Т. Экологийн эрх зүй, УБ 2009 он, 58 дахь тал, Амархүү О. Монголын орчин цагийн экологийн эрх зүй, УБ 2009 он, 73 дахь тал.



1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын эхэн үеийн байгаль орчны хууль тогтоомж /1911-1924/;

3. Үндэсний ардчилсан хувьсгалын ололтыг бататгаж, нийгмийн хөгжлийн цаашдын шатанд шилжих үеийн байгаль орчны хууль тогтоомж /1924-1940/;
4. Социалист байгуулалтын үеийн байгаль орчны хууль тогтоомж /1940-1990/;
5. Ардчилсан, зах зээлийн эдийн засгийн шинэчлэл, өөрчлөлтийн үеийн байгаль орчны хууль тогтоомж /1990 оноос хойш/.

Монголын эртний хууль, цаазын сурвалжуудад байгалийн баялгийн эрх зүйн зохицуулалтыг хэдийгээр тусгаж байгаагүй ч байгаль орчныг хамгаалах хэм хэмжээ нилээд агуулагдаж байсан бөгөөд тэдгээрийн агуулгыг ерөнхийлөн авч үзвэл, хууль цаазад тусгагдсан байгаль хамгаалах заалтууд нь нүүдэлчдийн аж төрөх ёсны онцлогийг тусган илэрхийлсэн заншлын хэм хэмжээг хуулийн зохицуулалтад оруулан гол төлөв хориглосон шинжтэй илэрч байсан ба бэлчээрийн газрыг хамгаалах, онголон дархлаа агуулгатай заалтуудаар зохицуулж байсан гэж үзэхээр байна⁹

⁹ *Supra* note 6. p.155. *Их засаг хуульд*: Газар, газрын хэвлий, ашигт малтмалын эрх зүйн асуудлаар энэ хуульд "өвс ургасан хойно газар нүхлэвээс цаазлана" гэж заасан бөгөөд "газар нүхлэх" гэдэг зан үйлд газрын хэвлийгээс ашигт малтмал олборлохоор түүнийг хөндөх, ухах, малтах, тэсэлж дэлбэлэх зэрэг ажиллагаа нь агуулгын хувьд багтана гэж үзвэл уг хуульд газар, газрын хэвлий, ашигт малтмалын эрх зүйн зохицуулалт байсан гэж үзэж болохоор байна. *Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичигт*: Байгаль орчныг хамгаалах асуудлыг өмнөх хуулиудаас илүү өргөн хүрээг хамарч олон чухал асуудлыг хуульчлан тусгасан, уг хуульд байгалийн ил, далд, ашигт малтмалыг хамгаалах, зүй зохистой ашиглах асуудлыг анх удаа хуульчилсан нь өнөөгийн ашигт

гэж тэмдэглэжээ.

Харин байгаль орчныг хамгаалах эрх зүйн үндэс нь 1921 оны Ардын хувьсгалын эхэн үеэс төрийн бодлогоор тодорхойлогдож энэ нь Ардын түр Засгийн газрын анхны тогтоол болон хэд хэдэн тогтоолуудад тусгагдаж, улмаар Анхдугаар Үндсэн хууль болон удаа дараагийн Үндсэн хуулиуд болон салбарын хуулиудаар зохицуулагдаж байсан онцлогтой. 1921-1990 оны үед батлагдсан байгаль орчны хуулиудад газрын баялаг, байгалийн бусад нөөцийг ашиглах, эдлэх, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбогдсон хэм хэмжээ нилээд тогтоогдож, эрх зүйн зохицуулалтын онцлог нь гарсан зөрчлийн хойноос хөөцөлдөж, захиргааны арга хэмжээ авах түгээмэл хандлагатай, хуулийг төрийн хүч ба албадлагаар хэрэгжүүлэх чиглэлтэй байсан.¹⁰

1940-өөд оноос хойш Монгол Улс хөдөө аж ахуй, аж үйлдвэрийг хөгжүүлж, социализмыг байгуулах үндэс суурь бүрэлдэх үе байсан тул байгалийн баялагт суурилсан аж үйлдвэр, барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, байгалийн баялгийг ашиглах зорилгоор геологи хайгуулын ажлыг өргөнөөр явуулах, ашиглалтыг нэмэгдүүлэх, хамгаалалтыг хүчтэй болгох үзэл баримтлалд тулгуурлаж байсан.

1960-1990 оны хооронд байгаль орчны хууль тогтоомж эрчимтэй хөгжлийнхөө үе шатанд орж, хүрээлэн

малтмалын болон газрын хэвлийн хуулиудын эх үүсвэрийг тавьсан гэж үздэг. *Халх журамд*: Хот суурины ногоон бус тогтоож хамгаалах, улс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг бий болгох, газар эзэмшиж ашиглах асуудлыг шинээр бий болгосноороо онцлог байсан бөгөөд "сангийн чулуу, нүүрс, шохой хулгай хийвэл гурван ест" гэж заасан бөгөөд үүнийг хориглох байдлаар байгалийн баялгаа хамгаалж байсан гэж үзэж болохоор байна.

¹⁰ *Ibid.*



буй орны объектуудыг бараг бүхэлд нь эрх зүйн хамгаалалтанд авснаас гадна 1988 онд Газрын хэвлийн тухай хууль батлагдан, Монгол Улс байгаль орчны чиглэлээр олон улсын 14 конвенцид нэгдэн орж, 36 хууль, 300 орчим дүрэм, журам, 180 орчим стандарт, норм, норматив мөрдөгдөж, 25 хөтөлбөр хэрэгжсэн байна.¹¹

1990 оноос хойш БОХТХ /1995/, Газрын тухай хууль /2002/, БОХТХ /2006/, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль /2012/-ууд батлагдсан. БОХТХ-иар “байгаль орчныг хамгаалах” гэдэгт нөхөн сэргээх ажиллагаа хамаарахаар, хамгийн анх байгаль орчныг нөхөн сэргээх, нөхөн сэргээгээгүйгээс учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, байгалийн баялгийг зохистой ашиглахаас гадна нөхөн сэргээх замаар байгалийн тэнцвэрийг хангах талаар хуульчилсан төдийгүй “байгаль орчинд учруулсан хохирол”, “байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөр”-ийн тодорхойлолтыг бий болгосон нь 1992 оны Ардчилсан Үндсэн хуулиар байгаль орчныг хамгаалах баталгааг хуулиар тогтоосон, нөхөн сэргээлтээс үүдэлтэй хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох эхлэлийг тавьсан нэн чухал алхам болсон юм.

Б.Байгаль орчин, уул уурхайн салбарын нөхөн сэргээлтийн бодлого

Уул уурхайн салбар нь төслийн бүхий л шатанд хүрээлэн буй орчин болон орон нутгийн иргэдийн амьдралд нөлөөлдөг төдийгүй газрын хэвлийгээс ашигт малтмал олборлох бүх арга технологиуд нь биосферийн бүхий л элементүүд болох усны нөөц, агаар мандал, газар ба түүний хэвлий, ургамал, амьтны ертөнц зэргийг хөндөж, экологийн тэнцвэрт байдалд

нөлөөлдөг. Төсөл хэрэгжүүлэх үйл явцаас үүдэх эдгээр шууд буюу дам нөлөөллийг орон нутгийн ард иргэд, хөрөнгө оруулагчид, төрийн бус байгууллага эмзгээр хүлээн авахад хүргэдэг байна. Иймээс уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэн байгаль орчинд учирч болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, учирсан тохиолдолд сөрөг нөлөөллийг арилгах, нөхөн сэргээх гэх мэт байгаль орчныг хамгаалах багц арга хэмжээг хэрэгжүүлэх учиртай бөгөөд үүний нэг нь байгаль орчныг хэвийн байдалд нь оруулах “нөхөн сэргээлт” арга хэмжээ юм.¹² Энэ нь уул уурхайн үйл ажиллагаа явуулахаас өмнөх газрын үржил шим, тухайн газарт байршиж байсан амьтан, ургамал, амьдарч буй хүн амын эрүүл мэнд, гол горхи, хүрээлэн буй орчин зэргийг өмнөх байдалд нь нөхөн сэргээх өргөн цар хүрээ бүхий ойлголт байдаг.¹³

Зарим эх сурвалжид “уул уурхайн нөхөн сэргээлт” гэдэг нь “уурхайн олборлолтоос үүдэж эвдрэлд орсон газар болон байгалийн онцлог, газар зүйн байршлаас шалтгаалан үржил шимт өнгөн хөрс муутай газрыг нөхөн сэргээж үржил шимтэй болгож байгалийг унаган төрхөнд нь оруулах цогц ажил бөгөөд уул уурхайн нөхөн сэргээлт” эцсийн зорилго бол олборлолт явагдсан газрыг эдийн засгийн эргэлтэд оруулж ашиглах явдал байдаг”¹⁴ гэж тодорхойлсон бол зарим эх сурвалжид “уурхайн үйл ажиллагаа зогссоны дараа тухай уурхайн талбайг хэрхэн яаж, ашиглахаар төлөвлөж байгаагаас хамааран тухайн газар нутгийн бүтцийн зураг төслийг боловсруулах, газар нутгийг хуучин

¹² Уул уурхайн салбар дахь тэргүүн туршлага-тогтвортой хөгжлийн хөтөлбөр, 2016 оны 8 дугаар сар, 1 дэх тал.

¹³ *Supra* note 6. p.162.

¹⁴ <http://monpolymet.mn/nsbodlogo/> Сүүлд үзсэн: 2022.05.30

¹¹ *Ibid.* p.156-157.



дүр төрхөнд нь оруулах, тогтвортой эко тогтолцоог бий болгох, эсхүл өөр төрлийн ургамал тарьж нутагшуулах үйл ажиллагааг хэлнэ”¹⁵, “уул уурхайн үйл ажиллагаанаас бий болсон газрын эвдрэлийг унаган төрхөнд нь эргэн оруулах шаардлагатай бөгөөд ийнхүү эвдэрсэн газрын аж ахуйн үнэ цэнэ, бүтээмжийг нь сэргээх, тэрчлэн хүрээлэн буй орчны нөхцлийг нийгмийн ашиг сонирхолд нийцүүлэн сайжруулахад чиглэж цогц арга хэмжээ авахыг хэлнэ”¹⁶ гэж тодорхойлжээ.

Дээрх тодорхойлолтоос нэгтгэн үзвэл, “уул уурхайн салбарын нөхөн сэргээлт” гэдгийг “уул уурхайн үйл ажиллагаа тасалдсан, зогссоноос үл хамааран тогтмол хийгдэж байх ёстой хүрээлэн буй орчныг өмнөх байдалд нь оруулах, хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалагдах эрхийг төрөөс чиг үүргийнхээ хүрээнд олгосон тусгай зөвшөөрөл, хяналт шалгалтаар дамжуулан хангаж, хамгаалж буй үйл ажиллагаа буюу хүн амын эрүүл мэнд, хөрсний үржил шим, усны нөөц, агаарын цэвэр байдал, амьтан, ургамлын хэвийн өсөлт, хөгжлийг уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнөх байдлаас дордуулахгүйгээр хийж гүйцэтгэж, байгалийн тэнцвэртэй байдлыг хамгаалах цогц ажиллагаа” гэж ойлгож болох юм.

Уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй нөхөн сэргээлтийг техникийн болон биологийн гэж хоёр үе шаттай хийдэг. Техникийн нөхөн сэргээлтийг төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага нь өөрсдийн хүч, хөрөнгөөр хариуцан гүйцэтгэдэг бол биологийн нөхөн сэргээлтийг төсөл хэрэгжүүлэгчийн хөрөнгөөр мэргэжлийн байгууллага

гүйцэтгэнэ.¹⁷

Нөхөн сэргээлтийн ажлын техникийн үе шатанд орд газрыг ашиглаж дууссаны дараа уурхайн чөлөөлөгдсөн орон зайг цаашид аж ахуйн тодорхой зориулалтаар үргэлжлүүлэн ашиглах зорилгоор ухаж эвдэрсэн газарт дүүргэлт хийх, хэлбэршүүлэх, талбайг засаж тэгшлэх, бэлтгэсэн талбайг биологийн нөхөн сэргээлт хийхэд зориулж, шимт хөрсөөр хучих зэрэг үйл ажиллагаа хамаарна.¹⁸

Техникийн нөхөн сэргээлтийн технологийг олборлолт, хөрс хуулалт, дотоод овоолго үүсгэлт зэрэг уулын ажлын технологитой харилцан уялдуулж гүйцэтгэх нь хосолмол аргаар илүү их нөхөн сэргээлтийн ажил явуулах боломжийг бүрдүүлдэг төдийгүй уул уурхайн ашиглалтын систем нь хөрс хуулалт, техникийн нөхөн сэргээлтийг хамтад нь түвшний тээвэрлэлттэй дотоод овоолгоор зэрэгцүүлэн хийж, гадаргууг анх байсан хэлбэрт нь оруулдаг. *Техникийн нөхөн сэргээлтийн нэгдүгээр үе шатанд* уурхайн ашиглалт явахаас өмнө ургамлын нөмрөг бүрхэвч болох шимт хөрсийг хуулж тусад нь овоолгоор хадгалж нөхөн сэргээлтийн хамгийн эхний үе шатны ажил хийгдэж эхэлдэг бол *хоёрдугаар үе шатанд* ашиглалтын үед үүссэн орон зайг дотоод овоолгоор дүүргэн газрын гадаргын анхдагч хэлбэрт оруулж, тэгшлэн биологийн нөхөн сэргээлтэд бэлэн болгодог.

Нөхөн сэргээлтийн үйл ажиллагааны техникийн үе шат бүрэн дуусч, овоолгын болон талбайн хөрс чулуулаг тогтворжиж, нягтарсны дараа овоолгод хадгалж байсан шимт хөрсийг эргүүлэн байршуулах замаар эвдэрсэн газрын

¹⁵ *Supra* note 13.

¹⁶ *Supra* note 6. p.163.

¹⁷ Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлалын 4 дүгээр зүйл.

¹⁸ *Ibid.*



биологийн нөхөн сэргээлтийн ажлыг эхлүүлнэ. Нөхөн сэргээлтийн биологийн үе шатны үндсэн зорилго нь өндөр үр өгөөжтэй хөдөө аж ахуйн эдэлбэр газар, таримал ой, загасны аж ахуй, усны аж ахуй, ангийн аж ахуйн зориулалттай объектууд, амралт сувилал, аялал жуулчлалын бүсийг бий болгох, ургамалжуулах замаар үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үед элэгдэж, эвдэрсэн газрыг нөхөн сэргээж, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх явдал байдаг.

Биологийн нөхөн сэргээлтийн ажлыг олборлолтын ажил эхлэхийн өмнө уурхайн эдэлбэрийн байгаль орчны суурь нөхцөл байдлыг тодорхойлох урьдчилсан судалгаа явуулах, уг судалгааны үр дүн болон бусад мэдээ, мэдээлэлд үндэслэн ургамалжуулах ажлын чиглэлийг тогтоох, эцэст нь техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд шимт хөрсний үе үүсгэн ургамалжуулалтыг байгалийн аясаар болон зохиомлоор тарьж ургуулах гэсэн дэс дараалалтайгаар гүйцэтгэнэ.¹⁹ Биологийн нөхөн сэргээлтийг малын бэлчээр бий болгох, эвдэрсэн газрыг ургамалжуулах буюу ойжуулах, хиймэл нуур цөөрөм байгуулах хэлбэрээр мөн хийж гүйцэтгэдэг.²⁰

Уул уурхайн үйл ажиллагаанаас эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээх нь ганцхан малтлагын талбайгаар хязгаарлагдахгүй бөгөөд уурхайн барилга байгууламж, ажиллагсдын тосгон барьж байгуулах, баяжуулах үйлдвэр, хаягдлын сан байгуулах, ашигт малтмалыг тээвэрлэх болон уурхайн үйл ажиллагаатай холбогдон эвдрэлд орсон бүхий л газруудыг хамаарна.²¹

В.Нөхөн сэргээлтийн менежмент, зорилго, ач холбогдол

Нөхөн сэргээлтийн менежмент гэдэг нь уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон талбай өмнө нь огт хөндөгдөөгүй байдалд орохын тулд нөхөн сэргээлтийг зохистойгоор хийж гүйцэтгэх, удирдан зохион байгуулах ажиллагаа юм. Нөхөн сэргээлтийн менежментийн хамгийн хүндрэлтэй асуудалд гал түймэр, хогийн ургамал, эзэнгүй эсхүл зэрлэг амьтан, газрын элэгдэл, өвс ургамлын өвчин, тэжээллэг чанарын мөчлөг ордог.

Нөхөн сэргээгдсэн газарт ургамлыг аль болохоор гал түймэрт өртүүлэлгүй ургуулах, гал түймэрт өртсөн бол түүнийг үржих боломжийг бүрдүүлэн галаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулах шаардлагатай. Гал түймрийг хянах стратегид галтай тэмцэх зурвас, зэргэлдээ газар нутагт гал түймэр шилжих аюулыг багасгах тухай тусгаж болно. Нөхөн сэргээгдсэн газарт дэс дараалсан бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэх, мөн гал нь байгалийн тэнцвэр алдагдуулагч хүчин зүйл болдгийн хувьд галд тэсвэртэй болгох ажлыг хийдэг олон улсын туршлага байдаг байна.

Түүнчлэн хогийн ургамал ургах, тархах явдлыг хянах асуудал нөхөн сэргээлтийн ажлын нэг чухал хэсэг тул түүнийг устгалд оруулахаас илүү урьдчилан сэргийлэх асуудалд анхаарах хэрэгтэй. Хогийн ургамлын үр тархахаас урьдчилан сэргийлэхийн тулд эвдрэлд орсон газрын ойр хавийн хогийн ургамлыг устгалд оруулахаас эхэлнэ. Хогийн ургамлыг устгах техникийн, механик, химийн, биологийн болон экологийн гэх мэт аргууд байдаг. Хогийн ургамлын тархалтыг таслан зогсоох хамгийн үр дүнтэй арга нь хөрс хагалалт,



хогийн ургамлыг гараар түүх, шатаах, гербицид цацах зэрэг юм. Гараар хогийн ургамлыг түүж устгах нь зардал ихтэй хэдий ч жижиг талбайд үр дүнтэй арга гэж үздэг.

Эзэнгүй эсхүл зэрлэг амьтад нөхөн сэргээгдсэн газрыг дахин эвдрэлд оруулах хамгийн аюултай хүчин зүйлсийн нэг тул уугуул амьтанд хоргүй өгөөш хэрэглэх, эсвэл хашаа тор татах замаар уурхайн талбай болон түүний ойр орчмын газарт байгаа амьтны төрлийг хязгаарлаж болно. Уурхайн талбайд галт зэвсгийг зөвшөөрдөггүй учир буудаж устгал хийх боломжгүй байдаг.

Уурхайн ажлын улмаас ургамалжуулалт устаж, улмаар талбай дээр байгаа ургамлын тэжээллэг чанар доройтдог тул тэжээллэг чанарын мөчлөгийг дахин сэргээх явдал маш чухал байдаг. Нөхөн сэргээлтийн ажлын үед тэжээллэг чанарын мөчлөгийг сэргээхээр нэг удаагийн бордоожуулалт хийж болох ба нөхөн сэргээгдсэн газрын тэжээллэг бодисын мөчлөгийг тогтмол хянах нь чухал байна.²²

Нөхөн сэргээлтийн зорилго нь ашиглагдсан газрын цаашдын аюулгүй, тогтвортой байдлыг хангах, уурхайн үйл ажиллагаа эхлэхийн өмнөх үеийнхтэй адил байхаар нөхөн сэргээгдсэн байх, байгалийн баялгийг хадгалан хамгаалах, экосистем нь бүс нутгийн хувьд тохиромжтой, тогтвортой байх зэргийг хангасан байхад оршихоос²³ гадна бохирдлын удирдлага, түүнчлэн хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд учруулж болзошгүй эрсдэлийн удирдлагыг хангахад оршино²⁴. Үүнээс нөхөн сэргээлтийн зорилгыг “эвдрэлд орсон газар дахин сэргээгдэх буюу хохирол

учраагүй, хүний гар хүрч хөндөгдөөгүй байдалд эргэн орох” гэж тодорхойлж болно.

Уурхайн нөхөн сэргээлт хийснээр эвдэгдсэн байгаль орныг сэргээж байгалийн баялгийн тогтвортой байдлыг хангах ач холбогдолтой ба ингэснээр агаар, хөрс, усны чанар сайжрах, ирээдүйд тухайн газарт эдийн засгийн хөрөнгө оруулалт хийх боломж бүрдэх, амьтан ургамлын амьдрах орчин хамгаалагдах, ард иргэд, бодлого боловсруулагчид, уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдийн хооронд эерэг харилцаа бий болох, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах зэрэг эерэг үр дагавартай байна.²⁵

Нөхөн сэргээлтийн бизнесийн ач холбогдол нь²⁶: Нөхөн сэргээлтийн тэргүүний туршлагыг нэвтрүүлснээр богино болон дунд хугацаанд өрсөлдөгчөөсөө давуу байдалтай болж, улмаар энэхүү давуу байдал нь тухайн газар нутгийг ашиглах эрх олж авах баталгаа нь болох магадлал ихтэй. Эзэмших газраа зөв ашиглах, ялангуяа нөхөн сэргээлтийн ажлыг амжилттай хийх хүсэл, үнэнч эрмэлзэлээ хангалттай илэрхийлээгүй тохиолдолд тусгай зөвшөөрөл олголтын асуудал хойшлогдохоос гадна уг уурхайг хөгжүүлэх боломжоо бүр мөсөн алдах эрсдэлд орж болзошгүй. Нөхөн сэргээлт нь тухайн компанийн үйл ажиллагааны үр дүнгийн гол шалгуур үзүүлэлт мөн гэж үздэгээс гадна сүүлийн үед уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг томоохон компаниуд ч олон нийтийн ойлголцол, итгэлцлийг хүлээх нь үйл ажиллагаагаа хэвийн явуулах нэг чухал хүчин зүйл гэж тооцогдох болсон. Энэ нь үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардлагатай эдийн засаг, техникийн хүчин зүйлүүдээс гадна нийгмийн хүчин

²² *Supra* note 13. p.42-43.

²³ *Ibid.*

²⁴ *Supra* note 6. p.15.

²⁵ *Ibid.* p.164.

²⁶ *Supra* note 13. p.12.



зүйлүүд чухлаар тавигдах болжээ гэж үзэхэд хүргэж байна.²⁷

Г."Бохирдуулагчаар төлүүлэх" (PPP) зарчмын агуулга, түүнийг гадаад улсын шүүхийн практикт хэрэглэсэн тохиолдол

Энэхүү зарчмын үндэс нь хүрээлэн буй орчны эрх зүйгээс илүү эдийн засгийн шинжлэх ухаанаас эхлэлтэй. "Бохирдуулагчаар төлүүлэх" зарчим нь байгаль орчинд хор хөнөөл учруулсан компаниуд ямар нэг арга хэмжээ авахгүйгээр үйл ажиллагаагаа явуулсаар байвал хойч үедээ дамжих сөрөг нөлөө үүсгэдэг²⁸ гэж үздэг ба хүний эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөл учруулахаас сэргийлэхийн тулд бохирдлыг бий болгож буй хүмүүс түүнийг зохицуулах зардлыг хариуцах ёстой гэсэн агуулгатай. Жишээлбэл: үйл ажиллагааныхаа үндсэнд хортой бодис үйлдвэрлэдэг үйлдвэр нь түүнийг аюулгүй устгах үүрэгтэй, хорт бодисоос үүсэх хохирлыг хариуцах үүрэгтэй гэсэн үг.

Бохирдуулагчаар төлүүлэх зарчим нь 1992 оны Хүрээлэн буй орчин ба хөгжлийн тухай Рио-де-Жанейрогийн тунхаглалын 16 дугаар зарчимд²⁹ тусгагдсаны дээр дэлхий даяар тогтвортой хөгжлийг чиглүүлэх өргөн хүрээний зарчмуудын нэг хэсэгт тооцогддог.³⁰

Байгаль орчныг хамгаалах олон нийтийн хөдөлгөөн нь "байгаль

орчинд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх", "учирсан хохирлыг арилгах, хариуцлага тооцуулах буюу ex-post" гэсэн үндсэн 2 чиглэлтэй³¹ ба энэ нь "бохирдуулагчаар төлүүлэх" зарчмыг хэрэгжүүлэх чиглэлтэй давхцдаг.

Энэхүү зарчмын сонгодог жишээг хэрэгжүүлж байгаа орноор Европын Холбоо /цаашид "ЕХ" гэх/-г дурдаж болно. Урьдчилан сэргийлэх чиглэлийн хувьд татвар ногдуулах, квот тогтоох эсвэл тодорхой технологи ашиглах гэсэн арга зам байдаг. Жишээлбэл: дэлхийн улсууд шатамхай түлшнээс татгалзаж байгаагаас үүдэн Европ тив даяар "илүү цэвэр" түлш нэвтрүүлж, шинээр үйлдвэрлэгдэж байгаа автомашины нүүрстөрөгчийн ялгаруулалтыг аажмаар бууруулж байна. Энэ нь Нэгдсэн Үндэсний Байгууллагын Уур Амьсгалын Өөрчлөлтийн Эсрэг Зөвлөгөөн /COP26/-өөс гарсан үр дүнг хэрэгжүүлж³², 2009 оны Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц буюу Парисийн хэлэлцээрийн³³ дагуу хүлээсэн үүргээ биелүүлж буй хэлбэр юм. Үүнээс гадна ЕХ-ны гишүүн орнууд усны цоргоны тоогоор бус усыг ашигласан хэмжээгээр төлбөр авдаг болсон нь энэ зарчимтай холбогдуулан хэрэгжүүлсэн дэвшилтэт

²⁷ Voluntary Approaches to Environmental Protection: Lessons from the Mining and Forestry Sectors, OECD Global Forum On International Investment, p.7-8.

²⁸ <https://www.lawnow.org/important-concepts-in-environmental-law-polluter-pays/> Сүүлд үзсэн: 2022.05.31

²⁹ 1993 оны 6 дугаар сарын 15-ны өдөр Монгол Улсын Их Хурлаас энэхүү Тунхаглалыг дэмжсэн тогтоол гарч байжээ. <https://legalinfo.mn/mn/detail/6367> Сүүлд үзсэн: 2022.05.31

³⁰ <https://www.lse.ac.uk/granthaminstitute/explainers/what-is-the-polluter-pays-principle/> Сүүлд үзсэн: 2022.05.31

³¹ Оюунтунгалаг Ж., Байгаль хамгаалах олон нийтийн хөдөлгөөн, үндэсний болон олон улсын туршлага. УБ 2021 он, 2 дахь тал. <https://legaldata.mn/b/980> Сүүлд үзсэн: 2022.06.02

³² 2021 оны Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх НҮБ-ын бага хурлын албан ёсны цахим хуудас, <https://ukcop26.org/the-conference/cop26-outcomes/> Сүүлд үзсэн: 2022.05.31

³³ *Ibid.* Тус хэлэлцээрээр дэлхийн дулаарлын хэмжээг 1.5 градусаас хэтрүүлэхгүй байхаар, энэ зорилгын хүрээнд ихээхэн хэмжээний үл сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс хэрэглээгээ хангадаг орнууд үе шаттайгаар үл сэргээгдэх эрчим хүчний хэрэглээгээ багасгаж, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахаар, байгалийн шавхагддаг нөөцийн олборлолтыг бууруулах, үл олборлох байдлаар ажиллахаар тохирсон.



алхам болсон байна.³⁴ Удаах чиглэл буюу хохирол учирсан тохиолдолд түүнийг нөхөн төлүүлж байгаа жишээ нь: ЕХ-ны улсуудын авто зам дагуу баригдсан барилгад амьдардаг хүмүүст ирэх дуу чимээг бууруулах хавтан эсвэл үүнтэй төстэй байгууламжуудыг барьж дуу чимээний түвшинг мэдэгдэхүйц бууруулж, тэнд амьдарч буй хүмүүст үзүүлэх хор хөнөөлийг бууруулах шалгарсан арга байдаг байна.

Канад Улсын олон хууль тогтоомжид “бохирдуулагч нь төлөх” зарчим тусгагдсан байдаг. Жишээлбэл: Альберта мужийн Байгаль орчныг хамгаалах, сайжруулах тухай хуулийн 2-р хэсэгт хуулийн зорилгыг тодорхойлохдоо “Бохирдуулагч үйл ажиллагааныхаа зардлыг төлөх үүрэг хүлээнэ.” гэж заасан байдаг. Энэхүү зорилгыг 108, 109-р зүйлд дэлгэрүүлэн “хэн ч байгаль орчинд зөвшөөрснөөс их хэмжээгээр”, эсвэл “их хэмжээний сөрөг нөлөө” үүсгэдэг бодисыг гаргахыг хориглоно” гэж тусгасан ба 112-р зүйлд “тэрхүү бодисын нөлөөг арилгах, хязгаарлах, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэхийн тулд бодисыг арилгах, зохицуулах, зайлуулах эсвэл өөр аргаар устгах, улмаар хүрээлэн буй орчныг сэргээх үүрэгтэй” гэж зохицуулсан.³⁵

Канад Улсын хуульд ийнхүү зохицуулсан хэдий ч иргэний эрх зүйн хариуцлагын хэлбэр нь уурхайн бохирдлын улмаас хохирсон хүмүүст нөхөн төлбөр бүрэн барагдуулах боломж олгодоггүй. Учир нь иргэн агаар, ус, хөрсний бохирдолтой холбоотой нэхэмжлэл шүүхэд гаргахад түүний эрх, ашиг сонирхол хөндөгдсөн, зөрчигдсэн байхыг шаарддаг. Олон нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэл гаргахад ч

эрх хэмжээний асуудлаас эхлээд олон бэрхшээлтэй тулгардаг амаргүй процесс байдаг. Нэхэмжлэл гаргахад тавигддаг хатуу шаардлага нь ихээхэн саад тотгор үүсгэж, шүүхээс “бохирдуулагчаар төлүүлэх” зарчмыг баримталж, уул уурхайн бохирдлын хохирогчдод шударга ёсыг тогтоох боломжийг хөндөж, бууруулдаг байна.³⁶

АНУ-ын Холбооны хууль тогтоомж нь иргэдэд хууль зөрчсөн бохирдуулагчдаас төлбөрийг гаргуулах боломж олгохын дээр төрийг иргэдийн эрүүл мэндийг хамгаалах үйлдэл хийгээгүйтэй холбоотой шүүхэд хандан нэхэмжлэл гаргахыг зөвшөөрдөгөөрөө³⁷ онцлог. АНУ-ын Цэвэр усны тухай хуулийн дагуу нэхэмжлэл гаргахад тавигдах шаардлага тийм ч хатуу биш бөгөөд иргэд хууль зөрчсөн этгээдийн эсрэг нэхэмжлэл гаргах эрхтэй байдаг. Хуулийн энэ заалт нь үйлдвэрийн бохирдлын хохирогчид шударга ёсыг тогтооход дэмжлэг үзүүлж, цаашид гарах зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд тустай³⁸ гэж үздэг.

Нөгөө талаас зарим судлаачид энэхүү зарчмыг “муу” гэж үздэг, учир нь энэ зарчим нь “бохирдуулах зөвшөөрөл олгосон” буюу “хэрэв та төлж чадах л бол бохирдуулахыг зөвшөөрнө гэсэн үг” гэх агуулгатай гэдэг. Энэхүү үзэлд тус зарчмыг хамгийн том дутагдалтай талыг “төлбөр” нь бүх “зардал”-ыг барагдуулдаггүй явдал гэж тодорхойлсон. Учир нь “зардал” нь ихэвчлэн үйл ажиллагааны зардлаар хязгаарлагддаг бөгөөд хохирлын хэмжээг бүрэн тусгадаггүй тул зарчмыг хэрэгжүүлэхэд саад учирна гэж үздэг байна.³⁹

³⁶ University of Victoria Environmental Law Centre, *Polluter Pays*, p.8.

³⁷ *Ibid.*

³⁸ *Ibid.*

³⁹ *Ibid.*

³⁴ <https://www.eea.europa.eu/signals/signals-2020/articles/interview-does-the-polluter-pay> Сүүлд үзсэн: 2022.05.31

³⁵ *Ibid.*



"Бохирдуулагчаар төлүүлэх" зарчмыг нийтлэг эрх зүйн тогтолцоо /common law/-той улсууд түгээмэл хэрэглэдэг ба хамгийн ихээр хэрэглэж шүүхийн шийдвэр гаргасан улсаар Энэтхэг Улсыг нэрлэж болохоор байна. Учир нь тус улс 1980-аад оноос эхлэн энэхүү зарчмыг ашиглан хэрэг маргааныг хянан шийдвэрлэж зарчмын үйлчлэх хүрээ хязгаар, хэрхэн хэрэглэх талаар практикийг тогтоосон. "Бохирдуулагчаар төлүүлэх" зарчмыг тайлбарлан хэрэглэж шийдвэр гаргасан жишээнээс дурдвал:

1. M.C. Mehta vs Union of India /1987/⁴⁰: Энэ нь нефтийн хий, аюултай, үхэлд хүргэх химийн бодис /эндээс идэмхий хлор, хүхрийн хүчил ялгарсан/ агаарт алдагдсан тохиолдол юм. Үүнээс үүдэн оршин суугч нарын эрүүл мэндэд аюул тулгарч байна гэж үзэж "аж үйлдвэрийн цогцолборыг нэн даруй хааж, нүүлгэн шилжүүлэхийг хүсч" гомдол гаргажээ. Шүүхэд хандсанаас 1 сарын дараа олон хүн тус хорт бодисоос үүдэн нас барж, хүндээр гэмтэж, ургийн хөгжилтэй хүүхэд төрсөн байна. Шүүх алдарт Rylands vs Fletcher маргаанд хэрэглэсэн хатуу хариуцлага /strict liability/-ыг энэ тохиолдолд хэрэглэх боломжгүй гэж үзэн үнэмлэхүй хариуцлагын /absolute liability/ талаар хэлэлцэж "бохирдуулагчаар төлүүлэх" зарчим нь тус улсын тогтвортой хөгжилд нэн чухал болохыг тэмдэглэн эдгээр үйлдвэрүүд нь улсын эдийн засгийн дэвшилд ихээхэн хувь нэмэр оруулсан буюу үйлдвэрээс усыг халдваргүйжүүлэхэд хэрэглэдэг хлор үйлдвэрлэдэг, ажлын байр бий болгосныг дурдсан. Шүүхийн шийдвэрээр "Бид үйлдвэрийг нийгэмд эрсдэл багатай байдлаар байршуулж, аюулгүй байдлын шаардлагыг оновчтой

⁴⁰ <https://www.lawcian.com/post/m-c-mehta-vs-union-of-india-1987-air-1086> Сүүлд үзсэн: 2022.06.03

болгохын тулд боломжтой бүх арга хэмжээг авснаар нийгэмд үзүүлэх аюул, эрсдэлийн хэмжээг багасгана." гэж үзээд үйлдвэрийг хүн ам багатай газарт нүүлгэн шилжүүлж, нөхөн төлбөр оногдуулахаар шийдвэрлээгүй байна.

2. Vellore citizens welfare forum vs Union of India /1996/⁴¹:

Тамил Наду мужийн арьс ширний үйлдвэрүүд Палар гол руу бохирдуулагч бодисыг хэт их хэмжээгээр хаяж байгаагаас ноцтой хэмжээнд усны бохирдол үүсч иргэд ундны усны нөөцийн хомсдолд өртсөн, газар тариалан эрхлэх аргагүй болсон, хөрс үржил шимгүй болсон, 467 худгаас 350 нь бохирдсон гэж шүүхэд хандсан маргаан. Улсын дээд шүүхээс "бохирдуулагчаар төлүүлэх" зарчим нь хүрээлэн буй орчны эрх зүйн нэг хэсэг гэж тогтоосон ба арьс ширний үйлдвэрүүд нь тус улсад хамгийн их орлого оруулдаг төдийгүй хүмүүсийг ажлын байраар хангадаг болохыг дурдаад бохирдуулагч арьс ширний үйлдвэрүүд өнгөрсөн хугацаанд үйлдвэрлэсэн бохирдлынхоо төлбөрийг төлөх үүрэгтэй гэж үзэн нэхэмжлэгчийн талд шийдвэрлэж, байгаль орчинд хор хөнөөл учруулсныг үнэлэх үнэмлэхүй хариуцлага нь зөвхөн хохирогчид учирсан хохирлыг нөхөн төлөхөөр хязгаарлагдахгүй гэж үзэн 10,000 рупигийн торгууль оногдуулсан.

3. M.C. Mehta vs Union of India /1996/⁴²:

Таж Трапецын бүсийг Таж Махалыг бохирдлоос хамгаалах зорилгоор барьсан. Тухайн бүс нутагт орших үйлдвэрээс ялгарах химийн хорт бодис нь борооны улмаас хүчиллэг бороо болон Тажийн цагаан гантиг

⁴¹ <https://lawsisto.com/legalnewsread/OTAONA==/Case-Analysis-Vellore-Citizens-Welfare-Forum-vs-Union-of-India> Сүүлд үзсэн: 2022.06.03

⁴² <https://indiankanoon.org/doc/1964392/> Сүүлд үзсэн: 2022.06.04



шарлахад нөлөөлсөн гэж үзэж үзэсгэлэнт газрыг хамгаалалтад авахыг хүсэн шүүхэд хандсан. Улсын дээд шүүх химийн бодисоос бусад нийгэм, эдийн засгийн хүчин зүйлүүд Тажийн доройтолд нөлөөлсөн, Усны урьдчилан сэргийлэх, хянах төв зөвлөлөөс гаргасан тайланд агаарын бохирдлын түвшинг өндөр гэж дүгнэсэн тул Трапедын бүсэд амьдардаг хүмүүс агаарын бохирдлын улмаас эрсдэлд орсон гэж дүгнэж 292 үйлдвэрийг аюулгүй түлшээр ажиллуулах, эсхүл нүүлгэн шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

4. M.C. Mehta vs Kamal nath /1997/⁴³: Спан Мотелийн хэрэг гэж нэрлэгддэг энэ хэргийг шийдвэрлэхдээ шүүхээс гол мөрөн, далайн эрэг, ой мод, агаар зэрэг байгалийн нөөц баялгийг олон нийт чөлөөтэй, саадгүй ашиглахын тулд засгийн газар хамгаалах ёстой гэх эртний Ромын эрх зүйн онолыг /public trust doctrine/ тайлбарлаж "байгаль орчныг бохирдуулсан хүн өөрийн үйлдлийнхээ улмаас учирсан хохирлоо нөхөн төлөх ёстой" гэж дүгнэсэн. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллаганы явцад Мотел нь үерээс хамгаалахын тулд гол мөрний урсгал /голдирол/-ыг өөрчилсөн нь нотлогдсон. Шүүхээс нөхөн төлбөрийн хэмжээг тогтооходоо Мотел нь тухайн бүс нутгийн байгаль орчин, экологийг нөхөн сэргээх хэмжээний зардлаар нөхөн төлбөр төлөх ёстой гэж үзжээ.

5. Indian Council for environmental legal action vs Union of India /2011/⁴⁴: Химийн үйлдвэрээс хорт бодис ялгарч байгаа нь ойролцоох тосгоны иргэдийн эрүүл мэндэд нөлөөлж байна гэсэн

⁴³ <https://lawcorner.in/m-c-mehta-v-kamal-nath-ors-critical-analysis-of-span-motels-case/> Сүүлд үзсэн: 2022.06.03

⁴⁴ <https://lawsuperior.com/indian-council-for-enviro-legal-action-v-union-of-india/#judgment> Сүүлд үзсэн: 2022.06.03

агуулга бүхий маргаан. Бохирдуулагч нь бохирдлоос урьдчилан сэргийлэх, аюултай үйл ажиллагаа явуулсны улмаас бохирдол үүсгэсэн тохиолдолд хохирлыг арилгуулах, санхүүгийн зардлыг бохирдуулсан этгээдэд ногдуулах, бохирдуулагч үл маргах журмаар төлнө гэсэн агуулгатай. Шүүхийн шийдвэрээр нөхөн төлбөр /байгаль орчинд учруулсан хохирол/ 37 сая рупиг нийлмэл хүүгийн хамт төлүүлэх, шийдвэр гарснаас хойш 15 жилийн турш түүнийг биелүүлээгүй тул 10 лакх буюу 1 сая рупиг нөхөн сэргээлтийн зардалд хариуцагчаас гаргуулан олгохоор шийдвэрлэсэн.

Энэтхэг Улсын шүүхийн шийдвэрийг дүгнэвэл, "бохирдуулагчаар төлүүлэх" зарчмыг "хатуу хариуцлага" буюу strict liability болгон хэрэглэдэг бус "үнэмлэхүй хариуцлага" буюу absolute liability гэж үзэн шүүхийн практикт хэрэглэдэг байхын сацуу бохирдуулагч хуулийн этгээдийн нийгэмд оруулсан эерэг нөлөөллийг харгалзан хохирлын нөхөн төлбөр төлүүлэх эсэх талаар шийдвэр гаргадаг, "байгаль орчинд учирсан хохирлын нөхөн төлбөр"-ийг "нөхөн сэргээлтийн зардал"-аас ялгаж үздэг, цаг хугацаа өнгөрөх хирээр "бохирдуулагчаар төлүүлэх" зарчимд үндэслэн нөхөн төлбөр гаргуулахаар шийдвэрлэдэггүй байсан нь үгүй болж буруутай этгээдээс нөхөн төлбөр гаргуулдаг, нөхөн төлбөр гэдэгт байгаль орчинд учирсан хохирол, нөхөн сэргээлтийн зардал хоёул багтахаар тодорхойлж байгаа практик тогтож эхэлсэн байна.

Энэтхэг Улсаас гадна бусад гадаад улсын шүүхэд "бохирдуулагчаар төлүүлэх" зарчимд үндэслэн уул уурхайн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учирсан хохирол, нөхөн сэргээлтийн зардлыг шийдвэрлэсэн маргаан байдаг эсэхийг судлахад, тийм тохиолдол



байгаагүй болно.

Гэвч энэ нь “бохирдуулагчаар төлүүлэх” зарчимд үндэслэн уул уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд учирсан хохирол, нөхөн сэргээлтийн зардлыг нэхэмжилсэн маргааныг хүний эрхийг хангаж хамгаалах, тогтвортой хөгжлийн суурь зарчимд нийцүүлэн улсын хөгжлийг хангах хүрээнд нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж шийдвэрлэх чиглэлээр хөгжих боломжийг хязгаарлахгүй гэж дүгнэлээ.

Д.Монгол Улсын шүүхийн практик

Уул уурхайн салбарын үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учруулсан хохирол нь нөхөн сэргээгдэх боломж хязгаарлагдмал, орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, амьдралын хэв маягт шууд болон дам, үе дамжсан байдлаар нөлөөлөх зэрэг ноцтой шинжтэй⁴⁵ ба энэхүү харилцаанд төрийн хүлээх үүргийг Үндсэн хуулиар⁴⁶ баталгаажуулсан. Дээрхээс үүдэн төрийн аль нэг байгууллагаас байгаль орчныг хамгаалах чиглэлээр уул уурхайн салбарын эсрэг нэхэмжлэл гаргаж болох хэдий ч энэ нь тэр бүр тохиромжтой арга хэрэгсэл биш бөгөөд ашиг сонирхлын зөрчил, үйл ажиллагааны үр нөлөө зэргээс шалтгаалан тэр бүр нэхэмжлэл гаргадаггүй байна⁴⁷.

Иргэний хэргийн шүүх нь уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэн байгаль орчныг нөхөн сэргээх хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгээгүйгээс байгаль орчинд учирсан хохирол, нөхөн сэргээлтийн зардлыг нэхэмжилсэн маргааныг иргэний хэрэг

⁴⁵ *Supra* note 32. p.2.

⁴⁶ Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлд “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасан.

⁴⁷ *Supra* note 32. p.4.

хянан шийдвэрлэх хуульд заасан журмын дагуу хянан шийдвэрлэдэг. Ингэхдээ “байгаль орчинд учруулсан хохирол⁴⁸ ба түүний нөхөн төлбөр⁴⁹” гэдгийг БОХТХ-д тодорхойлсон хүрээнд авч үздэг. Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим санд хайлт хийн судлахад ихэнх тохиолдолд хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлосон⁵⁰ тухай гэмт хэргийн шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр, тусгай зөвшөөрлийг цуцлуулахтай холбоотой нэхэмжлэлтэй захиргааны маргааныг хянан шийдвэрлэсэн шийдвэр түгээмэл байсан бол байгаль орчинтой холбоотой иргэний хэрэг, тэр дундаа уул уурхайн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учирсан хохирол, нөхөн сэргээлтийн зардлыг шийдвэрлэсэн иргэний хэргийн шүүхийн шийдвэр тун ховор илэрцтэй байсан болно. Хавсралт 1-ээр дурдсан агуулга бүхий нэхэмжлэлийн шаардлагатай маргаануудыг шүүхийн практикт хэрхэн шийдвэрлэж байгааг цөөн жишээгээр үзүүлэв.

Шүүхийн шийдвэрээс дүгнэж үзвэл, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, нөхөн сэргээлтийн зардлыг гаргуулах тухай нэхэмжлэлийн шаардлагатай маргаанд нэхэмжлэгч нараас нэхэмжлэлийн шаардлагын мөнгөн дүнгээ тодорхойлохдоо ихэвчлэн БОХТХ-ийн 49 дүгээр зүйлийн 49.4 дэх

⁴⁸ БОХТХ-ийн 3 дугаар зүйл. “байгалийн баялгийг зөвшөөрөлгүй бэлтгэсэн, олборлосон, эсхүл байгаль орчны чадавхын тогтоосон хэм хэмжээ, зөвшөөрөгдөх дээд хэмжээний хязгаараас хэтрүүлэн байгаль орчныг бохирдуулсан, доройтуулсан, гэмтээсэн, байгалийн нөөц баялгийг хомсдуулсан, экологийн тогтолцоог алдагдуулсан аливаа үйлдэл, эс үйлдэхүй.”

⁴⁹ Дээрх үйлдэл, эс үйлдэхүйн үр дагаврыг арилгах болон цаашид үүсч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай байгаль орчны экологи-дийн засгийн үнэлгээ, аргачлалын дагуу тогтоосон мөнгөн илэрхийллийг хэлнэ.

⁵⁰ Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлд заасан гэмт хэрэг.



хэсэгт зааснаар шинжээчийн дүгнэлтэд тодорхойлноос нэмэгдүүлсэн дүнгээр гаргадаг, шүүхийн шийдвэрийн агуулгаар нөхөн сэргээлт хийх зардал бус байгаль орчинд учирсан хохирлыг мөнгөн дүнгээр илэрхийлж шаардсаныг хангаж шийдвэрлэсэн байхаас гадна нийт шүүхийн хэмжээнд “байгаль орчинд учруулсан хохирол”, “байгаль орчныг нөхөн сэргээх зардал” гэсэн ойлголтуудыг шийдвэр гаргахдаа тайлбарлан хэрэглэж нарийн тодруулсан нэгдсэн ойлголт, практик харахан тогтоогүй⁵¹, шүүхийн шийдвэрээр нэхэмжлэгчийн гаргасан дүнг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн тохиолдол тун ховор, анхан шатны шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн боловч давж заалдах шатны шүүхээс шинжээч нарын дүгнэлт хэт зөрүүтэй байдаг тул анхан шатны шүүхэд буцаадаг, нэхэмжлэлийн шаардлагыг хангахгүй орхих тухай өөрчлөлт оруулдаг, нэхэмжлэлээр хангагдсан үнийн дүнд өөрчлөлд оруулж шийдвэрлэдэг байна.

Түүнчлэн хариуцагч хуулийн этгээдийн зүгээс уул уурхайн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд хохирол учруулсан үйл баримт нь шинжээч томилж дүгнэлт гаргуулахаас хугацааны хувьд “хэт өмнө” болсон тул бодитой дүгнэлт гаргах боломжгүй байдаг⁵² төдийгүй

⁵¹ УДШ-ийн 2017 оны 11 сарын 03-ны өдрийн 01383 дугаар тогтоолын ХЯНАВАЛ хэсэгт “байгаль орчинд учирсан хохирол болон хохирлын нөхөн төлбөр гэж тусдаа эрх зүйн ойлголт байна” гэжээ. https://shuukh.mn/single_case/3314?start_date=&end_date=&id=3&court_cat=1&bb=1 Сүүлд үзсэн: 2022.06.03

⁵² Сүхчулуун С. Байгаль орчинд учирсан хохирол, нөхөн сэргээлтийн зардлыг бохирдуулагч компаниас гаргуулах тухай нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг даргын нэхэмжлэлтэй иргэний хэргийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ, “Хэрэв байгаль орчинд учирсан хохирол үүссэнээс хойш олон жил өнгөрсөн зэрэг шалтгаанаар байгаль орчны хохирлын мөнгөн дүнг сэргээн тогтоох боломжгүй гэсэн дүгнэлтийг мэргэжлийн байгууллагаас гаргаж эхэлбэл цаашид байгаль орчинд учирсан хохирол,

зарим тохиолдолд хариуцагч хуулийн этгээдийн зүгээс тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулж байх боловч шинжээчийн дүгнэлт гарсны дараагаар техникийн нөхөн сэргээлтийг хийж эхэлдэг, энэ талаар маргаан үүсвэл дахин шинжээч томилох хүсэлт гаргадаг, ингэснээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад цаг хугацаа алдахаас гадна зардал их хэмжээгээр гардаг, хариуцагчийн тусгай зөвшөөрлийг цуцалсан эсхүл түдгэлзүүлсэн тул байгаль орчинг нөхөн сэргээх үүргээ биелүүлэхээс түдгэлздэг ба энэ тохиолдолд байгаль орчинд хохирол учирсан хэвээр, хохирол улам даамжирдаг, цаг хугацаа алдах нөхцөл үүсдэг байна гэж дүгнэлээ.

Дүгнэлт

Уул уурхайн салбарын онцлог нь үндэстэн дамнасан корпорациуудын хөрөнгө оруулалт, эдийн засгийн хувьд маш өргөн хүрээг хамарсан, байгаль орчинд учруулах хор аюул нь урт удаан хугацааны дараа илрэн гарах буюу үе дамжсан байх шинжтэй, энэ утгаараа ашигт малтмал олборлох салбарын хувьд байгаль орчныг хамгаалах асуудал нь олон нийтийн анхаарлыг татсан асуудлын нэг болж байдаг.⁵³

Монгол Улсад 2016 оны байдлаар 21 аймгаас 15 аймгийн 56 сумын нутаг дэвсгэрт 566 нэгж талбарт 3984.46 га газар уул уурхайн улмаас эвдрэлд орж эзэнгүй орхигдсон байсан төдийгүй эдгээр газрыг нөхөн сэргээхэд хамгийн багадаа 1 га талбайг 25 сая төгрөгөөр, бүрэн нөхөн сэргээхэд 80-100 тэрбум

түүний нөхөн төлбөрийг тогтоох үйл ажиллагаа үр дүнгүй болох, улмаар байгаль орчны хохирлыг нөхөн төлүүлэх үйл ажиллагаа хариуцагч этгээдгүй болох, байгаль орчны хохирлын нөхөн төлбөрийн шаардлагатай мөнгөн дүнг хэн хариуцан гаргах нь тодорхойгүй болох зэрэг олон асуудал үүсгэхээр байна.” гэж тэмдэглэжээ. <https://legaldata.mn/buteel/pdf?id=825> Сүүлд үзсэн: 2022.06.02

⁵³ *Supra* note 32. p.1.



төгрөгийн зардал шаардлагатай гэсэн судалгаа байдаг. Нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд 2016 оны эхний хагас жилийн байдлаар 10.5 тэрбум төгрөгийг байршуулсан⁵⁴ байсан нь эвдрэлд орсон талбайг бүгдийг нь, бүрэн хэмжээнд нөхөн сэргээх зардлын үнэлгээтэй харьцуулахад түүний маш бага хэсэг байна.

Монгол Улсын шүүхээс уул уурхайн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учирсан хохирол, нөхөн сэргээлтийн зардлыг гаргуулах тухай нэхэмжлэлтэй маргааныг Иргэний хуулийн 497 дугаар зүйл, БОХТХ, АМТХ-ийн зохицуулалтад үндэслэн хянан шийдвэрлэдэг байна. Түүнчлэн байгаль орчинд учирсан хохирлын нөхөн төлбөр, нөхөн сэргээлтийн зардал нь хоёр өөр ойлголт төдийгүй тэдгээрийг тус тусад нь үнэлэх⁵⁵ нь зүйтэй ба үүнийг шүүгч нар шийдвэр гаргахдаа анхаарах талаар судлаач тэмдэглэсэн байх нь бий. Энэ төрлийн маргааныг хянан шийдвэрлэхэд анхаарах асуудлын нэг нь шинжээч нарын дүгнэлтийн нэгдсэн байдал яах аргагүй мөн тул тухайн хөндөгдөж эвдэгдсэн газар нутгийн хохирлыг аргачлалын дагуу тооцоолсон шинжээчийн дүгнэлт, нөхөн сэргээлт хийхэд гарах зардлыг аргачлалын дагуу тооцоолсон шинжээчийн дүгнэлтэд үндэслэн, баталгааны дансанд байгаа мөнгөн хөрөнгөөс илүү зардал гарахаар бол түүнийг хуульд заасны дагуу үл маргах журмаар гаргуулахад анхаарах байдлаар цаашид хэрэг маргааныг хянан шийдвэрлэх нь зүйтэй гэж дүгнэлээ.

Монгол Улсын хууль тогтоомжид тусгагдсан зарчмын хүрээнд “бохирдуулагчаар төлүүлэх” зарчмыг

хуульчлаагүй боловч БОХТХ-ийн 49 дүгээр зүйлд агуулгын хүрээнд тусгасан байна гэж үзэх үндэслэлтэй.

Хэдийгээр дэлхийн хүн амын дийлэнх хэсэг мэддэг болсон “бохирдуулагчаар төлүүлэх” зарчмыг шүүхээс хэрэглэж хэрэг маргааныг хянан шийдвэрлэх явдал дэлгэрч байгаа боловч уул уурхайн салбараас учирсан хохирол, нөхөн сэргээлттэй холбоотой маргааныг энэхүү зарчимд үндэслэн, хариуцагчаас төлбөр гаргуулах тухай шийдвэрлэсэн маргаан судалгааны ажлын хүрээнд олдсонгүй.

Гэсэн хэдий ч энэ нь “бохирдуулагчаар төлүүлэх” зарчим цаашид хэрэгжиж шударга ёсыг тогтоож хүрээлэн буй орчныг “эрүүлжүүлж” хүн, амьтан, ургамал хэвийн ургаж нөхөн төлжих процессийг дэмжих, агаар, ус, хөрсний бохирдлоос ангид байх эх үндэс болохыг үгүйсгэх аргагүйгаас гадна энэхүү зарчмыг хэрэглэн шүүхээс шийдвэр гаргах боломжийг ч хязгаарлахгүй юм.

Эх сурвалж

Хууль, журам:

1. Ашигт малтмалын тухай хууль, 2006 он.
2. Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он.
3. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал.
4. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээх ажлын зардлын үнэлгээ тооцох аргачлал.
5. Үндсэн хууль, 1992 он.
6. Эрүүгийн хууль, 2015 он.

Ном, сурах бичиг, гарын авлага, хөтөлбөр:

1. Амархүү О., Байгаль орчныг

⁵⁴ БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга Д.Даваасамба, Нөхөн сэргээлтийн бодлого, эрх зүйн орчин 2016 он, илтгэл, хэлэлцүүлэг, 5 дахь тал.

⁵⁵ *Supra* note 53. p.4,8.



- хамгаалах Монгол зан заншил, хууль цааз, 2000 он.
2. БОАЖЯ-ны Нөхөн сэргээлтийн бодлого, эрх зүйн орчин /илтгэл, хэлэлцүүлэг/ 2016 он.
 3. Оюунтунгалаг Ж., Байгаль хамгаалах олон нийтийн хөдөлгөөн, үндэсний болон олон улсын туршлага, 2021 он.
 4. Уул уурхайн салбар дахь тэргүүн туршлага-тогтвортой хөгжлийн хөтөлбөр
 5. Эрдэс баялгийн эрх зүйн тойм, 2012 он.
 6. Сэнгэдорж Т., Экологийн эрх зүй, 2009 он.
 7. Сүхчулуун С., Байгаль орчинд учирсан хохирол, нөхөн сэргээлтийн зардлыг бохирдуулагч компаниас гаргуулах тухай нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг даргын нэхэмжлэлтэй иргэний хэргийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ.

Цахим эх сурвалж, гадаад хэл дээрх эх сурвалж:

1. Voluntary Approaches to Environmental Protection: Lessons from the Mining and Forestry Sectors, OECD Global Forum On International Investment.
2. University of Victoria Environmental Law Centre, Polluter Pays.
<https://www.lawnow.org>
<https://legalinfo.mn>
<https://www.lse.ac.uk>
<https://legaldata.mn>
<https://ukcop26.org>
<https://www.eea.europa.eu>
<https://lawsuperior.com>
<https://lawsisto.com>
<https://lawcorner.in>
<https://www.lawcian.com>
<https://shuukh.mn>



Abstract

JUDICIAL PRACTICE OF HANDLING DISPUTES ON NEGLIGENCE OF MINE REHABILITATION AND THE POLLUTER PAYS PRINCIPLE (PPP)

D.BYAMBA-OD

*Researcher of the Civil law Sector,
Judicial Training, Research and Information Institute under
Supreme Court of Mongolia*

In the context of the topic, the court's practice of resolving claims for damages and rehabilitation costs for non-compliance with its legal obligations to rehabilitate the environment has been examined in relation to the principle of "polluter pays".

Keywords: Environmental law, pollution, international principle, "polluter compensation", court practice, rehabilitation, damages, compensation

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАНХИМЫН ТЭРГҮҮН Г.АЛТАНЧИМЭГ

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Өнөөдрийн сэдэв маань үнэхээр чухал ач холбогдолтой болохыг өмнөх илтгэгч нар, мөн дүгнэлт үг хэлсэн хүмүүс хэллээ. Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-д уул уурхайн салбарыг тэргүүлэгч чиглэл болгон хөгжүүлэхэд ач холбогдол өгөхөөр тусгагдсан. Уул уурхайн салбар нь байгаль орчныг бохирдуулж буй хамгийн гол салбар юм. Тиймээс энэхүү үзэл баримтлалд уул уурхайг ил тод, хариуцлагатай олборлох үйлдвэрлэлийг хөгжүүлэхийн зэрэгцээ байгаль орчны нөхөн сэргээлтийн ажлаа зайлшгүй хийдэг байх, нөхөн сэргээлтийг хийхдээ олон улсын стандарт шаардлагад нийцүүлэх, өөрөөр хэлбэл, байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалах гэсэн чиглэл, үзэл баримтлалыг дэвшүүлсэн.

Өнөөдөр бидний ярьж буй зүйл бол эрүүгийн, захиргааны, иргэний эрх зүйн салбар чиглэлээр байгаль орчныг хэрхэн хамгаалах, хүрээлэн буй орчныг бохирдуулж буй энэ асуудалтай яаж тэмцэж байгаа тухай бид хэлэлцэж байна. Эдгээр салбарын харилцан уялдаа холбоо зайлшгүй нэг нэгэндээ шүтэлцэж, харилцан хамааралтай байгаа нь бидний өмнө тавьсан илтгэлүүдээр тодорхой харагдаж байна.

Нэгдүгээрт, хууль бус буюу зөвшөөрөлгүйгээр уул уурхайн олборлолт явуулж байгаа, байгалийг бохирдуулж байгаа үйл ажиллагаанаас үүсэж байгаа хохирол, үйлдэл иэхэвчлэн эрүүгийн гэмт хэрэг байх магадлал илүүтэй байна. Эрүүгийн эрх зүйн чиглэлийн илтгэлүүдээс харахад, эрүүгийн гэмт хэрэг нэлээд үйлдэгдэж байгаа юм байна, Энэ гэмт хэргийн улмаас учирсан хохирлын асуудал буюу гэмт хэргийн шинжид хэдий хэр хэмжээний хохирол учруулсан юм бэ гэдэг нь эрүүгийн гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл байдал болж байна. Тэгэхээр энд зайлшгүй хэдий хэмжээний хохирол учруулсан байна гэдэг асуудал хамгийн гол асуудал буюу, шинжээч үүнийг тодорхойлж, ямар нэгэн байдлаар гэм хорын асуудал эрүүгийн хэрэгтэй хамт шийдэгдэж байгаа юм байна.

Хууль бусаар буюу зөвшөөрөлгүй олборлолт хийх, бусад хууль бус үйлдлийн улмаас байгаль орчинд учирсан хохирлын асуудал иргэний хэргийн шүүхэд гарсан практик байдаг, гэхдээ их цөөн. Их цөөн байгаа болохоор шүүхийн практик иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бас төдийлөн сайн тогтож чадаагүй байгаа.

Хоёрдугаарт, хууль ёсоор зөвшөөрөлтэй уул уурхайн үйл ажиллагаа



явуулахад тухайн хуулийн этгээд зайлшгүй нөхөн сэргээлтийн ажиллагаа явуулах үүргийг хуулиар хүлээдэг. Нөхөн сэргээлтийн зардлыг урьдчилаад орон нутгийн санд төвлөрүүлдэг, өөрөө хийхгүй бол түүгээр нь орон нутгийн байгууллага энэ зардлыг нөхөн сэргээлтэд ашигладаг тухай Ашигт малтмалын хуулийн зохицуулалт байгаа.

Илтгэлийн хүрээнд дүгнэлт хийхэд, иргэний эрх зүйн чиглэлийн эхний илтгэл буюу Г.Энхбаяр докторын илтгэлд тэрээр өөрийн судалгааны хүрээг тодорхой тодорхойлсон байна. Нэгдүгээрт, шаардах эрхийг хэн хэрэгжүүлэх вэ, иргэний журмаар нэхэмжлэл гаргахад шаардах эрхийг хэрэгжүүлэх субъект хэн байхав, ямар асуудалд анхаарлаа хандуулах вэ гэдэг нь илтгэлийн гол зорилго, хөндөх зүйл нь байсан гэж би ойлголоо. Тэгэхээр хууль тогтоогч байгаль орчинд учруулсан хохирол шаардаж нэхэмжлэл гаргах эрхтэй этгээдийг хэд хэдэн хуульд тодорхойлон зааж өгсөн. Тухайн орон нутгийн байгууллагууд, мөн төрийн бус байгууллагууд, иргэд гаргадаг, Тэр тусмаа прокурор гаргадаг ийм шүүхийн практикууд байна. Гэсэн хэдий ч хуульд тодорхойлоод заагаад өгчихсөн этгээдүүд иргэний журмаар нэхэмжлэл гаргах нөхцөл нь бүрддэггүй учраас иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төдийлэн оролцож шүүхэд хандаад байдаггүй. Яагаад гэвэл түрүүн дурдсанаар хууль бус олборлолттой холбоотой бол хохирол эрүүгийн журмаар шийдвэрлэхийг хянаж байдаг асуудал байна. Дээрээс нь гаргах ёстой нэхэмжлэлээ гаргахгүй байх тохиолдол байхыг үгүйсгэхгүй. Яагаад гэхээр тухайн орон нутгийн удирдлагууд шүүхэд хандах, эсхүл иргэд санаачлаад шүүхэд хандах энэ асуудал учир дутагдалтай байдаг юм уу гэж харж байна. Харин

төрийн бус байгууллагууд харьцангуй тодорхой хэмжээнд энэ асуудал дээр дуу хоолойгоо гаргаад шүүхэд ханддаг. Төрийн бус байгууллагын гаргасан нэхэмжлэлтэй хэргийг шийдвэрлэсэн шүүхийн практик хэд хэд байгаа.

Прокурорын асуудал дээр илтгэгч шүүхийн практикт прокурор нэхэмжлэл гаргах эрхтэй, эрхгүй гэсэн янз янзаар шийдэгдээд байна аа, прокурор энэ төрлийн гэм хорын хохирол шаардаад иргэний шүүхэд хандах боломж нь юу байна аа гэдэг ийм асуудлыг хөндөж тавилаа. Шүүхийн практикт янз бүр байгаа гэдгийг олж харсан байна. Прокурор иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэл гаргах эрх нь Прокурорын тухай хуульд байна.

Түүнчлэн одоо 2022 оны 7 сарын 1-ний өдрөөс даган мөрдөгдөх гэж буй Иргэний процессын хуульд прокурор төрийн болон нийтийн ашиг сонирхлын үүднээс төрийн байгууллагын хүсэлтээр болон өөрийн санаачлагаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоор өөрчлөлт орж батлагдсан. Тэхээр зайлшгүй иргэний хэрэг шүүн таслах ажиллагаанд прокурор оролцохдоо яаж оролцох юм бэ гэдэг асуудал бидний шүүн таслах практикт гараад байгаа асуудал тодорхой хэмжээнд шийдэгдэнэ гэж харж байна. Прокурор хэмжээ хязгааргүй оролцох юм уу, эсвэл тодорхой маргаанд оролцох юм уу, оролцохдоо эрх, үүргээ яаж тогтоох юм бэ гэсэн энэ асуудал дээр Улсын дээд шүүх тэр тусмаа Иргэний хэргийн танхим энэ асуудлыг тал талаас нь ярьж хэлэлцэж байгаа.

Байгаль орчин, экологитой холбоотойгоор хүрээлэн буй орчныг хамгаалах, байгальд учирсан гэм хорыг төлүүлэх асуудлыг прокурор өөрөө



санаачлагаараа гаргах, эсвэл төрийн байгууллагын хүсэлтээр гаргах ийм шийдэл байж болно гэж үзэж байна. Учир нь, Монгол Улсын иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх байна, энэ эрхийг Монгол Улсын Их хурал, Засгийн газар Үндсэн хуулиар иргэдийнхээ өмнө хүлээсэн үүрэг нь байж байгаа.

Энэ асуудал, байгаль орчны бохирдол гэдэг маань эргээд иргэдийн аюулгүй байдал, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхтэй холбоотой учраас энэ хэмжээнд нь төр, нийгмийн ашиг сонирхолд харшилсан үйлдэл байна аа гэдэг агуулгаар прокурор нэхэмжлэл гаргах боломж нь байна. Гэхдээ ямар нэгэн төрийн байгууллага, иргэн, төрийн бус байгууллага нэхэмжлэл гаргах боломжтой байхад прокурор санаачлаад нэхэмжлэл гаргаад байх нь зохисгүй.

Харин нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд нь эрхээ хэрэгжүүлэхгүй байгаа тохиолдлууд байна. Санаатай, санамсаргүй янз бүрийн асуудлууд байна. Энэ санаатай, санамсаргүй асуудлаас болоод хэн ч гэм хорын хохирол нэхэхгүй үлдээд байдаг асуудал байгаа учраас энэ дээр прокурор асуудлыг хянах тогтолцоо хэрэгтэй гэж харж байна. Бүр нэхэмжлэх субъект байхгүй асуудал ч байна. Тэгэхээр энэ хэмжээнд нь прокурор нэхэмжлэл гаргаад явах боломж нь байгаа юм болов уу.

Улсын дээд шүүхийн 2002 оны иргэний процессын хуулийг тайлбарласан тайлбар байдаг 263 дугаар тогтоол гээд. Энэ тогтоолд одоо хүчин төгөлдөр үйлчлэх гээд байгаа прокурорын эрх хэмжээг арай өргөн болгоогүй байхад өмнөх хуулийн заалтыг тайлбарласан, энэ тайлбарын хүрээнд ч авч үзвэл, ач холбогдлоо алдаагүй байгаа. Юу гэж тайлбарласан бэ гэхээр Их хурал,

Засгийн газрын хэмжээнд Үндсэн хуульд заасан энэ эрхээ хэрэгжүүлэх явцад прокурор, тэр тусмаа байгаль орчинтой холбоотойгоор байгалийг хамгаалах, нөхөн сэргээх гэм хорын асуудал дээр прокурор шүүхэд нэхэмжлэл гаргаад оролцох боломжтой гээд тайлбарласан байдаг.

Хоёрдугаарт, эхний илтгэгчийн илтгэлд дурдсан улсын тэмдэгтийн хураамжийн асуудал байна. Шүүхэд нэхэмжлэл гаргахад улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх юм уу үгүй юу гэдэг энэ асуудал дээр бас тодорхойгүй байна. Хууль яг зааж өгөөгүй байгаа учраас ямар нэгэн иргэн шүүхэд нэхэмжлэл гаргах гэхээр улсын тэмдэгтийн хураамжаас болоод нэхэмжлэл гаргахгүй тохиолдол байх магадлалтай. Ямар төрлийн нэхэмжлэл улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх вэ гэдгийг заагаад өгчихсөн байдаг. Тэхээр энэ дээр илтгэгчийн хэлж байгаагаар байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан гэм хортой холбоотой асуудлыг шууд улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх тухай хууль тогтоогчид санаачлах ийм хэмжээнд байж болох юм аа гэсэн санааг дэмжиж байна.

Одоогийн байдлаар нэхэмжлэл гаргах байгаа шүүхийн практикаас харах юм бол ихэвчлэн орон нутгийн байгууллага нэхэмжлэл гаргаад явах, тэр нь төсвийн байгууллага гэдгээрээ улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгддөг. Прокурор гаргаад ирэх юм бол прокурорын нэхэмжлэлийг улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлдөг асуудал хуульд байна, Тэгэхээр иймэрхүү маягаар явж байна. Энийг нэг мөр тодорхой болгох нь зүйтэй байх аа. Илтгэлийн хүрээнд улсын тэмдэгтийн хураамжийг хөндсөн чухал асуудал боллоо гэж харж байна.



Дараагийн асуудал бол шинжээчийн дүгнэлттэй холбоотой. Бид шинжээчийн дүгнэлтийн хүрээнд хохирлыг шийддэг, харин шинжээч арга аргачлалаа, тодорхой ямар байдлаар гаргадаг юм бэ? Журмууд бол байгаа, тэр журмаараа арга аргачлалаа тогтоодог байх гэхдээ энэ дээр олон улсын жишиг, хандлага юу байна аа гэдэг ийм асуудлыг шүүгч хүн ойлгож, судалж байх ёстой.

Дараагийн илтгэлийн хувьд, Д.Бямба-Од илтгэгч нөхөн сэргээлт, нөхөн сэргээлтийн зөвшөөрөлтэй компаниуд нөхөн сэргээлтийн ажлаа хэрхэн хийх, уул уурхайн салбарт голцуу бохирдуулагчаар хохирлыг төлүүлэх зарчим гадаадын улсад ямар хэмжээнд байна, тэр тухай хөнджээ. Мөн манай иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ямархуу хэмжээнд байна вэ гэдэг дээр тодорхой судалгаа хийсэн байна. Гадаад улсын шүүхийн практикт янз бүрээр шийдсэн асуудал байдаг юм байна, Үүнийг их тодорхой, сонирхолтой жишээтэй ярилаа. Биологийн нөхөн сэргээлт, техникийн нөхөн сэргээлт гэсэн чиг заагийг тодрууллаа. Гэм хорын хохиролтой холбоотой гадаад улсын чиг хандлага нь юу байна гэхээр, эхлээд урьдчилан шийдвэрлэх арга хэмжээ, хэрвээ ямар нэгэн байдлаар бодитоор хохирол учирсан бол энэ хохирлыг төлүүлэх хариуцлагын арга хэмжээг авахыг чухалчилдаг, эдгээр асуудлууд дээр тодорхой тайлбарлаж сонирхолтой мэдээлэл өглөө.

Манай улсын энэ төрлийн маргаан шийдвэрлэх хууль эрх зүйн орчны хувьд бол гайгүй гэж миний хувьд боддог. Манай улс 10-аад олон улсын конвенцид нэгдэн орсон, Энэ чиглэлээр журам, дүрмүүд их байна. Нөхөн сэргээлтийг хугацаанд нь хийгээгүй, дутуу хийсэн, энэнээс болоод хохирол учирлаа гэдэг энэ нэхэмжлэлийн шаардлага өөрөө иргэний шүүх дээр ямар нэхэмжлэлийг гаргаж, үндэслэлээ хэрхэн тайлбарлаж байна вэ гэдгээсээ хамаараад янз бүрийн шийдэл гарч байна. Ашигт малтмалын тухай хууль, Иргэний хууль, Байгаль орчныг хамгаалах хууль эдгээрээс алийг нь хэрэглэх вэ, алинд нь хамааралтай шаардлага юм бэ гэдэг ийм асуудлууд шийдэгдэх ёстой болдог.

Ихэвчлэн нөхөн сэргээлттэй холбоотой, хууль ёсоор уул уурхайн үйл ажиллагаа явуулаад энэ ажиллагаагаа дутуу хийсэнтэй холбоотой нэхэмжлэлийн шаардлага гарч байна. Зөвшөөрөлгүйгээр уул уурхай эрхэлж түүнээс нь гэм хохирол учирлаа гэсэн маргаан би шүүхийн практикт төдийлөн их харсангүй. Ийм асуудал хүрээд ирэх юм бол бид энэ дээрээ сайн анхаарал хандуулж судалж шүүхийн практикаа зөв тогтоох ёстой. Судлаач нар цаашид энэ сэдвийн хүрээнд судалгаагаа үргэлжлүүлэх нь зүйтэй болов уу. Та бүхэнд амжилт хүсье.

**БАЙГАЛЬ ОРЧИН БОЛОН СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ
АСУУДЛААР ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГАД НЭХЭМЖЛЭЛ
ГАРГАХ ЭРХИЙГ ОЛГОХТОЙ ХОЛБООТОЙ ЯПОН УЛСЫН
ӨНӨӨГИЙН ЧИГ ХАНДЛАГА**

**THE CURRENT TENDENCY OF PUBLIC INTEREST LITIGATION
BY NGOS ON ENVIRONMENTAL ISSUES IN JAPAN.**

Сүхбаатарын СҮХЧУЛУУН¹

- I. Оршил
- II. Нэг. Захиргааны хэрэг дээрх нэхэмжлэл гаргах эрхийн хязгаар ба байгаль орчны ашиг сонирхол Санал
- III. Хоёр. “Байгаль орчин болон соёлын өвийг хамгаалах чиглэлээр төрийн бус байгууллага нэхэмжлэл гаргахтай холбоотой хуулийн төсөл” онцлог зохицуулалт
- IV. Дүгнэлт
- V. Ном зүй

¹ Сүхбаатарын Сүхчулуун LL.M (Nagoya University, Graduate School of law) Ph.D Candidate(Nagoya University, Graduate School of law) МУ-ын Үндсэн хуулийн цэцийн Судалгааны төвийн судлаач



**БАЙГАЛЬ ОРЧИН БОЛОН СОЁЛЫН ӨВИЙГ
ХАМГААЛАХ АСУУДЛААР ТӨРИЙН БУС
БАЙГУУЛЛАГАД НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХ ЭРХИЙГ
ОЛГОХТОЙ ХОЛБООТОЙ ЯПОН УЛСЫН
ӨНӨӨГИЙН ЧИГ ХАНДЛАГА**

С.СҮХЧУЛУУН. LL.M (Nagoya University, Graduate School of law)
Ph.D Candidate(Nagoya University, Graduate School of law) МУ-ын
Үндсэн хуулийн цэцийн Судалгааны төвийн судлаач

Түлхүүр үг: Байгаль орчны асуудал, нийтийн ашиг сонирхлыг төлөлөөн нэхэмжлэл гаргах, төрийн бус байгууллага, захиргааны хэргийн нэхэмжлэл, шүүхийн хяналт

Товчлол: Япон Улсад одоогоор байгаль орчны асуудлаар¹ төрийн бус байгууллагад шүүхэд нэхэмжлэл гаргах эрх нээлттэй биш юм. Иймд байгаль орчны асуудлаар төрийн бус байгууллагад нэхэмжлэл гаргах эрхийг нээлттэй болгох нь зүйтэй эсэх дээр онолын маргаан одоог хүртэл өрнөж байгаа билээ. Тухайлбал, 2012.06.15-ны өдөр Япон Улсын Өмгөөлөгчдийн холбооноос “Байгаль орчин болон соёлын өвийг хамгаалах² чиглэлээр төрийн бус байгууллага нэхэмжлэл гаргахтай холбоотой хуулийн төсөл” боловсруулсан байна³. Гэвч одоогоор уг

хуулийн төсөл батлагдаагүй хэвээр байна. Энэхүү илтгэлд тус хуулийн төслийн онцлог зохицуулалтыг танилцуулах замаар Монгол Улсын хувьд цаашид тус тогтолцоог илүү боловсронгуй болгоход анхаарах зүйл юу байж болохыг тусгасан болно.

Харин Монгол Улсын хувьд 2010.07.08-ны өдрийн Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиар (1)иргэн, (2) Байгаль орчин, түүний баялгийг хамгаалах дүрмийн зорилго бүхий олон нийтийн байгууллага болон байгалийн нөөцийн хамтын менежмент эрхлэн явуулах нөхөрлөл (цаашид ТББ)-д (гэм буруутай этгээдээс) байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг олгосон юм (БОХТХ 4.1.2 дахь заалт, 32.1.1 дэх заалт). Мөн 2016.02.04-ний өдрийн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж, захиргааны хэргийн шүүхэд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээдийн нэгээр тус хуулийн 18.3-т заасан шаардлага хангасан ТББ хүрээлэн байгаа орчинг хамгаалах

nichibenren.or.jp/document/opinion/year/2012/120615_3.html 2022.05.31-ний өдрийн хандалт. Мөн дараах бүтээлийн 393-412 талд хавсралт байдлаар хэвлэгдсэн байна. 阿部泰隆 = 齊藤浩編『行政訴訟第2次改革の論点』(信山社、2013年) 393-412頁。

¹ Япон Улсын хувьд “байгаль орчин” (自然環境) болон “хүрээлэн байгаа орчин” (環境) гэсэн тус тусдаа нэр томъёо ялгаатай агуулгаар хэрэглэгддэг. Эхнийх нь ан амьтан, уул ус гэх мэт зөвхөн байгаль эхтэй хамааралтай бол сүүлийнх нь дуу чимээ, агаар, усны бохирдол гэх мэт хүний амьдрах орчин зэргийг багтаасан өргөн утга бүхий юм. Уг илтгэлд “байгаль орчны асуудал” гэдгийг эхний утгаар буюу зөвхөн байгаль эхтэй хамааруулж авч үзсэн болно.

² Уг хуулийн төсөлд үндсэндээ хоёр агуулга багтсан байна. Нэгт, байгаль орчин(хүрээлэн байгаа орчин)-г хамгаалах асуудал юм. Хоёрт, соёлын өвийг хамгаалах асуудал юм. Илтгэлийн сэдэвт уялдуулан уг илтгэлд зөвхөн байгаль орчинтой холбоотой зохицуулалтыг авч үзлээ.

³ Тус хуулийн төслийг дараах холбоосоор үзэх боломжтой. Япон Улсын Өмгөөлөгчдийн холбооны цахим хуудас, <https://www.>



асуудлаар нэхэмжлэл гаргах эрхтэй болжээ (ЗХШХШТХ-ийн 3.1.9 дэх заалт, 18.3.1 дэх заалт).

Дүгнэвэл, байгаль орчны асуудлаар ТББ-д шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг нээлттэй болгох тухайд Япон Улс болон Монгол Улсын эрх зүйн тогтолцоо ихээхэн ялгаатай байна. Байгаль орчны асуудлаар ТББ-д нэхэмжлэл гаргах эрхийг нээлттэй хуульчилсан Монгол Улсын хувьд дээрх тогтолцоог нэвтрүүлээгүй Япон Улсын туршлагаас суралцах зүйл бага мэт санагдах нь зүйн хэрэг юм. Япон Улс одоог хүртэл (2022 он) ТББ-д тус нэхэмжлэл гаргах эрхийг нээлттэй болгоогүй шалтгаан юу болох түүнчлэн дээрх хуулийн төслийн онцлог зохицуулалтыг танилцуулах замаар Монгол Улсын хувьд цаашид тус тогтолцоог илүү боловсронгуй болгоход анхаарах зүйл юу байж болохыг уг илтгэлд тусгахыг хичээв.

Нэг. Захиргааны хэрэг дээрх нэхэмжлэл гаргах эрхийн хязгаар ба байгаль орчны ашиг сонирхол

Япон Улсын Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (行政事件訴訟法) -ийн 9.1-д нэхэмжлэл гаргах эрх (原告適格) -ийн тухайд “захиргааны акт, шийдвэрийг хүчингүй болгох нэхэмжлэлийг зөвхөн тухайн захиргааны акт, шийдвэрийг хүчингүй болгохтой холбоотойгоор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд гаргаж болно⁴” гэж заажээ. Япон Улсад 4 昭和三十七年法律第百三十九号 行政事件訴訟法, 第九条 処分の取消しの訴え及び裁決の取消しの訴え(以下「取消訴訟」という。)は、当該処分又は裁決の取消しを求めるにつき法律上の利益を有する者(処分又は裁決の効果が期間の経過その他の理由によりなくなつた後においてもなお処分又は裁決の取消しによつて回復すべき法律上の利益を有する者を含む。)に限り、提起することができる。Энд 「法律上の利益を有する者」 гэдгийг 2002 оны Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, болон 2016 он Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан нэр

захиргааны акт, шийдвэрийг хүчингүй болгох нэхэмжлэл гаргах эрх нь зөвхөн өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд нэхэмжлэл гаргах зарчимтай байна. Иймд байгаль орчны асуудлаар захиргааны хэргийн нэхэмжлэл гаргах үед тухайн зөрчигдсөн гэж үзэж буй ашиг сонирхол нь нэхэмжлэгчийн өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хамаарна гэж үзэхэд хүндрэлтэй тулгардаг.

Байгаль орчны асуудлыг шүүхэд нэхэмжлэл гаргах замаар хамгаалахын тулд үндсэндээ хоёр сонголт байна гэж дүгнэж болох юм. Нэгдүгээрт, тухайн байгаль орчны асуудал дээр хөндөгдөж буй ашиг сонирхол нь нэхэмжлэгчийн өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хамааралтай гэдгийг хуулийн заалтыг тайлбарлах замаар шийдвэрлэх юм. Хоёрдугаарт, байгаль орчны асуудал дээр хөндөгдөж буй ашиг сонирхол нь хувь иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхолд хамааруулж болохгүй тул нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэл гаргах эрхийг хуульчилж өгөх арга зам юм.

Тухайлбал, эхний сонголтын хүрээнд байгаль орчны ашиг сонирхол гэдгийг гурван түвшинд хувааж үзэх онолын санааг дэвшүүлдэг судлаач нар байна. Жишээлбэл, судлаач Ватари Тадасү⁵ (亙理格) өөрийн бүтээлдээ байгаль орчны ашиг сонирхол нь хувийн ашиг сонирхол эсхүл нийтийн ашиг сонирхол гэж хоёр хэсэгт хатуу хуваагдаж ирсэн байдлыг өөрчилж гурав дахь ашиг сонирхол “хосолмол ашиг сонирхол” (共同利益)

томьёонд нийцүүлэн “эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд” гэж орчуулсан болно.

⁵ Одоогоор Япон Улсын Chuo University-д харьяалагдаж байна. Хүрээлэн байгаа орчны эрх зүйг захиргааны эрх зүйн үүднээс голчлон судалдаг судлаач юм.



байж болох санааг дэвшүүлсэн байна⁶. Мөн судлаач Оцүка Тадаши⁷ (大塚直) хувь хүнд хамааралтай байгаль орчны ашиг сонирхол байж болох нь зүйн хэрэг тул (эрүүл мэнд, эд хөрөнгийн хохирол хүртсэн гэх мэт) түүнд хамаарахгүй байгаль орчны ашиг сонирхлыг (1) нийтийн ба хувийн ашиг сонирхол давхардсан ашиг сонирхол (環境関連の公私複合利益) болон (2) цэвэр байгаль орчны ашиг сонирхол (純粹環境利益) гэж хувааж болох санааг дэвшүүлжээ⁸.

Харин хоёр дахь хандлагын тухайд Окүбо Норико⁹ (大久保規子) Япон Улсад байгаль орчны асуудлаар захиргааны хэргийн нэхэмжлэл гаргахад нэхэмжлэгчийн өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн байхыг шаардах бөгөөд өнөөгийн шүүхийн шийдвэрийн жишигт дээрх “эрх, хууль ёсны ашиг сонирхол” гэдгийг хэт явцуу тайлбарлан, нэхэмжлэгчийн нэхэмжлэл гаргах эрхийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа шүүхийн хандлага өөрчлөгдөхгүй байгаа тул хууль батлах замаар асуудлыг шийдвэрлэх нь оновчтой гэсэн саналыг дэвшүүлдэг. Мөн Окүбо Норико судлаачийн хувьд хүрээлэн байгаа орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, шүүхэд хандах эрхийн талаарх Аархусын конвенцид Япон Улс нэгдэн орох зайлшгүй шаардлагатай гэсэн байр суурийг илэрхийлдэг бөгөөд

⁶ 亙理格「環境公益訴訟 環境団体訴訟の法制化を中心に」『環境法における参加』（環境法政策学会編、2019年）57頁参照。亙理格「共同利益と『権利』認定の方法」民商法雑誌2013年148巻6号519-520頁

⁷ Одоогоор Япон Улсын Waseda University-д харьяалагдаж байна. Иргэний эрх зүйн үүднээс хүрээлэн байгаа орчны эрх зүйг судалдаг судлаач юм.

⁸ 大塚直「環境訴訟における保護法益の主観性と公共性 序説」法律時報2010年82巻11号121頁。

⁹ Одоогоор Япон Улсын Osaka University-д харьяалагдаж байна. Хүрээлэн байгаа орчны эрх зүй, захиргааны эрх зүйн чиглэлээр голчлон судалгаа хийдэг.

энэ хүрээнд байгаль орчны асуудлаар ТББ-д нэхэмжлэл гаргах эрхийг хуульчлан тогтоох шаардлага тулгарч байна хэмээн үздэг байна¹⁰.

Дээрхээс дүгнэвэл, байгаль орчны холбогдолтой хэрэг дээрх зөрчигдсөн ашиг сонирхол нь хувь хүний өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хамааруулж тайлбарлахад хүндрэлтэй учраас уг асуудлаар шүүхэд захиргааны хэргийн нэхэмжлэл гаргахад нэхэмжлэл гаргах эрх зөвшөөрөгдөхгүй байх магадлал ихтэй ажээ. Япон Улсын хувьд өнөөдрийг хүртэлх хугацаанд тухайн хэрэг дээрх зөрчигдсөн ашиг сонирхол юу болохыг дэлгэрүүлэн тайлбарлах, нэхэмжлэгчийн өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хамааралтай ашиг сонирхол мөн гэж тайлбарлах арга ашиглагдаж иржээ. Гэвч дээрх судлаач нар бүтээлдээ дурдсанчлан байгаль орчны ашиг сонирхол нь хэдийгээр дэлгэрүүлэн тайлбарлаж болох ч хувь хүнд хамааралтай гэж тайлбарлах боломжгүй цэвэр байгаль орчны ашиг сонирхол (нийтийн ашиг сонирхол) гэж гарч ирэх тул уг асуудлыг хуульчлах замаар шийдвэрлэх нь зүйтэй гэдэг дээр ихэнх судлаач санал нэгддэг байна. Үүний тод илрэл нь дээр дурдсан 2012.06.15-ны өдөр Япон Улсын Өмгөөлөгчдийн холбооноос “*Байгаль орчин болон соёлын өвийг хамгаалах чиглэлээр төрийн бус байгууллага нэхэмжлэл гаргахтай холбоотой хуулийн төсөл*” боловсруулсан явдал юм. Доорх хэсэгт тус хуулийн төслийн онцлог зохицуулалтаас танилцуулах болно.

Хоёр. “Байгаль орчин болон соёлын өвийг хамгаалах чиглэлээр төрийн бус байгууллага нэхэмжлэл гаргахтай холбоотой хуулийн төсөл” онцлог зохицуулалт

¹⁰ 大久保規子「オーストラリア条約と環境公益訴訟」環境政策学会編『公害 環境紛争処理の変容』（商事法務、2012年）145-146頁。



Уг хуулийн төсөл нь нийт 6 бүлэг, 25 зүйлээс бүрдэхээр боловсруулагджээ. Өмнө дурдсанчлан Монгол Улсын хувьд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах тогтолцоог нэвтрүүлсэн юм. Иймд тус хуулийн төсөлд тусгагдсан

ялгаатай зохицуулалт, түүнчлэн цаашид Монгол Улсын тогтолцоог боловсронгуй болгоход санаа болох үүднээс дараах цөөн зохицуулалтыг сонгосон болно (Доорх хүснэгтийг үзнэ үү).

No.	Агуулга	Хуулийн төслийн заалтын дугаар
1	Иргэн өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзэн нэхэмжлэл гаргах эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй байх	• Хуулийн төслийн үзэл санаа
2	Нэхэмжлэл гаргах эрх бүхий ТББ нь эрх бүхий байгууллагаас урьдчилж батламж авсан байх	• 2 дугаар зүйл 2 дахь хэсэг • 9 дүгээр зүйл
3	ТББ-аас шүүхэд нэхэмжлэл гаргасан зэрэг тохиолдолд тэдгээрийн тухай шүүх нэн даруй нээлттэй мэдээлэх	• 20 дугаар зүйл
4	Нэхэмжлэгч ТББ-ын гаргасан өмгөөллийн хөлсний тодорхой хэсгийг хариуцагч талд хариуцуулах	• 21 дүгээр зүйл
5	Нэхэмжлэгч ТББ эдийн засгийн ашиг сонирхлын үүднээс зүй бус нэхэмжлэл гаргах зэрэгт хариуцлага тооцох	• 23 дугаар зүйл

1. Иргэн өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзэн нэхэмжлэл гаргах эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй байх тухайд:

Уг хуулийн төсөл нь олон нийтийн ашиг сонирхол эсхүл тодорхой хэсэг бүлгийн ашиг сонирхол хэмээн тодорхойлж болохуйц асуудлаар шаардлага хангасан ТББ-д уг асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг олгох агуулгатай тул дээрх ашиг сонирхолтой холбоотойгоор иргэн өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэсэн үндэслэлээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй гэдгийг хуулийн төслийн тайлбарт дурдаж өгчээ. Харин манай улсын хувьд 2016 оны ЗХШХШТХ-д хүрээлэн байгаа орчны асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийг ТББ-д олгосон тул шүүхээс байгаль орчны асуудлаар иргэн нэхэмжлэл гаргах тохиолдолд тэднийг энэ төрлийн нэхэмжлэл гаргах эрхгүй гэж

үзэх хандлага харагдаж байна¹¹.

2. Нэхэмжлэл гаргах эрх бүхий ТББ нь эрх бүхий байгууллагаас урьдчилж батламж авсан байх тухайд:

Тодруулбал, хуулийн төслийн 2-р зүйлд зааснаар “Энэ хуульд заасан <Шүүхэд нэхэмжлэл гаргах эрх бүхий ТББ> гэдэгт (1) “Хүрээлэн байгаа орчны асуудлаас шалтгаалан хүний эрүүл мэндэд хохирол учрах явдлаас урьдчилан сэргийлэх, байгаль орчин, хүний амьдралын орчин, хотын орчин, түүнчлэн эх дэлхийн орчинг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, түүний талаарх судалгаа шинжилгээ хийдэг, тус чиглэлээр мэдээлэл цуглуулдаг эсвэл түгээх ажиллагаа явуулдаг” дүрмийн зорилго бүхий (2) тус хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу Засгийн газрын тэргүүн эсхүл тухайн засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаас энэ хуульд заасан журмын дагуу ТББ-ын нэхэмжлэлийг гаргахад

¹¹ Өмнөх ишлэл (3) тал 395 頁。



тавигдах шаардлагыг бүрэн хангасан гэж үзэн батламж олгогдсон ТББ-ыг хэлнэ¹²” гэж заажээ. Харин Монгол Улсын хувьд 2016 оны ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлд зааснаар хүрээлэн байгаа орчны асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий ТББ-д тавигдах шаардлагыг нэхэмжлэгч ТББ хангасан эсэхийг шүүхээс тодорхой хэрэг тус бүр дээр үнэлэн тогтоодог ялгаатай байна.

3. ТББ-аас шүүхэд нэхэмжлэл гаргасан зэрэг тохиолдолд тэдгээрийн тухай шүүх нэн даруй нээлттэй мэдээлэх тухайд:

Тухайлбал, хуулийн төслийн 20 дугаар зүйлд дараах агуулга бүхий заалт тусгажээ. Тус зүйлд “Шүүх дараах тохиолдолд ТББ-ын нэхэмжлэл гаргах журамд заасныг баримтлан нэн даруй тухайн нэхэмжлэлийн зорилго болон агуулга түүнчлэн журамд тусгасан бусад зүйлийг Засгийн газрын тэргүүн эсхүл тухайн засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагад нэн даруй мэдэгдэх, мөн адил мэдэгдлийг цахим хэлбэрээр танилцах боломжоор хангасан байхыг шаардана. 1) Шүүхэд нэхэмжлэл ирсэн тохиолдолд, 2) Шүүхийн шийдвэр танилцуулсан тохиолдолд, 3) Дээрх 2)-д заасан шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргасан эсхүл энэ заалтад заасан

¹² Говьсүмбэр аймгийн Шивээ говь сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоол болон мөн сумын Засаг даргын захирамжийг тус тус хүчингүй болгуулах тухай Говьсүмбэр аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019.01.08-ны өдрийн 113 ШШ2019/0001 дугаар шийдвэр (113/2018/0013/3) Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, https://shuukh.mn/single_case/4876?start_date=&end_date=&id=1&court_cat=3&bb=1.

Тус хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал https://shuukh.mn/single_case/2729?start_date=&end_date=&id=2&court_cat=3&bb=1 үзнэ үү. Тус хэргийн Улсын дээд шүүхийн тогтоол https://shuukh.mn/single_case/1949?start_date=&end_date=&id=3&court_cat=3&bb=1 үзнэ үү. 2022.06.02-ны өдрийн хандалт.

шийдвэрт гомдол гаргасан тохиолдолд, 4) Шүүхийн шатанд талууд эвлэрсэн тохиолдолд¹³” гэж заажээ.

Шүүхээс дээрх дөрвөн тохиолдолд холбогдох мэдээллийг нээлттэй байлгах нь тухайн хэргийн нэхэмжлэгч ТББ-ын дурдсан асуудлаар дахин өөр ТББ-аас нэхэмжлэл гаргах байдлаас зайлсхийх, хэрэв тийм ТББ байгаа бол тус хэргийн нэхэмжлэлд гуравдагч этгээдээр оролцох боломжийг олгох зэрэгт чиглэсэн зохицуулалт хэмээн тайлбарлагддаг байна¹⁴. Харин Монгол Улсын ЗХШХШТХ-д дээрх агуулгатай төсөөтэй зохицуулалт хараахан тусгагдаагүй гэж дүгнэхээр байна¹⁵. Мөн Г.Банзрагч бүтээлдээ шүүх нэг маргааны зүйлийг олон дахин шийдэхгүй байх нь шүүхийн шийдвэрийн хүчин чадалтай холбоотой асуудал гэж дүгнэсэн¹⁶ байх тул тухайн нэг

¹³ (定義) 第2条 この法律において「団体訴訟」とは、第5条から第7条までの規定による訴訟をいう。2. この法律において「適格環境団体」とは、次の目的を持ち、この法律の規定による団体訴訟を提起するのに必要な適格性を有する団体として、第9条の定めるところにより内閣総理大臣又は都道府県知事(以下「内閣総理大臣等」という。)の認定を受けた団体(以下「適格環境団体」と総称する。)をいう。一 公害若しくは健康被害を防止し、自然環境、生活環境、都市環境若しくは地球環境を保護するための活動又はこれらに関する研究、情報の収集若しくは提供のための活動(以下「環境保護活動等」という。)

¹⁴ (公表) 第20条 裁判所は、次に掲げる場合には、団体訴訟等について規則で定めるところにより、遅滞なく、その旨及びその内容その他法令で定める事項を内閣総理大臣等に通知するとともに、電磁的方法(電子情報処理組織を使用する方法その他の情報通信の技術を利用する方法をいう。)を利用して同一の情報を閲覧することができる状態に置く措置であって法令で定めるものを講じなければならない。一 訴えの提起があったとき。二 判決の言渡しがあったとき。三 前号の判決に対する上訴の提起又は同号の決定に対する不服の申立てがあったとき。四 裁判上の和解が成立したとき。

¹⁵ Өмнөх ишлэл (3) тал 409-410-ийн 1-р хэсэг.

¹⁶ ЗХШХШТХ-ийн 131 дүгээр зүйл. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянах үндэслэл “131.1.4.гуравдагч этгээдийг татан оролцуулалгүйгээр шүүхээс хэргийг хянан шийдвэрлэсэн нь шүүхийн шийдвэрт ноцтойгоор нөлөөлсөн.” гэх зохицуулалт шууд бус байдлаар



хэргийг хянан шийдвэрлэхдээ нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах сонирхол бүхий өөр ТББ байгаа эсэх, тэдгээрийг тус нэхэмжлэлд нэгдэж оролцох боломжийг олгох нь зүйтэй байна.

4. Нэхэмжлэгч ТББ-ын гаргасан өмгөөллийн хөлсний тодорхой хэсгийг хариуцагч талд хариуцуулах тухайд:

Хуулийн төслийн 21 дүгээр зүйлд дараах агуулга тусгагджээ. Тодруулбал “Шүүх нэхэмжлэгч ТББ-ын нэхэмжлэл нь хангагдсан (бүрэн болон хэсэгчлэн) бол хэрэв тухайн хэрэг дээр өмгөөллийн хөлс төлөхөөр байгаа тохиолдолд нэхэмжлэгчийн хүсэлт гаргаснаар хариуцагч талд хэргийн ээдрээ төвөгтэй байдал, өмгөөлөгчийн өмгөөллийн үйл ажиллагааны оролцоо болон бусад нөхцөлийг харгалзан тэрхүү өмгөөллийн хөлсний хэмжээ дотор үндэслэлтэй гэж үзсэн тодорхой мөнгөн дүнг хариуцуулахаар шийдвэрлэж болно¹⁷” гэж заажээ. Мөн шүүх нэхэмжлэлийн шаардлага, хэргийн шийдвэрлэлт бусад нөхцөлийг харгалзан үндэслэлтэй гэж үзвэл нэхэмжлэгчийн хүсэлт гаргаснаар өмгөөллийн хөлс(бүтэн болон тодорхой хувь)-ийг хариуцагч захиргааны байгууллагад хариуцуулахаар шийдвэрлэж болохоор тусгасан байна¹⁸. Түүнчлэн шүүхийн зардалтай холбоотойгоор дээрхтэй адил заалт

хуулийн төсөлд тусгагджээ¹⁹. Энэ тухайд Монгол Улсын хувьд захиргааны хэргийн шүүхэд хандаж нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээдийн гаргасан нэхэмжлэлийг тэмдэгтийн хураамжаас чөлөөлөхөөр заасан (Улсын тэмдэгтийн хураамжийн тухай шинэчилсэн найруулга 2010 он, 41.1.13 дахь заалт). Түүнчлэн 2016 оны ЗХШХШТХ-д зааснаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжилж байгаа этгээдийг шүүхийн зардлаас чөлөөлнө(ЗХШХШТХ 2016 он, 46.3 дахь заалт). Харин нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжилж байгаа нэхэмжлэгч ТББ өмгөөллийн хөлс төлөхөөр байгаа тохиолдолд ямар нэгэн хөнгөлөлт, чөлөөлөлтийн зохицуулалт хараахан бүрэлдээгүй гэж дүгнэхээр байна.

5. Нэхэмжлэгч ТББ эдийн засгийн ашиг сонирхлын үүднээс зүй бус нэхэмжлэл гаргах зэрэгт хариуцлага тооцох тухайд:

Хуулийн төслийн 23 дугаар зүйлд “Шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийн асуудлаар батламж авсан ТББ-ын гишүүн болон ажилтан нь тухайн ТББ-ын нэхэмжлэлд дурдсан хариуцагч талаас хандив, санхүүгийн дэмжлэг түүнчлэн өөр бусад ямар ч байдлаар тухайн ТББ-ын гаргах нэхэмжлэлд дурдсан нэхэмжлэлийн шаардлага гаргахгүй байх эсхүл гаргаагүй, нэхэмжлэлээсээ татгалзах эсхүл татгалзсан, хариуцагч талтай нэхэмжлэлийн зүйлээр эвлэрэх эсхүл эвлэрсэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болсонтой холбоотойгоор шан харамж маягаар мөнгөн болон бусад эд хөрөнгийн ашиг хүртэх, эсхүл гуравдагч этгээд(тухайн

хэрэглэгдэх боломжтой эсэх нь маргаантай асуудал байж болох юм.

¹⁷ Г.Банзрагч, Захиргааны процессын эрх зүй, 2019 он, 145-146 дахь тал (ISBN 978-9919-22-620-6).

¹⁸ (弁護士報酬等の負担の特例) 第21条 裁判所は、団体訴訟を提起した適格環境団体が勝訴(一部勝訴も含む。)した場合において、その委任した弁護士又は弁護士法人に報酬を支払うべきときは、敗訴した被告に対し、申立てにより、事案の難易、弁護士の労力その他の事情を勘案し、その報酬額の範囲内で相当と認められる額を支払わせることができる。

¹⁹ 21.2. 裁判所は、前項の規定にかかわらず、請求の内容、事案の解決その他の事情を勘案して相当と認めるときは、原告の負担すべき弁護士又は弁護士法人に対する報酬の全部又は一部を、申立てにより、被告となった行政庁に対し、支払わせることができる。



ТББ мөн адил хамаарна)-д хүртээсэн бол 3-н жил хүртэлх хугацаагаар хорих эсхүл 300.000 иен хүртэлх хэмжээгээр торгоно²⁰ гэж тусгажээ. Энэ тухайд Монгол Улсын хувьд 2016 оны ЗХШХШТХ-д нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргасан этгээд нь хэрэг үүсгэснээс хойш нэхэмжлэлээсээ бүрэн болон хэсэгчлэн татгалзахыг хориглоно гэсэн зохицуулалт дам хэлбэрээр үйлчилж байна (ЗХШХШТХ 2016 он, 20.3 дахь заалт). Харин бусад байдлаар нэхэмжлэгч ТББ-ын нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах ажиллагааг илүү хариуцлагатай болгоход чиглэсэн зохицуулалт хараахан байхгүй.

Гурав. Дүгнэлт

Байгаль орчны асуудлаар ТББ-д шүүхэд нэхэмжлэл гаргах эрх (нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах)-ийг Япон Улсад одоогоор нээлттэй хуульчилж өгөөгүй байна. Япон Улсын Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар нэхэмжлэл гаргах эрх нь зөвхөн өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн байх тохиолдолд үйлчлэх журамтай тул байгаль орчин гэх мэт хувь хүний өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхол гэж үзэхэд эргэлзээтэй хэрэг дээр ихэвчлэн нэхэмжлэгчийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх үгүйсгэгддэг байна. Учир иймд ихэнх судлаачид байгаль орчны асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийг хуульчилж өгөх зайлшгүй шаардлагатай гэж үздэг байна. Үүний дүнд тухайлбал, тус илтгэлд танилцуулсан 2012.06.15-ны өдөр "Байгаль орчин

болон соёлын өвийг хамгаалах чиглэлээр төрийн бус байгууллага нэхэмжлэл гаргахтай холбоотой хуулийн төсөл" боловсруулагдсан гэж дүгнэхээр байна.

Төгсгөлд нь дээрх хуулийн төслөөс Монгол Улсын одоогийн хүрээлэн байгаа орчны асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах тогтолцоонд санаа болох зүйлсийг дурдах нь зүйтэй.

Нэгт, Монгол Улсын хувьд хэдийгээр хүрээлэн байгаа орчны асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг ТББ-д олгосон боловч тухайн тохиолдолд маргаж буй ашиг сонирхол нь хувь хүнд хамааруулж болох эрх, хууль ёсны ашиг сонирхол байж болохыг үгүйсгэхгүй тул уг асуудлаар иргэний өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэсэн үндэслэлээр нэхэмжлэл гаргах эрхийг хязгаарлах, тухайн хязгаарлалтыг зөвтгөх үндэслэл нь уг тогтолцоо болох учиргүй юм.

Хоёрт, шүүх хүрээлэн байгаа орчны асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл хүлээн авсан тохиолдолд энэ тухайд нэн даруй олон нийтэд мэдээлэх, тус хэрэг дээр нэгдэж оролцох хүсэл сонирхолтой бусад ТББ-ын оролцоо зэргийг хангах нь зүйтэй байна.

Гуравт, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжилж байгаа этгээдийг шүүхийн зардал болон тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх зохицуулалт нэгэнт үйлчилж байгаа тул цаашид нэхэмжлэгчийн өмгөөллийн хөлсийг хэрхэн хөнгөвчлөх боломж байгаа тухайд бусад холбогдох хуулийн хамаарлыг судлах шаардлага тулгарч байна.

Дөрөвт, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах нэн ялангуяа

²⁰ 21.3. 裁判所は、民事訴訟法第61条及び同法第64条の規定にかかわらず、請求の内容、事案の解決その他の事情を勘案して相当と認めるときは、訴訟費用の全部又は一部を、被告に対し、支払わせることができる。



хүрээлэн байгаа орчны асуудал дээр нэхэмжлэл гаргахад хариуцагч тал болон гуравдагч этгээдтэй ямар нэгэн санхүүгийн дэмжлэг, шан харамж зэрэг зүй бус тохиролцоо гарч болохыг үгүйсгэхгүй тул дээрхтэй холбогдох хариуцлагын зохицуулалт хэрэгтэй гэж дүгнэхээр байна. Одоогийн хууль дахь тухайлбал, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргасан этгээд нь хэрэг үүсгэснээс хойш нэхэмжлэлээсээ бүрэн болон хэсэгчлэн татгалзахыг хориглоно (ЗХШХШтХ 2016 он, 20.3 дахь заалт) гэсэн нь хангалттай хязгаарлалт болно гэж үзэхэд эргэлзээтэй.

Дөрөв. Ашигласан материал

1. Г.Банзрагч, Захиргааны процессын эрх зүй, 2019 он, (ISBN 978-9919-22-620-6).
2. 阿部泰隆＝斉藤浩編『行政訴訟第2次改革の論点』（信山社、2013年）393-412頁。
3. “*Байгаль орчин болон соёлын өвийг хамгаалах чиглэлээр төрийн бус байгууллага нэхэмжлэл гаргахтай холбоотой хуулийн төсөл*” Япон Улсын Өмгөөлөгчдийн холбооны цахим хуудас, https://www.nichibenren.or.jp/document/opinion/year/2012/120615_3.html 2022.05.31-ний өдрийн хандалт.
4. 亓理格「環境公益訴訟 環境団体訴訟の法制化を中心に」『環境法における参加』（環境法政策学会編、2019年）57-79頁。
5. 亓理格「共同利益と『権利』認定の方法」民商法雑誌2013年148巻6号513-550頁。
6. 大塚直「環境訴訟における保護法益の主観性と公共性 序説」法律時報2010年82巻11号116-126頁。
7. 大久保規子「オーフス条約と環境公益訴訟」環境政策学会編『公害 環境紛争処理の変容』（商事法務、2012年）133-147頁。



Abstract

THE CURRENT TENDENCY OF PUBLIC INTEREST LITIGATION BY NGOS ON ENVIRONMENTAL ISSUES IN JAPAN.

S.SUKHCHULUUN

LL.M (Nagoya University, Graduate School of law)

Ph.D Candidate(Nagoya University, Graduate School of law)

This article introduces the current tendency of environmental public interest litigation by NGOs in Japan. Currently, NGOs cannot file public interest litigation on environmental issues. On the other hand, almost scholars seek that Japan shall consider the establishment of public interest litigation by NGOs on environmental issues. For example, in 2012, the Japan Federation of Bar Associations drafted a bill on litigation by NGOs to protect the environment and cultural properties(hereafter referred to

as the Bill). Unfortunately, however, the Bill has not yet been enacted. This article shows the main point of the Bill and how the difference between the Mongolian system. Also, this article suggests what we can lesson from the Bill to Mongolian law, especially in NGOs litigation.

Keywords: The environmental issue, public interest litigation, NGOs, administrative litigation, judicial review

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХТАЙ ХОЛБООТОЙ
ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРҮҮДЭД
ЗАРИМ МАРГААНЫ ТӨРЛӨӨР ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

**ANALYSIS OF SOME TYPES OF DISPUTES
IN DECISIONS OF THE ADMINISTRATIVE COURT
RELATED TO ENVIRONMENTAL PROTECTION**

Советханы ЖАНСАЯ¹

- I. Үндсэн хэсэг
- II. Санал
- III. Дүгнэлт
- IV. Эх сурвалж

¹ Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн Үндсэн хууль, олон улсын эрх зүйн судлаач



БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХТАЙ ХОЛБООТОЙ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРҮҮДЭД ЗАРИМ МАРГААНЫ ТӨРЛӨӨР ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

С.ЖАНСАЯ. Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн Үндсэн хууль, олон улсын эрх зүйн судлаач, Москвагийн (ОХУ) Улсын Удирдлагын Их Сургуулийн магистр

Хураангуй: Энэхүү илтгэлийн хүрээнд байгалийн хүчин зүйлсийг ашиглах явцад бий болсон эрсдлүүд, сөрөг үр дагаваруудыг арилгах, цаашдын боломжит илүү их эрсдлүүдээс урьдчилан сэргийлэхийн тулд хувь хүмүүс, хуулийн этгээдүүдийн зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхолоо хамгаалуулахаар гаргасан нэхэмжлэл, гомдлуудад дүн шинжилгээ хийж, эрх зүйн хүрээнд тулгамдаж буй асуудлуудыг хөндөж, тус асуудлуудын шийдлийг олохыг зорьсон болно. Энэхүү илтгэлд бичсэн агуулга, санаа, дүгнэлт маань судлаачийн үүднээс хандаж, судлахыг хичээсэн судалгаа гэдгийг дурдах нь зүйтэй.

Түлхүүр үгс: байгаль орчин, зөрчигдсөн эрх, хувь хүмүүс, хуулийн этгээд, шүүхийн шийдвэр.

ҮНДСЭН ХЭСЭГ

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрүүд дотроос байгаль орчныг хамгаалах асуудалтай холбоотой “газар” гэсэн маргааны төрлөөс тусгай хамгаалалттай газрыг, ашигт малтмал гэсэн маргааны төрлөөс “ашигт малтмалын тухай” шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолуудыг¹ сонгон дүн шинжилгээ хийхээр болов. Тус маргааны

төрлүүдийг сонгосон шалтгаан маань “Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн” 3 дугаар зүйлд зааснаар² “Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар байгалийн дор дурдсан объектыг байгаль орчинд хортой нөлөөлж болзошгүй үйл ажиллагаанаас хамгаалж, байгаль орчны тэнцэл алдагдахаас сэргийлнэ. Үүнд: 1/газар, түүний хөрс; 2/газрын хэвлий, түүний баялаг г.м. орно” гэсэн бөгөөд үүнээс үзэхэд газар, түүний хөрс; газрын хэвлий, түүний баялаг (ашигт малтмал) нь яалтачгүй байгалийн бүрэлдэхүүн хэсэг хэмээн судлаачын зүгээс үзэн Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрүүдийн дотроос “газар” гэсэн маргааны төрлөөс “тусгай хамгаалалттай газрын тухай”, “ашигт малтмал” гэсэн маргааны төрлөөс “ашигт малтмалын тухай” шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолуудад дүн шинжилгээ хийхээр болов. Ингэхдээ анхан шатны шүүх, давж заалдах шатны шүүх, хяналтын шатны шүүх захиргааны хэргүүдийг ямар байдлаар шийдвэрлэж байгаа талаар тоон мэдээлэл гаргаж, нэхэмжлэгчид ямар – ямар нэхэмжлэлийн шаардлага гаргаж байгаа талаар дурьдаж, мөн гурван шатны шүүх тус захиргааны хэргүүдийг хэрхэн шийдвэрлэж

¹ Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сангийн албан ёсны цахим хуудас (2022 он) URL: <https://shuukh.mn/cases/1/1>(Сүүлд үзсэн 2022.05.27)

² Байгаль орчныг хамгаалах тухай (1995 он) URL: <https://legalinfo.mn/mn/detail/8935> (Сүүлд үзсэн 2022.05.27)



байгаа талаар Монгол Улсын шүүхийн тоон мэдээллүүдийг судлаачын зүгээс шийдвэрийн цахим санг ашиглаж дараах гаргасан болно.

Хүснэгт (1) (2). 2019-2021 оны хооронд улсын хэмжээнд Захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн “Тусгай хамгаалалттай газартай холбоотой маргааны судалгаа” болон “Ашигт малтмалтай холбоотой маргааны судалгаа”³

2019 – 2021 он							
“Газар” гэсэн маргааны төрлөөс “тусгай хамгаалалттай газрын тухай”							
АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН НИЙТ 98 ШИЙДВЭР			ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ НИЙТ 81 МАГАДЛАЛ			ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХИЙН НИЙТ 47 ТОГООЛ	
№	Нэхэмжлэлийг хэнд хандаж гаргасан	Нийт шийдвэрийн тоо	№	Гомдлыг хэнд хандаж гаргасан	Нийт магадлалын тоо	№	Гомдлыг хэнд хандаж гаргасан
1	Холбогдох нэр бүхий төрийн байгууллагын албан тушаалтанд	79	1	Холбогдох нэр бүхий төрийн байгууллагын албан тушаалтанд	74	1	Холбогдох нэр бүхий төрийн байгууллагын албан тушаалтанд
2	Орон нутгийн аймгуудын Засаг дарга нарт	6	2	Орон нутгийн аймгуудын Засаг дарга нарт	1	2	Нийслэлийн болон Нийслэлийн холбогдох дүүргийн Засаг дарга нарт
3	Нийслэлийн болон Нийслэлийн холбогдох дүүргийн Засаг дарга нарт	13	3	Орон нутгийн аймгуудын Засаг дарга болон ИТХд	1		
			4	Нийслэлийн болон Нийслэлийн холбогдох дүүргийн Засаг дарга нарт	5		
ХЭРГҮҮДИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ							
Тоо	Анхан шатны шүүхийн хэргүүдийг шийдвэрлэсэн байдал	Тоо	Давж заалдах шатны шүүхийн хэргүүдийг шийдвэрлэсэн байдал	Тоо	Хяналтын шатны шүүхийн хэргүүдийг шийдвэрлэсэн байдал		
49	нэхэмжлэлийг хангасан	19	гомдлыг хангаж	2	гомдлыг хангасан		
40	хэргийг хэрэгсэхгүй болгож	47	гомдлыг хангаагүй	35	гомдлыг хангаагүй		
2	нэхэмжлэлийн зарим хэсгийг хангаж, зарим хэсгийг хэрэгсэхгүй болгосон	7	анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасан	3	магадлалыг хүчингүй болгож, Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн		
1	захиргааны байгууллагаас дахин шинэ акт гартал тус байгууллагын холбогдох тушаалын нэхэмжлэгчид холбогдох хэсгийг дөрвөн сарын хугацаагаар түдгэлзүүлсэн	5	хэргийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон	3	хэргийг дахин хэлэлцүүлэхээр Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд буцаасан		
2	захиргааны байгууллагаас дахин шинэ акт гарах хүртэл холбогдох байгууллагын тушаалыг гурван сарын хугацаагаар түдгэлзүүлсэн	2	давж заалдах гомдлын зарим хэсгийг хангасан	2	хэргийг хэрэгсэхгүй болгосон		
1	захиргааны байгууллагаас дахин шинэ акт гарах хүртэл холбогдох байгууллагын тушаалыг зургаан сараар түдгэлзүүлсэн	1	Хэргийн нөхцөл байдлыг тодруулах шаардлагатай тул дахин шинэ акт гаргах захиргааны байгууллагын актыг 6 сарын хугацаагаар түдгэлзүүлсэн	1	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн “ТОГООХ” хэсгийн нэхэмжлэгчид холбогдох хэсгийг захиргааны байгууллагаас дахин шинэ акт гаргах хүртэл 6 сарын хугацаагаар түдгэлзүүлсүлсэн		
3	захиргааны байгууллагаас дахин шинэ акт гарах хүртэл холбогдох байгууллагын тушаалыг 2 сарын хугацаагаар түдгэлзүүлсэн			1	хяналтын журмаар гаргасан гомдлын зарим хэсгийг хангасан		

2019-2021 ОН



“Ашигт малтмал” гэсэн маргааны төрлөөс “ашигт малтмалын тухай”								
АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН НИЙТ 254 ШИЙДВЭР			ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ НИЙТ 159 МАГАДЛАЛ			ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХИЙН НИЙТ 81 ТОГТООЛ		
№	Нэхэмжлэлийг хэнд хандаж гаргасан	Нийт шийдвэрийн тоо	№	Гомдлыг хэнд хандаж гаргасан	Нийт магадлалын тоо	№	Гомдлыг хэнд хандаж гаргасан	Нийт тогтоолын тоо
1	Холбогдох нэр бүхий төрийн байгууллагын албан тушаалтанд	61		Холбогдох нэр бүхий төрийн байгууллагын албан тушаалтанд	75	1	Холбогдох нэр бүхий төрийн байгууллагын албан тушаалтанд	18
2	орон нутгийн аймгуудын Засаг дарга нарт	52		орон нутгийн аймгуудын Засаг дарга нарт	30	2	орон нутгийн аймгуудын Засаг дарга нарт	15
	холбогдох төрийн байгууллагад	141		холбогдох төрийн байгууллагад	54		холбогдох төрийн байгууллагад	48
ХЭРГҮҮДИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ								
Тоо	Анхан шатны шүүхийн хэргүүдийг шийдвэрлэсэн байдал		Тоо	Давж заалдах шатны шүүхийн хэргүүдийг шийдвэрлэсэн байдал		Тоо	Хяналтын шатны шүүхийн хэргүүдийг шийдвэрлэсэн байдал	
106	нэхэмжлэлийг хангасан		29	гомдлыг хангасан		60	гомдлыг хангаагүй	
122	хэргийг хэрэгсэхгүй болгосон		80	гомдлыг хангаагүй		12	гомдлыг хангасан	
13	захиргааны актыг хариуцагчаас дахин акт гартал 3 сарын хугацаагаар түдгэлзүүлсэн		7	хэргийг хэрэгсэхгүй болгосон		7	хэргийг дахин хэлэлцүүлэхээр Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд буцаасан	
7	захиргааны акт гаргах хүртэл холбогдох байгууллагын актыг зургаан сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлсэн		36	Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр тус шүүхэд буцаасан		1	нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон	
5	нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, зарим хэсгийг хэрэгсэхгүй болгосон		1	Гомдлыг хүлээн авахаас татгалзалсан		1	гомдлын зарим хэсгийг хангаж, зарим хэсгийг нь хэрэгсэхгүй болгосон	
1	Захиргааны актыг хариуцагчаас дахин акт гартал 2 сарын хугацаагаар түдгэлзүүлсэн		1	шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж, гомдлын зарим хэсгийг хангасан				
			5	гомдлын зарим хэсгийг хангаж, үлдсэнийг хэрэгсэхгүй болгосон				



Хүснэгт (3) Тусгай хамгаалалттай газрын тухай маргааныг хянан шийдвэрлүүлэхийн тулд улсын хэмжээнд анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан, хэрхэн шийдвэрлэсэн талаар тоон болон нэхэмжлэлийн шаардлагуудын судалгаа⁴

Тусгай хамгаалалттай газрын тухай маргааныг хянан шийдвэрлүүлэхийн тулд улсын хэмжээнд анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан, хэрхэн шийдвэрлэсэн талаар тоон болон нэхэмжлэлийн шаардлагуудын судалгаа				
Хэн нэхэмжлэл гаргасан?	Тоо	Хэргүүдийг шийдвэрлэсэн байдал	Тоо	Нэхэмжлэлийн шаардлагууд нь
Иргэн	14	Нэхэмжлэлийг хангасан	3	тусгай хамгаалалттай газрыг аялал жуулчлалын чиглэлээр ашиглах эрхийг нь дуусгавар болгосон холбогдох төрийн байгууллагын албан тушаалтны тушаалыг хүчингүй болгуулах тухай
		Нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон	11	байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа болон Б аймгийн Г сумын Засаг дарга нарт, мөн гэрээний дагуу газар ашиглуулах захирамж гаргахыг сумын Засаг даргад тус тус даалгах" шаардлага бүхий нэхэмжлэл, хуулийн этгээдэд нөхөх олговрыг олгоогүйгээс үүдэн учирсан хохирол болох амины орон сууц буюу үл хөдлөх эд хөрөнгийн үнийг хариуцагч холбогдох төрийн байгууллагаас хувь тэнцүүлэн гаргуулах" шаардлага бүхий нэхэмжлэл, холбогдох төрийн байгууллагын албан тушаалтны тушаалын хуулийн этгээдийн эзэмшил газартай давхцах хэсгийг илт хууль бус болохыг тогтоолох, тусгай хамгаалалттай газар нутгийн байгалийн цогцолборт газрын ангиллын хязгаарлалтын бүсэд орших газраас уламжлалт мал аж ахуй эрхлэх зориулалтаар газар ашиглуулах гэрээ байгуулахыг даалгах тухай.
Хуулийн этгээд	81	нэхэмжлэлийн зарим хэсгийг хангаж, зарим хэсгийг хэрэгсэхгүй болгосон	2	тусгай хамгаалалттай газрыг аялал жуулчлалын чиглэлээр ашиглах эрхийг нь дуусгавар болгосон холбогдох төрийн байгууллагын албан тушаалтны тушаалыг хүчингүй болгуулах тухай, хуулийн этгээдэд газар эзэмшүүлсэн Засаг даргын захирамжийн хуулийн этгээдийн ашиглалтын газартай давхцаасан хэсгийг илт хууль бус болохыг тогтоолох" тухай, холбогдох байгууллагын холбогдох албан тушаалтны "Газар ашиглах эрхийг дуусгавар болгох тухай тушаалтны "Газар ашиглах эрхийг дуусгавар болгох тухай тушаалыг хүчингүй болгуулах" тухай, газар ашиглах гэрчилгээний дагуу эзэмшиж байсан ... га талбай бүхий газар ашиглах эрх сэргээхийг холбогдох байгууллагын холбогдох албан тушаалтанд даалгах", га газрын ашиглах эрхийн гэрээг байгуулахгүй байгаа хариуцагчийн эс үйлдэхүйг хууль бус болохыг тогтоож, газар ашиглах гэрээ байгуулахыг даалгах тухай, холбогдох байгууллагын холбогдох албан тушаалтны "Газар ашиглах эрхийг дуусгавар болгох, газар ашиглах зөвшөөрөл олгох тухай" тушаалын хуулийн этгээдэд холбогдох хэсгийг хүчингүй болгуулахыг хүссэн тухай нэхэмжлэл, тусгай хамгаалалттай газрыг аялал жуулчлалын чиглэлээр ашиглах эрхийг нь дуусгавар болгосон холбогдох төрийн байгууллагын албан тушаалтны тушаалыг хүчингүй болгуулах тухай
		захиргааны байгууллагаас дахин шинэ акт гартал тус байгууллагын холбогдох тушаалын нэхэмжлэгчид холбогдох хэсгийг дөрвөн сарын хугацаагаар түдгэлзүүлсэн	1	холбогдох байгууллагын холбогдох албан тушаалтны "Газар ашиглах эрхийг дуусгавар болгох, газар ашиглах зөвшөөрөл олгох тухай" тушаалын хуулийн этгээдэд холбогдох хэсгийг хүчингүй болгуулахыг хүссэн тухай нэхэмжлэл
		захиргааны байгууллагаас дахин шинэ акт гарах хүртэл холбогдох байгууллагын тушаалыг гурван сарын хугацаагаар түдгэлзүүлсэн	2	тусгай хамгаалалттай газрыг аялал жуулчлалын чиглэлээр ашиглах эрхийг нь дуусгавар болгосон холбогдох төрийн байгууллагын албан тушаалтны тушаалыг хүчингүй болгуулах тухай
		захиргааны байгууллагаас дахин шинэ акт гарах хүртэл холбогдох байгууллагын тушаалын нэхэмжлэгчид холбогдох хэсгийг зургаан сараар түдгэлзүүлсэн	1	тусгай хамгаалалттай газрыг аялал жуулчлалын чиглэлээр ашиглах эрхийг нь дуусгавар болгосон холбогдох төрийн байгууллагын албан тушаалтны тушаалыг хүчингүй болгуулах тухай, газар ашиглах гэрчилгээний дагуу эзэмшиж байсан ... га талбай бүхий газар ашиглах эрх сэргээхийг холбогдох байгууллагын холбогдох албан тушаалтанд даалгах",
		захиргааны байгууллагаас дахин шинэ акт гарах хүртэл холбогдох байгууллагын тушаалыг 2 сарын хугацаагаар түдгэлзүүлсэн	3	тусгай хамгаалалттай газрыг аялал жуулчлалын чиглэлээр ашиглах эрхийг нь дуусгавар болгосон холбогдох төрийн байгууллагын албан тушаалтны тушаалыг хүчингүй болгуулах тухай
		Нэхэмжлэлийг хангасан	44	
Нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон	28			
НҮТББ	3	Нэхэмжлэлийг хангасан	2	НҮТББ-ын газрыг зөвшөөрөлгүй дур мэдэн эзэмшиж байгаа иргэд, тэдний гэр, хашаа бусад эд хөрөнгийг уг газраас албадан чөлөөлөх захирамж гаргахгүй байгаа холбогдох дүүргийн Засаг даргын эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоож, газар албадан чөлөөлөх захирамж гаргахыг даалгах тухай, нэхэмжлэгчийн гаргасан хүсэлтийн дагуу газар ашиглах шийдвэр гаргахыг даалгуулах, холбогдох төрийн байгууллагын холбогдох албан тушаалтны тушаалын холбогдох хэсгийг хууль бус байсан болохыг тогтоолох" тухай
		Нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон	1	Богдхан-Уулын Дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны санал хүргүүлэх тухай албан бичигт тусгагдсан 10 сонбицлын цэг бүхий га газрыг нэхэмжлэгчид ашиглуулахыг хариуцагчид даалгах тухай



Хүснэгт (4) Ашигт малтмалын тухай маргааныг хянан шийдвэрлүүлэхийн тулд улсын хэмжээнд анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан, хэрхэн шийдвэрлэсэн талаар тоон болон нэхэмжлэлийн шаардлагуудын судалгаа⁵

Ашигт малтмалын тухай маргааныг хянан шийдвэрлүүлэхийн тулд улсын хэмжээнд анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан, хэрхэн шийдвэрлэсэн талаар тоон болон нэхэмжлэлийн шаардлагуудын судалгаа				
Хэн нэхэмжлэл гаргасан?	Тоо	Хэргүүдийг шийдвэрлэсэн байдал	Тоо	Нэхэмжлэлийн шаардлагууд нь
Хуулийн этгээд	251	нэхэмжлэлийг хангасан	105	ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сэргээхийг холбогдох төрийн байгууллагад даалгуулах тухай, холбогдох төрийн байгууллагын холбогдох албан тушаалтны тушаалын хуулийн этгээдэд холбогдох хэсгийг хүчингүй болгуулах" тухай, ашигт малтмалын хайгуулын XV-01.... дугаар тусгай зөвшөөрлийг сэргээхийг холбогдох төрийн байгууллагын албан тушаалтанд даалгах тухай, ашигт малтмалын XV-... дүгээр тусгай зөвшөөрөл бүхий талбайг төрийн мэдэлд шилжүүлэн авсны нөхөн олговорт улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны ажлын явцад тогтоогдсон эрдсийн хуримтлал бүхий талбайгаас дүйцүүлэн олгох шийдвэрийг холбогдох байгууллагуудаас гаргахгүй байгаа эс үйлдэхүйг хууль бус болохыг тогтоож, шийдвэрүүд гаргахыг даалгах тухай, тодорхой нэгэн аймгийн сумын газарт нөхөн сэргээлтээр ажиллах хуулийн этгээдийн, сумын Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээг илт хууль бус болохыг тогтоолгох" тухай, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзаж байгаа хариуцагчийн эс үйлдэхүйг хууль бус болохыг тогтоож, хавсралтад заасан солбицол бүхий талбайд шинээр ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг холбогдох төрийн байгууллагын даргад даалгах тухай.
		хэргийг хэрэгсэхгүй болгосон	121 га талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл хүсч хамгийн түрүүнд өргөдөл гаргасан, хайгуулын тусгай зөвшөөрөл түрүүлж авах боломжтой этгээд гэж үзэх эрх зүйн харилцаа байгааг тогтоолуулах тухай, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн гектар талбайд дүйцүүлэн нөхөн олговрын зориулалтаар хавсралтад заасан солбицол бүхий талбайд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзаж байгаа хариуцагчийн эс үйлдэхүйг хууль бус болохыг тогтоож, хавсралтад заасан солбицол бүхий талбайд шинээр ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг холбогдох төрийн байгууллагын даргад даалгах" тухай,
		захиргааны актыг хариуцагчаас дахин акт гартал 3 сарын хугацаагаар түдгэлзүүлсэн	13	хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын шийдвэр буюу хуулийн этгээдийг шалгаруулсан холбогдох төрийн байгууллагын холбогдох албан тушаалтны тушаалыг хүчингүй болгуулах" тухай, ашигт малтмалын XV-... дүгээр тусгай зөвшөөрөл бүхий талбайг төрийн мэдэлд шилжүүлэн авсны нөхөн олговорт улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны ажлын явцад тогтоогдсон эрдсийн хуримтлал бүхий талбайгаас дүйцүүлэн олгох шийдвэрийг холбогдох байгууллагуудаас гаргахгүй байгаа эс үйлдэхүйг хууль бус болохыг тогтоож, шийдвэрүүд гаргахыг даалгах тухай, тодорхой нэгэн аймгийн сумын газарт нөхөн сэргээлтээр ажиллах хуулийн этгээдийн, сумын Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээг илт хууль бус болохыг тогтоолгох" тухай, байгаль орчны менежментийн шинэчилсэн төлөвлөгөөг батлахыг сумын Засаг даргад даалгах тухай.
		захиргааны акт гаргах хүртэл холбогдох байгууллагын актыг зургаан сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлсэн	7	ашигт малтмалын хайгуулын XV-01.... дугаар тусгай зөвшөөрлийг сэргээхийг холбогдох төрийн байгууллагын албан тушаалтанд даалгах тухай, талбайд хийж гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүн, нөөцийн тайланг хэлэлцэхгүй байгаамэргэжлийн зөвлөлийн эс үйлдэхүйг хууль бус болохыг тогтоолгох, хуулийн этгээдийн хайгуулын ажлын үр дүн, нөөцийн тайлан, холбогдох бусад материалуудыг хуралдаанаар хэлэлцэж, дүгнэлт гаргахыг холбогдох төрийн байгууллагад даалгуулах тухай, хуралдаанаар ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох асуудлыг хэлэлцэхгүй, санал өгөхгүй байгаакомиссын эс үйлдэхүйг хууль бус болохыг тогтоож, холбогдох захиргааны акт /санал/ гаргах зорилгоор хуралдаанаар хэлэлцүүлэхийгкомисст даалгах" тухай, тусгай зөвшөөрлийн бүртгэлийг сэргээж, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахыг холбогдох төрийн байгууллагын хэлтэст даалгуулах" тухай, хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд цацраг идэвхт бодисын хайгуулын зөвшөөрөл олгоогүй холбогдох төрийн байгууллагын эс үйлдэхүйг хууль бус болохыг тогтоолгох" тухай.
		нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, зарим хэсгийг хэрэгсэхгүй болгосон	5	Холбогдох төрийн байгууллагын хэлтэсийн хуулийн этгээдийн ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрлийг цуцалсан хэсгийг хүчингүй болгуулах, "Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг кадастрын бүртгэлийн системд дуусгавар болгохгүй байх эрх зүйн харилцаа байгаа болохыг тогтоож, тусгай зөвшөөрлийг дуусгавар болгож бүртгэсэн бүртгэлийг хүчингүй болгуулах" тухай, холбогдох төрийн байгууллагын хэлтэсийн хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг сунгахаас татгалзаж шийдвэрлэсэн шийдвэрийг хүчингүй болгож, тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахыг даалгах" тухай.
НҮТББ	2	Нэхэмжлэлийг хангасан	1	НҮТББ-ын гаргасан хуулийн этгээдийн эзэмшилд байх 56..А, 43..А, 5...А, 1....А ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг хүчингүй болохыг холбогдох төрийн байгууллагад даалгах тухай,
		Хэргийг хэрэгсэхгүй болгосон	1	"Холбогдох төрийн байгууллагын хэлтэсийн даргын шийдвэрүүдийг тус бүр илт хууль бус болохыг тогтоолгох, ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрлүүдийг тус тус хүчингүй болгож цуцлахыг хариуцагчид даалгах" тухай
Иргэн	1	Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангасан	1Банк иргэний худалдсан алтны үнийн дүнгээс ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 1 тэрбум төгрөг, өсөн нэмэгдэх нөөцийн төлбөр 1 тэрбум төгрөгийг суутган авсан үйлдлийг илт хууль бус болохыг тогтоолгох тухай.



Тусгай хамгаалалттай газрын тухай маргааныг хянан шийдвэрлүүлэхийн тулд улсын хэмжээнд анхан шатны шүүхэд 14 хувь хүн, 81 хуулийн этгээд, 3 НҮТББ нэхэмжлэл гаргасан байна. 2019-2021 оны хооронд улсын хэмжээнд Захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн “Тусгай хамгаалалттай газартай холбоотой маргааны судалгааны” дагуу⁶ Захиргааны хэргийн анхан шатны шүүх 98 шийдвэрээс 40 шийдвэр буюу 40%-ийг хэрэгсэхгүй болгосон, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх 81 магадлалаас 58% буюу 47 гомдлыг хангаалгүй орхисон бол Захиргааны хэргийн Хяналтын шатны шүүх 47 тогтоолоос 74% буюу 35 гомдлыг хангаагүй байна.

Ашигт малтмалын тухай маргааныг хянан шийдвэрлүүлэхийн тулд улсын хэмжээнд анхан шатны шүүхэд 251 хуулийн этгээд, 2 НҮТББ, 1 иргэн нэхэмжлэл гаргасан байна. 2019-2021 оны хооронд улсын хэмжээнд Захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн “Ашигт малтмалтай холбоотой маргааны судалгааны” дагуу Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 254 шийдвэрээс 122 шийдвэр буюу 48% -ийг хэрэгсэхгүй болгосон, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх 159 магадлалаас 50,3% буюу 80 гомдлыг хангаалгүй орхисон бол Захиргааны хэргийн Хяналтын шатны шүүх 81 тогтоолоос 74% буюу 60 гомдлыг хангаагүй байна.

2012 онд судлаач Ц. Цогт “Байгаль орчныг хамгаалах асуудалд Захиргааны хэргийн шүүхийн гүйцэтгэх үүрэг, оролцоо” гэсэн илтгэлийнхээ хүрээнд 2004-2011 оны хооронд улсын хэмжээнд Захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн “Ашигт малтмалтай холбоотой маргааны” судалгааг хийсэн байна. Тухайлбал:

Д/Д	Он	НЗХ Ш	21 аймгийн ЗХШ нийлбэр	Нийт дүн
1.	2004	6	-	6
2.	2005	15	4	19
3.	2006	25	3	28
4.	2007	44	6	50
5.	2008	56	6	62
6.	2009	59	2	61
7.	2010	71	5	76
8.	2011	84	2	86
9.	Нийт	360	28	388

Мөн Ц. Цогт судлаач өөрийн илтгэлдээ: Монгол Улсын Захиргааны хэргийн шүүх байгуулагдаад 8 гаруй жил үйл ажиллагаа явуулж, төлөвшиж байгаа боловч хариуцлагатай захиргааг бий болгох зорилго “тодорхой хэрэг дээр” хангагдах боловч харин өргөн утгаараа энэ зорилго хангагдахгүй байна. Учир нь захиргааны байгууллагын албан тушаалтны шийдвэрийг захиргааны хэргийн шүүхээс хууль зөрчсөн гэдгийг тогтоож хүчингүй болгосон байхад дахин алдаатай шийдвэрийг удаа дараа гаргаж иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөөр байгаа нь захиргааны хэргийн шүүхээр хянан хэлэлцэгдэж буй маргааны төрөл, тоо баримтаас харагдаж байна” хэмээн дурьдсан байна.⁷ Тус илтгэлийг бичсэнээс хойш хэдийгээр 10 жил өнгөрсөн ч байдал огтхон ч өөрчлөгдөөгүй байгааг дээрхи хоёр хүснэгтээс анзаарч болохоор байна. Судлаачын зүгээс Ц. Цогт судлаачын үгтэй санал нийлж байна.

Газраас ашигт малтмал олборлохтой холбоотой шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолуудын дундаас байгаль орчныг

⁷ Ц.Цогт, Байгаль орчныг хамгаалах асуудалд Захиргааны хэргийн шүүхийн гүйцэтгэх үүрэг, оролцоо. Шихихутуг Хууль зүйн дээд сургуулийн эрдэм шинжилгээний хурал. Улаанбаатар хот.2012.10.26 URL:<https://tsogt.coo.mn/98378/baigali-orchniig-hamgaalah-asuudald-zahirgaanii-hergiin-shuuhiin-guitsetgeh-uureg,-oroltsoo.html>



хамгаалахад чухал ач холбогдолтой Улсын Дээд⁸ Шүүхийн дараах тогтоолыг сонгон авч дүн шинжилгээ хийлээ. НҮТББ нь анхан шатны шүүхэд: тодорхой хуулийн этгээдийн эзэмшилд байх 3..А, 4...А, 5...А, 1....А ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг хүчингүй болохыг холбогдох төрийн байгууллагын холбогдох албан тушаалтанд даалгах тухай нэхэмжлэлийн шаардлага гаргажээ. Учир нь “2005, 2006 онуудад хариуцагч этгээдээс хуулийн этгээдийн эзэмшилд олгосон 3..., 4...А, 5....А, 10....А ашиглалтын тусгай зөвшөөрлүүдэд гуравдагч этгээдийн зүгээс алт олборлолтын үйлдвэрлэлийн үйл ажиллагааг явуулж эхлэх нь тухайн орон нутагт амьдарч буй хүн амын эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөх, эрүүл мэндэд хортой тоос шороо, хорт хий агаарт дэгдэж амьсгалын эрхтэн гэмтэх, үүнтэй холбоотойгоор хүний биед хорт хавдар, өвчин эмгэг үүсэх, байгаль экологийн тэнцвэрт байдал алдагдаж ан амьтан ургамал өвс, ус, гол мөрөн устаж үгүй болох, байгалийн унаган төрх алдагдсан нөхөн сэргээгдэх боломжгүй байдал үүсэх, эртний хаадын булш бунхан, археологи, плантелогийн ховор олдвор, соёлын үнэт өв сүйтгэгдэн устах зэрэг Монголын ард түмний агуу их түүхийн дурсгал үүрд алга болох зэргээр олон нийтийн ашиг сонирхолд ноцтой хохирол учруулах болсон байна. Өөрөөр хэлбэл дээрх тусгай зөвшөөрлүүдийг гуравдагч этгээд зориулалтын дагуу буюу техник эдийн засгийн үндэслэл, уулын ажлын төлөвлөгөөнд тусгасан байдлаар уурхайн ажлыг эхлүүлж олон тооны хүнд машин механизм, уулын тэсэлгээ дэлбэрэлт, өрөмдлөг, олон зууны турш үүсэн бий болсон үржил

шимт газар шороог ухаж зөөн эрүүл газарт шилжүүлэн байршуулж, үүнтэй холбоотой алт шүүлт, угаалтын хүнд тоног төхөөрөмжүүд өргөн цар хүрээтэйгээр зэрэгцэн ажиллуулж асар их тоос шороог агаар мандалд дэгдээж, алт олборлолтын улмаас бий болох гүнзгий ангал нүх, овоолгуудыг тухайн газарт үүсгэж тэр орчинд амьдарч буй ан амьтан, араатан, жигүүртнийг үргээн зайлуулах, устах, өвс ургамал, газар нутгийг үржил шимгүй цөл болгож хувирна. Маргаан бүхий тусгай зөвшөөрлүүдэд олборлолт явагдсанаар уул уурхайн эдэлбэр газрын эргэн тойронд амьдарч буй нутгийн ард түмний эрүүл мэнд, амь нас, түүх соёл, хүрээлэн байгаа орчинд бодит хохирол бодитойгоор учирсан, ирээдүйд учрах болох нь хавтаст хэрэгт авагдсан эрх бүхий байгууллагуудын дүгнэлт, баримт, нотолгооны хэрэгслүүдээр нотлогдож байна. Ашигт малтмалын нөөцийн үнэлгээ болон холбогдох албан татваруудыг худал тайлагнасан нотлох баримт байгаа нь тухайн тусгай зөвшөөрлүүдийг цуцлах нэг үндэслэлүүдийн нэг юм. Үүний учир маргаан бүхий татгалзал хууль бус гэдэг нь тогтоогдож байх тул анхан шатны шүүх нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, давж заалдах шатны шүүх: анхан шатны шүүхийн Тогтоох хэсгийн 1 дэх заалтыг “Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4, 39 дүгээр зүйлийн 39.1.4, 56 дугаар зүйлийн 56.1.5-д заасныг тус тус баримтлан хуулийн этгээдийн эзэмшлийн 3..А, 4...А, 5...А, 10....А тоот ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг хүчингүй болгосугай” гэж өөрчлөн, шийдвэрийн бусад заалтыг хэвээр үлдээв. Хяналтын шатны шүүх магадлалыг хүчингүй болгож, Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн “Тогтоох” хэсгийн 1 дэх заалтын “...Соёлын өвийг хамгаалах

⁸ Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сангийн албан ёсны цахим хуудас (2022 он) URL: <https://shuukh.mn/cases/1/1>(Сүүлд үзсэн 2022.05.27)



тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.5, 5.1.6, 5.1.8, 6 дугаар зүйлийн 6.1.6, 6.1.8, 6.1.11, 6.1.16, 27 дугаар зүйлийн 27.1"⁹ гэснийг хасч, "Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.7" гэснийг "Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.5"¹⁰ гэж өөрчлөн, шийдвэрийн бусад хэсгийг хэвээр үлдээв. Тус шүүхийн шийдвэрүүдэд, ашигт малтмал олборлох газруудад¹¹ түүхийн өндөр ач холбогдолтой, түүхийн дурсгалт булш, бунхан г.м. олон зүйлс байж болохыг үгүйсгэхийн аргагүй болох нь тодорхой нотлох баримтуудаар нотлогдсон байна.¹² Зөвхөн тус шүүхийн шийдвэр дэхь ашигт малтмалын ордод бус, Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж буй ашигт малтмалын ордуудад түүхийн өндөр ач холбогдолтой, түүхийн дурсгалт олон зүйлс байж болохыг үгүйсгэхийн аргагүй. Монгол Улсад улсын тусгай хамгаалалттай 10 газарт ашигт малтмалын хайгуул, ашиглалтын 25 хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл байна. Тухайлбал, Тосон хулстай, Их газрын чулуу, Зэд-Хантай- Бүтээлийн нуруу, Тэнгис-Шишгэд, Мөнххайрхан уул-Үенчийн хавцал, Чигэртэйн голын ай сав, Алтан хөхий уул, Хурх хүйтэний хөндий, Хөх нуур бумбат, Ноён уул зэрэг тусгай хамгаалалттай газар нутагт ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөр үйл ажиллагаа явуулж байна.¹³ Мөн уурхайн

ажлаас шалтгаалж тусгай зөвшөөрөл олгогдсон газруудад амьдарч байгаа иргэдийн эрүүл орчинд амьдрах эрх зөрчигдөхөд нөлөөлөхүйц байгаль орчинд хор нөлөөлөл бий болж үүнд: ус, хөрс бохирдож хүнцэл, цианант илрэх, хөрс эвдэрч, элэгдэх, эмийн ургамал, амьтан, мод, сөөг устаж үгүй болох, гол тасрах магадлал өндөр. Цаашид ашиглалт явуулбал: гол ширгэж, ан амьтан, ургамал устах, үржил шимгүй хөрс бий болох, цөлжих аюул тулгарч байна. Ашигт малтмалын ордод үйлдвэрлэлийн үйл ажиллагааг явуулах нь тухайн орон нутагт амьдарч буй хүн амын эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөх, эрүүл мэндэд хортой тоос шороо, хорт хий агаарт дэгдэж амьсгалын эрхтэнг гэмтэх, үүнтэй холбоотойгоор хүний биед хорт хавдар, өвчин эмгэг үүсэх, байгаль экологийн тэнцвэрт байдал алдагдаж ан амьтан өвс ургамал, байгалийн унаган төрх алдагдах, байгальд хохирол учруулах эрсдэлтэй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

АНУ, Герман, Итали, Франц, Орос, Хятад, Швейцарь, Япон, Энэтхэг, Нидерланд алтны хамгийн их нөөцтэй (тонноор) улсууд. Гэвч ОХУ сүүлийн арван жилийн хугацаанд бусад улсуудаас их хэмжээгээр алт худалдан авсан улсуудын нэг. Сүүлийн таван жилийн хугацаанд ОХУ 683.31 тонн алт нэмсний 474.81-ийг 2017, 2018 онуудад худалдаж авсан байна. Сүүлийн таван жилийн хугацаанд Польш улс 125.7 тонн алт худалдан авснаас 100.01 тонныг 2019 онд худалдан авчээ. Хятад улс алтны нөөцөөрөө дэлхийд зургадугаарт ордог - 1948.31 тонн нь албан ёсны нөөцийн 3.3 хувь юм. Хятад улс 2019 онд 95.8 тонн алт худалдан авчээ. 2021 онд Тайланд алтны нөөцөө 90.2 тонноор нэмэгдүүлж, нийт нөөцөө 244.16 тоннд хүргэсэн

⁹ Соёлын өвийг хамгаалах тухай хууль (2014 он) URL: <https://legalinfo.mn/mn/detail/10439> (Сүүлд үзсэн 2022.05.27)

¹⁰ Ашигт малтмалын тухай хууль (2006 он) URL: <https://legalinfo.mn/mn/detail/63> (Сүүлд үзсэн 2022.05.27)

¹¹ Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сангийн албан ёсны цахим хуудас (2022 он) URL: <https://shuukh.mn/cases/1/1>(Сүүлд үзсэн 2022.05.27)

¹² Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сангийн албан ёсны цахим хуудас (2022 он) URL: <https://shuukh.mn/cases/1/1>(Сүүлд үзсэн 2022.05.27)

¹³ Статистикийн мэдээллийн нэгдсэн саны албан ёсны цахим хуудас (2022 он) URL: https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_2800_030V1(Сүүлд үзсэн 2022.05.27)



байна. Бразил 2021 онд 62.29 тонн алт худалдаж авсан байна.¹⁴ “Монгол Улсад газрыг ухчаад нөхөн сэргээх асуудал ярих биш, тухайн газраа ер ухахгүй байх хэрэгтэй. Хөгжилтэй орнууд газраа ухахгүйгээр, буурай хөгжилтэй эсвэл хөгжиж буй орнуудаас ашигт малтмалуудыг татан авч ашиглаж байгаа нь өөрсдийн улс орнуудынхаа байгалийн тэнцвэрт байдлыг хадгалж үлдэх стратеги бодолгыг баримталж байгааг харуулж байна” гэж судлаачын зүгээс үзэж байна.

Тусгай хамгаалалттай газарт эрх зүйн хүрээнд тулгамдаж буй асуудлыг дурдвал: Монгол Улсын 1994 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулинд” “тусгай хамгаалалттай газар нутгийн зөвхөн ангиллыг, ангилалд багтсан нэр томъёонуудын тодорхойлтууд багтсан¹⁵ бөгөөд тусгай хамгаалалттай газар нутгийн тодорхойлолт дээрхи хуулинд тусгагдаагүй байгааг судлаачын зүгээс анзаарсан. Харин гадаадад буюу ОХУ-ын 1995. 03.14 –ний өдрийн № 33 “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн” эхлэл хэсэгт нь “Тусгай хамгаалалттай газар нутаг гэж төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр ашиглалтаас бүхэлдээ буюу хэсэгчлэн хасагдсан, тусгай хамгаалалтын дэглэм тогтоосон, байгаль орчин, шинжлэх ухаан, соёл, гоо зүй, амралт зугаалга, эрүүл мэндийн онцгой ач холбогдолтой байгалийн цогцолбор, объектууд байрладаг, газар, усны гадаргуу, тэдгээрийн дээрх агаарын орон зайг

¹⁴ Пралин Баджпай. Какие страны активнее всего покупают золото? Изд: Золотой Запас. 2022г.// Пралин Баджпай. Ямар улс орнууд алтыг хамгийн их идэвхтэй худалдан авдаг вэ? Алтан нөөц. 2022 он URL: <https://www.zolotoy-zapas.ru/news/market-analytics/kakie-strany-aktivnee-vsego-pokupayut-zoloto/>(Сүүлд үзсэн 2022.05.27)

¹⁵ “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль” (1994 он) URL: <https://legalinfo.mn/mn/detail/479> (Сүүлд үзсэн 2022.05.27)

хэлнэ”¹⁶ хэмээн тодорхойлолтыг тусгаж өгсөн байна. Ингэснээр ОХУ-ын хууль тогтоогчид иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан хэмээн судлаачын зүгээс үзэж байна. “Дэлхийн бараг бүх улс орнууд хууль зүйн шинжлэх ухаан, хууль тогтоох практикт нэгдмэл байдлаар “Тусгай хамгаалалттай газар нутаг” гэсэн ойлголтын тодорхойлолтыг хэрэглэдэг гэж үзэж болно” хэмээн эрдэмтэн, судлаач Рахимбаев Б.Б. үзсэн байна.¹⁷

Тусгай хамгаалалттай 16 газарт газар ашиглалтын 5.9 мянган га газрыг хамарсан 3,069 гэрчилгээ гарсан байна. Үүний 98.3 хувь нь Богдхан уулын дархан цаазат газар, Горхи-Тэрэлж, Хөвсгөл нуурын цогцолбор газарт байгаа бөгөөд суурьшлын бүс хэт хавтгайрч байгалийн доройтлыг ихээхэн хэмжээгээр үүсгэж байна.¹⁸ Тусгай хамгаалалттай газар ашиглагч нар гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэлгүй зориулалтын бусаар ашиглах, газрын төлбөрөө бүрэн гүйцэд төлөөгүй зэрэг асуудлууд бодит байдал дээр түгээмэл байна.¹⁹ Жишээлбэл: Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын

¹⁶ Федеральный закон "Об особо охраняемых природных территориях" от 14.03.1995 N 33-ФЗ// (ОХУ-ын "1995. 03.14 –ний өдрийн № 33 “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль”) URL: http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_6072/ (Сүүлд үзсэн 2022.05.27)

¹⁷ Рахимбаев Б.Б. Понятие, принципы организации особо охраняемых природных территорий в республике Казахстан. Вестник Казахстанско-Американского Свободного Университета. г. Алматы. 2017 г. Стр 34.// Бүгд Найрамдах Казахстан улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тухай тодорхойлолт, зарчимууд. Казах-Америкийн хамтарсан Чөлөөт Их Сургуулийн мэдээллийн товхимол. Алматы хот. 2017 он. 34 дахь тал.

¹⁸ Статистикийн мэдээллийн нэгдсэн саны албан ёсны цахим хуудас (2022 он) URL: https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_2800_030V1(Сүүлд үзсэн 2022.05.27)

¹⁹ Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны (2022.05.10) хуралдаан Ж.Батжаргал гишүүний танилцуулга. URL: <https://www.mnb.mn/j/42>(Сүүлд үзсэн 2022.05.27)



шатны Захиргааны хэргийн шүүх хуралдааны 2020 оны тогтоолыг сонгон авч дүн шинжилгээ хийлээ. Нэхэмжлэгч “холбогдох Засаг даргын “Тусгай зөвшөөрлийг цуцалж, газрын хэвлий ашиглах эрхийг дуусгавар болгох тухай захирамжийн тухайн хуулийн этгээдэд холбогдох хэсгийг хүчингүй болгуулахыг” хүссэн нэхэмжлэлийн шаардлага гаргажээ. Маргаан бүхий захиргааны акт болох холбогдох Засаг даргын захирамжаар хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг Улаанбаатар хотын ундны усны хамгаалалтын бүстэй давхацсан, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн албан шаардлага биелүүлээгүй үндэслэлээр цуцалсан байна. Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн албан шаардлаганд нь хуулийн этгээд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч ашигт малтмалын нөөц²⁰ ашигласны төлбөр төлөөгүй гэж заасан болох нь хэрэгт авагдсан нотлох баримтуудаар тогтоогдсон байна. Нэхэмжлэгчээс уг албан шаардлагыг биелүүлсэн эсэхтэй холбоотой баримтыг гаргаж, шаардлагад заасан дээрх зөрчлүүдийг арилгасан, зөрчилгүй болохоо шүүхэд нотлоогүй байна. Дээрхи үндэслэлээр анхан шатны шүүх нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож давж заалдах шатны шүүхээс “...маргаан бүхий тусгай зөвшөөрлийн талбай нь холбогдох төрийн байгууллагуудын тогтоолуудаар баталсан ойн сан бүхий болон усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийн хилийн заагтай хэдий хэмжээгээр давхцаж байгаа, ...тусгай зөвшөөрөлтэй талбайн тодорхой хэсгийг ашиглах боломжтой эсэх, Ашигт малтмалын

тухай хуульд зааснаар нөхөн олговрыг ямар хэмжээгээр олгох зэрэг асуудлыг шүүхээс тогтоох боломжгүй” гэж дүгнэн, захиргааны актын хуулийн этгээдэд холбогдох хэсгийн биелэлтийг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлж шийдвэрлэсэн бол хяналтын шатны шүүх магадлалыг хүчингүй болгож, Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн Тогтоох хэсгийн 1 дэх заалтын “Газрын хэвлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1” гэснийг “Газрын хэвлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5”²¹ гэж өөрчлөн, шийдвэрийн бусад заалтыг хэвээр үлдээсэн байна. Дээрхи хэрэгт үнэхээрийн нэхэмжлэгчийн зүгээс алдаа гарсан гэдэг нь нотлох баримтуудаар тогтоогдсон байна. Анхан шатны шүүхийн тодорхойлох хэсэгт шүүх тусгай зөвшөөрөлтэй талбай нь Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулиар ашигт малтмал ашиглах, хайхыг хориглосон талбай буюу Засгийн газрын 2012 оны 194 дүгээр тогтоолоор²² /Засгийн газрын 2015 оны 289 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон/ баталсан Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хилийн заагтай болон нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 50 дугаар тогтоолоор тогтоосон хамгаалалтын бүстэй 96 хувийн давхцалтай, үлдэх талбай нь иргэдийн суурьшлын бүсэд орсон болох нь Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас шүүхэд ирүүлсэн лавлагаа болон шүүхийн үзлэгээр тогтоогдож байгаа, энэ талаар хэргийн оролцогчид маргаагүй болно”²³

²⁰ Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сангийн албан ёсны цахим хуудас (2022 он) URL: <https://shuukh.mn/cases/1/1>(Сүүлд үзсэн 2022.05.27)

²³ Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сангийн албан ёсны цахим хуудас (2022 он) URL: <https://shuukh.mn/cases/1/1>(Сүүлд үзсэн 2022.05.27)



хэмээн дурдсан байна. Гэвч тухайн газрыг ашиглуулахаар тусгай зөвшөөрөл олгоход яагаад энэ асуудлуудыг хөндөж, шалгаж, нягтлаагүй юм бол? Судлаач би, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, тухайн орон нутгийн Засаг дарга нар болон Мэргэжлийн хяналтын газар хамтран түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрлийг авсан хуулийн этгээдүүдийн явуулж буй үйл ажиллагаа нь хамгаалалтын бүстэй давхцалтай эсэх эсвэл иргэдийн суурьшлын бүсэд орсон эсэхийг жилд 9 удаа хяналт тавьж, шалгаж, байнга дээрхи асуудлуудыг тодруулбал иргэдийн эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд өндөр ач холбогдолтой гэж бодож байна.

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан нийт 15 байгалийн нөөц болон дурсгалт газрууд хилийн заагийг²⁴ тогтоохоор Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж Барилга, хот байгуулалтын яамнаас санал авахад газрын кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй 390 нэгж талбартай давхцалтай гэсэн үндэслэлээр, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас санал авахад Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайтай давхцалтай байна гэсэн үндэслэлээр, мөн 2020 оны 46 дугаар тогтоолоор²⁵ батлагдсан 4 газар нутгийн хилийн заагийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас санал авахад ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй давхцалтай гэсэн үндэслэлээр, нийт 19 тусгай хамгаалалттай газрын хилийн заагийг одоо болтол баталгаажуулаагүй байна. Тиймээс ойрын саруудад тус газруудын хилийн заагийг баталгаажуулах нэн

²⁴ Монгол Улсын Их Хурлын 2019 оны 41 дүгээр тогтоол. URL: <https://old.legalinfo.mn/law/?cat=28> (Сүүлд үзсэн 2022.05.27)

²⁵ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 46 дугаар тогтоол. URL: <https://old.legalinfo.mn/law/?cat=28> (Сүүлд үзсэн 2022.05.27)

шаардлагатай гэдгийг УИХ гишүүд Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны (2022.05.10) хуралдаанд хэлэлцсэн байна.²⁶ Тус асуудлуудыг нэн даруй шийдвэрлэх шаардлагатай гэдэгтэй судлаачын зүгээс УИХ-ын гишүүдтэй санал нийлж байна.

САНАЛ

“Монгол Улсад газрыг ухчаад нөхөн сэргээх асуудал ярих биш, тухайн газраа ер ухахгүй, ашигт малтмал олборлохгүй байгалийн баялагаа хадгалах нь байгаль орчныг хамгаалж, хадгалж үлдэх нөхцөлийг бүрдүүлнэ” гэж судлаачын зүгээс үзэж байна. Тиймээс “холбогдох төрийн байгууллагууд нь ашигт малтмал олборлолгүй байгалийн баялагаа хадгалж, хамгаалж үлдэх стратеги, бодлогыг боловсруулвал байгаль орчныг хамгаалах, хадгалахад үнэтэй хувь нэмэр оруулах болно” гэдгийг дурдмаар байна.

Мөн Байгаль орчин, аялал жуулчлалын яам, тухайн орон нутгийн Засаг дарга нар болон Мэргэжлийн хяналтын газар хамтран түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрлийг авсан хуулийн этгээдүүдийн явуулж буй үйл ажиллагаа нь хамгаалалтын бүстэй давхцалтай эсэх эсвэл иргэдийн суурьшлын бүсэд орсон эсэхийг жилд 9 удаа хяналт тавьж, шалгахыг санал болгож байна. Ингэснээр “хуулийн этгээдүүдийн явуулж буй үйл ажиллагаа нь хамгаалалтын бүстэй давхцалтай эсэх эсвэл иргэдийн суурьшлын бүсэд орсон эсэхийг нэн даруй илрүүлж, цаашид үүсэх ямарваа нэгэн асуудлуудаас урьдчилан сэргийлж чадна” гэж судлаачын зүгээс бодож байна. Жич: тус саналыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны стратеги, тухайн орон

²⁶ Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны (2022.05.10) хуралдаан. URL: <https://www.mnb.mn/j/42> (Сүүлд үзсэн 2022.05.27)



нутгийн Засаг дарга нарын мөрийн хөтөлбөр, Мэргэжлийн хяналтын газрын жилийн төлөвлөгөөнд нь оруулж болно.

Монгол Улсын 1994 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж, тусгай хамгаалалттай газар нутгийн тодорхойлолтыг тус хуулинд тусгахыг судлаачын зүгээс санал болгож байна. Дээрхи хуулинд тусгай хамгаалалттай газрын тодорхойлолтыг тусгаж өгснөөр иргэд тусгай хамгаалалттай газрын талаар тодорхой ойлголттой болох бөгөөд иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд ач тустай гэж бодож байна.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сангаас “газар” гэсэн маргааны төрлөөс “тусгай хамгаалалттай газрын”, “ашигт малтмал” гэсэн маргааны төрлөөс “ашигт малтмалын” тухай захиргааны хэргийн шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийх нь байгаль орчныг хамгаалахтай холбоотой асуудлуудаас үүсэх эрсдлүүд, сөрөг үр дагаваруудаас урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой. Шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийхэд Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэгчид болох хувь хүмүүс эсвэл хуулийн этгээдүүд холбогдох нэр бүхий төрийн байгууллагын албан тушаалтануудад, орон нутгийн аймгуудын Засаг дарга нарт, Нийслэлийн болон Нийслэлийн холбогдох дүүргийн Засаг дарга нарт, холбогдох төрийн байгууллагуудад хандан тус байгууллага, албан тушаалтнуудын тушаал, шийдвэр, дүгнэлтүүдийг хүчингүй болгуулахаар нэхэмжлэл гаргадаг гэдгийг дээрхи судалгаанаас анзаарч болно.

Мөн ашигт малтмалын тухай маргааныг хянан шийдвэрлүүлэхийн тулд

улсын хэмжээнд анхан шатны шүүхэд 251 хуулийн этгээд, 2 НҮТББ, 1 иргэн нэхэмжлэл гаргасан байна. 2019-2021 оны хооронд улсын хэмжээнд Захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн “Ашигт малтмалтай холбоотой маргааны судалгааны” дагуу Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 254 шийдвэрээс 122 шийдвэр буюу 48% -ийг хэрэгсэхгүй болгосон, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх 159 магадлалаас 50,3% буюу 80 гомдлыг хангаалгүй орхисон бол Захиргааны хэргийн Хяналтын шатны шүүх 81 тогтоолоос 74% буюу 60 гомдлыг хангаагүй байна.

Тусгай хамгаалалттай газрын тухай маргааныг хянан шийдвэрлүүлэхийн тулд улсын хэмжээнд анхан шатны шүүхэд 14 иргэн, 81 хуулийн этгээд, 3 НҮТББ нэхэмжлэл гаргасан байна. 2019-2021 оны хооронд улсын хэмжээнд Захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн “Тусгай хамгаалалттай газартай холбоотой маргааны судалгааны” дагуу Захиргааны хэргийн анхан шатны шүүх 98 шийдвэрээс 40 шийдвэр буюу 40%-ийг хэрэгсэхгүй болгосон, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх 81 магадлалаас 58% буюу 47 гомдлыг хангаалгүй орхисон бол Захиргааны хэргийн хяналтын шатны шүүх 47 тогтоолоос 74% буюу 35 гомдлыг хангаагүй байна. Үүнээс үзэхэд, хариуцлагатай захиргааг бий болгох зорилго “тодорхой хэрэг дээр” хангадаг боловч харин өргөн утгаараа энэ зорилго хангагдахгүй байна. Учир нь Монгол Улсын Захиргааны хэргийн шүүх захиргааны байгууллагын албан тушаалтны шийдвэрийг захиргааны хэргийн шүүхээс хууль зөрчсөн гэдгийг тогтоож хүчингүй болгосон байхад дахин алдаатай шийдвэрийг удаа дараа гаргаж иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөөр



байгаа нь захиргааны хэргийн шүүхээр хянан хэлэлцэгдэж буй маргааны төрөл, тоо баримтаас харагдаж байна. Тусгай хамгаалалттай газар ашиглагч нар гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэлгүй зориулалтын бусаар ашиглах, газрын төлбөрөө бүрэн гүйцэд төлөөгүй зэрэг асуудлууд бодит байдал дээр түгээмэл байна.

Уурхайн ажлаас, ашигт малтмал олборлосноос шалтгаалж тусгай зөвшөөрөл олгогдсон газруудад амьдарч байгаа иргэдийн эрүүл орчинд амьдрах эрх зөрчигдөхөд нөлөөлөхүйц байгаль орчинд хор нөлөөлөл бий болж үүнд: ус, хөрс бохирдож хүнцэл, цианант илрэх, хөрс эвдэрч, элэгдэх, эмийн ургамал, амьтан, мод, сөөг устаж үгүй болох, гол тасрах магадлал өндөр. Цаашид ашиглалт явуулбал: гол ширгэж, ан амьтан, ургамал устах, үржил шимгүй хөрс бий болох, цөлжих аюул тулгарч байна. Ашигт малтмалын ордод үйлдвэрлэлийн үйл ажиллагааг явуулах нь тухайн орон нутагт амьдарч буй хүн амын эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөх, эрүүл мэндэд хортой тоос шороо, хорт хий агаарт дэгдэж амьсгалын эрхтэнг гэмтэх, үүнтэй холбоотойгоор хүний биед хорт хавдар, өвчин эмгэг үүсэх, байгаль экологийн тэнцвэрт байдал алдагдаж ан амьтан өвс ургамал, байгалийн унаган төрх алдагдах, байгальд хохирол учруулах эрсдэлтэй болохыг дээрхи дүн шинжилгээ хийсэн тогтоолоос ажиглаж болохоор байна. Монгол Улсад газрыг ухчаад нөхөн сэргээх асуудал ярих биш, тухайн газраа ер ухахгүй байх хэрэгтэй юм болов уу? Учир нь хөгжсөн улс орнууд болох АНУ, Герман, Итали, Франц, Орос, Хятад, Швейцарь, Япон, Энэтхэг, Нидерланд зэрэг улсууд газраа ухахгүйгээр, ухсан ч гэсэн маш бага хэмжээгээр ухах, буурай

хөгжилтэй эсвэл хөгжиж буй орнуудаас ашигт малтмалуудыг татан авч ашиглаж байгаа нь өөрсдийн улс орнуудынхаа байгалийн тэнцвэрт байдлыг болон газар доорх баялагаа хадгалж үлдэх стратеги бодолгыг баримталж байгааг харуулж байна. “Монгол Улсад газрыг ухчаад нөхөн сэргээх асуудал ярих биш, тухайн газраа ер ухахгүй, ашигт малтмал олборлохгүй байгалийн баялагаа хадгалах нь байгаль орчныг хамгаалж, хадгалж үлдэх нөхцөлийг бүрдүүлнэ” гэж судлаачын зүгээс үзэж байна. Тиймээс “холбогдох төрийн байгууллагууд нь ашигт малтмал олборлолгүй байгалийн баялагаа хадгалж, хамгаалж үлдэх стратеги, бодлогыг боловсруулвал байгаль орчныг хамгаалах, хадгалахад үнэтэй хувь нэмэр оруулах болно” гэдгийг дурдмаар байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, тухайн орон нутгийн Засаг дарга нар болон Мэргэжлийн хяналтын газар хамтран түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрлийг авсан хуулийн этгээдүүдийн явуулж буй үйл ажиллагаа нь хамгаалалтын бүстэй давхцалтай эсэх эсвэл иргэдийн суурьшлын бүсэд орсон эсэхийг жилд 9 удаа хяналт тавьж, шалгахыг санал болгож байна. Жич: тус саналыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны стратеги, тухайн орон нутгийн Засаг дарга нарын мөрийн хөтөлбөр, Мэргэжлийн хяналтын газрын жилийн төлөвлөгөөнд нь тусгаж болно. Мөн Монгол Улсын 1994 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж, тусгай хамгаалалттай газар нутгийн тодорхойлолтыг тус хуулинд тусгахыг судлаачын зүгээс санал болгож байна. Дээрхи хуулинд тусгай хамгаалалттай



газрын тодорхойлолтыг тусгаж өгснөөр иргэд тусгай хамгаалалттай газрын талаар тодорхой ойлголттой болох бөгөөд иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд ач тустай гэж бодож байна. Хүн байгальтай салшгүй холбоотой. Байгаль хүмүүс бидний эрүүл мэнд, амьдралын тав тухыг хангах гол эх сурвалж бөгөөд үүнийг дэлхий дээр амьдарч буй бүх хүмүүс ойлгож, ухамсарлах нь нэн чухал. Шинжлэх ухаан хурдацтай хөгжиж буй бидний эрин үед, хүмүүс бид байгальтай зүй бусаар харьцаж, хохирол учруулахгүй байх хэрэгтэй бөгөөд хүний байгальд учруулсан хохирол, хүн өөртөө учруулж байгаа хохиролтой тэнцүү гэдгийг бид мартаж болохгүй!

ЭХ СУРВАЛЖ

1. Ашигт малтмалын тухай хууль (2006 он) URL: <https://legalinfo.mn/mn/detail/63> (Сүүлд үзсэн 2022.05.27)
2. Байгаль орчныг хамгаалах тухай (1995 он) URL: <https://legalinfo.mn/mn/detail/8935> (Сүүлд үзсэн 2022.05.27)
3. Газрын хэвлийн тухай хууль” (1988 он) URL: <https://legalinfo.mn/mn/detail/218> (Сүүлд үзсэн 2022.05.27)
4. Соёлын өвийг хамгаалах тухай хууль (2014 он) URL: <https://legalinfo.mn/mn/detail/10439> (Сүүлд үзсэн 2022.05.27)
5. “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль” (1994 он) URL: <https://legalinfo.mn/mn/detail/479> (Сүүлд үзсэн 2022.05.27)
6. Монгол Улсын Их Хурлын 2019 оны 41 дүгээр тогтоол. URL: <https://old.legalinfo.mn/law/?cat=28>
7. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 46 дугаар тогтоол. URL: <https://old.legalinfo.mn/law/?cat=28>
8. Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 194 дүгээр тогтоол. URL: <https://legalinfo.mn/mn/detail/8732> (Сүүлд үзсэн 2022.05.27)
9. Федеральный закон “Об особо охраняемых природных территориях” от 14.03.1995 N 33-ФЗ/(ОХУ-ын “1995. 03.14 –ний өдрийн № 33 “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль”) URL: http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_6072/ (Сүүлд үзсэн 2022.05.27)
10. Пралин Баджпай. Какие страны активнее всего покупают золото? Изд: Золотой Запас. 2022г.// Пралин Баджпай. Ямар улс орнууд алтыг хамгийн их идэвхтэй худалдан авдаг вэ? Алтан нөөц. 2022 он URL: <https://www.zolotoy-zapas.ru/news/market-analytics/kakie-strany-aktivnee-vsego-rokupayut-zoloto/> (Сүүлд үзсэн 2022.05.27)
11. Рахимбаев Б.Б. Понятие, принципы организации особо охраняемых природных территорий в республике Казахстан. Вестник Казахстанско-Американского Свободного Университета. г. Алматы. 2017 г. Стр 34.// Бүгд Найрамдах Казахстан улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тухай тодорхойлолт, зарчимууд. Казах-Америкийн хамтарсан Чөлөөт Их Сургуулийн мэдээллийн товхимол. Алматы хот. 2017 он. 34 дахь тал.
12. Ц.Цогт, Байгаль орчныг хамгаалах асуудалд Захиргааны хэргийн шүүхийн гүйцэтгэх үүрэг, оролцоо. Шихихутуг Хууль зүйн дээд сургуулийн эрдэм шинжилгээний хурал. Улаанбаатар хот.2012.10.26 URL:<https://tsogt.coo.mn/98378/>



baigali-orchniig-hamgaalah-asuudald-
-zahirgaanii-hergiin-shuuhiin-
guitsetgeh-uureg,-oroltsoo.html

13. Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны (2022.05.10) хуралдаан. URL: <https://www.mnb.mn/j/42> (Сүүлд үзсэн 2022.05.27)
14. Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сангийн албан ёсны цахим хуудас (2022 он) URL: <https://shuukh.mn/cases/1/1>(Сүүлд үзсэн 2022.05.27)
15. Статистикийн мэдээллийн нэгдсэн саны албан ёсны цахим хуудас (2022 он) URL: https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_2800_030V1(Сүүлд үзсэн 2022.05.27)

**Abstract****ANALYSIS OF SOME TYPES OF DISPUTES IN DECISIONS
OF THE ADMINISTRATIVE COURT RELATED TO
ENVIRONMENTAL PROTECTION****SOVYETKHAN ZHANSAYA**

*Researcher of the Constitutional and International law Sector,
Judicial Training, Research and Information Institute under
Supreme Court of Mongolia*

The report analyzes claims and complaints filed by individuals and legal entities in defense of their violated rights and legitimate interests in order to eliminate risks and negative consequences of environmental management, as well as to prevent the occurrence of potential risks in the future. The goal is to solve existing

problems and find solutions for them. It is important to note that the content, ideas and conclusions presented in this report are written from the researcher's point of view.

Keywords: environment, violated rights, individuals, legal entities, court decisions.

**ҮНДСЭН ХУУЛЬ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАЛ, БАЙГАЛИЙН
БАЯЛАГ, ЭРҮҮЛ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХ БА ЦЭЦ**

**CONSTITUTION, ENVIRONMENTAL PROTECTION, NATURAL
RESOURCES, RIGHT TO LIVE IN HEALTHY ENVIRONMENT AND THE
CONSTITUTIONAL COURT OF MONGOLIA**

Дашпүрэвийн БАЯР¹

- I. Үндсэн Хууль - Үндсэн Асуудал: Хамгаалал, Баялаг, Эрх
- II. Үндсэн хууль ба байгаль хамгаалал
- III. Үндсэн хууль ба эрүүл орчинд амьдрах эрх
- IV. Үндсэн хууль ба байгалийн баялагДүгнэлт
- V. Дүгнэлт

¹ ХБНГУ-ын Нийгмийн Антропологийн Макс Планк хүрээлэнгийн “Хууль ба Антропологи” судлаач, докторантаар ажиллаж байгаа. “Эрүүл орчинд амьдрах эрхийг тодорхой соёлд, соёлын хандлагаар тайлбарлах” гэсэн төсөл дээр ажилладаг. Өөрийн судалгааны сэдэв нь “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх” гэдэг ойлголт нь ялангуяа байгалийн баялгийг ашиглах, хамгаалах харилцаанд хэрэглэгдэхдээ ямар нөлөө үзүүлж ба эргээд энэ нөлөөлөл нь уг эрхийг ойлголтыг тайлбарлах, томъёолоход ямар үүрэг үзүүлж байна вэ гэдгийг сонирхож байгаа. Энэхүү сэдвийн хүрээнд та бүхэн санал бодлоо хуваалцахыг хүсвэл дараах мэйл хаягаар холбогдохыг хүсэж байна: dashpurev@eth.mpg.de, миний тухай болон төслийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг доорх линкээр авна уу: <https://www.eth.mpg.de/dashpurev>.



ҮНДСЭН ХУУЛЬ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАЛ, БАЙГАЛИЙН БАЯЛАГ, ЭРҮҮЛ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХ БА ЦЭЦ

Д.БАЯР. ХБНГУ-ын Нийгмийн Антропологийн Макс Планк хүрээлэнгийн “Хууль ба Антропологи” судлаач, докторант

Хураангуй: Үндсэн хуулийн Цэцээс иргэний эрүүл орчинд амьдрах эрх зөрчигдсөн эсэх асуудлаар хоёр хэрэг шийдсэн байдаг. Эхний хэрэг нь зарим нэг хилийн боомтын статусыг өөрчилж, “химийн аюултай болон хортой бодис” нэвтрүүлэх эрх хэмжээтэй болгосон Засгийн Газрын тогтоол нь иргэний эрүүл орчинд амьдрах эрхийг зөрчсөн эсэх маргаан. Нөгөө нь эрүүл мэндийн тухай хуулиар мэргэжлийн эмч биш, эмчлэх эрхийн тусгай зөвшөөрөлгүй дадлагажигч эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхээр зохицуулсан нь мөн эрхийг зөрчсөн эсэх юм. Үүнээс гадна уг эрхийн зөрчилтэй холбоотойгоор олон мэдээлэл, хүсэлтэд Цэцийн зүгээс маргаан үүсгэхээс татгалзсан харагддаг. Эрүүл орчинд амьдрах эрхийн агуулга, хэрэглээ нь нийгэм, улс төр, соёлын хүчин зүйлүүдээс хамаарч өөрчлөгдөж байгаа нь маргааны төрөл, хүсэлт, мэдээллийн агуулгаас тодорхой ажиглагддаг. Хамгийн чухал нь эрүүл орчинд амьдрах эрх нь өөрөө байгаль хамгаалах бодлогын суурь, үндэс болдог. Эрүүл орчинд амьдрах эрхийг хангах нь төр, түүний институтын үүрэг байдаг. Гэтэл энэхүү үүрэг нь уул уурхайгаас эдийн засаг, улс төр, гадаад бодлого нь бүрэн хамааралтай улсын хувьд бүдгэрч, алга болдог зүй тогтол нэгэнт хэвшсэн байна. Шүүх, Үндсэн

хуулийн Цэц төрийн байгаль хамгаалах үүрэг, эрүүл орчинд амьдрах эрхийг хангах үүрэг, байгалийн баялгийг зөв зохистой ашиглах үүрэг зэргийг хэрэг, маргааныхаа хүрээнд анхаарч, шаардах нь байгаль хамгаалах бодлого хэрэгжих чухал үндэс болно. Тиймээс үр дүнтэй байгаль хамгаалах бодлого хэрэгжих, эрүүл орчинд амьдрах эрхийн зөрчлийг сэргээн тогтооход ямар тайлбар, үзэл санаа, зарчмыг үндэс болгох ёстой вэ гэдэгт энэ илтгэл хариулахад зорино.

Түлхүүр үг: Эрүүл орчинд амьдрах эрх (Environmental rights), байгаль орчныг хамгаалах үндсэн хуулийн зохицуулалт (constitutional environmental protection provisions), тэнцлийн зарчим (proportionality), төрийн үүрэг (State responsibility).

Талархал

“Байгаль орчныг хамгаалахтай холбоотой хэрэг маргааныг шүүхэд хянан шийдвэрлэж буй байдал, дүн шинжилгээ, анхаарах асуудал” сэдвээр эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж байгаа Улсын дээд шүүх, Ханнс Зайделийн сан, МУИС-ийн Хууль зүйн сургууль ба Дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн хамт олонд баярласнаа илэрхийлье. Мөн энэ хуралд оролцох,



илтгэл хэлэлцүүлэх боломжоор хангасанд талархаж байна. Түүнчлэн хэлэлцүүлгийн үеэр асуулт тавьсан, санал хэлсэн нийт оролцогчдоо баярлалаа.

1. Үндсэн Хууль – Үндсэн Асуудал: Хамгаалал, Баялаг, Эрх

Байгаль хамгаалал, байгалийн баялгийг ашиглах, иргэний эрүүл орчинд амьдрах эрх гэх гурван ойлголтын хамаарлыг цогцоор нь харж, хууль зүйн зөв тайлбар хийх шаардлага хэрэгцээ байна. Учир нь байгаль хамгаалал, иргэний эрүүл орчинд амьдрах эрхийг хамгаалах харилцаанд хувь иргэн, иргэдийн нэгдлийн байгууллага (төрийн бус байгууллага гэж ойлгох) болон захиргааны чиг үүргийг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлдэг бүтцийн эрх, үүрэг, оролцоог салбарын хуулиудаар сүүлийн жилүүдэд баталгаажуулж, сайжруулсан үйл явц үргэлжилсээр байна. Гэтэл төр, түүний институт болон албан тушаалтны үүрэг оролцоо нөгөө талдаа орхигдсон. Тиймээс энэхүү гурван ойлголтын хамаарлыг Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн агуулга дээр тодорхойлох, төрийн оролцоог тодорхой шийдвэрээр дамжуулан нэмэгдүүлэх бололцооны талаар энэ илтгэлд маргана.

Байгаль хамгаалал, байгалийн баялгийг ашиглах, эрүүл орчинд амьдрах эрхийн асуудлыг үндсэн гурван өнцгөөр харж байна.¹ Нэгт, иргэдийн эрүүл орчинд амьдрах эрхэд тулгуурлан, уг эрхийг хамгаалах замаар байгалийн баялгийг зөв, зохистой ашиглах, байгалийн бүрдэл хэсгийг хамгаалах (rights-based approach) аргачлал юм.

¹ Харах: Тим Хейворд, Үндсэн хуулийн эрүүл орчинд амьдрах эрх, 2005; Дэвид Бойд, Эрүүл орчинд амьдрах эрхийн хувьсгал: Үндсэн хуулиуд, хүний эрх, ба хүрээлэн буй орчны талаар олон улсын харьцуулсан судалгаа, 2012 он; Жон Нокс болон Рамин Пежэйн, Эрүүл орчинд амьдрах хүний эрх, 2018 он, г.м.

Хоёрт, байгаль, түүний бүрдэл хэсгийг амьд, хүний оюун сэтгэхүйгээс гадна бие даан оршдог дотоод үнэт зүйлтэй гэж хүлээн зөвшөөрч, байгалийг эрхжүүлэх байдлаар (rights of nature) хамгаалж байна.² Өөрөөр хэлбэл хүн бол байгалийн нэг хэсэг бөгөөд биологийн төрөл зүйл юм. Харин хүн гэдэг төрөл зүйл нь том бохирдуулагч болсон бөгөөд байгалийн оршихуйд гол халдагч болжээ. Тийм учраас хүний төрөл зүйлс байгалийн өмнө үүрэг хүлээх, эсрэгээрээ байгаль хуулиар тогтоосон эрх эдлэх ёстой гэж маргадаг. Ялангуяа энэ төрлийн хандлага нь сүүлийн үед өмнөд Америк болон зарим нэгэн арлын орнуудад хүчтэй хөгжиж, үндсэн хуулиараа хамгаалсан тохиолдол ч цөөнгүй байна.

Гурав дахь хэлбэр бол тодорхой бүлийн (indigenous group, peasant communities, nomadic people) газар, байгалийн баялгийг эзэмших, ашиглах эрхийг хүлээн зөвшөөрөх замаар байгаль хамгаалал, байгалийн баялаг ашиглах харилцааг зохицуулж болдог.³

Дээрх гурван хандлагаас хүний эрхэд суурилсан байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг ашиглах хандлага нь хамгийн түгээмэл олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн. Мөн тодорхой уугуул иргэдийн газар, байгалийн баялгийг ашиглах эрхийг хүлээн зөвшөөрөх замаар байгаль хамгаалах үүргийг хэрэгжүүлдэг бодлого зарим газруудад түгээмэл байна. Дээрх хоёр хандлага

² Энэ сэдвээр маш олон бүтээл сүүлийн жилүүдэд бичигдэж байгаа. Ялангуяа Эквадор, Шинэ Зеланд, түүнчлэн Папуа – Шинэ Гвиней зэрэг орнуудын үйл баримтад үндэслэн Байгаль эхийг хууль ёсны эрхтэй оршихуй гэж үзэж, шүүхээр хамгаалах үндэслэл бүрдэж байгаа. Харах: Дэвид Боуд, Байгалийн эрх, 2017.

³ Харах: Мариана Монтейро Матос, Америкийн бүс нутгийн эрх зүйн систем дэх уугуул иргэдийн газрын эрх: материаллаг ба процессийн эрх, 2020 он.



нь олон улсын эрх зүйн хүрээнд хүлээн зөвшөөрөгдөж, хуульчлагдсан. Харин Монгол Улсын хувьд хүний эрх-эрүүл орчинд амьдрах эрхэд суурилсан байгаль хамгаалал, байгалийн баялгийг ашиглах бодлого хэрэгжүүлэхээр Үндсэн хуулиараа тодорхойлсон.

Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхэд суурилсан байгаль орчны хамгаалал, байгалийн баялгийг ашиглах тогтолцоо нь хоёр үндсэн давуу талыг бий болгодог. Нэгт, Үндсэн хуулийг дагалдан гарч байгаа байгаль орчныг хамгаалах салбар хуулиудын зорилго ойлгомжтой, тогтолцоо системтэй болно. Хоёрт, иргэний эрүүл орчинд амьдрах эрхийг байгаль хамгаалах тогтолцооны төвд тавьснаар байгаль хамгаалах систем бүрэн ажиллах, үр дүнд нь байгаль хамгаалах зорилго биелнэ гэж маргадаг. Хэдийгээр Монгол Улсын хувьд эрүүл орчинд амьдрах эрхийг байгаль хамгаалал, байгалийн баялаг ашиглах суурь зохицуулалтын үндэс болгож зохицуулсан боловч эерэг үр дүн харагдахгүй байгаа нь шинжлэх ухааны тоо баримт гаргаж тавихгүйгээр бидэнд ойлгомжтой ажиглагдаж байгаа.⁴

Эрүүл орчинд амьдрах эрхийг байгаль хамгаалал, байгалийн баялгийг ашиглах хууль зүйн зохицуулалтын үндэс болох ёстой гэж маргадаг судлаачид, хуульчид үзэхдээ энэ эрх нь бодитой хэрэгжихгүй байгаа нь улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын бусад олон хүчин зүйлээс шалтгаална гэж маргадаг. Монгол Улсын хувьд авлигал, сул хууль дээдлэх ёс, улс төрийн гажуудсан тогтолцоо зэргээс болж байгааг “хүний эрх ба амьдрах орчны” талаарх НҮБ-ын тусгай илтгэгч тайландаа

⁴ Харах: Жон Нокс, НҮБ-ын тусгай илтгэгч, Эрүүл, аюулгүй, цэвэр орчин ба хүний эрхийн нөхцөл байдлын талаарх Монголын тайлан, дүгнэлт, 2017 он - <https://digitallibrary.un.org/record/1629996?ln=en>

тусгасан байдаг.⁵ Үүнээс гадна хууль зүйн тогтолцооны хувьд (1) хууль хэрэгжилт муу байхын зэрэгцээ (2) эрүүл орчинд амьдрах эрхийг салбарын бусад хуульд буулгахдаа хязгаарласан, утга санааг нь дордуулсан, эсхүл (3) стандартжуулахдаа дордуулсан байдал зэргээс шалтгаалдаг гэж үздэг.⁶ Иймд дээрх асуудлыг үндэс шалтгааныг тодруулахын тулд байгаль хамгаалал, байгалийн баялаг, эрүүл орчинд амьдрах эрхийн зохицуулалтын Үндсэн хуулийн агуулгыг зөв томьёолох нь зүйтэй.

Байгаль хамгаалал, байгалийн баялгийг ашиглах, эрүүл орчинд амьдрах эрхийг хангах тогтолцоонд дээр хэлсэнчлэн олон бэрхшээл тулгарч байгаа. Хууль хэрэгждэггүй, эрх зүйт төрийн үзэл санаа бүрэн төлөвшөөгүй, Үндсэн хуулийнхаа үзэл санаагаа салбарын хуулиудаар хязгаарладаг, эрүүл орчныг тогтоох стандарт нь доогуур гэх мэт. Гэхдээ энэ байдалд яагаад хүрсэн бэ гэдэг асуултад хариулах түлхүүр бол төрийн үүрэг юм. Уул уурхайгаас эдийн засаг, улс төр, нийгэм нь бүхэлдээ хамааралтай улсын хувьд төр, түүний институтийн байгаль хамгаалах үүргээ биелүүлэхээс татгалзаж, орон нутгийн иргэд болон уул уурхайн компанийн хооронд орхидог нь түгээмэл хэлбэр болсон.⁷ Энэхүү төрийн үүрэг оролцоо гээгдсэн байдлыг шүүхийн шийдвэрийн агуулгаас ч харч болно. Тиймээс төр, түүний институтийн үүргийг ирсэн маргааны хүрээнд шалгаж, шаардах эрх хэмжээ нь шүүх, Цэцэд

⁵ Мөн илтгэлд

⁶ Тим Хейворд, Дэвид Боуд, Жон Ноксийн бүтээлүүд.

⁷ Паскаль Хатчер, Эрсдэлтэй тогтолцоо: Дэлхийн банк ба Азийн уул уурхайн өөрчлөлт, 2014 он. Женнифер Ландер, Үндэстэн дамнасан хуулийн тогтолцоо ба төрийн өөрчлөлт: Монгол Улс дахь олборлох аж үйлдвэрийн хөгжлийн жишээ, 2020 он гэх мэт олон бүтээл энэхүү асуудлыг олон өнцөгөөс томьёолсон байдаг.



байгаа, үүнийг Үндсэн хуулийн үзэл санаагаар тогтоосныг сануулах зорилгод хөтлөгдөж энэхүү илтгэл бичигдсэн.

Дээрх гурван ойлголтын хамаарлыг Үндсэн хуулийг төвшинд томъёолохдоо Дэвид Боудын аргачлалыг хэрэглэж Монгол Улсын Үндсэн хууль тогтолцооны хөгжлийн үйл явцад анализ хийх байдлаар авч үзнэ. Байгаль орчныг хамгаалах Үндсэн хуулийн тогтолцоог Дэвид Боуд ангилахдаа үндсэн 5 бүтцээр авч үзсэн. Үүнд: Иргэний материаллаг эрх, процессын эрх, төрийн үүрэг, хувийн үүрэг, болон бусад байгаль орчныг хамгаалах зохицуулалт багтана гэжээ.⁸ Эдгээр зохицуулалтыг шалгуур болгож байгаль орчныг хамгаалах Монгол Улсын тогтолцоог социалист болон ардчилсан үндсэн хуулиудад хэрхэн туссаныг илтгэлээр харуулна. Иймд илтгэл нь дараах бүтэцтэй байна. Нэгт, Үндсэн хууль ба байгаль хамгаалал буюу байгаль хамгаалах үүргийг хэрхэн харж, хэнд хамааруулж ойлгож байсан, түүнчлэн (хоёр) Эрүүл орчинд амьдрах эрхийг ямар агуулгаар харж, хүлээж авч байгаа, (гурав) дээрх хоёр ойлголт нь байгалийн баялгийг ашиглах харилцаанд хэрхэн бууж байгаа болон (дөрөвт) шүүх, Цэц энэ харилцааг хэрхэн зөв харж, дүгнэх үүрэгтэй вэ? гэсэн 4 бүлэг асуудлыг хөндөнө.

2. Үндсэн хууль ба байгаль хамгаалал

Байгаль орчныг хамгаалах Үндсэн хуулийн зохицуулалтыг 1992 оны Үндсэн хуулийн хүрээнд авч үзвэл: Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн

16.2⁹, 17 дугаар зүйлийн 17.2¹⁰, 38 дугаар зүйлийн 38.2.(4)¹¹ заалт болон Үндсэн хуулийн 2019 оны 6 дугаар зүйлийн 6.2¹²-ийн нэмэлт өөрчлөлт зэрэг багтана. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Үндсэн хууль нь байгаль орчныг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бүхэлд нь Үндсэн хуульчилсан. Монгол Улсын иргэн нь эрүүл орчинд амьдрах үндсэн эрхтэйн зэрэгцээ, байгаль орчны нөлөөллийн талаар мэдэх буюу процессын эрхтэй байхаар тогтоосон. Түүнчлэн иргэн бүр байгаль орчноо хамгаалах журамт үүрэгтэй, харин хүрээлэн буй орчныг хамгаалах нь засгийн газрын үндсэн үүрэг, эрх хэмжээний асуудал байхаар хуульчлагдсан.

Дээрх байгаль орчныг хамгаалах үндсэн хуулийн зохицуулалтыг социалист

⁹ Монгол Улсын Үндсэн хуулийн 16.2. “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй, харах: <https://legalinfo.mn/mn/detail/367>.

¹⁰ Үндсэн хуулийн 17.2. “Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн.”

¹¹ Үндсэн хуулийн 38.2.4. “Засгийн газар төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийн дагуу дараахь үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ авах;”

¹² Үндсэн хуулийн 6.2. “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн.

Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй.

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.”

⁸ Дэвид Бойд, Эрүүл орчинд амьдрах эрхийн хувьсгал: Үндсэн хуулиуд, хүний эрх, ба хүрээлэн буй орчны талаар олон улсын харьцуулсан судалгаа, 47-58 тал, 2012 он



Үндсэн хуулиудын хүрээнд харж, байгаль хамгаалах эрх зүйн зохицуулалтыг хөгжлийг өнгөцхөн ав үзвэл: Байгаль орчныг хамгаалах, ялангуяа байгалийн баялгийг хамгаалах нь иргэний, мөн төрийн үндсэн үүрэг байхаар 1960 оны Үндсэн хуульд зохицуулсан байдаг.¹³ 1940 оны Үндсэн хууль, 1924 оны Үндсэн хуульд байгалийн баялаг, байгаль орчныг хамгаалах нь төрийн үндсэн үүрэг байхаар зохицуулсан.¹⁴ 1924 оны Үндсэн хуулиар тогтоохдоо байгалийн баялаг нь эрт цагаас нааш ард нийтийн хөрөнгө байсаар ирсэн зан суртал нь одоогийн ард улсын ёсонд нийлэлцэх болон улсын дээд эрхийг барилцах байгууллага нь дэлхийн баялгийг ашиглах дүрэм заавар тогтоох эрхтэй байхаар зохицуулсан байдаг.¹⁵

Дээрх үндсэн хуулиудын зохицуулалтыг задлан харвал хэд хэдэн дүгнэлт хийж болохоор байна. Нэгт, эрт цагаас байгалийн баялаг нь ард нийтийн хөрөнгө байсан. Харин хэрхэн, яаж ашиглахыг төрөөс-эзнээс тогтоодог байсан. Тиймээс байгаль хамгаалах бодлого нь нэг талаараа баялгийг ашиглаж байгаа хүмүүст үүрэг болгох, нөгөө талаас төр-эзэн нь өөрөө ашиглах заавар дүрмийг батлах замаар хэрэгжиж байсан гэж үзэж болно. Хоёрт, байгаль орчныг хамгаалах уламжлалт бодлого нь үүрэгжүүлэх – нутаг усаа сахих, зүй зохистой ашиглах, зөрчигчдийг шийтгэх – замаар зохицуулж байсан нь мөн социалист төрийн бодлоготой нийцэж

байсныг илтгэнэ. Тийм ч учраас 1940, 1960 оны Үндсэн хуулиудад байгаль орчин, түүний баялгийг хамгаалах нь иргэний үүрэг – нүдний цөцгий мэт хайрлах ёстой гэж зохицуулж байсан байна.¹⁶

Гуравт, харин 1992 оны Үндсэн хуулиар байгаль орчныг хамгаалах тогтолцоо үүрэгжүүлснээс эрхжүүлсэн тогтолцоо руу шилжсэн. Энэ нь байгаль орчныг хамгаалах үүргийг иргэнд хүлээлгэдэг байдлыг өөрчилж, эрх зүйн үр дагаваргүй “журамт” үүргийн зохицуулалтыг оруулах үндэс болсон байна. Дөрөвт, гэхдээ байгаль орчныг хамгаалах, иргэний эрүүл орчинд эрхийг баталгаатай эдлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үүргийг 1992 оны Үндсэн хуулиар “Төрд” тогтоож өгсөн нь Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 болон 38 дугаар зүйлийн 38.2.4 заалтаар тус тус илэрдэг.

Эцэст хэлбэл байгаль орчныг хамгаалах үүрэг нь эртнээс нааш төрийн үүрэг байсан, харин эрхийн зохицуулалтыг Үндсэн хуульд оруулж өгснөөр төрийн үүргийг улам тодруулах, ойлгомжтой болгох ёстой байсан атал эрхжүүлсэн зохицуулалтыг үүргээ бүдгэрүүлэх зохицуулалт болгож хүлээж авсан нь тодорхой харагддаг. Энэ нь дараа дараагийн байгаль орчныг хамгаалах салбарын бусад хуулиудын агуулга, бичилтээс бүрэн ажиглагдахаас гадна, шүүхэд гомдол гаргах эрх зүйн зохицуулалтын өөрчлөлтүүдээс мөн харагдана.

¹³ БНМАУ-ын Үндсэн хууль, 1960 он, 9, 10, 41(д), болон 89(г)(е) зүйлүүдийг харах: <https://legalinfo.mn/api/front/cons-detail-1960.html>.

¹⁴ БНМАУ-ын Үндсэн хууль, 1924 он, Хоёрдугаар бүлэг, 5 дугаар зүйлийн 10 заалт; БНМАУ-ын Үндсэн хууль, 1940 он, Хоёрдугаар бүлгийн 10-р зүйлийн 17 заалт, харах: <https://legalinfo.mn/api/front/index.html>.

¹⁵ БНМАУ-ын Үндсэн хууль, 1924 он, Нэгдүгээр бүлгийн 3-р зүйлийн 1 заалт.



Байгаль орчныг хамгаалах салбарын бусад хуульд үүрэгжүүлэх зохицуулалтын үлдэгдэл хэвээр хадгалагдсаар байгаа. Жишээ нь: Байгаль орчныг хамгаалах 1995 оны хуулиар иргэний эрүүл орчинд амьдрах эрхийг хангах, түүнчлэн байгалийн баялгийг зохистой ашиглах зорилгыг тодорхойлсон.¹⁷ Энэ нь тогтвортой хөгжлийн үзэл санаатай шууд холбогддог. Гэтэл хуульд иргэний эрхийг хамгаалах зорилгыг тодорхойлсон мөртлөө иргэдэд байгаль орчныг хамгаалах үүргийг тогтоож өгсөн байдаг.¹⁸ Мөн иргэнд, байгаль орчныг хамгаалах, төрийн бус байгууллагад нийтийн эрх ашиг, төрийн өмнөөс байгаль орчинд учирсан хохирол, учруулж болохуйц үйлдлийг нэхэмжилж болохоор зохицуулсан нь үүрэгт тулгуурласан байгаль орчны зохицуулалтын хэлбэр юм.¹⁹

Энэ нь салбарын бусад хуулиудад ч зарим тохиолдолд шууд хадгалагдсан байдаг. Ойн тухай хуулиар иргэд ой, ойн нөөцийг хамгаалахад үүрэг хүлээхээр зохицуулсан байна.²⁰ Түүнчлэн үүрэгт тулгуурлан байгаль орчныг хамгаалах зохицуулалт нь байгаль орчны салбарын бусад хуулиудад дам байдлаар туссан байдаг. Ийнхүү иргэдэд, эсхүл төрийн бус байгууллагад байгаль орчныг хамгаалах ерөнхий үүргийг тусгаж өгсөн нь нэг талаар зүйтэй мэт харагдах боловч нөгөө талаар төр, түүний институт, албан тушаалтнуудын байгаль орчныг хамгаалах үүргийг бүдгэрүүлэх, эс үйлдэхүй гаргах, эрх зүйн хэм хэмжээг сонголттой хэрэглэх орон зайг бий болгож байна.

Эцэст нь энэ бүлэг асуудлыг томъёолон хэлбэл байгаль орчныг хамгаалах үүрэг бол төрийн үндсэн үүрэг мөн. Учир нь төр нь (1) байгалийн баялгийг өмчлөгч болох, (2) иргэний эрүүл аюулгүй орчинд

амьдрах эрхийг хангах үүргийг хүлээсэн институт болох, (3) нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэгч болохынхоо байгаль орчныг хамгаалах үүргийг хүлээх ёстой. Ийм ч агуулгаар Үндсэн хууль тогтоож өгсөн. Гэтэл байгаль орчныг хамгаалдаг уламжлалт буюу үүрэгжүүлдэг тогтолцоог хадгалж үлдэх оролдлого хийхийн зэрэгцээ иргэдийн эрхийг хамгаалах гэхээс илүүтэйгээр иргэд өөрсдөө эрхээ хамгаалах ёстой гэдэг байр сууринаас байгаль орчныг хамгаалах асуудалд хандаж байгаа нь төрийн үүргийг бүдгэрүүлсээр, төр хуулиар хүлээсэн үүргээ сонголттойгоор хэрэгжүүлэх үндэс болсоор байна. Энэ нь байгаль хамгаалал, байгалийн баялгийг ашиглах болон иргэдийн эрүүл орчинд амьдрах эрхийн хэрэг маргаанд төр, түүний институт болон албан тушаалтны оролцож байгаа хэлбэрээс тодорхой ажиглагддаг. Хэдийгээр байгаль орчныг хамгаалах чиг үүрэгт иргэдийн эрхийг нээж өгсөн нь сайн зохицуулалт боловч нөгөө талдаа төрийн үүрэг оролцоог үгүйсгэсээр байгаа нь хууль тогтоомж сул хэрэгжих үндэс болж байна.

Дараагийн хэсэгт эрүүл орчинд амьдрах эрхийн хөгжил, оролцоог тодорхойлох замаар энэ нь байгаль хамгаалах бодлого, ашиглах харилцаанд ямар өөрчлөлтийг авчир байгааг авч үзэх болно.

3. Үндсэн хууль ба эрүүл орчинд амьдрах эрх

Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг ашиглах болон эрүүл орчинд амьдрах эрхийг хангах үндсэн хуулийн зохицуулалтууд нь ялгаатай заалтуудаар илрэх боловч хоорондоо салшгүй холбоотой. Энэхүү зохицуулалтын хөгжил, хамаарлыг үндэсний болон олон улсын эрх зүйн хүрээнд, түүнчлэн шинэ



Үндсэн хууль батлагдах, үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн хамааралд энэ бүлгээр авч үзнэ.

Байгаль орчныг хамгаалах үндсэн хуулийн зохицуулалтыг төрийн үүрэг, оролцоогоор тодорхойлдог онцлог хэлбэр нь дэлхийн үндсэн хуулиудад эртнээс туссан харагддаг. Жишээ нь 1971-ээс 1979 оны хооронд энэ төрлийн зохицуулалт нь 20 гаруй улс орны Үндсэн хуульд ямар нэгэн хэлбэрээр тусгалаа олсон байдаг.²¹ Байгаль орчныг хамгаалах асуудлыг үндсэн хуулиар хамгаалах, үндсэн хуульд зайлшгүй тусгаж өгөх хандалга нь 1990 оноос эхлэн түгээмэл зохицуулалтын хэлбэр болж хувирсан. Монгол Улсын хувьд ч мөн ялгаагүй байгаль хамгаалал, байгалийн баялгийг ашиглах харилцаа энэ үеэс эхлэн илүү системчлэгдсэн байдлаар Үндсэн хуульд тодорхойлогдсон.

Харин хүний эрх ба хүний амьдрах орчны үзэл санаа нь олон улсын эрх зүйн хүрээнд 1972 оны Стокхолмын тунхаглалаас эхлэлтэй.²² Хүний эрх болон эрүүл орчинд амьдрах эрхийг тодорхойлж, хамгаалсан тохиолдол нь хамгийн анх Португал Улсын үндсэн хуульд 1978 онд туссан байдаг.²³ Эрүүл орчинд амьдрах эрхийг үндсэн хуулиараа тодорхойлж, хамгаалсан үйл явц нь мөн л ялгаагүй 1990 онд хамгийн хүчтэй өрнөсөн. 1990-1999 онд нийт 47 улс “эрүүл орчинд амьдрах эрх”-ийг Үндсэн хуульчилсан.²⁴ Өөрөөр хэлбэл эрүүл

²¹ Дэвид Боуд, Эрүүл орчинд амьдрах эрхийн хувьсгал, 49-р тал, 2012 он.

²² НҮБ-ийн Хүрээлэн буй орчин ба Тогтвортой хөгжил Олон Улсын уулзалт, Стокхолмийн тунхаг, 1972 он, харах: <https://www.un.org/en/conferences/environment/stockholm1972>.

²³ Протукал Улсын Үндсэн хууль, 1976 он, 66-р зүйл, харах: https://www.constituteproject.org/constitution/Portugal_2005.pdf.

²⁴ Дэвид Боуд, 62 тал, 2012 он.

хамгаалах зохицуулалтууд нь Үндсэн хуулийн төвшинд тодорхойлогдож, эрх зүйн хамгаалалтыг тогтоосон үйл явц нь 20-р зууны сүүлийн 10 жилтэй салшгүй холбоотой. Энэ нь хэд хэдэн хүчин зүйлстэй шууд холбогдоно.

Олон улсын эрх зүйн үүднээс харвал 1992 онд “Рио-гийн тунхаглал”-аар хүний эрүүл орчинд амьдрах, байгалийн баялгийг зөв ашиглах буюу тогтвортой хөгжлийн үзэл санаа дэлхийн түвшинд хүчтэй тавигдсан.²⁵ Энэ нь шинжлэх ухаан, улс төр, нийгмийн хүрээнд хүний байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөлөл нь хүрээлэн буй орчин, биологийн төрөл зүйл, улмаар хүн төрөлхтөнд хөнөөлтэй болохыг хүлээн зөвшөөрч, бодит шийдлийг эрэлхийлсэн үйл явцын үр дүн байсан.

Стокхолмоос Рио хүртэлх хугацаанд дэлхийн зарим улс орон, бүс нутгийн түвшинд байгаль орчныг хамгаалах харилцааг үндсэн хуулиар зохицуулж, эрүүл орчинд амьдрах эрхийг үндсэн хуульчилсан үйл явц тасралтгүй үргэлжилсэн. Эрүүл орчинд амьдрах эрх нь өнөөдөр дэлхийн олон улсын Үндсэн хуулиудын салшгүй нэг хэсэг болсон төдийгүй байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг ашиглах харилцааны суурь үзэл санаа болжээ. Харин энэхүү эрүүл орчинд амьдрах эрхийг үндсэн хуульчлах үйл явц нь эцэстээ олон улсын эрх зүйн төвшинд хамгаалагдсан. 2021 оны 10-р сарын 08-ны өдрийн НҮБ-ын Хүний эрхийн салбар комиссын хурлаар “Эрүүл аюулгүй, тогтвортой орчинд амьдрах эрх”-ийг хүний үндсэн эрх болохыг баталгаажуулж, тогтоосон.²⁶

²⁵ НҮБ-ийн Хүрээлэн буй орчин ба Тогтвортой хөгжил Олон Улсын уулзалт, Риогийн тунхаг, 1992 он, харах: <https://www.un.org/en/conferences/environment/rio1992>.

²⁶ НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн 48-р салбар хуралдаа, 2021 оны 09-р сарын 13-ны өдрөөс 10-р



Монгол Улс бол энэхүү үйл явцын салшгүй нэг хэсэг мөн.

1985 оны хагасаас эхлэн Монгол Улс, түүнчлэн олон социалист улсуудын хүрээнд өөрчлөлт шинэчлэлт болох нь тодорхой болж эхэлсэн.²⁷ Энэ өөрчлөлт шинэчлэлийн үр дүн нь 1990 оноос эхэлсэн шинэ үндсэн хууль батлах үйл явцаар үргэлжилсэн. Монгол Улсын хувьд ч ялгаагүй. Өмнө хэлсэнчлэн энэ үетэй зэрэгцэн дэлхийн төвшинд байгаль орчин, хүний амьдрах орчны доройтол, хүн төрөлхтний оршихуй асуудал эрчимтэй тавигдсан. Тиймээс ч 1990 онуудад батлагдсан бүх л Үндсэн хуулиуд нь эрүүл орчинд амьдрах эрх, энэ эрхийг бодитоор хамгаалах, хэрэгжүүлэх процессын эрхүүдийг тодорхой төвшинд өөртөө тусгаж өгсөн. Монгол Улс мөн адил эрүүл орчинд амьдрах эрхийг Үндсэн хуульдаа тодорхойлж, эрх зүйн хамгаалалтыг бий болгосон. Гэхдээ энэ үйл явц нь тийм ч тодорхой байгаагүй нь шинэ Үндсэн хууль батлах үеийн процессоос харагддаг.

3.1. Шинэ Үндсэн Хуулийн төсөл ба эрүүл орчинд амьдрах эрх

Шинэ ардчилсан Үндсэн хууль батлах процесс болон эрүүл орчинд амьдрах эрхийн хөгжлийг дараах үндсэн дөрвөн төсөл баримт бичгийн хүрээнд авч үзлээ. Нэгт, 1991 оны 4 сарын 19-нд үндсэн хууль боловсруулах комиссоос үндсэн хуулийн анхны төслийг Улсын Бага Хуралд өргөн барьсан хуулбар. Хоёрт, 1991 оны 05 дугаар сарын 25 өдөр “Ардын эрх” сонинд хэвлэгдэж, олон нийтийн санал авсан хуулбар, Гуравт, 1991 оны 10-р сард УБХ-д хэлэлцүүлэхээр өргөн

сарын 11-ны өдөр, А/HRV/48/13 дүгнэлт, харах: <https://documents-dds-ny.un.org/doc/UNDOC/GEN/G21/289/50/PDF/G2128950.pdf?OpenElement>.

²⁷ Алан Ж.К. Сандерс, Монгол Улс 1984 онд: Цэдэнбалаас Батмөнх, Азийн Судалгаа, 1985 оны 1-р сар, Дэвтэр 25, дугаар 1.

барьсан хуулбар. Дөрөвт, 1991 оны 11-р сард Ардын Их Хуралд өргөн барьсан төсөл зэргийн хүрээнд эрүүл орчинд амьдрах эрхийг хүлээж авсан, бусад үндсэн хуулийн заалтуудад нөлөөлсөн байдлыг авч үзнэ.

Нэг. 1991 оны 04-р сар:²⁸ Уг төсөл дээр эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх гэдэг ойлголтын агуулга анх орж ирсэн. Төслийн 16 дугаар зүйлийн 16.1-т “иргэн бүр амьдрах, эрүүл саруул орчинд аж төрөх эрхтэй. Хүний амь насыг дур зоргоороо бусниулахыг хатуу цээрлэнэ” гэж тодорхойлсон байдаг. Өөрөөр хэлбэл төсөлд тодорхойлсноор иргэний амьд явах эрх болон эрүүл саруул орчинд амьдрах хоёрыг нэг заалтаар тодорхойлсон гэсэн үг. Энэхүү зохицуулалтын онцлог нь эрүүл саруул орчинд амьдрах эрхийг уламжлалт, шашинлаг буюу “үйлийн үр” гэсэн өнцгөөс харж байсан гэж үзэх үндэстэйг харуулж байна.²⁹ Учир нь байгаль, байгалийн баялгийг арга гамтай ашиглахгүй бол муу үр дагавар эргэх байдлаар учирна гэдэг хандлагаар эрүүл орчинд амьдрах эрхийг харж байсан. Ийм төрлийн тайлбар буюу иргэний амьд явах эрхийг тайлбарлах замаар эрүүл орчинд амьдрах эрхийг хамгаалдаг хандлага нь Энэтхэгийн шүүхийн шийдвэрээс шууд харагддаг.³⁰

Хоёр. 1991 оны 5-р сар:³¹ Үндсэн хуулийн төслийг “Ардын эрх” сонинд нийтэлж, олон нийт, судлаач, болон гадны зөвлөхүүдээс санал авч эхэлсэн.

²⁸ Төрийн Их Цааз (төсөл), 1991 оны 04-р сарын 19-ны өдөр, Архив материалаас.

²⁹ Динг Ян, Төвдийн Буддизмын нөлөө Монголын орчин үеийн эко-утга зохиолд, Хятадын Төвд судлал, дугаар 2, 2017 он.

³⁰ Шям Диван, Нийтийн Ашиг Сонирхлын Маргаан, 2016 он; Парвез Хассан, Азим Азфар, Өмнөд Азийн Бүс Нутагт Эрүүл Орчинд Амьдрах Эрхийг Нийтийн Ашиг Сонирхлын Маргаанаар Дамжуулан Хамгаалах нь, 2004 он.

³¹ Монгол Улсын Их Цааз (төсөл), 1991 оны 05-р сарын 25-ны өдөр, Ардын эрх сонин.



Энэхүү сонинд нийтлэгдсэн хувь нь 4-р сарын үг хэллэг, агуулгыг бүхэлд нь хадгалсан гэж үзэж болно.

Гурав. 1991 оны 10-р сар:³² Үндсэн хуулийн төслийг Улсын Бага Хуралд танилцуулсан. Энэ мөчөөс эхлэн хэд хэдэн өөрчлөлт гарсан. Хамгийн чухал өөрчлөлт нь уг эрхийг бие даасан зүйл байдлаар зохицуулсан. Мөн хэллэг өөрчлөгдсөн. Тус хувилбарт заахдаа “эрүүл, аюулгүй орчинд амьдарч, аж төрөх, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалагдах эрхтэй” буюу одоогийн үндсэн хуульд тусгалаа олсонтой төстэйгээр зохицуулсан.

Дөрөв. 1991 оны 11-р сар:³³ Ардын Их Хуралд өргөн барьсан хувилбарт “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэсэн хэллэгээр танилцуулагдсан. Энэ хэллэг, бүтэц нь ямар нэг өөрчлөлт, маргаангүйгээр үндсэндээ батлагдсан.

Эдгээр өөрчлөлтөөс хэд хэдэн үзэл санаа харагдаж байгааг анхаарах нь зүйтэй. Нэгт, эрүүл орчинд амьдрах эрхийг амьд явах эрхтэй холбож харж байсан. Хоёрт, зөвхөн эрүүл, саруул орчинд аж төрөх гэдгээс “бохирдолгүй, байгалийн тэнцэл алдагдаагүй орчинд амьдрах” болон өөрчлөгдсөн. Гурав, энэ эрхийг хүлээж авах үйл явцыг иргэний байгаль орчныг хамгаалах үүргийн зохицуулалтын өөрчлөлттэй холбон харвал байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг ашиглах харилцаа “эрхэд суурилж” зохицуулах хандлагыг үндсэн хуулиар хүлээн авсан зэргийг харж болно.

³² Монгол Улсын Их Цааз (төсөл), 1991 оны 10-р сарын 05-ны өдөр, Улсын Бага Хуралд өргөн барьсан хуулбар.

³³ Монгол Улсын Их Цааз (төсөл), 1991 оны 11-р сарын 07-ны өдөр, Ардын Их Хуралд өргөн барьсан хуулбар.

Байгалийн баялгийг ашиглах, иргэний эрүүл орчинд амьдрах эрх хэрхэн холбогдох, үүнд процессын эрх буюу мэдээлэл авах эрх хэрхэн үйлчилж байгаа асуудлыг 4-р бүлэг асуудлаар авч үзнэ. Харин доорх хэсэгт эрүүл орчинд амьдрах эрх нь салбарын хуульд хэрхэн буусан, ялангуяа нэхэмжлэх боломжоор хэрхэн хангагдсан байдлыг салбарын хуулийн хүрээнд авч үзнэ. Улмаар энэ нь төрийн үүрэг бүдгэрэхэд хэрхэн нөлөөлсөн талаар товч дүгнэлт өгнө.

3.2. Салбарын хуулиуд ба эрүүл орчинд амьдрах эрх

Эрүүл, орчинд амьдрах эрхийг Үндсэн хуулиар тодорхойлох нь чухал үйлдэл боловч энэхүү эрхийг салбарын хуулиудаар хамгаалах, энэ эрхийг ашиглаж хэрэг маргаан үүсгэх боломжийг нээлттэй болгох бол хамгийн чухал зохицуулалт юм. Өөрөөр хэлбэл Үндсэн хуулиар уг эрхийг тогтоож, хамгаалж өгсөн боловч салбарын хууль, дүрэм, стандарт, шийдвэрээр уг эрхийн агуулга, хүрээг хязгаарлах нь элбэг байдаг. Зарим тохиолдолд Үндсэн хуульд ч энэ мэт хязгаарлалтыг хийсэн харагддаг. Жишээ нь Үндсэн хуулийн “хуулиар тогтооно” эсхүл шууд нэрлэсэн байдлаар буюу Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-т “хязгаарлаж үл болох эрх эрх чөлөө” зэрэг нь энэ хязгаарласан зохицуулалтын нэг хэлбэр юм.

1992 оноос хойш байгаль орчныг хамгаалахтай холбоотой маш олон хуулиуд батлагдсан. Салбарын 20 гаруй хууль, 100 гаруй хэм хэмжээний акт, хэдэн зуун стандарт бий. Гэхдээ эдгээр хуулиудыг ашиглаад иргэн эрүүл орчинд амьдрах эрхээ хамгаалах боломжийг маш удаашралтай, агуулгын хувьд хумигдмал байдлаар хийж өгсөн. Жишээ нь Байгаль орчныг хамгаалах



ерөнхий хуулийн 4, 17, 32 дугаар зүйлүүдээр иргэний хохирол нэхэмжлэх эрх зүйн зохицуулалтуудыг хуульчилсан байдаг. Гэхдээ бусдын байгаль орчинд учруулсан хохирол нь иргэнийн эрүүл мэнд, өмч хөрөнгөд хохирол учруулсан бол нэхэмжлэх эрх зүйн зохицуулалт нь 1995 онд, харин байгаль орчинд учирсан хохирлыг иргэн, төрийн бус байгууллага, байгалийн нөөцийг хамгаалах захиргааны байгууллага нэхэмжлэх эрх зүйн зохицуулалт 2010, 2012 онуудад туссан.³⁴

Байгаль орчинд учирсан хохирлыг нэхэмжилдэг зохицуулалт нь байгаль хамгаалах бусад хуулиудаар 2012 оноос эхлэн тусгалаа олсон. Жишээ нь Усны тухай хуулийн 13, 17-р зүйлээр, Ойн тухай хуулийн 25-р зүйлээр сум дүүргийн засаг дарга, сав газрын зөвлөл, иргэн, төрийн бус байгууллага хохирол нэхэмжлэх боломжтой болсон.³⁵ Энэ нь эрүүл орчинд амьдрах эрхийг хамгаалах үндсэн хуулийн зохицуулалтын баталгаа мөн боловч маш удаашралтай явсны зэрэгцээ зөвхөн хохирол нэхэмжлэх хүрээгээр хязгаарлагдсан. Өөрөөр хэлбэл байгаль орчин хохирсон, хохирлыг тодорхойлсон, зарим тохиолдолд хохирол нь тодорхой үр дагавар гаргасан байхыг шаардаж, хамгаалж байгаа нь эрүүл, орчинд амьдрах эрхийн агуулгыг хязгаарласан үйлдэл юм.

Үндсэн хууль батлагдсанаас хойш буюу иргэний эрүүл орчинд амьдрах эрхийг хамгаалснаас хойш 24 жилийн дараа Захиргааны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх хуулиар зөрчигдөж болзошгүй эрхийг хамгаалах зохицуулалт орж ирсэн.³⁶ Түүнчлэн энэ хүрээнд

³⁴ Байгаль орчныг хамгаалах тухай Монгол Улсын хууль, нэмэлт/ өөрчлөлт, 2010 – 2012 он.

³⁵ Усны тухай, Ойн тухай Монгол Улсын хуулиуд, нэмэлт/ өөрчлөлт, 2012 он.

³⁶ Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх

байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд нийтийн эрх ашгийг хамгаалж шүүхэд нэхэмжлэл гаргах эрх нээгдсэн.³⁷ Гэхдээ зөрчигдөж болзошгүй эрхийг хамгаалах, нийтийн эрх ашгийг байгаль орчны асуудлын хүрээнд хамгаалах эрх зүйн зохицуулалтын амин сүнс нь байгаль орчныг хамгаалах процессын эрх байдаг. Ямар шинжлэх ухааны мэдээлэл-дата-статистик-судалгааг үндэслэлтэй гэж үзэх, хэрхэн ил болгох, бодитой оролцоог хангах, эцэст нэхэмжлэх эрх зэрэг цогц процессын эрхийн тогтолцоо хамаарна. Процессын эрхийг хангах, хамгаалах замаар материаллаг зохицуулалтыг зөв хамгаалах эрх зүйн үндэс бүрддэг. Гэтэл салбарын байгаль орчныг хамгаалах салбарын хуулиуд төр, түүний институт байгалийн баялгийг тусгай зөвшөөрлийн тогтолцоонд үндэслэн хэрхэн зохистой, шударга ашиглах вэ гэдэгт анхаарснаас уг шийдвэрийн үр дүнд иргэний амьдрах орчинд хэрхэн нөлөөлөх, энэхүү нөлөөллийг зөв тодорхойлохын тулд ямар процесс эрхүүдийг тусгаж өгөх тал дээр сул анхаарсан байдаг. Шууд хэлбэл тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрхийг хамгаалах буюу өмчийн эрхийг хамгаалах, өмчийн эрхийг бусад эрх, ашиг сонирхлоос дээгүүр авч үзэх эрх зүйн хамгаалалтыг салбарын хуулиар тогтоосон болохоос бусад эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хэрхэн хангахад

тухай хууль, 2016 он, 1-р зүйл “Энэ хуулийн зорилт нь хүн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд заасан бол захиргааны байгууллагаас гаргасан нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино,” харах: <https://legalinfo.mn/mn/detail/11703>.

³⁷ Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2016 он, 18-р зүйлийн 18.3.



огт анхаараагүй гэж дүгнэж болно.

Эцэст нь дүгнэж хэлэхэд байгалийг хамгаалах болон эрүүл орчинд амьдрах эрхийн хамаарлыг Үндсэн хуульд тусгахдаа эрүүл орчинд амьдрах эрхийг суурь болгохоор зохицуулсан. Энэ нь төр иргэнийхээ өмнө үүрэг хүлээх буюу иргэний эрүүл орчинд амьдрах эрхийг хамгаалах зарчмаар илрэх ёстой. Харин энэ үүрэг суларсан нь иргэд өөрсдөө эрхээ хамгаалах, иргэд эрхээ хамгаалах боломжийг хуулиар нээх төдийхнөөр илэрч, төрийн зүгээс байгалийн баялгийг ашиглах, тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хамгаалахад л хуулийн, бодлогын агуулга чиглэсэн. Ийм хандлагаар хууль, түүний үзэл санаа, зохицуулалт бичигдсэн учраас иргэний эрүүл орчинд амьдрах эрх, үүнийг хангах процессын эрхүүд хөгждөггүй, зөв үнэлэгддэггүй, шүүх тэнцлийн зарчимд тулгуурлаж хэрэг маргааныг хардаггүй юм.

4. Үндсэн хууль ба байгалийн баялаг

Байгалийн баялгийг ашиглах, байгаль орчныг хамгаалах суурь харилцаа Монгол Улсын Үндсэн хуулиудад тодорхой зохицуулагдсан. Энэ харилцаанд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх болон байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг мэдэх эрхийг оруулж өгснөөр асуудлыг бодитоор, цогцоор харах шаардлагыг илүү тодорхой бүрдүүлж өгсөн. Тиймээс энэ хэсгээр байгалийн баялгийг ашиглах харилцаа болон 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн холбоо, хамаарлыг тодруулах замаар төрийн үүрэг оролцоог тодорхойлоход зорино.

1924 оны Үндсэн хууль нь бүх талаараа 1918 оны Зөвлөлт Холбоот Орос Улсын Үндсэн хуулийн хуулбар мэт боловч байгалийн баялгийг ашиглах, хамгаалах харилцаанд зарчмын ялгаатай. 1924 оны Үндсэн хуульд зааснаар “БНМАУ-н

хязгаарын дотор бүхий газар ба уурхай хийгээд ой мод, ... эрт цагаас нааш ард нийтийн хөрөнгө байсаар ирсэн *зан суртаал* нь чухам одоогийн ард улсын ёсонд нийлэлцэх тул энэхүү хөрөнгө бүрнээ ардын мэдэлд байвал зохино”³⁸ гэж тунхагласан байдаг. Энэ өгүүлбэр нь нэг талаар, иргэдийн байгаль түүний баялгийг ашиглах эрхийг хүлээж авсан, нөгөө талаараа, төр байгалийн баялгийн эцсийн өмчлөгч байх зарчмыг тогтоож өгсөн. Тухайлбал энэ өгүүлбэрийн суурь үзэл санаа нь иргэн нь байгалийн баялгийн ашиглагч болохын хувьд түүний хамгаалах, төр нь байгалийн баялгийн өмчлөгч болохын хувьд мөн хамгаалах болон төр нь байгалийн баялгийг ашиглагчид байгаль хамгаалах үүрэг ногдуулах гэдэг гурван бүтэц агуулгаар тайлбарлагдана. Дээрх үзэл санаа бол Монголын байгаль хамгаалах, байгалийн баялгийг ашиглах харилцаанд эртнээс нааш мөрдөж байсан суурь зарчим гэж харагдаж байна.

Харин энэ зарчим нь 1940 болон 1960 оны Үндсэн хуулиудаар өөрчлөгдсөн.³⁹ Өөрчлөлт нь иргэд байгалийн баялаг ашиглагчийн хувьд байгаль орчныг хамгаалах харилцаанд оролцогч биш харин байгалийн баялаг нь улсын өмч болохын хувьд байгалийн баялаг ашиглах, хамгаалах үүрэг хүлээдэг гэдэг агуулгаар хувирсан. Өөрөөр хэлбэл байгалийн баялаг, түүнийг ашиглах харилцааг төр зохицуулах бөгөөд иргэн хүн нь уг баялгийг хамгаалах үүргийг хүлээхээр зохицуулагдсан гэж үзэж болно.



Байгалийн баялаг ард түмний мэдэлд байх, төр өмчлөгч байх, байгаль хамгаалал нь төрийн үүрэг байх болон байгаль – хүн хоорондын харилцааг өмчийн агуулгаар социалист Үндсэн хуулиудад тодорхойлсон. Энэхүү ерөнхий зохицуулалт, агуулга нь 1992 оны Үндсэн хуульд хэвээр хадгалагдсан. Харин гол Үндсэн өөрчлөлт нь дээрх агуулга, ойлголттой зэрэгцээд эрүүл орчинд амьдрах эрх, хувийн өмч, тогтвортой хөгжил, орон нутгийн бие даасан байдал зэрэг шинэ ойлголтууд үндсэн хуульчлагдсан. Гэтэл энэхүү хоёр бүлэг ойлголтуудын хамаарал, харилцааг зөв тодорхойлохоос илүүтэйгээр төрийн үүрэг оролцоог байгаль хамгаалах харилцаанд бууруулах, бүдгэрүүлэх үндэслэл болгож харсан. Өөрөөр хэлбэл эрхэд суурилсан тогтолцоог төрийн байгаль хамгаалах үүргийг сулруулах үндэслэл болгосон. Энэ нь зөвхөн иргэн, ТББ болон бусад төрийн бус институтын үүргийг байгаль хамгаалах харилцаанд нэмэгдүүлэх өөрчлөлтөөр тодорхой ажиглагддаг. Мөн байгалийн баялгийг ашиглах харилцаанд эрүүл орчинд амьдрах эрхийн ойлголт, үзэл санаа хэрхэн буух, ямар өнцгөөр томъёологдохыг шууд гээгдүүлсэн.

2019 оны нэмэлт өөрчлөлт нь дээрх зайг нөхөж, илүү тодорхой болгох үүрэгтэй орж ирсэн гэж харагдаж байгаа.⁴⁰ Байгалийн баялгийг ашиглах харилцаа болон иргэний эрүүл орчинд амьдрах эрхийг зөв дэнслэх зүй ёсны шаардлагын үр дүнд энэхүү өөрчлөлт орж ирсэн. Нэмэлт, өөрчлөлтөд зааснаар (1) байгалийн баялгийг ашиглахдаа иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг баталгаажуулах, (2) байгалийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар иргэн мэдэх эрхтэй байхаар зохицуулсан. Энэ нь

хэдэн давуу талыг бий болгосон буюу төр, түүний институт, албан тушаалтанд хүлээлгэх үүргийг тодорхой ногдуулсан.

Нэгт, ялангуяа мэдэх эрхийг хангах буюу процессын эрхийг байгаль орчны салбарын хуулиудад тусгаж өгөх үүргийг ногдуулсан. Хоёрт, байгалийн баялгийг ашиглахдаа зайлшгүй иргэний эрүүл орчинд амьдрах эрхэд хэрхэн нөлөөлөх талаар харьцуулалт, дүн шинжилгээ хийхийг үүрэгжүүлсэн. Гуравт, ийнхүү харьцуулалт, дүн шинжилгээ хийхдээ ирээдүйн иргэдийн эрүүл орчинд амьдрах эрхийг анхаарахыг тогтоосон. Дөрөвт, байгалийн баялгийг ашиглах харилцаанд зайлшгүй иргэний эрүүл орчинд амьдрах эрх болон хөгжих боломжийг дэнслэх, үүний хамаарлыг зөв харж төрийн захиргааны институт шийдвэр гаргах төдийгүй энэ төрлийн маргааныг шийдэх шүүх байгууллагын шийдвэр нь дээрх тэнцэлд үндэслэсэн байх зэрэг юм.

Эцэст нь Үндсэн хуулийн 6 дугаар зүйл буюу байгалийн баялгийг ашиглах харилцааг иргэний эрүүл орчинд амьдрах эрхтэй холбож өгсөн үндсэн шалтгааныг харахдаа төр, түүний институт илүү үүрэг хүлээлгэсэн, энэ харилцаанд зөв тэнцлийг удирдлага болгохыг шаардсан, үүний тулд процессын эрхийг салбарын хуулиудад суулгахыг тогтоосон, энэ төрлийн маргаанд шүүх тэнцлийн зарчимд тулгуурлахыг үүрэгжүүлсэн гэж дүгнэж болно.

Дүгнэлт: Цэц

Үндсэн хуулийн Цэцээс эрүүл орчинд амьдрах иргэний эрх зөрчигдсөн эсэх асуудлаар хоёр хэрэг шийдсэн байдаг. Эхний хэрэг нь зарим нэг хилийн боомтын статусыг өөрчилж, “химийн аюултай болон хортой бодис” нэвтрүүлэх эрх хэмжээтэй болгосон Засгийн Газрын тогтоол нь иргэний эрүүл орчинд амьдрах



эрхийг зөрчсөн эсэх маргаан.⁴¹ Нөгөө нь эрүүл мэндийн тухай хуулиар мэргэжлийн эмч биш, эмчлэх тусгай зөвшөөрөлгүй дадлагажигч эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхээр зохицуулсан нь мөн эрхийг зөрчсөн эсэх юм.⁴² Үүнээс гадна хэрэг үүсгэхээс татгалзсан олон тогтоол бий.

Байгалийн баялгийг ашиглах харилцаатай холбоотойгоор Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 болон 6.2 -ийг хэрэглэж шийдсэн хэрэг цөөнгүй. Эдгээр хэргийн гол агуулга нь өмчийн эрхийн асуудал, ард түмний мэдэлд байх зарчим, төрийн бүрэн эрх - төлөөлөл болон татвартай холбогдсон маргаанууд байдаг.⁴³ Харин байгаль хамгаалах төрийн үүргийг хэрэглэж шийдсэн хэрэг маргаан нэгээр тоологдох нь “зарим боомтыг химийн аюултай болон хортой бодис нэвтрүүлэхээр тогтоосон” Засгийн Газрын тогтоолтой холбоотой маргаан

юм.

Үндсэн хуулийн цэц нь дээрх хэрэгт байгалийн баялгийг ашиглах, байгаль хамгаалал, болон иргэний эрүүл орчинд амьдрах эрхийг хамгаалах ойлголтуудыг цогц байдлаар үнэлж, дүгнэж, шийдэж чадаагүй. Гол асуудал нь Үндсэн хуулийн цэцээс энэхүү харилцаанд төрийн бүрэн эрхийг буруу томъёолж, төрийн үүрэг оролцоог орхигдуулж, бүдгэрүүлж хэрэг, маргааныг шийдэж байгаатай шууд холбоотой. Өөрөөр хэлбэл, төр нь байгалийн баялгийн өмчлөгч болох, төр /УИХ/ нь хууль тогтоогч болох, төр /ЗГ/ нь хүрээлэн байгаа орчныг хамгаалах бүрэн эрхтэй болох зэргийн хувьд иргэний эрүүл орчинд амьдрах эрхийг хангах, байгаль орчныг хамгаалах үүргийг өөртөө хүлээдэг. Гэтэл хэрэг үүсгэхээс татгалзсан тогтоолын агуулгаас харахад хууль батлах нь, тогтоол шийдвэр гаргах нь төрийн бүрэн эрхийн асуудал тул Үндсэн хууль зөрчөөгүй гэж үзэх эсхүл төрийн байгаль орчныг хамгаалах үүргээ хангалттай биелүүлсэн эсэхийг дүгнэхээс зайлсхийж, татгалздаг. Тодорхой жишээ нь Засгийн газрын 2007 оны 65 дугаар тогтоол иргэний эрүүл орчинд амьдрах эрхийг зөрчсөн эсэх маргаанд Монгол Улсын Их Хуралаас “хуулиар” хилийн боомтын статусыг тогтоох эрх хэмжээг Засгийн газарт олгосон, энэхүү бүрэн эрхийнхээ хүрээнд Засгийн газар шийдвэр гаргасан учраас Үндсэн хууль зөрчсөн гэж үзэх үндэслэл байхгүй гэдэг маргааныг Цэц дэмжсэн байдаг.⁴⁴ Түүнчлэн Засгийн газрын 65-р тогтоол болон иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хөндсөн эсэх асуудал нь хоорондоо шалтгаант холбоогүй буюу Засгийн Газар тогтоол баталсан үйлдэл

⁴¹ Монгол Улсын Засгийн Газрын 2007 оны 65 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргаан, 2008 оны 02 дугаар сарын 20-ны өдөр, дугаар 02, харах: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1030>.

⁴² Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1, 17.6 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох хэсгийг зөрчсөн эсэх, 2009 оны 04-р сарын 15-ны өдөр, дугаар 03, харах: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1146>.

⁴³ Ашигт малтмалын тухай хууль, Иргэний хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргаан, 2009 оны 11-р сарын 25-ны өдөр, дугаар 07 дүгнэлт; Цөмийн энергийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох хэсгийн зөрчсөн эсэх маргаан, 2009 оны 11-р сарын 13-ны өдрийн, дугаар 05 дүгнэлт; Ашигт малтмалын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох хэсгийг зөрчсөн эсэх маргаан, 2004 оны 06-р сарын 08-ны өдөр, дугаар 03; Монгол Улсын Их Хурлын 2014 оны 54 дүгээр тогтоол Үндсэн хуулийн холбогдох хэсгийг зөрчсөн эсэх маргаан, 2015 оны 05-р сарын 20-ны өдөр, дугаар 07; Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн холбогдох хэсэг Үндсэн хуулийн холбогдох хэсгийг зөрчсөн эсэх маргаан, 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдөр, дугаар 03; Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны 299 дүгээр тогтоолын 3-р заалт Үндсэн хуулийн холбогдох хэсгийг зөрчсөн эсэх, 2011 оны 12-р сарын 27 өдөр, дугаар 05, гэх мэт 12 хэрэг байдаг.

⁴⁴ Засгийн Газрын 2007 оны 65-р тогтоол Үндсэн хуулийн холбогдох хэсгийг зөрчсөн эсэх маргаан, харах: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1030>.



нь иргэний эрүүл орчинд амьдрах эрхийг зөрчих үндэслэл болохгүй гэж үзсэн. Үүний зэрэгцээ төрийн бусад байгууллага /Гаалийн Ерөнхий Газар, Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар, Цагдаагийн Ерөнхий Газар/ буюу төрийн өөрийнх нь харьяа институт, байгууллагын дүгнэлт, саналыг үндэслээд эрүүл, орчинд амьдрах эрх зөрчигдөх үндэслэлгүй бүрдээгүй байна гэж тогтоосон. Хамгийн сонирхолтой нь уг шийдвэрийг гаргахдаа иргэний эрүүл орчинд амьдрах эрхэд ЗГ-ын шийдвэр нь хэрхэн нөлөөлөх, төрийн байгаль орчныг хамгаалах үүрэгт ямар асуудал үүсэх зэргийг урьдчилан дүгнэж, үнэлээгүй нь тодорхой харагддаг. Өөрөөр хэлбэл шийдвэр гаргахдаа иргэдийн эрх, байгаль орчинд хэрхэн нөлөөлөх талаар ямар ч урьдчилсан төсөөлөл, төлөвлөгөө Засгийн газрын зүгээс боловсруулалгүй, харин эсрэгээрээ зөвхөн маргаанд зориулж хэд хэдэн байгууллагынхаа дүгнэлт, тайлбарыг хүргүүлсэн байдаг. Гэтэл Цэц эдгээр тайлбар, дүгнэлтийг хүлээж аваад маргааныг шийдсэн байх жишээтэй.

Байгалийн баялгийг ашиглах, байгаль хамгаалах, иргэдийн эрүүл орчинд амьдрах эрхийг хангах харилцаанд Үндсэн хуулийн Цэц дээрх хандлагыг баримталж байгаа нь илт ажиглагддаг. Өөрөөр хэлбэл, төр баялгийн өмчлөгч болохын хувьд өмчийн зүйлийг хэрхэн зохицуулах нь төрийн бүрэн эрх. Хэрэв төр өмчийн эрхийг хууль ёсоор шилжүүлсэн нь өмчлөгчийн эрхийг нөхцөлгүй хамгаалах үндэс болно. Эцэст нь байгаль хамгаалал, иргэний эрүүл орчинд амьдрах эрхийг хангах харилцаа бол иргэний, байгууллагын идэвхтэй үйлдэл дээр оршино гэж үзэх зэрэг юм. Гэтэл өмчлөх эрх бол абсолют эрх биш. Үүнийг ч Үндсэн хуульд “хуулиар” зохицуулна, “хуулиар” хязгаарлана, “хуульд” заасан

үндэслэлээр эргүүлэн авна, “хуулиар” нөхцөл тогтоож болно гэсэн олон зохицуулалтаар тодорхой тогтоосон. Төр нь байгалийн баялгийн өмчлөгч болохын хувьд байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, хүрээлэн буй орчныг хамгаалах, нөхөн сэргээх үүрэг хүлээдэг. Энэ үүрэг бол байгаль хамгаалал, иргэний эрүүл орчинд амьдрах эрхийг зөв үнэлж, харьцуулахтай шууд холбогдоно. Харин энэ төрлийн үүрэг байнга гээгдэж, бүдгэрч байдаг ба шүүх, цэцийн зүгээс шаарддаггүй нь шийдвэрийн агуулгаас нь тодорхой харагддаг.

Байгаль хамгаалал, байгалийн баялгийг ашиглах, эрүүл орчинд амьдрах эрхийн хамаарлыг цогцоор нь харах зайлшгүй шаардлагатай. Цогцоор нь харахыг Үндсэн хуулиар үүрэг болгосон. Энэ хүрээнд өөр олон асуудлыг хөндөж болох ч дараах үндсэн 5 дүгнэлтийг шүүх, ялангуяа Цэц өөрийн шийдвэртээ анхаарч үзвэл энэ харилцааг зохицуулахад эерэг үр дүн гаргана гэж итгэж байна:

Нэгт. Байгаль хамгаалал, баялгийг зүй зохистой ашиглах, эрүүл-аюулгүй орчинд амьдрах эрхийг хамгаалах бол төрийн үүрэг. Иргэн өмчлөгчийн хувьд эсхүл тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эсхүл эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн хүрээнд эрхээ хамгаалуулахаар шүүхэд хандах нөхцөл, бололцоог хангах нь төрийн үүрэг мөн. Гэхдээ төрийн байгаль орчныг хамгаалах үүрэг нь иргэдийн эрхийн мэдрэмжээр бүдгэрч, гээгдэж болохгүй. Тиймээс төр ямар үүргээ гүйцэтгээгүйгээс эсхүл хангалттай гүйцэтгээгүйгээс байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа, иргэний эрүүл орчинд амьдрах эрх хөндөгдөж байгаа зэргийг анхаарч хэрэг, маргааныг шийдэх нь Үндсэн хуулиар тогтоосон үүрэг мөн.

Хоёрт. Байгаль хамгаалал, баялаг



ашиглах, эрүүл орчинд амьдрах эрхийн ойлголтын хамаарал нь аливаа сөрөг нөлөөлөл, эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ойлголттой шууд холбогддог. Төр, түүний институт аливаа шийдвэр гаргахдаа үүсэх нөлөөлөл, эрхийн зөрчил, байгаль орчны бохирдол зэргийг урьдчилан, боломжит хэмжээнд харсан, төлөвлөсөн байх үүргийг Үндсэн хуулиар хүлээлгэсэн. Тийм учраас Цэц нь төрийн хууль батлах, шийдвэр гаргах ажиллагаа хангалттай үндэслэл, судалгаанд үндэслэсэн эсэхийг хянах нь зүй ёсны зарчим юм.

Гуравт. Байгаль хамгаалал, ашиглах, эрүүл орчинд амьдрах эрхийн хамаарал нь төрийн эс үйлдэл гаргахыг хориглодог. Эс үйлдлийг тогтоохдоо утга учиргүй, зорилгогүй, дүр үзүүлсэн, рационал биш /Шинжлэх ухаан, технологи, судалгаанд суурилаггүй г.м/ үйлдлийн хүрээнд тогтоож, төрийн байгаль хамгаалах, иргэний эрүүл орчинд амьдрах эрхийг хангах үүргийг идэвхжүүлэхийг Үндсэн хуулийн суурь зарчим гэж харах нь зүйтэй.

Дөрөвт. Байгалийн баялгийг ашиглах, байгаль хамгаалах бодлого нь иргэний эрүүл орчинд амьдрах үндсэн эрх, мэдээлэл авах процессын эрхтэй Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр шууд холбогдсон. Иймд байгаль орчны салбарын хуулиудад мэдэх эрхийг суулгах зайлшгүй шаардлагатай. Гэхдээ энэ эрхийн хүрээнд шүүх, Цэцээс энэ төрлийн хэрэг маргааныг шийдэхдээ иргэдийн мэдэх эрхийг хангасан буюу зөв

мэдээлэл – дата - судалгаагаар хангасан эсэх, бодит оролцоог бүрдүүлсэн эсэх, түүнчлэн хөндөгдсөн эрхээ хамгаалуулах боломж байгаа эсэхийг шалгахыг Үндсэн хуулиар тогтоосон.

Тавд. Байгалийн баялгийг ашигласан ч, байгаль хамгаалах бодлого хэрэгжүүлсэн ч, иргэний эрүүл орчинд амьдрах эрхийг хамгаалсан ч бүгд Монгол Улс, иргэнд хамгийн боломжит эерэг нөлөөллийг үзүүлэхүйц байхыг Үндсэн хуулиар үүрэг болгосон гэж харах нь зүйтэй. Тиймээс байгаль хамгаалал, баялгийг ашиглах, эрүүл орчинд амьдрах эрхийг хангах асуудалд үүсэж байгаа маргаан “тэнцлийн анализ”-ийг байнга хийж, шийдэж байх бол үндсэн хуулиар тогтоосон нэг үүрэг мөн.

Эцэст нь хэлэхэд сүүлийн 30 гаруй жил байгаль хамгаалал, байгалийн баялгийг ашиглах, иргэний эрүүл орчинд амьдрах эрхийг хамгаалах харилцаанд төрийн үүрэг оролцоог байнга хумьж, гээгдүүлж, эсхүл санаатайгаар төр, түүний институт үүрэг оролцоогоо бүдгэрүүлж ирсэн. Энэ нь эдийн засгийн, улс төрийн нөхцөл байдалтай шууд холбоотой буюу хөрөнгө оруулагчийг татах, тогтвортой, таатай хууль зүйн орчин бүрдүүлэх зэрэг ойлголттой холбоотой. Гэхдээ энэ нь Үндсэн хуульд ёс, Үндсэн хуулийн үзэл санааг бүдгэрүүлэх, гээгдүүлэх хангалттай үндэслэл биш гэдгийг анхаарч “Төр”-ийг байгаль хамгаалах харилцааны төвд тавьж, хэрэг маргааныг шийдэх нь зүйн.



Abstract

CONSTITUTION, ENVIRONMENTAL PROTECTION, NATURAL RESOURCES, RIGHT TO LIVE IN HEALTHY ENVIRONMENT AND THE CONSTITUTIONAL COURT OF MONGOLIA

D.BAYAR

Ph.D Candidate

Max Planck Fellow Group Environmental Rights in Cultural Context

The constitutional court of Mongolia, Tsets, has decided on two cases invoking the right to a healthy environment. One is whether the government of Mongolia's decision to change the status of border points that permit importing chemical and hazardous substances into Mongolia violates the constitutionally protected rights to a healthy environment. The other is whether a trainee with no medical license could provide medical services under the health law of Mongolia violates environmental rights. Tsets has also rejected to review many other cases invoking environmental rights. It appears that socio-economic, political, and cultural factors have reshaped the meaning of environmental rights in Mongolia. Nevertheless, the Constitution of Mongolia commands that the State is responsible for protecting the environment,

ensuring environmental rights, and undertaking measures for sustainable use of natural resources. Moreover, environmental rights are the fundamental sustenance of environmental protection. However, in countries where extractive activities are extensively dominant in socio-economic and political spaces, the States are mostly silent on environmental protection. Tsets has failed to recognize the State's responsibility for environmental protection in its decisions. This article aims to bring back Tsets' attention to the State's responsibility for environmental protection.

Keywords: Environmental rights, constitutional environmental protection provisions, proportionality, State responsibility.



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМЫН ТЭРГҮҮН Ч.ТУНГАЛАГ

Япон Улсын Нагоягийн Их сургуулийн Хууль зүйн сургуулийн докторант С.Сүхчулуун "Байгаль орчин болон соёлын өвийг хамгаалах асуудлаар нэхэмжлэл гаргах эрхийг төрийн бус байгууллагад олгохтой холбоотой Япон улсын өнөөгийн чиг хандлага" сэдэвт илтгэлийнхээ хүрээнд тус улсын Өмгөөлөгчдийн холбооноос 2012 онд боловсруулсан байгаль орчин, соёлын өвийг хамгаалах чиглэлээр төрийн бус байгууллагын нэхэмжлэл гаргах эрхийн талаарх хуулийн төсөлд туссан зарим онцлог зохицуулалтыг судлан, энэ чиглэлээрх Монгол Улсын эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгоход хувь нэмэр болох санаа авууштай асуудлаар өөрийн байр суурийг илэрхийлэн тодорхой санал дэвшүүлжээ.

1995 онд батлагдсан Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2010 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар байгаль орчин, түүний баялгийг хамгаалах дүрмийн зорилго бүхий олон нийтийн байгууллагад байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн зөрчилтэй тэмцэх болон байгаль орчинд хортой нөлөөлсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг шаардах, байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй болсон

боловч тухайн үед мөрдөж байсан Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай 2002 оны хуульд нийтийн эрх ашгийг төлөөлөн аливаа төрийн бус байгууллага захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхгүй байснаас хуулийн дээрх заалтын дагуу байгаль орчныг хамгаалах дүрмийн зорилго бүхий төрийн бус байгууллага нь байгаль орчныг хамгаалах асуудлаар захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах боломжгүй байсан.

Иргэний хувьд, байгаль орчныг хамгаалах асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах, байгалийн нөөц, баялгийн халдашгүй байдлыг хангах, байгаль орчинд хортой нөлөөлөх аливаа үйл ажиллагааг хязгаарлах, таслан зогсоох шийдвэр гаргахыг болон байгаль орчинд хортой нөлөөлж болзошгүй аж ахуйн нэгж, байгууллагыг шинээр байгуулах зөвшөөрөл олгохгүй байхыг холбогдох эрх бүхий байгууллагаас шаардах зэрэг эрхүүд Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай 2010, 2012 оны хуулиудаар зохицуулагдсан боловч захиргааны хэргийн шүүх иргэний субъектив эрхийг хамгаалахад чиглэгдэж байсан, нөгөө талаар байгаль орчны асуудлаар хөндөгдөж болох ашиг сонирхлыг тэр бүр хувь хүнд хамааруулж авч үзэх нь эргэлзээтэй байдаг.



Энэ тохиолдолд, захиргааны хэргийн шүүх ямар шийдвэр гаргах магадлалтай вэ гэхээр, таны байгаль орчныг хамгаалах чиглэлээр гаргаж байгаа нэхэмжлэлийг хангах боломжгүй гэж шийднэ, учир нь субъектив эрхэд халдсан байхыг шаарддаг учраас.

Япон улс, байгаль орчин болон соёлын өвийг хамгаалах асуудлаар нэхэмжлэл гаргах эрхийг төрийн бус байгууллагад олгохоор тусгайлсан хуулийн төслийг боловсруулсан байгаа бол манай улсын хувьд Улсын Их Хурал 2016 онд баталсан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээдээс захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг хуульчлан процессийн эрх олгосноороо эрх зүйн хөгжлийн энэ чиглэлд түрүүлээд алхсан гэж хэлж болохоор.

Судлаачийн зүгээс Япон улсын хуулийн төслийг, Монгол Улсын Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хүрээлэн байгаа байгаль орчны асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээдээс нэхэмжлэл гаргах эрх, түүнд хуулиар тавигдсан шаардлага, олгогдсон процессийн эрх хэмжээг харьцуулан судалж, цаашид энэ чиглэлийн хууль тогтоомжийг боловсронгуй болгоход ач холбогдолтой бөгөөд анхаараасай гэсэн дараах 5 саналыг дэвшүүлжээ.

Захиргааны хэргийн шүүхэд байгаль орчны асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн төрийн бус байгууллага нэхэмжлэл гаргах нь иргэнээс өөрийн зерчигдсэн эрх, эсхүл зерчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг хязгаарлах шалтгаан

болохгүй бөгөөд материаллаг болон процессийн хуулиудаар, байгаль орчны асуудлаар иргэний захиргааны хэргийн шүүхэд иргэн нэхэмжлэл гаргах эрх хуульчлагдсан учраас судлаачийн дэвшүүлсэн "хуульчлах" санал дэмжигдэх боломжгүй юм.

Нөгөө талаар, судлаач маань энэхүү санааг дэвшүүлэхдээ, шүүх уг асуудлаар гаргасан хувь хүний нэхэмжлэлийг нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд гэж үзэн хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн шүүхийн статистик мэдээг судалж, үүн дээр үндэслэсэн болохыг судалгаагаар харуулаагүй байна, харин нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн тохиолдлоор "нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд гэж үзэх хандлага харагдсан" гэсэн дүгнэлт хийсэн байна.

Япон улсын хуулийн төсөлд тусгагдсанаар нэхэмжлэл гаргах төрийн бус байгууллагын эрх зүйн байдлыг шүүхээс өмнө эрх бүхий байгууллага урьдчилан шалгаж, шүүхэд нэхэмжлэл гаргах шаардлагыг хангасан болохыг нотолсон "батламж" авсан ТББ нэхэмжлэл гаргах бол Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-т заасан шаардлагыг хангасан төрийн бус байгууллага нэхэмжлэл гаргасан эсэхийг шүүх өөрөө тухайн хэрэг бүр дээр шалган тогтоодог байна.

Өөрөөр хэлбэл, нэхэмжлэлийн шаардлага нь тухайн байгууллагын дүрмийн зорилгод нийцсэн эсэх, дүрмийн зорилгын дагуу сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан эсэхийг тогтоох ажиллагааг шүүх, тухайн төрийн бус байгууллагын дүрэм, татварын байгууллагад гаргадаг татварын тайланг гол баримт болгон авч үзэж, нэхэмжлэл гаргах эрхтэй этгээд мөн болохыг тогтоож байна.



Хуулийн төслийн 20 дугаар зүйлтэй холбоотой буюу ТББ нэхэмжлэл гаргасныг нийтэд мэдээлэх ач холбогдлыг судлаачийн зүгээс нэхэмжлэлд нэгдэх бусад төрийн бус байгууллагыг, эсхүл гуравдагч этгээдээр оролцох сонирхолтой ТББ-ын шүүхэд хандах эрхийг нэг мөр хангуулах замаар нэг асуудлаар дахин дахин шүүхэд хандахаас сэргийлэх, шүүхийн шийдвэрийн хүчинтэй байдал зэрэгт нөлөөлөхүйц зэрэг байдлаар авч үзжээ.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-т зааснаар тухайн нэхэмжлэл гаргах эрхтэй этгээдэд тавигддаг нэг шалгуур нь тухайн ТББ-ын нэхэмжлэл нь уг байгууллагынхаа дүрмийн зорилгод нийцсэн байхыг шаарддаг.

Шүүхийн практикт гарсанчлан байгаль орчныг хамгаалах тодорхой зорилго, чиглэлтэй байгуулагдсан төрийн бус байгууллага, тухайлбал "Хөвсгөл далайн эзэд" гэх, эсхүл "Ноён уулаа аврах хөдөлгөөн" нэртэй төрийн бус байгууллагуудын нэхэмжлэлийн шаардлага нь уг байгууллагын дүрмийн зорилгын хүрээнд буюу энэ тохиолдолд тодорхой хязгаарлагдмал хүрээний дүрэмтэй эдгээр нэхэмжлэгч нарын нэхэмжлэлд Япон улсынх шиг нийтийн ашиг сонирхлын төлөө нэгдмэл сонирхолтой гэх байдлаар авч үзэн анх гаргаж буй нэхэмжлэлд "нэгтгүүлэх нь" Монгол Улсын ЗХШХШТХ-иар боломжгүй зүйл юм.

Гэхдээ уг саналыг цаашид, шүүхийн зардал, цаг хугацаа, ажлын ачаалал, нэг маргааны зүйлийг шүүх олон дахин шийдвэрлэдэггүй байх зэрэг шүүхийн үйл ажиллагаанд шууд хамааралтай байдлаар тухайн зохицуулалтын ач холбогдолтой нь уялдуулан судалж,

хууль тогтоомжийг улам боловсронгуй болгох ёстой.

Дараагийн асуудал нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 44 дүгээр зүйлд зааснаар "шүүхийн зардал"-д өмгөөллийн хөлс ордоггүй тул нэхэмжлэгч төрийн бус байгууллагын нэхэмжлэл хангагдсан тохиолдолд түүнээс өмгөөлөгчид төлсөн "өмгөөллийн хөлс"-ийг хариуцагчид шууд хариуцуулах боломжгүй юм. Нийтийн эрх ашгийн төлөө нэхэмжлэл гаргасан гэдэг утгаар төрийн бус байгууллага, өмгөөлөгчид төлсөн "хөлс"-ийг шүүхийн зардалд хамааруулан авч үздэг хуулийн орчин, улмаар нэхэмжлэл хангагдсан тохиолдолд хариуцагчаас гаргуулдаг тодорхой зохицуулалтыг хуульчлах шаардлага байж болохыг үгүйсгэхгүй.

Илтгэгчийн дэвшүүлсэн 5 дахь саналын хүрээнд авч үзэхэд, Япон улсын хуулийн төсөлд тусгагдсан ТББ эдийн засгийн ашиг сонирхлын үүднээс зүй бус нэхэмжлэл гаргасан бол хариуцлага тооцох зохицуулалт манай хуульд байдаггүй ч Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т "нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргасан этгээд нь хэрэгүүсгэснээс хойш нэхэмжлэлээсээ бүрэн болон хэсэгчлэн татгалзахыг хориглосон"-ноор, нэхэмжлэлийг нийтийн ашиг сонирхлын төлөө биш өөр зорилгоор /тухайлбал эдийн засгийн/ гаргах явдлаас сэргийлэх, улмаар уг зорилго нь шүүхэд нэхэмжлэл гаргах замаар хангагдсан гэж үзэж, шүүхэд гаргасан нэхэмжлэлээс татгалзах боломжийг шууд хязгаарлан хориглож, уг үр дагавраас хуулийн дээрх зүйл заалтаар сэргийлж байгаа юм.

ТББ-аас нийтийн эрх ашгийг хамгаалах бус өөр зорилгоор нэхэмжлэл



гаргахыг үгүйсгэхгүй, иймээс Япон улсын хуулийн төсөлд тусгасан уг зохицуулалтыг манай хуульд ч бас тусгах асуудлыг илтгэгч маань цаашид судлах байхаа.

Дараагийн судлаач С.Жансаяа "Байгаль орчныг хамгаалахтай холбоотой захиргааны хэргийн шүүхийн шийдвэрүүдэд зарим маргааны төрлөөр хийсэн дүн шинжилгээ" гэсэн илтгэлдээ тусгаснаар нэлээд өргөн хүрээнд гурван шатны шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолыг хамруулан судалгаа хийжээ.

Судалгаанаас нь үзвэл, энэхүү хурлын сэдэв болох байгаль орчныг хамгаалах чиглэлд холбогдож байгаа анхаарах асуудлын талаар гэхээсээ бүхэлд нь газрын маргаан, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн маргааныг хянан шийдвэрлэсэн 3 шатны шүүхийн шийдвэрийг авч үзсэн байх тул өнөөдрийн сэдвээс бага зэрэг хазайв уу гэсэн ийм дүгнэлттэй байна.

Ер нь газар эзэмших, ашиглах эрх, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмших эрхтэй холбогдуулаад уг эрх эзэмшигч нь үйл ажиллагаа явуулахдаа байгаль орчны асуудлаарх хууль тогтоомжийг биелүүлээгүй, зөрчсөний улмаас түүний газар эзэмших эрхийг хүчингүй болгосон, эсхүл тусгай зөвшөөрлийг цуцалсан зэрэг захиргааны акттай холбоотой маргааныг хэрхэн шийдвэрлэсэн байдлын судалгааг хийхдээ, өнөөдрийн эрдэм шинжилгээний хурлын зорилгод чиглүүлсэн бол ач холбогдолтой байлаа.

Хэд хэдэн санаа дэвшүүлэхдээ, мөн нэлээд хатуу тухайлбал, "захиргааны хэргийн 3 шатны шүүхийн шийдвэрээс үзэхэд шүүх ард түмний эрх ашгаас улсын эрх ашгийг дээгүүр тавьдаг" гэсэн нь газрын маргаан, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн маргааныг

хянан шийдвэрлэхдээ нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон тоонд үндэслэж уг дүгнэлтийг хийсэн гэж үзэхээр байна.

Иймээс судалгаандаа газрын маргаан, ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүдийг бүхэлд нь хамруулсан болохоор байгаль орчны асуудлаар нийтийн эрх ашгийг хамгаалан гаргасан ТББ-ын нэхэмжлэлийг шүүх хэрхэн шийдвэрлэсэн байдлын судалгааны дүн гэж шууд дүгнэх боломжгүй юм.

Судлаачийн сонгож авсан сэдвийн хүрээнд шүүхийн шийдвэрүүдийг судлахдаа, газар эзэмшигч нь эсхүл ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс хүчингүй болсон, цуцлагдсан захиргааны акттай маргасныг ялган үзэж, уг маргааныг шүүх хэрхэн шийдвэрлэсэн тоонд үндэслэн өгөх дүгнэлт өөр байх нь эргэлзээгүй.

Герман улсаас оролцож байгаа Нийгмийн андрологийн Макс Планк институтийн Хууль ба Андрологийн тэнхимийн докторант Д.Баяр "Үндсэн хууль, байгаль орчны хамгаалал, байгалийн баялаг, эрүүл орчинд амьдрах эрх ба Цэц" сэдвээр сонирхолтой илтгэл тавьлаа.

Үндсэн хуульд заасан иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх буюу иргэний үндсэн уг эрхийн баталгааг хэрхэн хангахтай холбоотой судалгаанд суурилсан тодорхой мэдээлэл өгч, зарим асуудал дэвшүүлж байна.

Үндсэн хууль дахь иргэний байгаль орчныг хамгаалах журамт үүрэг нь тодорхой хуулиудад тухайлбал, Байгаль



орчныг хамгаалах тухай хуулиар хэлбэржин зохицуулагдсан байдаг.

Уг хуулийн 4 дүгээр зүйлийн 2-т байгаль орчныг хамгаалах талаар иргэний хүлээсэн үүргүүдийг жагсаасан байна. Үүнээс заримыг дурдвал, иргэн байгаль орчныг хамгаалах үндэсний уламжлал, зан заншил эзэмшиж хэрэглэх, үр хүүхдэдээ экологийн хүмүүжил олгох; байгалийн баялгийг хууль бусаар ашигласан, гэмтээсэн, хөнөөж сүйтгэсэн үйлдлийг олж мэдсэн иргэн тэр тухайгаа тухайн орон нутгийн Засаг дарга, улсын

байцаагч, байгаль хамгаалагчид нэн даруй мэдэгдэх. Үүргийг хуульчилсан байна.

Гол усаа бохирдуулахгүй байх талаар, мод, ургамал түүний дагалдах баялгийг зөв зүйтэйгээр амьдрал ахуйдаа хэрэглэдэг зан заншлаа дагаж мөрдөхөө больсон, байгалиа арчлан хамгаалж ирсэн уламжлалаа умартах хүүхэд залуучууддаа зааж сургахаа больсон зэргээр бид өөрсдөө байгаль хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байна.



САХИЛГЫН ХОРОО БАЙГУУЛАГДСАНААР ШҮҮГЧИЙН САХИЛГА ЁС ЗҮЙН ЗӨРЧИЛ ХЯНАН ШАЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ХӨНДЛӨНГИЙН ХАРААТ БУС БИЕ ДААСАН ХЭЛБЭРТ ОРСОН

Д.МЯГМАРЦЭРЭН

Шүүхийн сахилгын хорооны дарга

Энэ удаагийн ярилцлагын зочноор Шүүхийн сахилгын хорооны дарга, хууль зүйн ухааны доктор, дэд профессор Д.Мягмарцэрэнг урьж, хийж хэрэгжүүлж буй ажил, хорооны үйл ажиллагааны талаар ярилцлаа.

- Шүүхийн сахилгын хороог байгуулж, шүүгч болон шүүгч бус гишүүдийг сонгон шалгаруулан үйл ажиллагааг нь эхлүүлснээс хойш 6 сарын хугацаа өнгөрч байна. Шүүхийн сахилгын хороо ямар үүрэгтэй байгууллага вэ гэдгээс ярилцлагаа эхлүүлбэ?

-2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр Шүүхийн сахилгын хороог бие даасан хараат бус үндсэн хуулийн байгууллага болгон шинэчлэн зохион байгуулахаар заасан. Энэ өөрчлөлтийн хүрээнд шүүхийн тухай хуулийг батлан мөрдүүлснээр манай улсын үндсэн хуулийн байгууллагын бүрэлдэхүүнд шүүх эрх мэдэл, түүний хараат бус байдалд хөндлөнгөөс нөлөөлөх, хэн нэгэнд давуу эрх олгохоос сэргийлэх, олон нийтийн оролцоог хангах, хяналтыг тогтоох зорилгоор Монгол Улсын Шүүхийн сахилгын хороо байгуулсан.

2021 оны гуравдугаар сарын 1- нээ Шүүхийн тухай хууль хүчин төгөлдөр болж, хэрэгжиж эхэлсэн. Энэ хуулийн

дагуу нийт шүүгчдийн анхдугаар чуулган 2021 оны аравдугаар сарын 11-нд зохион байгуулагдаж, тухайн өдрийн тогтоолоор Шүүхийн сахилгын хорооны шүүгч гишүүнээр дөрөв, УИХ-ын 2021 оны 11 сарын 18-ны нэгдсэн чуулганаар шүүгч бус таван гишүүнийг томилсон. Улмаар ШСХ-ны бүрэн эрх тухайн өдрөөс хэрэгжиж эхэлснээс хойш өдгөө зургаа дахь сардаа үйл ажиллагаа явуулж байна.

Шүүхийн тухай хуульд заасны дагуу нийт шүүгчдийн чуулганаар нэр дэвшсэн шүүгч нараас хяналтын шатны шүүхээс нэг, давж заалдах шатны шүүхээс хоёр, анхан шатны шүүхээс нэг нийт 4 шүүгчийг Шүүхийн сахилгын хорооны гишүүнээр сонгосон. Шүүгч бус гишүүнээр нэр дэвшигчдийг хуульд нийцүүлэн гаргасан журмын дагуу гурван үе шаттай сонгон шалгаруулалт, нээлттэй сонсгол хийж Хууль зүйн байнгын хороо, УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэж 5 шүүгч бус гишүүнийг сонгосон. Энэ өдрөөс Шүүхийн сахилгын хорооны 9 гишүүн бүрэлдсэн учир бүрэн эрх хэрэгжиж эхэлсэн юм.

Шүүхийн сахилгын хороо нь хамтын удирдлагын зарчимтай бөгөөд нийт гишүүдийн хурлаар ажлын албаны бүтэц, орон тоо, үйл ажиллагааны



дүрмээ 2022 оны нэгдүгээр сарын 26-ны баталж, Сахилгын хорооны чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна. Ажлын алба нь Захиргааны удирдлагын, Хууль зүйн, Мэдээлэл, дүн шинжилгээний хэлтэс гэсэн гурван нэгжтэй байхаар журамлан ажиллаж байгаа. Сахилгын хорооны даргыг гишүүд дотроосоо нууц санал хураалтаар сонгох эрх зүйн зохицуулалтай байдаг. Энэ утгаараа 2021 оны 11 сарын 29-ны хуралдаанаараа Шүүхийн сахилгын хорооны анхны даргаар миний бие сонгогдон ажиллаж байна.

Шүүхийн сахилгын хорооны үйл ажиллагааны үндсэн чиглэлийг Монгол Улсын Үндсэн хууль болон Шүүхийн тухай хуульд шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл оногдуулахаар хуульчилсан. Энэ дагуу сахилгын хороо нь иргэд албан тушаалтнаас өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авч, сахилгын хэрэг үүсгэж, зөрчил шалгах ажиллагаа хэрэгжүүлж хянан шийдвэрлэдэг.

- Монгол Улсад шүүгч нарын сахилга, ёс зүйтэй холбоотой үйл ажиллагаа явуулж байсан туршлага, түүхэн үйл явцыг танилцуулбал?

- Шүүхийн сахилга ёс зүйн зөрчлийг хянан шалгадаг алба нэгж Сахилгын хороо байгуулагдахаас өмнө Шүүгчийн ёс зүйн хороо нэрээр Шүүхийн Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байсан түүхтэй байдаг. Монгол Улсын шүүх 1954, 1970, 1989, 1997, 2003, 2010, 2014 онуудад тус тус Шүүгчийн ёс зүйн дүрмийг батлан мөрдүүлж байсан. Шүүхийн болон шүүгчийн эрх зүйн байдлыг зохицуулж байсан бүхий л хууль тогтоомжид ёс зүйн дүрмийн талаарх зохицуулалтыг

тусгаж ирсэн ба сахилгын хороо байгуулагдахаас өмнө энэхүү дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байсан.

- Шүүгч эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашигласан тохиолдолд тус хороо бүрэн эрхээс нь түдгэлзүүлэх асуудлыг шийдвэрлэж, хууль сахиулах байгууллага шалгах ёстой байх аа?

- Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн эсэх талаар шүүгчид эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татан шалгагдах тохиолдолд эрх бүхий байгууллагаас ирүүлсэн саналыг үндэслэн шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг сахилгын хорооны гишүүд зөвлөгөөнөөрөө шийдвэрлэдэг. Харин Шүүхийн тухай хуулийн 50, 51, 52, 53 дугаар зүйлд заасан нийт 45 тохиолдлыг зөрчвөл сахилгын зөрчилд тооцож, шүүгчид хариуцлага ногдуулахаар хуульчилсан.

- Танай байгууллага нийгэмд ямар ач холбогдол, үр нөлөөтэй гэж та үздэг бол?

- Монгол Улс эрх зүйт төр, ардчилсан нийгмийн байгууллыг цогцлон байгуулахаар 1990 оноос эргэлт буцалтгүй шилжин хөгжиж байна. Шүүх, шүүгчийн хараат бус байдлыг болон шударга шүүхээр шүүлгэх иргэдийн эрхийг Үндсэн хуульд тунхаглан заасан байдаг. Сүүлийн жилүүдэд өрнөж буй эрх зүйн шинэчлэлтийн хүрээнд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, шүүхийн шинэчлэлийг хэрэгжүүлж байна. Энэ утгаар шүүхийн хараат бус байдалд нөлөөлөхгүйгээр хууль дээдлэх, шударга ёсыг бэхжүүлэх, иргэдийн итгэлийг хадгалах, хамгаалах зорилгоор төрөөс бүрдүүлж буй зохистой бүтэц, арга хэмжээний нэг нь хараат бус бие даасан Шүүхийн сахилгын хороо байгуулсан явдал юм. Шүүхийн сахилгын хороо байгуулагдсанаараа олон жил



шүүхийн системд дотор нь байсан сахилга ёс зүйн зөрчил хянан шалгах үйл ажиллагаа хөндлөнгийн хараат бус бие даасан хэлбэрт орсон нь илүү үр дүнтэй шийдэл болсон.

2022 оны зургаадугаар сарын байдлаар Сахилгын хороо байгуулагдаад багахан хугацаа өнгөрч байгаа хэдий ч тус хорооны үйл ажиллагааны үр дүн гарч байна гэж миний хувьд дүгнэн хэлж чадахаар байгаа. Тус хороо бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлснээс хойш нийт 114 шүүгчид холбогдуулж 489 өргөдөл гомдол мэдээлэл хүлээн авч шалгасан үүнээс 206 нь шинээр хүлээн авсан ба 23 шүүгчид сахилгын зөрчил гаргасанд тооцож шийтгэл оногдуулаад байна.

- Тус хороонд одоогоор хэдэн шүүгчид холбогдох хэчнээн өргөдөл, мэдээлэл бүртгэлтэй байна вэ?

- Шүүхийн сахилгын хороо нийт 489 гаруй өргөдөл, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 200 гаруй буюу 40 хувьд нь сахилгын хэрэг үүсгэж шалгах ажиллагаа явуулсан. Шүүхийн сахилгын хорооны хуралдаанаар 23 шүүгчид сануулах арга хэмжээ авч, 6 шүүгчид цалингийн хэмжээг зургаа хүртэл сараар 20 хүртэл хувиар бууруулах, 5 шүүгчид огцруулах шийтгэл оногдуулсан байгаа. Өнөөдрийн байдлаар нийт 23 шүүгчид зөрчил гаргасанд тооцож зохих шийтгэл оногдуулснаас 3 шийдвэр нь хуулийн хүчин төгөлдөр болсон байгааг анхаарах хэрэгтэй. Бусад нь шүүхийн сахилгын хорооны шийдвэрт гомдол гаргасан учир хянан шалгагдаж байгаа.

Шүүхийн тухай хуулийн 39.6 дахь хэсэгт заасныг үндэслэн нэг шүүгчийн бүрэн эрхийг сэргээж, мөн хуулийн 56.8.2 дахь хэсэгт заасан үндэслэлээр гурван шүүгчийг албан тушаалаас нь огцруулсан бол Нийслэлийн Прокурорын Газраас

ирүүлсэн саналыг хянан хэлэлцээд гурван шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлж шийдвэрлэсэн байна.

Өмнөх Шүүхийн Ерөнхий зөвлөлийн ёс зүйн хороо хүлээн авч шийдвэрлээгүй байсан 283 өргөдөл гомдлыг Сахилгын хороо хүлээн авч хянан үзээд нийт 35 шүүгчид зөрчил гаргасанд тооцсон боловч өмнөх эрх зүйн зохицуулалтаар хөөн хэлэлцэх хугацаа дууссан учир сахилгын хэргийн нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байдаг. Энэ бол хоёр эрх зүйн зохицуулалтын шилжилтийн үеийн нөхцөл байдал юм. Цаашид энэ байдал багсах бөгөөд шинэ эрх зүйн охицуулалтаар хөөн хэлэлцэх хугацаа 1 жилээс таван жил хүртэл уртассан ба олон удаа давтан зөрчил гаргагчдад огцруулах шийтгэл оноох бүрэн эрхийг шүүхийн сахилгын хороонд олгосон.

- ШСХ-ны гишүүд гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэхдээ холбогдсон шүүгч, гомдол гаргагч зэрэг хүмүүсээс тайлбар мэдүүлэг авах, нотлох баримт цуглуулах ажиллагаа хийдэг үү?

- ШСХ-ны гишүүдэд хуулиар хянан шалгах ажиллагаа хэрэгжүүлэх онцгой эрх олгогдсон. Өргөдөл, гомдол, мэдээлэл хянан шалгах ажиллагаатай холбоотой давхардсан тоогоор бүх шатны шүүхүүдээр 133 удаа томилолтоор явж ажиллажээ. Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг тасралтгүй хэвийн явуулахад шаардлагатай техник, тоног төхөөрөмж, хүний нөөцийг бүрдүүлэх, ажлын байрны нөхцөл, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дэд бүтцийг сайжруулах зэрэг асуудлыг шийдвэрлэж зохих стандартад хүргэхээр ажиллаж байгаа. Одоогоор хараахан зохих түвшинд хүрээгүй хэдий ч гишүүд албан ажилтнууд хуулиар олгогдсон үүргээ бүрэн хэмжээнд хэрэгжүүлэн ажиллаж байгаа.



Олон нийтийг мэдээллээр хангах, нээлттэй ил тод ажиллах чиг үүргийн хүрээнд ШСХ-ны албан ёсны цахим хуудас www.judiscom.mn болон “Шүүхийн сахилгын хороо” гэсэн хаягтай фэйсбүүк, инстаграм, твиттер хаяг нээн, хуралдааны тов, шийдвэр, өргөдөл гомдлын бүртгэл, шийдвэрлэсэн хэрэг болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бусад мэдээ, мэдээллүүдийг өдөр тутам тогтмол нийтэлж, олон нийтэд хүргэж байгааг хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлч, сурвалжлагч та бүхэн өргөн ашиглахаар боломж бололцоог ханган ажиллаж байгаа.

-Тус хороонд ирсэн 400 гаруй өргөдөл, гомдлоос 50 гаруй хувьд нь сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан гэлээ. Яг ямар үндэслэлээр сахилгын хэрэг үүсгэж шалгадаг талаар тодруулахгүй юу?

- УИХ-аас 2021 оны нэгдүгээр сарын 15-нд баталсан Шүүхийн тухай хуульд зааснаар шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл оногдуулах чиг үүрэг бүхий бие даасан байгууллага болох Шүүхийн сахилгын хорооны эрх зүйн байдлыг хуульчилсан. Сахилгын хороо нь дээрх хуульд заасан хориглосон, хязгаарласан, үүрэг болгосон зохицуулалтыг зөрчсөн талаарх өргөдөл, мэдээллийг хүлээн авч, түүнийг зөрчсөн байж болзошгүй гэж үзсэн тохиолдолд сахилгын хэрэг үүсгэн, хянан шийдвэрлэх ажиллагаа явуулдаг.

Ямар тохиолдолд сахилгын хэрэг үүсгэхээс татгалзах вэ гэдгийг хуульд тодорхой заасан байгаа. Нэгдүгээрт, Шүүхийн тухай хуульд заасан зөрчил буюу хориглосон, хязгаарласан, үүрэг болгосон зохицуулалтыг зөрчөөгүй гэж үзвэл, хоёрдугаарт, өргөдөл, мэдээлэлд заасан үйл баримт, шүүгчийн үйл ажиллагааны талаар, эсхүл уг өргөдөл, мэдээллийн

дагуу сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгосон Сахилгын хорооны гишүүний захирамж, тус хорооны магадлал, тогтоол, хянан үзэх хуралдааны тогтоол хүчин төгөлдөр байгаа бол, гуравт, өргөдөл, мэдээлэл гаргасан этгээд тодорхойгүй бол сахилгын хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэдэг. Энгийнээр тайлбарлан хэлбэл шүүхийн тухай хуульд нэрлэн заасан тодорхой 50 орчим хориглосон хязгаарласан, үүрэг болгосон заалтуудыг зөрчсөн үйлдэл эс үйлдэхүйд хамаарахгүй тохиолдолд татгалзаж шийдвэрлэдэг.

Гомдол, өргөдөл, мэдээлэл гаргагч нь татгалзсан шийдвэрт гомдол гаргах эрхтэй. Гомдол шийдвэрлэх хуралдаанаар гомдлыг хэлэлцэн дахин шийдвэр гаргадаг. Одоогийн байдлаар 16 гомдолд татгалзсан шийдвэрийг хүчингүй болгож, сахилгын хэрэг үүсгэх шийдвэр гаргасан байна.

Мөн гишүүдийн шийдвэр гаргах үндсэн ажил нь хуралдаан бөгөөд өнөөдрийн байдлаар 349 хуралдаан хийж ажилласан тоо мэдээ байгаа. Нийт гишүүдийн зөвлөгөөн 26, гомдол шийдвэрлэх хуралдаан 96, сахилгын хорооны хуралдаан 217 гаран, хянан үзэх хуралдаан 10 орчим хийгдсэн байгаа. Сахилгын хорооны гишүүдээс дээд тал нь давхардсан тоогоор 100 орчим хуралдаан даргалсан ба бүрэлдэхүүнд орсон тоо мэдээ байна. Бүрэн эрх хэрэгжиж эхэлснээс хойш мянга орчим захирамж, 130 тогтоол, 199 магадлал гаргасан статистик мэдээ байгаа. Эдгээр байдлуудыг нэгтгэн үзвэл сахилгын хорооны үйл ажиллагаа өвөрмөц онцлогтой бөгөөд ачаалалтай гэж хэлж болохоор юм.

Цаашид хууль хэрэглээний явцад болон шүүхийн практик үйл ажиллагаа,



эрх зүйн зохицуулалтын үр дүнд энэ зөрчлийн тоо нэмэгдэх нөхцөл байдал үүсэн бий болж болно гэж хуульч эрдэмтний хувьд бодож байгаа.

- Хагас жил шахмын хугацаанд дүрэм, журмаа боловсруулж батлахын зэрэгцээ тэр олон өргөдөл, гомдлыг шийдвэрлэн багагүй ачаалалтай ажиллажээ. Олон нийтийн дунд байгаа шиг, цахим орчинд тархаад байдаг шиг шүүх, шүүгч нар бүхэлдээ зохих ёсоор ажиллахгүй болсон гэж харагдаж байна уу. Та энэ талаар ямар нэг дүгнэлт хэлж болох уу?

- Шүүхийн системийг бүхэлд нь зохих ёсоор ажиллахгүй байна, шүүгч нар бүгд ёс зүйн зөрчил гаргаж байна гэж өрөөсгөл ойлгож болохгүй. Иргэн, хуулийн этгээд нь гомдол гаргах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь нээлттэй учраас гомдол гаргана. Тэр болгоныг шүүгч ёс зүйн зөрчил гаргаад байна гэж үзэж, дүгнэж болохгүй. Сахилгын хороонд ирж байгаа өргөдөл, мэдээллийг хорооны гишүүд хүлээн авч, зөрчил гаргасан, эсхийг хуульд заасан үндэслэл журмын дагуу шалгах ажиллагааг явуулж байж тогтоодог. Нэг жилийн ой дээрээ нэлээд дэлгэрэнгүй судалгаа хийж дүгнэн үзэх төлөвлөгөөтэй байна. Судалгаа нь хууль, эрх зүйн болон практик үйл ажиллагааны нөхцөл байдлыг бодитоор үнэлэн дүгнэх, тодруулах, чанаржуулах олон ач холбогдолтой.

- Шүүгч нарын сахилгын асуудлаар ханддаг хамгийн олон тоотой гардаг гэх үү тийм төрлийн ёс зүйн зөрчлүүдээс та дурдаач. Иргэд, өргөдөл мэдээлэл гаргагч яг ямар асуудлаар хамгийн их гомдол гаргадаг вэ?

- Шүүхийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 дэх хэсэгт “Шүүгчийг сахилгын зөрчил гаргасан гэж үзсэн хүн, албан тушаалтан, хуулийн этгээд

холбогдох шүүгчид сахилгын хэрэг үүсгүүлэхээр Сахилгын хороонд өргөдөл, мэдээлэл гаргана” гэж заасан бөгөөд дээр дурдсанчлан нийт 45 тохиолдолд Сахилгын хороонд гомдол гаргах үндэслэл бий болно. Голлон хэргийн оролцогчийн нэг талд үйлчилсэн, хэрэг шийдвэрлэхгүй удаашруулсан, хуулийн илт тодорхой заалтыг зөрчсөн гэх гомдлууд ирж байгаа ч шүүх хуралдааны явцад гар утас хэрэглэж үл хүндэтгэсэн гэх зэрэг гомдлууд ч бас байна.

- Тэгэхээр эдгээр зөрчлүүд бүс нутгаар нь авч үзвэл хотод, орон нутагт гардаг гомдлын төрлүүд гээд бас ялгаатай байгаа байх танилцуулж болох уу?

- Одоо байгаа статистик тоон мэдээллээс авч үзвэл өргөдөл, мэдээлэл орон нутгаас бага, хотоос их ирж байгаа гэсэн дүн гарч байна. Мөн иргэний, захиргааны шүүхийн шүүгч нарт болон давах, хяналтын шатны шүүхийн шүүгч нарт холбогдуулан ирсэн хувь дийлэнх байна.

- Танай сахилгын хорооны хуралдааны шийдвэрүүд олон нийтэд нээлттэй мэдээлэгдэж, байршиж эхэлсэн. Тэндээс хуульчид, иргэд шүүгчид өөрсдөө ч гэсэн тодорхой ойлголттой, зүй ёсны хүлээлттэй болох боломж нээлттэй болсон гэж харж байна. Энэ шийдвэрүүд байнга ингэж байрших уу, эсхүл гомдлын төрлөөс хамаараад тодорхой хугацааны дараа нийтэд нээлттэй биш болох тийм боломж байх уу?

- Монгол Улсын Шүүхийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн 116 дугаар зүйлд Ажлын алба шүүгчийн сахилгын хэргийн бүртгэл хөтөлж, хамаарах мэдээлэл хөтлөх журамтай байх бөгөөд тайланг цахим хуудаст байршуулах бөгөөд Сахилгын хорооны магадлал, хяналтын тогтоол, Улсын



дээд шүүхийн хяналтын шатны сахилгын хэргийн хуралдааны тогтоолыг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 21 хоногийн дотор цахим хуудаст байршуулна гэж хуульчилж өгсөн байдаг. Иймд тухайн шийдвэрүүдийн хувьд ямагт олон нийтэд ил тод байна.

- Хуульчдын дунд нэг ийм яриа яваад байна л даа. Аливаа юм хоёр талтай гэж, нэг талаас шүүгчдийн сахилга ёс зүйн асуудлыг ингэж өндөр хэмжээнд авч үзэж, нэгдмэл байдлаар хариуцлага хүлээлгэж эхэлсэн нь үнэхээр том дэвшил болсон гэдэг нь гарцаагүй. Нөгөө талаас шинэ тутам бий болсон энэхүү эрх зүйн орчныг бас буруугаар, хортойгоор ашиглах хандлага байх шиг байна. Тодруулбал, зарим итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч нар шүүгчийг айдаст автуулах, үндэслэлгүй гомдол гаргаж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нь нөлөөлөх арга хэрэгсэл болгож ашиглах байдал нэгэнт бий болсон гэж байгаа нь хэр үнэний ортой вэ. Ийм маягаар өмгөөллийн үйл ажиллагаа явуулаад байгаа өмгөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгч нарт МӨХ, Монголын хуульчдын холбоогоор дамжуулаад авах ямар арга хэмжээ байж болох вэ. Энэ талаар ШЕЗ-тэй хамтран ажиллах боломж хэр нээлттэй байдаг бол?

- Шүүхийн Сахилгын хороо хуульд заасан үндэслэл журмын дагуу гомдол мэдээлэл хүлээн аваад шалган шийдвэрлээд явж байна. Бүхий үйл ажиллагаа хуульд захирагдах ба хүн бүр хуулийн өмнө адил тэгш эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Шүүгч нарын зүгээс айдаст автаад байх ч юм уу, тийм боломж байхгүй байх гэж бодож байна. Тодорхой хянан шалгах ажиллагаа явагдаж хангалттай нотлох баримт бүрдүүлж хуралдаанаар шийдвэрүүд гарч байгаа шүү дээ. Гагцхүү

ямар ч үндэслэлгүй “Шүүхийн Сахилгын хороо гэж байгууллага байгаа юм чинь өргөдөл, гомдол, мэдээлэл өгчихье” гэдэг байдлаар хандаад байгаа байдал байхыг үгүйсгэхгүй. Тодорхой цаг хугацааны дараа өөрийн гэсэн практик тогтоод ирэх байх гэж бодож байна.

- Танд, танай байгууллагад шүүгч нарт мэдээлэх, миний танаас асууж чадаагүй өөр нэмж хэлмээр зүйл байна уу?

- Цаг хугацаа бүгдийг тодруулна гэсэнтэй санал нийцдэгийн хувьд Шүүхийн сахилгын хорооны үйл ажиллагаанд тулгарч буй олон асуудлыг дэс дараалалтай хууль журмын дагуу шийдвэрлэх, цаашдын хэтийн стратеги төлөвлөгөө боловсруулах талаар судалгаа хийж ажиллаж байгаа. Шүүхийн сахилга ёс зүйн асуудлыг хянан шалгах ажиллагаа өөрөө онцлог, олон талт үйл ажиллагаа болох нь өнөөдөр практик хэрэгжилтээс ч харагдаж байна. Нийт агуулгаараа хянан шалгах ажиллагаа нь зөв чиглэлд, мөн үр дүнтэй хэрэгжиж байгаа гэсэн судалгааны урьдчилсан дүн гарах төлөвтэй байна. Шүүхийн сахилгын хорооны шийдвэрүүд хуулийн хүчин төгөлдөр болсноор зохих үр дүн ойрын хугацаанд харагдана. Шүүхийн сахилгын хороог анх байгуулах болсон үндэслэл нь ч шударга ёс, хууль дээдлэх зэрэг Үндсэн хуулийн зарчмыг нийгэмд нэг мөр хэрэгжүүлэх чиглэлтэй бөгөөд энэ хугацаанд хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээгээр Шүүхийн сахилгын хороотой холбоотой түгээгдсэн мэдээллийг авч үзвэл иргэд, олон нийт харьцангуй тэнцвэртэй, үнэн бодит, эерэг төсөөлөлтэй байгаа нь ч ажиглагдаж байна.

Аливаа шинээр бүрдсэн байгууллага нь олон төрлийн хүндрэл бэрхшээлтэй тулгардаг. 1990 оноос хойш эрх зүйт



төрийг цогцлоон байгуулахын тулд шинээр бүрдүүлсэн байгууллага бүр үүнийг туулж ирсэн. Гэхдээ жил ирэх тусам энэ байдал төлөвшиж хууль тогтоомжид зөв тусгалаа олж байна. Үүний нэг илрэл нь ч Шүүхийн сахилгын хорооны гишүүдийг бүрдүүлэх асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд маш нарийн зохион байгуулалттайгаар гүйцэтгэсэн явдал мөн. Харин одоо цаашид шинэ тутам байгууллага байгуулахад

анхаарах асуудал нь үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд зохих материаллаг орчныг хууль тогтоомжийн хүрээнд урьдчилан тооцоолж, зөв зохистой бүрдүүлэх ажил гэж харж байна. Шүүхийн сахилгын хороо нь богино хугацаанд цомхон хүний нөөцийг бүрдүүлж хууль тогтоомжид заасан чиг үүргээ амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна.



📍 Монгол Улсын Дээд шүүх 15170-Улаанбаатар
40. 50 мянгат-1 Ж.Самбуугийн гудамж

☎ 51-261811

✉ info@jtrii.gov.mn

